

2022 ОУ 08.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХОВЧЛИГ БИРЖ
МОНГОЛЫН ХОВЧЛИГ БИРЖ
2022.08.10
БҮРТГЭВ-43



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА 2022

Үнэт цаас гаргагч



Үндсэн андеррайтер



Туслах андеррайтер





АГУУЛГА



АГУУЛГА 1

НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР 6

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР 6

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД 7

ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД 8

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ 9

ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 10

НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 11

1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 11

1.1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 12

1.1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ ХАЯГ 13

1.1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ 14

1.1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ 15

1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД 16

1.2.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ 16

1.2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОЛГОЙ КОМПАНИ 17

1.2.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭРГЭЛДЭЭ КОМПАНИУД 19

1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 23

1.3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ 23

1.3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД 24

1.3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГЫН БАГ 26

1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 28

1.4.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ 28

1.4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА 38

1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ 40

1.5.1 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ 40

1.5.2 СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ 40

1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ 44



1.7 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА 44

1.8 КОМПАНИЙН АЖИЛЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ 54

1.9 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО 54

ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 56

2.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 57



2022 оо. 08. 10 өдөр

БҮРТГЭВ

2.1.1 МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

2.1.2 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1.3 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.2 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

2.2.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

2.2.2 МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЗАХ ЗЭЭЛ

2.2.3 ЗЭЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛ

2.2.4 НИЙТ ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ

2.3 ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

2.3.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨРСӨЛДӨГЧИД

2.3.2 МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ӨРСӨЛДӨГЧИД

2.3.3 SWOT шинжилгээ

2.4 САНХҮҮГИЙН ТААМАГЛАЛ

2.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

3.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1.1 Хувьцааны нэрлэсэн үнэ, хугацаа нөхцөл

3.1.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

3.2 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

3.3 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

3.4 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.5 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ

3.5.1 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

3.5.2 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь

3.5.3 Эрх бүхий байгууллагын зөвшөөрөл

3.5.4 Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах

3.5.5 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа

3.5.6 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

3.5.8 Арилжааны шимтгэл

3.5.9 Албан татвар

3.6 ҮНЭ ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД

4.1 АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

4.2 ХАМТРАГЧ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

4.3 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

4.4 ҮНЭДГЭЭНИЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

2022-08-05
57

БҮРТГЭВ 58

2022.08.10

2022-08-05

4.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ.....	130
ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТАЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ДҮГНЭЛТ.....	131
АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ.....	131
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	141
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	162
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ.....	192
ХУУЛИЙН ДҮГНЭЛТ.....	242
ХУУЛИЙН НЭМЭЛТ ДҮГНЭЛТ.....	294
ХАВСРАЛТ-1 Улсын бүртгэлийн гэрчилгээ.....	297
ХАВСРАЛТ-2 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ.....	299

ХҮСНЭГТ

Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөл.....	15
Хүснэгт 2: Хувьцаа эзэмшигчид.....	16
Хүснэгт 3: 2021.12.31-ний өдрийн байдлаарх зээлийн багц /бүтээгдэхүүний төрлөөр/.....	35
Хүснэгт 4: Санхүү байдлын тайлан.....	40
Хүснэгт 5: Орлого үр дүнгийн тайлан.....	41
Хүснэгт 6: Мөнгөн урсгалын тайлан.....	43
Хүснэгт 7: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	45
Хүснэгт 8: Монгол Улсын зээлжих зэрэглэл.....	57
Хүснэгт 9: Монгол улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд.....	58
Хүснэгт 10: Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл.....	60
Хүснэгт 11: Гадаад худалдааны тэнцэл, экспорт, импорт.....	61
Хүснэгт 12: Инфляцийн төсөөлөл.....	62
Хүснэгт 13: Уламжлалт ба финтек ББСБ.....	68
Хүснэгт 14: ББСБ тоо, хөрөнгө.....	68
Хүснэгт 15: Аппликейшнээр зээл олгож буй компаниуд.....	72
Хүснэгт 16: Гадаадад оршин суугаа Монгол иргэд – Зорилгоор.....	76
Хүснэгт 17: Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамж.....	78
Хүснэгт 18: Банк болон ББСБ худалдааны салбарт олгогдсон зээлийн нөхцөл/2021 он/	79
Хүснэгт 19: Худалдааны салбарын нийт борлуулалт /Нэгж: их наяд төгрөг/	80
Хүснэгт 20: Жижиглэн худалдааны газруудын тоо /2020 он/	85
Хүснэгт 21: Худалдааны газрын ангилал /2020 он/	85
Хүснэгт 22: Худалдаа үйлчилгээний төвийн түрээслэгчдийн тоо.....	86
Хүснэгт 23: Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд.....	89
Хүснэгт 24: Сэндли ББСБ-ийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нийт багтаамж.....	90
Хүснэгт 25: Сэндли ББСБ-ийн зорилтот зах зээлийн нийт багтаамж.....	91
Хүснэгт 26: Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-уудад олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчид.....	93
Хүснэгт 27: Үйлчилгээний харьцуулсан үзүүлэлт.....	93
Хүснэгт 28: ББСБ-уудын орон нутаг дахь тархац.....	93
Хүснэгт 29: Санхүүгийн тайлангийн төсөөлөл.....	100
Хүснэгт 30: Орлогын тайлангийн төсөөлөл /2022-2026/	102
Хүснэгт 31: Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл /2022-2026/	103
Хүснэгт 32: Компанийн харилцагчдын тоо.....	104



2022.08.10

2022-08-05 105

БҮРТГЭЭ-03

Хүснэгт 33: Зохистой харьцааны үзүүлэлт 105

Хүснэгт 34: ATL, BTL, TTL арга замуудын харьцуулалт 112

ЗУРАГ

Зураг 1: Сэндли ББСБ ХХК-ийн хамт олон.....	12
Зураг 2: "SENDLY" мөнгөн гуйвуулгын үйлчилгээний түүх.....	15
Зураг 3: Хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	16
Зураг 4: Толгой компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	18
Зураг 5: Бүтэц зохион байгуулалт.....	23
Зураг 6: Тухайн улсад оршин сууж буй Монгол улсын иргэдийн тоо /2021 оны эцсийн байдлаар/.....	28
Зураг 7: Сэндли ББСБ ХХК салбар нэгжийн байршил.....	35
Зураг 8: Мерчантын зээлийн хэрэгцээ, зах зээл.....	88
Зураг 9: Финтекийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн матриц.....	92

ГРАФИК

График 1: Төгрөгийн гуйвуулга.....	29
График 2: Ам.долларын гуйвуулга.....	29
График 3: Австрали долларын гуйвуулга.....	29
График 4: Япон иенийн гуйвуулга.....	29
График 5: Гуйвуулгын тоо.....	30
График 6: 2021.12.31-ний өдрийн байдлаарх зээлийн багц бүтээгдэхүүний төрөл.....	36
График 7: Нийт харилцагч Нийт зээлдэгч.....	36
График 8: Нийт зээлийн үлдэгдэл (сая.төг).....	37
График 9: Зээлийн багцын чанар.....	37
График 10: Бодит ДНБ /2015 оны зэрэгцүүлэх үнээр/.....	59
График 11: Гадаад худалдааны нөхцөл.....	60
График 12: Инфляцийн түвшин.....	61
График 13: Мөнгөний нийлүүлэлт.....	62
График 14: Төлбөрийн тэнцэл.....	63
График 15: Гадаад валютын албан нөөц.....	64
График 16: Валютын ханш.....	65
График 17: ХЗЗ-н үнэлгээ, ТОП-20 индекс.....	65
График 18: Арилжааны идэвх.....	66
График 19: Нийт хөрөнгө, нийт зээл.....	67
График 20: ББСБ тоо, харилцагчийн тоо.....	67
График 21: Зээлийн жингэсэн дундаж хүү.....	68
График 22: Нийт зээлийн хуваарилалт.....	69
График 23: Иргэдэд олгосон зээл.....	69
График 24: Хуулийн этгээдэд олгосон зээл.....	69
График 25: Эх үүсвэр.....	70
График 26: Ашигт ажиллагаа.....	70
График 27: Харилцагчид.....	71
График 28: Дэлхийн мөнгөн гуйвуулгын хэмжээ.....	73
График 29: Хүлээн авсан мөнгөн гуйвуулгаар тэргүүлэгч 10 улс.....	73
График 30: Илгээсэн мөнгөн гуйвуулгаар тэргүүлэгч 10 улс.....	73
График 31: 200 ам.доллар шилжүүлэхэд гарах зардал.....	74
График 32: Дэлхийн мөнгөн гуйвуулгын төсөөлөл.....	74
График 33: Дотоод мөнгөн гуйвуулгын хэмжээ.....	75




График 34: Шилжүүлсэн мөнгөн гуйвуулга.....	76
График 35: Хүлээн авсан мөнгөн гуйвуулга.....	76
График 36: Гадаад улсад суугуу Монгол иргэдийн тоо.....	77
График 37: Гадаадад суугаа Монгол иргэдийн тоо.....	78
График 38: Арилжааны банкны зээлийн бүтэц.....	80
График 39: Нийт зээлд эзлэх хувь.....	81
График 40: Чанаргүй зээлийн түвшин.....	81
График 41: Мерчантуудын санхүүжилтийн эх сурвалж ба санхүүжилтийн зарцуулалт.....	82
График 42: Мерчантуудад шаардлагатай зээлийн хэмжээ.....	82
График 43: Мерчантууд банкнаас зээл авахад тулгардаг асуудал.....	83
График 44: Сэндли ББСБ компанийн мерчантын зээл авах боломжит зах зээл.....	88
График 45: Улсын дундаж цалин.....	89
График 46: Өр төлбөр болон эздийн өмчийн харьцааны төсөөлөл.....	101
График 47: Нийт зээлийн багц /2022-2026/.....	101
График 48: Нийт орлого болон цэвэр ашгийн төсөөлөл /2022-2026/.....	103
График 49: Өгөөж.....	106
График 50: Санхүүгийн хөшүүрэг.....	106





Эндлийн ББСБ Хэвч. Үндэсний танилцуулга



НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР

Үнэт цаас гаргагч	Үнэт цаасаа олон нийтэд худалдахаар санал болгож буй компани
Финтек	Санхүүгийн үйлчилгээг технологитой хамтатгасан бизнесийн загвар
Бичил зээл	Бага хэмжээтэй хэрэглээний зээл
Аппликейшн	Гар утсанд суулгаж ашигладаг программ
Андеррайтер	Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг зохион байгуулагч компани
Их хэмжээний хэлцэл	Компанийн өөрийн хөрөнгийн 25 хувиас дээш хэмжээтэй гэрээ, хэлцэл
Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасныг ойлгоно.
Анхдагч зах зээл	Анх удаа олон нийтэд үнэт цаасаа худалдаж байгаа арилжаа
Арилжаа	Үнэт цаас худалдах, худалдан авах ажиллагаа
Мерчант	Жижиглэнгийн худалдаа эрхлэгч
Хиймэл оюун ухаан	Өөрийгөө хөгжүүлж байдаг программ
Лиценз	Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх
Корпораци	Хувь нийлүүлсэн байгууллага; эвлэл, нэгдэл
Синержи	Хамтын ажиллагаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХК	Хувьцаат компани
ҮЦК	Үнэт цаасны компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
МХБ	Монголын хөрөнгийн бирж
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
IT	Information Technology (Мэдээллийн технологи) товчилсон үг
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
МБ	Монгол банк
ГВАН	Гадаад валютын албан нөөц
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ҮЦТХТ	Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв






ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

“Сэндли ББСБ” ХХК /цаашид “Үнэт цаас гаргагч”, “Компани” гэх/ нь Монгол улсын “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Санхүүгийн Зохицуулах Хороо” болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн холбогдох журмын дагуу олон нийтэд анх удаа хувьцаагаа нээлттэй санал болгон гаргаж байгаа болно.

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны хувьцаа худалдан авах шийдвэр гаргалтад туслах, шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг оруулахыг зорилоо. Таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болох буюу лавлах тодруулах нэмэлт зүйл гарвал Үнэт цаас гаргагч “Сэндли ББСБ” ХХК болон Андеррайтер “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК, “Райнос инвестмент ҮЦК” ХХК-д хандана уу.





ЭНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

АНДЕРРАЙТЕР



"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК

- 📍 Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 25 давхар, 2506 тоот
- ✉ info@ucc.mn
- ☎ +976 7777 6377
- 🌐 www.ucc.mn

ХАМТРАГЧ АНДЕРРАЙТЕР



"РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК

- 📍 Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1308Б тоот
- ✉ info@rhinosinvest.mn
- ☎ +976 7510 0575
- 🌐 www.rhinosinvest.mn

ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ



"ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ" ХХК

- 📍 Монгол улс, Улаанбаатар 14200, СБД, 8-р хороо, Сүхбаатрын талбай 20-6, Эрдэм цамхаг, 1004 тоот
- ✉ gantulga@geregepartners.mn
- ☎ +976 7000 5000

ХУУЛИЙН ФИРМ



"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ХААНЛЕКС" ХХН

- 📍 Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
- 🌐 www.mdsa.mn
- ☎ +976 11 330048
- 🌐 +976 11 330049

АУДИТЫН КОМПАНИ



"ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ" ХХК

- 📍 Монгол улс, Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Метро бизнес төв, 6 давхар, 603 тоот
- ✉ shonkhor.mn@gmail.com
- ☎ +976 8011 0088





ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИЙДВЭР

2022 оны 08 сарын 17-ны өдөр

№ 08

Улаанбаатар хот

Хувьцаагаа анх удаа нийтэд санал болгон гаргах тухай

"Хувьцаа хуваах тухай" "Сэндли ББСБ" ХХК-ийн 2022 оны 4 дүтээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоол, "Сэндли ББСБ" ХХК-д "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэх замаар оорчлон байгуулах болон түүнтэй холбогдох бусад асуудлыг батлах тухай "Сэндли ББСБ" ХХК-ийн 2022 оны 4 дүтээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 06 дугаар тогтоол тус гарч, зохиж журмын дагуу ажллагаа хийгдэж байгааг ТЭМЦЭГ ЛЭН,

Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, "Сэндли ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7.3 дахь заалт, "Гэрээг эсгэлэгт" ХХК-ийн "Хараат бус бизнесийн үнэлгээний тайлал", 2022 оны 05 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн тэжээт бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэг бүр нь 50 /тавы/ төгрөгийн нэрлэсэн үзэгтэй 156,570,000 /нэг зуун тавин зургаан сая таван зуун далан мянга/ ширхэг зигийн хувьцаан дээр 50 /тавы/ төгрөгийн нэрлэсэн үзэгтэй 67,000,000 /жаран долоон сая/ ширхэг зигийн хувьцааг ирээж гарган, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох замаар 10,050,000,000 /Арван тэрбум тавин сая/ төгрөгийг татан төвлөрүүлж, оорний тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж байгаа үндсэн үйл ажиллагаандаа зарцуулахаар тогтсугай.
2. Хувьцаа ирээж гарган нийтэд санал болгох зохицол, журам, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Нэмж гарган нийтэд санал болгох хувьцааг олоогийн хувьцаа эзэмшигч нар тэргүүн эрхэнд худалдан авах эрхээ эдлэхгүй буюу уг эрхээсээ татгалзсан болохыг дурдсугай.
4. Мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулж, үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбоотой үйл ажиллагааг шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Одюрал)-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

"Монголын Финтек група" ХК-ийн төлөөлөгч Төлөөлөн Уширдах зөвлөлийн дарга:





Сэндли ББСБ ХХК - Үнэт цаасны танилцуулга



ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч	Сэндли ББСБ ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Биржид бүртгүүлэх нийт хувьцааны тоо ширхэг	223,570,000 ширхэг
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	50 төгрөг
Нэмж гаргах хувь	29.97%
Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг	67,000,000 ширхэг
Стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох	75% - 50,250,000 ширхэг
Олон нийтэд санал болгох	25% - 16,750,000 ширхэг
Анхдагч зах зээлд санал болгох үнэ	150 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	10,050,000,000 төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Өөрийн тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үндсэн үйл ажиллагааны эх үүсвэрт
Арилжаалах арга хэлбэр	Тогтоосон үнийн арга
Үндсэн андеррайтер	Өлзий Энд Ко Капитал ҮЦК ХХК
Туслах андеррайтер	Райнос Инвестмент ҮЦК ХХК

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДЭЭС ГАРГАСАН ШИЙДВЭР

“Сэндли ББСБ” ХХК-ийн 2022 он 2 дугаар сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын №02 тоот тогтоолоор нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж, компанийн цаашдын бизнесийг санхүүжүүлэх, үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 08 тоот тогтоолоор компани нээлттэй хүрээнд нэмж хувьцаа гаргах, үнэлгээний компанийг сонгон шалгаруулах, үнэлгээний компанийн дүгнэлтэд тулгуурлан нэмж гаргаж буй хувьцааны нэгж үнийг тогтоох шийдвэр гаргасан бөгөөд Үнэт цаас гаргагч болон андеррайтер хамтран үнэлгээний дүгнэлтэд үндэслэн нэмж гаргаж буй хувьцааны нэг бүрийн үнийг 150 /нэг зуун тавин/ төгрөгөөр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн байна.





Нэг.

Үнэт цаас гаргагчийн тухай



“Сэндли ББСБ” ХХК нь 2015 оны 5 дугаар сард “Гялс кредит” нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллага юм.


Зураг 1: Сэндли ББСБ ХХК-ийн хамт олон



Үнэт цаас гаргагч нь финтек технологид суурилсан, “Sendly” гар утасны аппликейшнээр дамжуулан олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2020 оны 5 дугаар сард зах зээлд амжилттай нэвтрүүлж, Америкийн нэгдсэн улс, Австрали, Япон зэрэг улсад оршин суугаа Монгол улсын иргэдэд түргэн шуурхай, олон улсын стандартын дагуу, хямд өртөгтэй мөнгөн гуйвуулгын үйлчилгээг үзүүлж байна. Цаашлаад Европын холбооны улсууд болон Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг Монгол улсын иргэд олноор суурьшсан улс орнуудад бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

“Sendly” мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь гадаад болон дотоодын зах зээлд өөрийн гэсэн өнгө төрх, брэндийг бий болгож, хэрэглэгч үйлчлүүлэгчдэдээ таниулах зорилгоор 2021 оны 12 дугаар сард компанийн оноосон нэрийг “Сэндли ББСБ” ХХК хэмээн өөрчилсөн билээ.





Алсын хараа

Харилцагчид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн хурдан, хамгийн бага зардлаар хүргэх дэлхийн стандартад нийцсэн санхүүгийн эко дэд бүтцийг бий болгох.

Эрхэм зорилго



Ажилтан бүрийн чин сэтгэлээр санхүүгийн хүртээмжтэй үйлчилгээг хэрэглэгч бүрт найдвартай хүргэнэ.



Үнэт зүйлс

Мэргэжлийн өндөр ур чадвартай баг хамт олон, харилцагч, технологи, мэдээллийн аюулгүй байдал, харилцагчийн үйлчилгээ

Давуу тал



- Мэргэжлийн боловсон хүчин
- МУ даяар хамгийн өргөн сүлжээг бий болгосон, ОУ-д нэвтэрсэн үйлчилгээ
- Өөрсдийн хөгжүүлсэн IT систем

1.1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ ХАЯГ

Хуулийн этгээдийн нэр "Сэндли ББСБ" ХХК

- Үйл ажиллагааны төрөл
- Зээл
 - Гадаад валютын арилжаа
 - Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
 - Факторинг
 - Итгэлцэл
 - Төлбөрийн баталгаа гаргах

Үүсгэн байгуулагдсан огноо 2015/05/04

Улсын бүртгэлийн дугаар 9015003084

Регистрийн дугаар 5961548

Хаяг Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40,50 мянгат Бакула ренбүчи гудамж 8/4

Утас +976 7012-7700, 7799-7700

Цахим шуудан info@sendly.mn

Цахим хаяг www.sendly.mn





1.1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

“SENDLY” үйлчилгээний үүсэл

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид нь 2016 онд Монгол Улсын гадаад төлбөр тооцооны системд шинэ гарцыг эрэлхийлэх, и-коммерс буюу онлайн худалдааг хөгжүүлэх, дэлхий даяарх төлбөр тооцооны цахим шилжилтэд хөл нийлүүлэн алхах зорилгоор АНУ-ын “ACI WORLDWIDE” компанитай хамтран ажиллах болжээ.

Төслийн эхэн үед зөвхөн төлбөрийн системийн шийдэлд анхаарч байсан бол хэрэгжүүлэх явцад зах зээлд бат бөх байр сууриа эзлэхийн тулд өөрийн компанийн бусдаас ялгарах онцлог, давуу талыг бий болгох бизнесийн шийдлүүд байгааг олж харсан. Ингээд гадаадад амьдарч байгаа Монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын зардлыг бууруулах, гадаадад амьдарч байх хугацаандаа өөрийн эх орондоо ипотекийн зээл, сайн дурын нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах, Монгол улс руу гаднаас орох валютын урсгалыг нэмэгдүүлэх боломжийг бий болгожээ.

“SENDLY” үйлчилгээний тухай



Сэндли төсөл эхэлснээр Лондон, Сингапур, Люксембург зэрэг олон улсын санхүүгийн төвүүдэд оффис нээх, тухайн улсуудын хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг авах зэрэг цаг хугацаа, хичээл зүтгэл их шаардагдсан ажлын ард чадварлаг хамт олныхоо хүчин чармайлтаар амжилттайгаар гарсан билээ.

Үнэт цаас гаргагчийн Англи улс дахь охин компани болох MonRemit Limited нь 2021 онд тус улсын Санхүүгийн зохицуулах хороо (FCA буюу Financial Conduct Authority)-оос Англи болон Европын холбооны орнуудад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг авч чадсан байна.


Сэндли нь 2020 оны 5 дугаар сард буюу Монгол Улс FATF (Financial Action Task Force буюу Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага)-ийн “саарал жагсаалт”-д ороод байх үед АНУ-ын 31 мужид албан ёсоор үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий XXX компани (харилцагчийн хүсэлтээр нэрийг нууцалсан болно) -тай хамтарч эхэлсэн. Эхэн үедээ тус улсаас Монгол улс руу мөнгөн гуйвуулга хийхэд шаардагддаг 14 хоногийг 30 минут болгон товчилж чадсан бол өнөөдөр энэ хугацаа 10 минутад хүрээд байна.

2021 онд WechatPay үйлчилгээний Монгол Улс дахь албан ёсны түнш болсноор БНХАУ-ын иргэд Монгол Улсад аялан ирэхдээ Улаанбаатар хот доторх худалдаа, үйлчилгээний газруудад тусгайлан байршуулсан QR-ийг wechat аппликейшнээр уншуулснаар төлбөр нэн даруй хийгдэх боломжтой болсон юм.





Зураг 2: "SENDLY" мөнгөн гуйвуулгын үйлчилгээний түүх




1.1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭЗЭМШИЖ БҮЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 318 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Одоогоор зээл, гадаад валютын арилжаа, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, факторинг, итгэлцэл, төлбөрийн баталгаа гаргах зэрэг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөл

Д/д	Үйл ажиллагааны төрөл, хэлбэр	Олгосон огноо	Олгосон шийдвэрийн дугаар
1	Зээл	2015.07.03	№318 тогтоол
2	Гадаад валютын арилжаа	2018.02.07	№62 тогтоол
3	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	2018.02.07	№62 тогтоол
4	Факторинг	2021.10.13	№441 тогтоол
5	Итгэлцэл	2021.10.13	№441 тогтоол
6	Төлбөрийн баталгаа гаргах	2021.10.13	№441 тогтоол





1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД
 1.2.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Зураг 3: Хувьцаа эзэмшигчдийн бүтэц




* (давхардсан захиалгын тоогоор)


“Сэндли ББСБ” ХХК-ийн 80.56 хувийг Монголын финтек групп ХК эзэмшдэг бөгөөд 12.77 хувийг “Сэндли Эмплоие” ХХК, 5.10 хувийг Б.Наранбат, 1.10 хувийг “Sendly” аппликейшнийг хөгжүүлэгч Радикс технологи компани, үлдсэн 0.47 хувийг компанийн 7 ажилчид тус тус эзэмшиж байна.

Хүснэгт 2: Хувьцаа эзэмшигчид

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	“Монголын финтек групп” ХК	126,141,700	80.56%
2	“Сэндли Эмплоие” ХХК	20,000,000	12.77%
3	Б.Наранбат	8,000,000	5.10%
4	Радикс технологи ХХК	1,714,200	1.10%
5	Батдорж Нямжаргал	285,700	0.18%
6	Зургаа Цолмон	107,100	0.07%
7	Чойжоо Дашсүрэн	71,400	0.05%
8	Лхагважав Нарантуяа	71,400	0.05%
9	Охиндоо Нямдэлэг	71,400	0.05%
10	Ганхуяг Саруул-Од	71,400	0.05%
11	Гантөмөр Гантуяа	35,700	0.02%

НИЙТ





1.2.2 ҮНЭТ ЦААСТАРГАГЧИЙН ТОЛГОЙ КОМПАНИ

MFG МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП ХК

“Монголын финтек групп” хаалттай ХК нь финтек технологид суурилсан бизнес эрхлэгч өөрийн охин компаниудыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай холбох, олон улсад тэдгээрийн бизнесийг таниулах, өргөжүүлэн тэлэх гүүр нь буюу “Санхүүгийн Холдинг” компани болох зорилгоор байгуулагдсан билээ.

Тус компани нь санхүү, үл хөдлөх хөрөнгө зуучлал, хөрөнгийн зах зээл зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж буй өөрийн охин компаниуддаа дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үйл ажиллагааг нь удирдлагаар ханган ажиллаж байна. Тус компанийн нийт хувьцааны 76.6 хувийг “Монголиан мючүал финанс групп” ХХК, үлдсэн 23.4 хувийг 252 (давхардсан захиалгын тоогоор) хувь хүн болон байгууллагууд эзэмшиж байна.



“МОНГОЛИАН МЮЧУАЛ ФИНАНС ГРУПП” ХХК

“Монголиан мючүал финанс групп” ХХК нь 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсын санхүүгийн болон технологийн салбарт шинэлэг, шуурхай үйлчилгээг нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготойгоор үүсгэн байгуулагджээ.

Тус компани нь худалдаа үйлчилгээ, санхүү, үл хөдлөх хөрөнгийн зуучлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй өөрийн охин компаниуддаа дэвшилтэт технологийг нэвтрүүлж, харилцагч үйлчлүүлэгчдийнхээ найдвартай хамтрагч нь болох замаар зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвар, үнэ цэнийг нь нэмэгдүүлэхэд удирдлагаар ханган ажиллаж байна.



“МОНГОЛ МЮЧУАЛ” ПТЕ.ЛТД

“Монголиан мючүал финанс групп” ХХК-ийг Сингапур улсад бүртгэлтэй “Монгол Мючуал” Пте.Лтд компани 100 хувь эзэмшдэг. Монгол Мючуал Пте.Лтд-ийн 70 хувийг Монгол Улсын иргэн Б.Наранбат, 30 хувийг М.Цолмон нар эзэмшиж байна.

Тус компани нь 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулагдсан ба АНУ, Англи, Япон, Солонгос, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй орнуудтай төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх боломжтой төлбөрийн системийн платформыг хөгжүүлэх, хамтран ажиллах, дэлхийн зах зээлд өөрийн охин компаниудыг сурталчлах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах үндсэн зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.





ТОЛГОЙ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Зураг 4: Толгой компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц



80.56%



Олон улсын мөнгөн гуйвуулга

100%



Төлбөрийн цогц шийдэл

65%



Хөрөнгө итгэмжлэн удирдах

95.2%



Үнэт цаасны арилжаа

10%



Хадгаламж зээлийн хоршоо

97.5%



Стартап компаниудын хөрөнгө оруулагч

100%



БНСУ-ын мөнгөн гуйвуулга

90%



Даатгалын зуучлалын үйлчилгээ

46%



Мөнгөний зах зээлийн платформ





1.2.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭРГЭЛДЭЭ КОМПАНИУД

HiPay ХАЙ ПЭЙМЭНТ СОЛЮШНС ХХК

“Хай пэймэнт солюшнс” ХХК нь 2018 оноос эхлэн Монгол улсад цахим төлбөр тооцооны иж бүрэн, найдвартай экосистемийг нэвтрүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд финтек технологид суурилсан “Hi-Pay” гар утасны аппликейшнийг хөгжүүлж, төлбөр тооцооны цогц шийдлийг бий болгохоор ажиллаж байна.



“Хай пэймэнт солюшнс” ХХК нь Монгол улсад анх удаа “E-commerce payment gateway” төлбөрийн системийг нэвтрүүлж, дэлхийн жишигт нийцсэн төлбөр тооцоо гүйцэтгэх боломжийг “HiPay” аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэж байна. Мөн, дэлхийн топ 19 банкны хэрэглэгчдийн картын мэдээллийг хүлээн авах, хадгалах, аюулгүй байдлын стандартын технологийг нийлүүлэгч “ACI WorldWide” компанитай хамтран ажиллаж байна.

“Хай пэймэнт солюшнс” ХХК 2021 оны жилийн эцсийн байдлаар 246.1 мянга гаруй хэрэглэгчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

ГЯЛС ТӨГРӨГ ГЯЛС ТӨГРӨГ ХЗХ


“Гялс төгрөг” ХЗХ нь 2016 онд үүсгэн байгуулагдсан ба 2021 оны эцсийн байдлаар нийт 15,395 гишүүнтэй болоод байна. Гялс төгрөг нь Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт нийт 45 салбар нэгжээр дамжуулан 12 төрлийн хадгаламж, зээлийн үйлчилгээг уламжлалт болон онлайн хэлбэрээр хослуулан хүргэж, салбартаа өөрийн байр суурийг эзлэн, дэвшилтэт технологийг амжилттай нэвтрүүлж чадсан хоршоо юм.

2018 онд олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “Micro Finanza Rating” байгууллага Гялс төгрөг ХЗХ-ны санхүүгийн чадавхад үнэлгээ хийн “BB” зэрэглэл тогтоосон нь тус хоршооны үйл ажиллагааг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал ач холбогдол үзүүлжээ.


HOME MORTGAGE CORPORATION ХӨҮМ МОРГЕЙЖ КОРПОРЭЙШН ХХК

“Хөүм моргейж корпорэйшн” ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан, хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл бүхий компани юм. Тус компани нь гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэдэд санхүүгийн хүртээмжийг бий






болгож, эх сурвалж орон сууц худалдан авах боломжийг www.1home.mn вэб сайтаар дамжуулан олгох зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.



“Хөүм моргейж корпорэйшн” нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, өөрийн зэргэлдээ компани болох Сэндли ББСБ-ын аппликейшнээр дамжуулан гадаад улсад амьдарч буй Монгол улсын иргэд орон сууцны зээл авах, зээлийн төлөлтийг саадгүй төлөх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

hi-daatgal МАСТЕР ШИЙДЭЛ ХХК




Мастер шийдэл ХХК нь 2014 онд байгуулагдаж, 2015 оны 01 дүгээр сард “Даатгалын зуучлагч”-ын тусгай зөвшөөрлийг авснаар үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Тус компани нь “Hi-charge” аппликейшнээр дамжуулан даатгалын гэрээг онлайнаар зуучлан борлуулах “Hi-daatgal” платформыг хөгжүүлж буй даатгалын зуучлагч компани юм.

2021 оны жилийн эцсийн байдлаар, Мастер шийдэл ХХК нь “Hi-daatgal” платформоор дамжуулан 202.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий 3781 ширхэг даатгалын гэрээг амжилттай зуучлан борлуулсан байна.

Investlab ИНВЕСТЛАБ ВИ СИ ХХК

“Инвестлаб ви си” ХХК нь 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулагдсан, гарааны бизнест шаардлагатай санхүүжилтийг олгож, хууль эрх зүй, технологийн чиглэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилготой, олон улсын “Venture capital fund”-н үйл ажиллагааны зарчмаар ажиллаж буй компани юм. Одоогийн байдлаар “Инвестлаб ви си” ХХК - ийн хөрөнгө оруулалтын багцад 10 гаруй гарааны бизнес нэгдээд байна.

Тэдгээр компаниудаас онцлох төслүүд нь “Дижитал вэндинг” ХХК ийн “Hi-charge” зөөврийн цэнэглэгч түрээс, “Эко кэш” хог хаягдал төлбөртэй хүлээн авах автомат машин, “Зочил” онлайн худалдааны платформ зэрэг төслүүд багтаж байна.





Digital Vending

Зөөврийн powerbank түрээсийн үйлчилгээ



Zochil

Онлайн худалдааны цахим платформ



Wings Pos

Эмнэлэгийн програмын цогц шийдэл



HoReCa Soft

Зочлох үйлчилгээний салбарын цогц шийдэл



Skyticket

Тийз болон аялалын платформ



Ecocash

Хог хаягдал төлбөртэй хүлээн авах машин



“Стоклаб секьюритиз ҮЦК” ХХК нь 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрлөө авч, Монгол улсынхаа хөрөнгийн зах зээлийн хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрээ оруулж, мэргэжлийн өндөр ёс суртахуун, ур чадварыг баримтлан түргэн шуурхай Гадаад улсад ажиллаж амьдарч буй болон Улаанбаатар хот, орон нутгийн харилцагчдадаа дэвшилтэт технологид суурилсан, төлбөрийн уян хатан нөхцөлтэй, хамгийн бага шимтгэлтэйгээр Хөрөнгийн зах зээлийн зуучлалын үйлчилгээ”-г үзүүлж байна.

Гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдэд хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг бий болгох, хөрөнгө оруулалтын бааз суурийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарт цахим мөнгөний хэрэглээг нэмэгдүүлэх боломжийг хамтран бүрдүүлэх зорилгоор 2022 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр “Монголбанк”, “Санхүүгийн зохицуулах хороо”-ны дэмжлэгтэйгээр “Стоклаб секьюритиз ҮЦК” ХХК, “Хай пэймэнт солишнс ХХК”, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нар хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд анх удаа гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол иргэд үнэт цаасны данс нээх, түүгээрээ дамжуулан Эрдэнэс тавантолгой компанийн 1072 хувьцааныхаа ногдол ашгаа авах, Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцох, бусад брокерын компанид байгаа үнэт цаасаа шилжүүлэн, удирдах боломжийг нээж өгсөн юм.



3



Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа нийт Монгол иргэдийн 30 орчим хувь нь буюу 50 мянга орчим иргэд БНСУ-д ажиллаж, амьдарч байна. Монгол улсаас тус улсад хөдөлмөр эрхлэх иргэдийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тухайн иргэдэд зориулсан албан ёсны мөнгөн гуйвуулгын үйлчилгээг бий болгох зорилготойгоор “Кореа ремитанс” ХХК нь байгуулагдсан билээ. Тус компани нь Монгол болон Солонгос улсын хооронд “Sendly” аппликейшнээр дамжуулан мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор “Gmoney Transfer” компанитай хамтран ажиллаж байна.

Одоогийн байдлаар “Кореа ремитанс” ХХК нь БНСУ-д “Сэндли Монголиа” хэмээх охин компаниа байгуулж, тус улсын Санхүүгийн зохицуулах хорооноос мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авахаар ажиллаж байгаа бөгөөд энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэд хэрэглэхэд хялбар, цаг хугацаа хэмнэсэн, албан ёсны эрхтэй, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг авах боломжтой болох юм.



Мони маркет фонд нь 2021 оны 6 дугаар сард дөрвөн хувьцаа эзэмшигчтэйгээр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь сул чөлөөтэй, богино хугацаат эх үүсвэрийг нэгдсэн платформын тусламжтай, харилцан ашигтайгаар банк бус санхүүгийн байгууллагуудын хооронд зуучлах, тэдгээрийг холбох, цаашлаад мөнгөний зах зээлийн хамтын санг олон улсын жишигт нийцүүлэн байгуулах эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.




БУСАД ҮҮСГЭН БАЙГУУЛСАН КОМПАНИУД:

Үнэт цаас гаргагчийн толгой компани нь өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Арт кредит” ХХК, “Сэндли эмплойе” ХХК, “Гялс пропертиз” ХХК, “Даталүүл Монголиа” ХХК, “Хай лоялти” ХХК нарыг үүсгэн байгуулсан байгаа боловч идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

1.3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ

Зураг 5: Бүтэц зохион байгуулалт



УЛААНСАТАР ХОТ
 ӨЛЗНИЙ ЭНД ХО
 РАЛТИЛАЛ ҮНД
 5162855
 9921031195 CTC2420

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК
 ХХК
 РИЙНОС
 INVESTMENT UTUK
 LLC
 УЛААНСАТАР ХОТ
 9019120758 3-6401209

1.3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Б.Наранбат
ТУЗ-ийн дарга
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 15 жил
ажилласан

Туршлага

2021 - одоо Монголын финтек групп
ХК, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх
захирал

2018 - одоо Хай пэймэнт солюшнс
ХХК, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх
захирал

2016 - одоо Гялс төгрөг ХЗХ, Үүсгэн
байгуулагч, Гүйцэтгэх захирал

2015 - 2016 Төрийн банк, Гүйцэтгэх
захирлын орлогч

2014 - 2015 Төрийн банк, Хөрөнгө

зохицуулалтын газрын захирал

2007 - 2013 Сангийн яам: Санхүү

эдийн засгийн бодлогын газар

мэргэжилтэн



Б.Эрдэнэ
ТУЗ-ийн гишүүн
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 15 жил
ажилласан

Туршлага

2018 - одоо Техбокс ХХК, Гүйцэтгэх
захирал

2017 - 2018 Төрийн банк, Актив,
пассивын удирдлагын газрын
захирал

2007 - 2015 Сангийн яам, Эрсдэлийн

удирдлага дотоод аудитын газар

Ахлах мэргэжилтэн



М. Цолмон
ТУЗ-ийн гишүүн
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 10 жил
Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт
5 жил ажилласан

Туршлага

2021 - одоо Монголын финтек групп
ХК, Төлөөлөн удирдах зөвлөлийн
дарга

2017 - одоо Монгол алт ХК,
Гүйцэтгэх захирал

2014 - 2016 Тариалан эрхлэлтийг
дэмжих сан, Гүйцэтгэх захирал

2008 - 2012 Сангийн яам, Санхүү

эдийн засгийн бодлогын газар

мэргэжилтэн



Н.Билгүүн
ТУЗ-ийн гишүүн,
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 9 жил
ажилласан

Туршлага

2022 - одоо Инвестлаб Ви Си ХХК,
Гүйцэтгэх захирал

2020 - 2022 Дэлхийн банкны Төсөв,
санхүүгийн тогтвортой байдлыг
бэхжүүлэх төслийн зөвлөх

2018 - 2020 Селус Номадс ХХК-ийн
ерөнхий менежер

2013 - 2018 Сангийн яам,

Санхүүгийн бодлогын газар

мэргэжилтэн






Л.Нарантуяа
ТУЗ-ийн гишүүн
Хуульч

Туршлага
2022 - одоо Монголын Финтек Групп ХК-ийн Хууль, эрх зүй хариуцсан захирал
2018 - 2022 Монголиан Мючуал Финанс Групп ХХК, Хууль, эрх зүй хариуцсан захирал

Банк санхүүгийн салбарт 15 жил ажилласан



Б.Анужин
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Бизнесийн удирдлага

Туршлага
2021- одоо Central TV, Бизнес хөгжил хариуцсан захирал
2018 - 2021 Австралын худалдааны танхим, Гүйцэтгэх захирал
2015 - 2018 Эрнст энд янг монголиа аудит ХХК, Ахлах аудитор

Банк санхүүгийн салбарт 10 жил ажилласан




Г.Гантуяа
ТУЗ-ийн нарийн бичиг
Эдийн засагч

Туршлага
2021 - одоо Сэндли ББСБ,Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
2020 - 2021 Гялс кредит ББСБ ХХК, Дотоодын данс хариуцсан менежер

Банк санхүүгийн салбарт 10 жил ажилласан





1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГЫН БАГ



Б.Одгэрэл
ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал
Санхүүч Банк санхүүгийн салбарт 16 жил ажилласан

Туршлага
2021 - одоо Сэндли ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал
2016 - 2021 Гялс төгрөг ХЗХ, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал
2013 - 2016 Төрийн банк, Орон нутгийн зээлийн хэлтсийн захирал
2011 - 2013 Хадгаламж банк, Орон нутгийн зээлийн хэлтсийн захирал



Х.Ичинхорлоо
Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал
Нягтлан бодогч Банк санхүүгийн салбарт 18 жил ажилласан

Туршлага
2021 - одоо Сэндли ББСБ ХХК, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал
2016 - 2021 Гялс төгрөг ХЗХ, Ерөнхий нягтлан бодогч
2015 - 2016 Төрийн банк, Харилцааны менежер, мэргэжилтэн
2009 - 2014 Төрийн банк, Салбарын Ерөнхий нягтлан бодогч



П.Болорчулуун
Салбарын удирдлага хариуцсан захирал
Санхүүч Банк санхүүгийн салбарт 18 жил ажилласан

Туршлага
2021 - одоо Сэндли ББСБ ХХК, Салбарын удирдлага хариуцсан захирал
2013 - 2021 Төрийн банк, Тооцооны төвийн захирал
2010 - 2013 Хадгаламж банк, Дотоод аудитын газар, Ахлах аудитор
2004 - 2010 Монголшуудан банк, Эдийн засагч



Д. Баярбат
Эрсдэл хяналт хариуцсан захирал
Санхүүч Банк санхүүгийн салбарт 15 жил ажилласан

Туршлага
2022 - одоо Сэндли ББСБ ХХК, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал
2017 - 2022 Гялс төгрөг ХЗХ, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал
2010 - 2017 Төрийн банк, Хяналт шалгалтын газрын ахлах хянан шалгагч





Сэндли ББСБ ХХК-г үндэсний газрын захирал



И.Түвшинзул
Мэдээлэл технологи хариуцсан захирал
Эдийн засагч

Туршлага
2022 - одоо Сэндли ББСБ ХХК, Мэдээллийн технологи хариуцсан захирал
2017 - 2021 Тээвэр хөгжлийн банк, Иргэдийн банкны газрын захирал

Банк санхүүгийн салбарт 20 жил ажилласан

2011 - 2015 Төрийн банк, Программ ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн



Э. Мөнхдэлгэр
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал
Эдийн засгийн кибернетик

Туршлага
2022 - одоо Сэндли ББСБ ХХК, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал
2016 - 2021 Гялс төгрөг ХЗХ, Ахлах менежер

Банк санхүүгийн салбарт 12 жил ажилласан

2013 - 2016 Төрийн банк, Хүний нөөцийн газар, Сургалт хөгжлийн ахлах мэргэжилтэн



Б. Нямжаргал
Мөнгөн гуйвуулга хариуцсан дэд захирал
Эдийн засагч

Туршлага
2022 - одоо Сэндли ББСБ ХХК, Мөнгөн гуйвуулга хариуцсан захирал
2022 - одоо Монголын ББСБ-уудын холбоо, Мэргэжлийн комплаенсийн хорооны дарга

Банк санхүүгийн салбарт 12 жил ажилласан

2017 - 2018 Дэлхийн банк: Экспортыг дэмжих төсөл : Бизнес хөгжүүлэлтийн ажилтан





1.4.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ


Үнэт цаас гаргагч нь олон улсын мөнгөн гуйвуулга болон зээл, санхүүгийн бусад үйлчилгээ гэсэн хоёр үндсэн чиглэлд үйл ажиллагаа явуулж байна.

“Sendly” Олон улсын мөнгөн гуйвуулга

Үнэт цаас гаргагч нь олон улсын мөнгөн гуйвуулга хийх “Sendly” гар утасны аппликейшнийг 2020 оны 5 дугаар сард зах зээлд амжилттай нэвтрүүлсэн бөгөөд энэхүү аппликейшнээр дамжуулан дэлхийн өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэд мэдээллийн аюулгүй байдал, олон улсын стандартыг хангасан түргэн шуурхай мөнгөн гуйвуулгын үйлчилгээг авах боломжтой болсон юм.


Сэндли ББСБ ХХК нь анх 2020 оны 5 дугаар сард АНУ-аас Монгол улс руу мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлснээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2021 оны 5 дугаар сард Австрали улс, 2021 оны 11 дүгээр сард Япон улсаас мөнгөн гуйвуулга хүлээн авах боломжтой болсон бөгөөд цаашид илүү олон улс оронтой мөнгөн гуйвуулгын үйлчилгээг гар утасны аппликейшнээр дамжуулан, түргэн шуурхай, хямд өртөгөөр хийх боломжийг бүрдүүлж, өөрийн сүлжээнд нэгтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Зураг 6: Тухайн улсад оршин сууж буй Монгол улсын иргэдийн тоо /2021 оны эцсийн байдлаар/



Эх сурвалж: Гадаад харилцааны яам






"Sendly" үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлт

Өнгөрсөн хугацаанд Sendly аппликейшнээр дамжуулан нийт 8.9 сая ам.доллар буюу 25.3 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын гүйлгээг хүлээн авсан байна. Үнэт цаас гаргагч нь 2021 онд 19.6 мянган ширхэг гүйлгээ хүлээн авсан нь арилжааны банкуудын нийт хүлээн авсан 42.4 мянган ширхэг SWIFT гүйлгээний 46.2 хувьтай тэнцэж байна.


2022 оны нэгдүгээр улирлын байдлаар мөнгөн гуйвуулгын тоо болон үнийн дүнг валют тус бүрээр (өссөн дүнгээр) тооцвол:

График 1: Төгрөгийн гуйвуулга




Sendly аппликейшн нь Монгол улсаас АНУ руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2021 оны 03 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2021 оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 800.94 сая төгрөгийн гүйлгээг дамжуулаад байна.

График 2: Ам.долларын гуйвуулга



Sendly аппликейшн нь АНУ-аас Монгол улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2020 оны 05 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2021 оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 6.64 сая ам.долларын гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

График 3: Австрали долларын гуйвуулга



Sendly аппликейшн нь Австрали улсаас Монгол улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2021 оны 03 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2021 оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 648.57 мянган австрали долларын гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

График 4: Япон иенийн гуйвуулга



Sendly аппликейшн нь Япон улсаас Монгол улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2021 оны 11 дүгээр сард анх нэвтрүүлсэн бол 2021 оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 49.1 мянган иений гүйлгээг амжилттай дамжуулаад байна.







График 5- Гүйвуулгын тоо




Sendly аппликейшнийг нэвтрүүлсэнээс хойш 2021 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр нийт 27.1 мянган гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

“Sendly” Америкийн нэгдсэн улсад

Анх 2020 оны 5 дугаар сард АНУ-ын 33 мужаас Монгол улс руу мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсноор Sendly мөнгөн гуйвуулгын үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд Сэндли ББСБ ХХК нь одоогийн байдлаар АНУ-д мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Golden Transfer, Prabhu Money Transfer, Moneytun зэрэг компаниудтай хамтран ажиллаж байна.




“Sendly” үйлчилгээ нэвтэрсэн АНУ-ын 33 муж



Sendly аппликейшнийг Америкийн нэгдсэн улсаас дансаа бүртгүүлэхэд аливаа хүндрэл гаргахгүй байхаар загварчилсан бөгөөд Plaid систем дэмжин ажиллаж байна. Энэхүү систем нь Sendly аппликейшнийг АНУ-д үйл ажиллагаа явуулж буй 5,000 орчим банктэй холбогдож ажиллах боломжоор хангадаг байна.

Plaid: Энэхүү систем нь АНУ-ын арилжааны банкуудын нэгдсэн систем ба системд нэгдсэн дурын банкны аппликейшн руу нэвтрэн гүйлгээ хийх боломжтой, аюулгүй байдлыг бүрэн хангасан найдвартай банкны цогц систем юм. Энэ нь Sendly аппликейшнээр гүйлгээ үүсгэсэн харилцагч өөрийн ашигладаг интернэт банкны аппликейшн руу давхар нэвтрэх шаардлагагүйгээр шууд өөрийн ашигладаг банкны аппликейшнээр дамжуулан мөнгөн гуйвуулга хийх боломжийг бүрдүүлсэн, хялбар, цаг хугацааг хэмнэх боломжтой дэвшилтэт шийдэл болсон юм.





PLAID системээр дамжуулан найдвартай шилжүүлэх боломж



PCI DSS стандарт хангасан төлбөр дамжуулагч




Картын шилжүүлэг хийхэд олон улсын PCI DSS стандартыг хангасан Америкийн Tabaray Inc компанитай хамтран ажилладаг бөгөөд Visa, Mastercard, American Express, Discover, Star, NYCE, Accel cards зэрэг өргөн хэрэглээнд ашиглагддаг бүх картыг дэмждэг байна.

Монгол улсаас АНУ-руу шилжүүлэх мөнгөн гуйвуулга

Sendly мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь 2021 оны 3 дугаар сараас эхлэн Монгол улсаас АНУ руу мөнгөн гуйвуулга хийх шугамыг нээсэн бөгөөд шилжүүлэг хийгдэх хугацаа нь АСН буюу АНУ-ын цахим гүйлгээ, төлбөр тооцооны системээс хамааран 1-3 өдөрт хийгддэг билээ. Шимтгэлийн хувьд хамгийн хямд буюу 1.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгийн 1.25 хувь, 1.0 сая төгрөгөөс доош тогтмол 12,500 төгрөг байдаг буюу нэг удаагийн шилжүүлгээр дээд тал нь 8.0 сая төгрөгийг гуйвуулах боломжтой байдаг юм.


Монгол улсаас 1-3 өдөрт хамгийн хямд



Sendly Австрали улсад

Австрали улсаас шилжүүлэг хийхэд мөнгөн гуйвуулгын програм хангамж нийлүүлэгч Flexwallet болон Австрали, Шинэ Зеланд улсын мөнгөн гуйвуулгын нэгдсэн систем болох POLi Payments зэрэг компаниудаар дамжуулан харилцагчийн шилжүүлгийг найдвартай дамжуулан ажиллаж байна.





POLi төлбөр тооцооны аюулгүй систем



Sendly Япон улсад

Сэндли ББСБ ХХК нь мөнгөн гуйвуулгын City Express компанийн Япон дахь салбартай хамтран ажилладаг бөгөөд 2021 оны 11 дүгээр сараас эхлэн Япон улсаас Монгол улс руу мөнгөн гуйвуулга хийж эхэлсэн билээ. Япон улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг гурван төвшинд олгодог бөгөөд хамтран ажиллагч City Express компани нь 2 дугаар төвшний зөвшөөрөлтэй компани болно.

Japan Post банкны 30,000 гаруй
КИОСК машиныг ашиглан
шилжүүлэг хийх боломжтой



Sendly Европт





Сэндли ББСБ ХХК-ийн Англи улс дахь охин компани болох MonRemit Limited нь 2021 онд Англи улсын Санхүүгийн зохицуулах хороо болох FCA /Financial Conduct Authority/-с Англи болон Европын холбооны орнуудад үйл ажиллагаа

явуулах API /Authorized Payment Institution/ тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд 2022 оны 5 дугаар сард багтаан Европын холбооны орнуудад үйлчилгээгээ нэвтрүүлэхээр ажиллаж байна.

WeChat Pay хамтын ажиллагаа

Сэндли ББСБ ХХК нь өнгөрсөн 2021 онд БНХАУ-ын "WechatPay" үйлчилгээний Монгол Улс дахь албан ёсны түнш байгууллага болсон бөгөөд "WechatPay" төлбөр тооцооны үйлчилгээг нэвтрүүлснээр Монгол улсад суугаа Хятад улсын иргэд төлбөрийн хялбар систем ашиглах, Монгол улсын бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ БНХАУ-д худалдаалан төлбөр тооцоогоо хийх боломжийг бүрдүүлсэн байна.






QR Code
Payment



Web
Payment



In-App
Payment



Mini
Program



Official
Account

Sendly Зээлийн үйлчилгээ

Сэндли ББСБ ХХК нь зээлийн үйл ажиллагааны уламжлалт арга барилыг орчин үеийн технологитой хослуулсан цахим зээлийн үйлчилгээг үзүүлж байгаа билээ. 2021 онд жижиг дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдэд зориулсан богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой зээлийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд энэхүү үйлчилгээ нь зэргэлдээ компани болох "Хай пэймент солюшнс" ХХК-ийн зах зээлд нэвтрүүлсэн "HiPay" болон "HiPay-Merchant" аппликейшнээр дамжин хэрэглэгчдэд хүрч байна.

Sendly цахим зээлийн үйлчилгээ




Хэрэглэгч, харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг хангах зорилгоор сар бүр тэнцүү төлбөр хийх нөхцөлтэй 12 сарын хугацаатай зээлийн шугамын эрх, "HiPay" аппликейшн дахь бүтээгдэхүүн үйлчилгээний төлбөрийг төлөх боломжтой "E-zeel" үйлчилгээ, даатгалын зээл зэрэг Sendly цахим зээлийн үйлчилгээг "HiPay" болон "HiPay-Merchant" аппликейшнээр дамжуулан гар утаснаасаа авах боломжийг нэвтрүүлээд байна. Үүнээс гадна уламжлалт аргаар авсан орон сууцны

зээл, лизинг, хөрөнгө барьцаалсан зээл гэх мэт бусад төрлийн зээлүүдийнхээ үлдэгдлийг хянах, эргэн төлөлтөө хийх зэрэг зээл олголтоос бусад үйлчилгээг "HiPay" болон "HiPay-Merchant" аппликейшний "Sendly зээл" дэд цэсээр дамжуулан авах боломжтой юм.





Сэндлэ 2022-07-26 өдөр танилцуулга



Sendly Мерчант зээлийн үйлчилгээ

Жижиг дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдэд зориулсан богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой мерчант зээлийн үйлчилгээний хэрэглэгч болсноор тухайн бизнес эрхлэгчдэд 1.0 сая төгрөг хүртэлх зээлийн шугам нээгдэхээс гадна тухайн бизнес эрхлэгчдэд нэмэлт үнэлгээ, судалгаа хийгдсэнээр 10.0 сая хүртэлх төгрөгийн зээлийг 12 сарын хугацаанд шугамаар авч ашиглах боломжтой эрх олгох, хялбар, шуурхай давуу талыг бий болгосон үйлчилгээ юм. Мөн энэхүү аппликейшнээр дамжуулан дараах нэмэлт үйлчилгээг авах боломжийг хэрэглэгч, харилцагчиддаа үзүүлж байна.

Санхүүгээ хянах боломж

Өдөр тутмын орлогоо хянах, бизнесээс удирдах



Автомат төлөлт
Нірау Аппликейшнд картаа холбосон бол зээл төлөхдөө үйлдэл хийх шаардлагагүй

Цахим зээлийн үйлчилгээ

Эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх шуурхай



QR төлбөр
Шуурхай төлбөр тооцоо


И-баримт

Мерчант нь үйлчлүүлэгчдээ НӨАТ-ын баримт олгох

Мерчантын зээлийн онцлог

- Боломжит эрхийн хэмжээнд хүссэн үедээ зээл авах
- Зээл авах бүрт төлбөрийн хуваарь 30 хоногийн хугацаанд өдөр бүр төлөх нөхцөлтэйгээр шинэчлэгдэх
- Өдөр бүр бага дүнгээр төлбөр хийх нь харилцагчийг санхүүгийн ачаалалд өртөхгүй байхаас хамгаалах
- Зээл төлөлтийн гүйлгээг Нірау аппликейшнд холбосон картнаас автоматаар төлүүлэх
- Харилцагч аппликейшн ашиглан цахим хэтэвч, эсвэл арилжааны банк дах картан данснаасаа зээлээ шууд төлөх
- Зээлээ хугацаандаа төлбөл хүү тооцохгүй зэрэг онцлог давуу талтай

Зээлийн үйлчилгээний уламжлалт аргачлалыг технологитой хослуулснаар хэрэглэгчид илүү хялбар, хямд өртөгтэй, цаг хугацаа, зардал хэмнэсэн үйлчилгээг авах боломжтой болж байна.



Сэндли ББСБ ХХК нь Монгол орны өнцөг булан бүрт суугаа харилцагчиддаа илүү ойр хүрч ажиллах зорилгоор Улаанбаатар хотод 6, орон нутагт 48, нийт 54 салбар нэгжээр үйл ажиллагаагаа явуулж байна. Зээлийн эрх олгох судалгааг салбар нэгжээрээ дамжуулан хэрэгжүүлж байгаа нь зээлийн эрсдэлийг бууруулах гол хүчин зүйлийн нэг болж байна.

Зураг 7: Сэндли ББСБ ХХК салбар нэгжийн байршил



Зээлийн үлдэгдлийн мэдээлэл

Хүснэгт 3: 2021.12.31-ний өдрийн байдлаарх зээлийн багц /бүтээгдэхүүний төрлөөр/

№	Төрөл	Бүтээгдэхүүн	Тоо	Үлдэгдэл /сая төгрөг/	Дундаж зээл /сая төгрөг/	Эзлэх хувь	
1	Уламжлалт	Зээлийн шугам	17	171.31	10.08	1.99%	
		ҮХХ барьцаалсан зээл	8	38.09	4.76	0.44%	
		Лизингийн зээл	61	42.45	0.70	0.49%	14.8%
		Автомашин барьцаалсан зээл	7	35.63	5.09	0.41%	
		Цалингийн зээл	850	988.04	1.16	11.48%	
2	Цахим	Мерчант зээл	3,906	7,319.65	1.87	85.03%	85%
		Даатгал	251	13.05	0.05	0.15%	
		Дүн	5,100.00	8,608.22	1.69	100.00%	100%



3





График 6: 2021.12.31-ний өдрийн байдлаарх зээлийн багц бүтээгдэхүүний төрөл




2021 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын 85.2 хувь цахим, 14.8 хувийг уламжлалт хэлбэрээр олгосон зээл эзэлж байна. Цахимаар олгосон зээлийн багцын 85 хувийг мерчантын зээлийн багц эзлэж байна.

Нийт зээлийн үйл ажиллагаа


Сэндли ББСБ ХХК нь 2021 оны 4-р сараас эхлэн зээлийн үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд харилцагчдын тоо улирал тутамд тасралтгүй нэмэгдсээр 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 5,100 харилцагчтай болсон ба эдгээр харилцагчдийн 3,966 нь зээлийн үйлчилгээг ашиглаж байна.

График 7: Нийт харилцагч | Нийт зээлдэгч






Сэндли ББСБ ХХК-ийн Үнэт цаасны танилцуулга




Сэндли ББСБ ХХК-ийн нийт зээлийн багцын хэмжээ мерчант зээлийн үйл ажиллагаа эхлүүлсэн 2021 оны 4-р сараас 6.7 дахин нэмэгдэж жилийн эцсийн байдлаар 8.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Зээлийн үлдэгдлийг олгосон хэлбэрээр нь хуваан авч үзвэл цахимаар олгосон зээл 85 орчим хувийг эзэлж байгаа бол уламжлалт буюу салбар нэгжээр дамжин олгогдсон зээлийн хэмжээ 15 орчим хувийг эзэлж байна.

График 8: Нийт зээлийн үлдэгдэл (сая.төг)



Үнэт цаас гаргагчийн нийт олгосон зээлийн 98.6 хувь хэвийн ангилалтай бол хугацаа хэтэрсэн зээлийн төвшин маш бага хэмжээнд буюу 1.2 хувьтай, чанаргүй зээлийн хэмжээ ердөө 0.1 хувь байна. ББСБ-ын салбарын дундаж хэвийн зээл 90.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 2.5 хувь, чанаргүй зээлийн хэмжээ 7.0 хувь байгаатай харьцуулахад Сэндли ББСБ ХХК-ийн зээлийн чанар сайн үзүүлэлттэй байна.

График 9: Зээлийн багцын чанар





1.4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Үнэт цаас гаргагч компанийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд нь нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхлэх, эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд, иргэдийн боловсролд тогтмол анхаарч, дэмжихэд чиглэсэн байдаг.

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа



ширхэг мод тарихаар батламжилсан.


Сэндли ББСБ нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилт, газрын доройтолтой тэмцэх, ой мод, ойн санг нэмэгдүүлэх, усны эх үүсвэр, нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилтыг дэмжин “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд хамт олны санаачлагаар нэгдэж 2030 он хүртэл 1,500,000

Хорт хавдрын эсрэг аян



Нийгмийн хариуцлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь зээлийн хүүгийн орлогын 1.0 хувийг хавдрын эсрэг сайн үйлсийн аян болон хавдрын эсрэг эмч мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэхэд зориулдаг. Энэ хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал, Эрүүл хүнс, хавдаргүй иргэн ТББ, “Элэг нэгт монголчууд” ТББ-н тэргүүн Ж.Чинбүрэнтэй хамтран ажиллаж байна. Эрүүл хүнс, Хавдаргүй иргэн төрийн бус байгууллагаар дамжуулан “Монгол улсад амьд донороос элэг шилжүүлэн суулгах төсөл”-д нийт 124.8 сая төгрөг хандивлаж, 9 хүний алтан амийг аврах үйлсэд хувь нэмэр оруулжээ. Мөн түүнчлэн Хавдар судлалын үндэсний төвийн 49 эмч, ажиллагсдыг гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахад зардлыг бүрэн хариуцсан байна.





Монголын Аутизмын холбооны хамтын ажиллагаа



Үнэт цаас гаргагч нь 2021 оны 6 дугаар сард Монголын аутизмын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд 2021 онд мөнгөн гуйвуулгын шимтгэл бүрт 1000 төгрөг, 2022 онд мөнгөн гуйвуулгын гүйлгээний шимтгэлийн орлогын 2 хувийг уг холбоонд хандивлаж олон нийтэд аутизмыг таниулах, ойлгуулах, боловсролын хүртээмж, сургалт мэдээлэл, зөвлөгөө өгөх чиглэлд дэмжин ажилласан байна.

Шагнал урамшуулал



Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооны 2020 оны "Шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй ББСБ" болж "Алтан од" цомыг хүртсэн юм.



2021 оны 12 дугаар сард "Global Banking & Finance Review" сэтгүүлээс жил бүр тодруулдаг "Fastest Growing FinTech Company In Central Asia 2021" буюу "Төв Азийн хамгийн хурдацтай хөгжиж буй Финтек компани 2021" шагналыг "Sendly" олон улсын мөнгөн гуйвуулгын аппликейшн хүртсэн юм.



2021 оны 12 дугаар сард Монгол Улсын хөгжилд бодит хувь нэмэр оруулж, бизнесийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн шилдгүүдийг тодруулдаг "Bloomberg TV Mongolia Awards"-с High Payment Solutions маань амжилттай оролцож "Best Solution Of The Year" шагналын эзэн болсон



2021 оны 12 дугаар сард "Forbes Mongolia Finance Awards 2021"-ийн "Шилдэг мөнгөн гуйвуулгын аппликейшн" шагналыг хүртсэн.





1.5.1 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ

“Шонхор үнэлгээ аудит” ХХК нь “Сэндли ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн тайланд аудит хийж дараах дүгнэлтийг гаргасан байна.

“Сэндли ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, санхүүгийн байдлын тайлан, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр “Сэндли ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.” хэмээн дүгнэсэн байна.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Аудитын компаниас гаргасан “Аудитын дүгнэлт”-ээс уншиж танилцана уу.


*Мөн “Шонхор үнэлгээ аудит” ХХК нь “Сэндли ББСБ” ХХК-ийн “Гэгээн алтан од ББСБ” ХХК-тай нэгтгэсний дараах буюу 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд аудит хийж, дүгнэлтийг гаргасан байна. Дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлан нь 2022 оны 6 сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.” гэж дүгнэжээ.



Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Аудитын компаниас гаргасан “Аудитын дүгнэлт”-ээс уншиж танилцана уу.

1.5.2 СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Хүснэгт 4: Санхүү байдлын тайлан

Мянган төгрөг	2019	2020	2021	2022-II*
Хөрөнгө				
Эргэлтийн хөрөнгө	1,403,679.4	1,809,207.9	10,395,000.9	22,280,194.4
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	33,467.2	925,009.1	1,169,363.3	1,369,502.5
Зээл	1,017,134.0	663,053.4	8,600,430.5	15,311,622.0
Дансны авлага	353,078.1	221,145.3	505,485.4	4,942,270.7
Бусад эргэлтийн хөрөнгө	77,549.2	3,701.2	119,721.7	656,799.1
Эргэлтийн бус хөрөнгө	447,049.6	80,229.4	209,634.6	324,812.6
Үндсэн хөрөнгө (цэвэр)	25,213.3	16,678.4	168,744.6	233,419.1
Биет бус хөрөнгө (цэвэр)	344,287.0	59,849.7	40,890.0	91,396.5
Нийт хөрөнгийн дүн	1,850,729.0	1,889,437.3	10,604,635.5	22,605,007.1
Өр төлбөр ба эздийн өмч				
Өр төлбөр	467,415.4	321,838.5	3,457,430.7	11,656,746.1





Богино хугацаат өр төлбөр	467,415.4	321,838.5	3,457,430.8	11,656,746.1
Урт хугацаат өр төлбөр				
Эздийн өмч	1,383,313.5	1,567,598.8	7,147,204.7	10,948,261.0
Дүрмийн сан	1,428,500.0	1,428,500.0	6,428,500.0	7,828,500.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(45,186.4)	139,098.8	718,704.7	3,103,977.4
Нийт өр төлбөр болон эздийн өмч	1,850,729.0	1,889,437.3	10,604,635.5	22,605,007.1

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2021 оны жилийн эцсийн байдлаар 10.6 тэрбум, эздийн өмч 7.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хөрөнгө, эздийн өмч ийнхүү өссөн шалтгаан нь мерчант зээлийн үйлчилгээг идэвхжүүлэх зорилгоор толгой компанийн зүгээс дүрмийн санг 5.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ.




Өр төлбөрийн хувьд: 2021 оны байдлаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй нийт Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгөд эзлэх өр төлбөрийн хэмжээ 33.6 хувь байсан байна. Үнэт цаас гаргагчийн хувьд энэ үзүүлэлт нь салбарын дундажтай ойролцоо буюу 32.6 хувийг эзэлж байгаа нь өр төлбөрийн дарамт багатай, сайн үзүүлэлт юм.


Сэндли ББСБ
Өр төлбөр | эздийн өмч



Хүснэгт 5: Орлого үр дүнгийн тайлан

Мянган төгрөг	2019	2020	2021	2022-II*
Хүүгийн орлого	119,561.9	444,601.4	558,315.5	1,714,152.0
Хүүгийн зардал	-	-	1,436.6	130,383.1
Цэвэр хүүгийн орлого	119,561.9	444,601.4	556,878.9	1,583,768.8
Хүүгийн бус орлого	601.3	328,990.1	1,808,592.2	3,324,784.3
Хүүгийн бус зардал	346,457.0	537,272.8	1,706,887.7	2,419,519.1
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(226,293.7)	236,318.7	658,583.4	2,265,222.3
Болзошгүй эрсдэлийн зардал	-	-	7,793.0	223,811.7
Ердийн үйл ажиллагааны ашиг(алдагдал)	(230,336.8)	205,513.1	650,790.4	2,240,992.8
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	-	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4,043.0	30,805.6	30,346.3	24,229.4
Татварын өмнөх ашиг (алдагдал)	(230,336.8)	205,513.0	620,444.1	2,240,992.8





Орлогын татварын зардал	-	-	45,236.2	24,645.8
Цэвэр ашиг (алдагдал)	(230,336.8)	205,513.1	575,207.9	2,216,347.0

Тайлант хугацаанд Сэндли ББСБ ХХК нь 575.2 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оноос 179.8 хувь буюу 369.7 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтийн 90.0 хувийг мерчант зээлийн үйлчилгээ нэвтэрснээс үүссэн ашиг тайлбарлаж байгаа бол үлдсэн 10.0 хувь нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс орсон орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүүгийн орлого:

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт олгосон уламжлалт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 86.0 хувь өсөж 1.3 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнийг дагаад зээлээс олох хүүгийн орлогын хэмжээ өсөж 558.3 саяд хүрчээ.

Хүүгийн зардал:

2021 онд нийт 1.4 сая төгрөгийн хүүгийн зардал гарсан бөгөөд, энэ нь банкнаас авсан зээлийн хүүд зориулагджээ.

Хүүгийн бус орлого:

Тайлант хугацаанд Сэндли ББСБ-ын хүүгийн бус орлого өмнөх оноос 5.4 дахин өсөж нийт 1.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү өсөлтийг мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн, Мерчант зээлийн үйлчилгээний шимтгэл хураамж өндөр зэрэг шалтгаанууд тайлбарлаж байна.

Хүүгийн бус зардал:

Хүүгийн бус зардалд боловсон хүчний зардал болон бусад компанийн үндсэн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардлууд багтсан бөгөөд энэхүү зардал өнгөрсөн оноос 3.1 дахин нэмэгдэж 1.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хүүгийн бус зардлын 24.8 хувь буюу 423.9 сая төгрөгийг боловсон хүчний холбогдолтой зардал, 65.4 хувийг үйл ажиллагааны бусад зардал, 9.8 хувийг гадаад валюттай холбоотой зардал эзэлж байна. Тайлант хугацаанд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлсэнтэй холбоотой зардлууд гарсан нь зардлын өсөлтөд нөлөөлсөн байна.

Орлогын албан татвар:

Сэндли ББСБ нь 2021 онд 620.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан бөгөөд үүнээс 45.2 сая төгрөгийн орлогын албан татвар төлсөн байна.





Монгол Улсын ХХК - Үнэт цаасны танилцуулга
СЭХ
 о.2077 с/б: 10 дөр
СЭХ
 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ АЖ АХУЙН
 МОНГОЛЫН УСТ
 2022-33-03

Хүснэгт 6: Мөнгөн урсгалын тайлан


Мөнгөн төгрөг	2019	2020	2021	2022-II*
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(226,523.8)	254,384.0	274,700.5	224,368.7
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	120,163.2	773,369.5	2,199,391.7	5,038,935.7
Зээлийн хүүгийн орлого	119,480.4	444,574.9	558,315.6	1,714,152.0
Харилцах дансны хүүгийн орлого	81.5	26.6	0.0	0.0
Гадаад валютын арилжааны орлого	0.0	285.9	59,386.2	76,198.7
Гадаад валютын ханшийн зөрүү	339.4	0.0	84,040.9	417,098.1
Мөнгөн гуйвуулгын орлого	0.0	80,149.2	260,027.5	138,404.4
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	261.9	0.0	1,237,621.5	2,693,082.6
Бусад үйлчилгээний орлого	0.0	248,332.9	0.0	0.0
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	346,687.0	518,985.5	1,924,691.2	4,814,567.0
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	0.0	0.0	0.0	130,383.1
Үндсэн ба нэмэгдэл цалин	118,372.4	112,184.0	380,426.1	550,250.7
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	0.0	375.0	0.0	1,411.8
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	11,636.5	5,722.7	43,510.2	68,937.8
Албан томилолт, сургалтын зардал	3,757.2	978.0	8,545.1	32,460.0
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	7,125.0	0.0	131,949.2	102,299.5
Цатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	18,298.9	4,249.5	47,544.4	66,749.1
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	1,933.4	1,197.8	14,416.2	21,169.9
Татвар, даатгалын төлсөн мөнгө	0.0	1,000.0	0.0	357.0
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	790.0	10,949.4	176,223.2	150,220.4
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	2,041.4	9,851.0	274.5	100.0
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	0.0	0.0	27,825.5	255,203.7
Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарах мөнгө	0.0	9,000.0	0.0	0.0
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	150,096.6	256,341.0	275,647.4	46,160.7
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	1,980.0	2,320.0	0.0	4,100.0
Хувьцаа болон үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	30,655.6	0.0	0.0	0.0
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	0.0	104,817.2	818,329.4	3,388,863.2
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	253,986.4	637,157.9	-30,346.30	(24,229.5)
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	258,029.4	667,963.5	0.0	0.0
Бусад	258,029.4	667,963.5	0.0	0.0
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	4,043.0	30,805.6	30,346.3	24,229.5

УЛААНБААТАР ХОТ
 ӨЛӨНГӨ ЗИЛ
 2022.08.15
 CTC2420

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ АЖ АХУЙН
 МОНГОЛЫН УСТ
 2022-33-03



Сандги ББСБ ХХК - Үнэт цаасны танилцуулга



аяар, еслол, зочин төлөөлөгчийн зардал	1 582.1	305.6	19,803.0	15,309.2
Оргуулийн зардал	2 460.9	30,500.0	0.0	0.0
	0.0	0.0	10,543.3	8,920.3
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,462.6	891,541.9	244,354.2	200,139.3
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	6,004.6	33,467.2	925,009.1	1,169,363.3
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	33,467.2	925,009.1	1,169,363.3	1,369,502.6

МӨНГӨН ХӨРӨНГИЙН БИРМ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2022-08-05

БҮРТГЭСЭГ

1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Хуулийн дүгнэлтийн хэсгээс:

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:

Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 14 хэлцэл хийсэн бөгөөд тус гэрээнүүдээс 13 хэлцэл дүгнэлт гаргах өдрийн байдлаар бүгд хэвийн хэрэгжиж байгаа ба ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна.

Их хэмжээний хэлцлийн талаар:

Компанийн их хэмжээний хэлцлийн хувьд нийт 2 хэлцэл одоогоор хэрэгжиж байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гараагүй болно.


Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний талаар:

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 6 гэрээ байгуулсан. Тэдгээрээс их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг оруулан нийт 6 гэрээ тус тус хэвийн хэрэгжиж байна.

1.7 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 07 тоот тогтоолоор “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг баталсан байна. Тус эрх зүйн баримт бичигт эрсдэлийн удирдлагын тодорхойлолт, ангилал, төрөл, зарчим, хэмжих нэгж, үзүүлэлт, хүлээн зөвшөөрөх хязгаар, хяналт тавих асуудлыг тусган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх журам” болон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 06 тоот тогтоолоор, “Дотоод хяналтын үйл ажиллагааны журам”-ыг



Гүйцэтгэх захирлын 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалаар шинэчлэн баталсан байна.

Дотоод хяналт шалгалтыг газар дээрх болон зайны гэсэн хэлбэрээр зээл, нягтлан бодох бүртгэл, салбарын үйл ажиллагаа, мэдээлэл технологи, комплаенс, бусад гэсэн хүрээнд гүйцэтгэж байна.

Сэндли ББСБ нь Covid 19 цар тахалын тархалт, дэгдэлтийн хугацаанд зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаанд болон ББСБ-д учирч болох эрсдэлийг тооцон түүний сөрөг нөлөөг бууруулах, зайлсхийх эрсдэлийн удирдлагын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Байгууллагын дотоод сүлжээ, серверт зайнаас хандаж онлайн горимоор ажиллах боломжийг fortclient программ ашиглан орон нутгийн бүх салбар, нэгжийн хүрээнд бүрдүүлсэн.
- Гамшигаас хамгаалах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан бүх нэгжид мөрдүүлсэн.
- 2021 онд нийт 295 мерчант зээлийн нэмэгдүүлсэн хүүг тэглэсэн.
- Цар тахалын нөлөө, барааны хомсдол, тээврийн үнийн өсөлт зэргээс шалтгаалан зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа доголдсон, зээлийн гэрээний хугацаа сунгах хүсэлт гаргасан 74 зээлдэгчийн 210 сая төгрөгийн зээлийн гэрээний бүтэцэд өөрчлөлт оруулсан.

Сэндли ББСБ-ын зээлийн эрсдэлийн бодлогын хүрээнд нэг зээлдэгчид олгох зээлийн дээд дүнг бага байлгах, төвлөрлийн эрсдэлийг боломжит доод түвшинд барих бөгөөд 2021 оны эцсийн байдлаар нэг зээлдэгчид ногдох зээлийн дүн 2.15 сая төгрөг байна.

Чанаргүй зээлийн эзлэх хувь 2021 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын 0.1 хувийг эзэлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2019 оноос хойш бүрэн хангаж ажиллажээ.



Хүснэгт 7: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	2019	2020	2021
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, Эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	69.40%	72.80%	70.60%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-аас доошгүй	69.40%	72.80%	70.60%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-аас доошгүй	74.50%	82.30%	67.40%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас дээш	8%	277%	34.00%





Сэндли ББСБ ХХК-ийн үнэт цаасны танилцуулга



Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа

30%-аас хэтрэхгүй 19.80% 17.40% 4.20%

ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ Гүйцэтгэх Захирал ажилтан, Холбогдох нэг Этгээдэд олгосон зээл, адилтан тооцох актив, бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа

10%-аас хэтрэхгүй 2.50% 0.00% 0.00%

Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

(+/-40%) 2.20% 54.20% 4.70%

Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгээс:

Эрсдэлийн удирдлагын тодорхойлолт:

Эрсдэлийг тодорхойлох, ангилах, шинжлэх, үнэлэх, хязгаарлах, арга хэмжээ авах, хянах цогц үйл ажиллагааг хэлнэ.

Эрсдэлийн ангилал:

"Сэндли ББСБ" ХХК-ийн үйл ажиллагаанд учирч болох үндсэн эрсдэлүүдийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас хохирол хүлээх эрсдэлийг

Үйл ажиллагааны эрсдэл:

Ажилтны санаатай, санамсаргүй үйлдэл, дотоод үйл ажиллагааны доголдол, алдаатай эсхүл дутуу зохицуулсан үйл явц, журам, заавар, мөн автоматжуулсан систем, гадаад хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас хохирол хүлээх эрсдэлийг

Хөрвөх чадварын эрсдэл:

Компанийн өөрийн хөрөнгө хүрэлцээтэй боловч бусад хүчин зүйлийн нөлөөллөөр аливаа гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, эсхүл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нөхцөл байдал үүсэх эрсдэлийг хэлнэ.

Нэр хүндийн эрсдэл:

Компанийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээлэл олон нийтэд тархсаны улмаас одоо болон ирээдүйд орлого буурах, тооцоолоогүй зардал гарах зэрэг эрсдэлийг хэлнэ.





Бизнесийн буруу шийдвэр, алдаатай бизнес төлөвлөгөө, оновчгүй бизнесийн стратегийг биелүүлэх, макро эдийн засгийн өөрчлөлтөд цаг тухайд нь хариу үйлдэл үзүүлээгүйгээс үүсэх эрсдэлүүдийг хэлнэ.

Комплаенсийн эрсдэл:

Хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдөж ажиллаагүйн улмаас тухайн байгууллага хуулийн хариуцлага, эрх бүхий байгууллагын торгууль, шийтгэл хүлээх, санхүүгийн бодит алдагдалд орох, нэр хүндийн эрсдэл хүлээхийг хэлнэ.

Эрсдэлийн удирдлагын зарчим:

“Сэндли ББСБ” ХХК нь Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтлан ажилладаг. Үүнд:

Хараат бусаар үнэлгээ хийх:

Эрсдэлийн удирдлагыг хариуцсан эрх бүхий албан тушаалтан компанийн бусад газар, нэгжээс хараат бус ажиллаж, компанийн эрсдэлийг бодитой, бие даасан байдлаар тодорхойлон үнэлнэ

Тайлагнадаг байх:

Бүх төрлийн эрсдэлийн тайланг тогтоосон хэлбэр, загварын дагуу тогтмол давтамжтай болон тухай бүр, шуурхай гаргаж, удирдлагад тайлагнана.

Тогтмол сайжруулан шинэчилж байх:


Компанийн эрсдэлийн удирдлагатай холбоотой эрх зүйн баримт бичгийг эргэн хянаж сайжруулах арга хэмжээг тогтмол авна.

Хэмжигдэхүйц байх

Эрсдэлийг хэмжихдээ тоон болон чанарын шинжилгээний аргыг ашиглах бөгөөд эрсдэл хэмжигдэхүйц байвал удирдах боломжтой гэсэн зарчимд үндэслэн тоон шинжилгээг суурь арга болгоно.

Баримтжуулалт хийх

Эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, хязгаар тогтоох, хяналт тавих, тайлагнах зэрэг эрсдэлийн удирдлагын бүх үйл ажиллагаа, түүнтэй холбогдох шийдвэрийг баримтжуулж, баталгаажуулсан байна



Компанид эрсдэл учруулж болзошгүй шийдвэр гаргах эрх мэдлийг нэг албан тушаалтанд төвлөрүүлэхээс зайлсхийж, дөрвөн нүдний зарчмыг баримтална

Эдийн засгийн үр ашигтай байх

Эрсдэлийг удирдах үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь аливаа хохирлыг бууруулахад чиглэсэн байх бөгөөд гарах зардал нь эрсдэлээс үүсэх хохирлоос бага байхад чиглэнэ.

Эрсдэлийн удирдлага нь компанийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтын нэг хэсэг байх

Компанийн удирдлага, холбогдох эрх бүхий албан тушаалтнууд шийдвэр гаргахдаа эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтны бэлтгэсэн тайлан мэдээ, судалгаа шинжилгээтэй танилцаж, харгалзан үзнэ.

Эрсдэлийн удирдлагын процесс:



Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлт


Эрсдэлийн удирдлагыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), Дотоод хяналт шалгалтын чиг үүрэг хариуцсан албан тушаалтан, Гүйцэтгэх удирдлага болон компанийн бусад ажилтнууд дараах байдлаар хэрэгжүүлнэ.


Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, зарчмыг тодорхойлно

Дотоод хяналт шалгалтын чиг үүргийг хариуцсан албан тушаалтан

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилт, компанийн засаглал болон бүтэц зохион байгуулалтын бодлогын хэрэгжилт, компанийн засаглал болон бүтэц зохион байгуулалтын уялдаа холбоо, үр дүнтэй байдал, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж буй бодлого, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, ТУЗ-д тайлагнаж ажиллана.





ГУЗ-ийн тодорхойлсон эрсдэлийн удирдлагын стратеги, зарчмыг компанийн үйл ажиллагаанд мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна

Бусад ажилтнууд


Эрсдэлийг илрүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа эрсдэлийг зохистой төвшинд удирдах үүрэгтэй

Эрсдэлийн удирдлагын бодлого

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

1. Компани нь зах зээлийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, зохистой удирдах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хянах замаар удирдлагын үр ашигтай системийг тусгаж хэрэгжүүлнэ.
2. Компанийн зах зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь зах зээлийн таагүй нөхцөл байдлын улмаас үүсэх хохирлыг хамгийн бага төвшинд барьж ажиллахад оршино.
3. Зах зээлийн эрсдэлийн удирдлагын зарчим
 - 3.1. Зах зээлийг байнга ажиглаж өөрчлөлтийг тухай бүр мэдэрч байх
 - 3.2. Газар, хэлтэс, алба нь уялдаа холбоотой ажиллаж зах зээлийн эрсдэлийн талаарх мэдээллийг тасралтгүй солилцдог байх
 - 3.3. Зах зээлийг бодитоор илэрхийлэх мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийдэг байх
 - 3.4. Зах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийг хянаж, удирдлагыг тогтмол мэдээллээр хангаж тайлагнадаг байх
 - 3.5. Тогтоосон хязгаарт эрсдэлийг хамгийн бага төвшинд барьж ажиллахыг эрмэлздэг байх
 - 3.6. Эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлдэг байх
 - 3.7. Эрсдэлийн үнэлгээний аргачлал болон дүгнэлтэд эргэн хяналт хийж сайжруулдаг байх
4. Зах зээлийн эрсдэлийн удирдлагын үе шат
 - 4.1. Зах зээлийн эрсдэлийг тодорхойлохдоо дараах байдлаар тодорхойлно
 - 4.1.1. Зах зээлийн өнгөрсөн цаг хугацааны шинж чанар давтамжийг тодорхойлох
 - 4.1.2. Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн хандлагыг ажиглах, таамаглах





4.1.3. Зах зээлд гарсан өөрчлөлт бүрийг тухай бүр мэдэрч түүнээс үүдэх эрсдэлийг тодорхойлох

5. Зах зээлийн эрсдэлийг дараах байдлаар үнэлнэ:
 - 5.1. Зах зээлийн бодит мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийнэ
 - 5.2. Эрсдэлийг тооцоолох загварын илэрхийлэх чадварыг бодит мэдээлэлтэй харьцуулах замаар буцаан шалгалт хийнэ.
 - 5.3. Эрсдэлийн төвшин зөвшөөрсөн хязгаараас давсан тохиолдолд залруулах арга хэмжээг шуурхай авна.
 - 5.4. Зах зээлийн эрсдэлийн хяналт, тайлагнал
 - 5.4.1. Зах зээлийн өөрчлөлтийг байнга хянаж, зах зээлийн өөрчлөлтөөс үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг тооцоолж удирдлагуудад тухай бүр тайлагнана
 - 5.4.2. Зөвшөөрсөн эрсдэлийн хязгаарт хяналтыг байнга тавьж, боловсруулсан холбогдох тайланг эрх бүхий албан тушаалтанд тогтмол танилцуулна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

1. Компани нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг зохицуулах журамтай байх бөгөөд уг журамд үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, зохистой удирдах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хянах замаар удирдлагын үр ашигтай системийг бүрдүүлж хэрэгжүүлнэ.
2. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын зорилго нь тухайн эрсдэлийг үүсэхээс урьдчилан сэргийлэх, учирсан эрсдэлийн хохирлыг хамгийн бага төвшинд оновчтой удирдахад оршино.
3. Үйл ажиллагааны эрсдэлийг үүсгэгч шалтгаанаар нь дараах байдлаар ангилж болно.
 - 3.1. Хүний хүчин зүйл- Компанид хохирол учруулахаар ажилтны санаатай, санамсаргүй үйлдэл
 - 3.2. Процесс- Дотоод үйл ажиллагааны доголдол, алдаатай эсхүл дутуу зохицуулсан үйл явц, журам зааврын зөрчилтэй байдал
 - 3.3. Автоматжуулсан систем- мэдээллийн технологийн систем, програм хангамж, үйл ажиллагааг автоматжуулсан систем зэргийн доголдол





2022-07-26

9-03

3.4. Гадаад хүчин зүйл - Байгалийн гамшиг, улс төрийн сөрөг нөлөө, улс орны санхүүгийн сул бодлого, залилан

4. Компани нь оновчтой үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд дараах зарчмуудыг баримтална.

4.1. Компанийн бүх шатны албан тушаалтнууд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагатай холбоотой өөр өөрсдийн үүрэг хариуцлагыг ойлгож мэдсэн байна.

4.2. Ажилтан бүр өөрийн үйл ажиллагаанд хяналт тавих

4.3. Ажилтан бүр компанид учирсан томоохон хэмжээний, аюултай, нэр хүндэд муугаар нөлөөлөхүйц, хууль бус тохиолдлуудыг нэн даруй шууд удирдлагад мэдэгдэж байх

4.4. Компани нь бүхий л үйлчилгээ, үйл ажиллагаа болон системд оршиж байгаа эрсдэлийг тодорхойлох

4.5. Эрсдэлийг цаг алдалгүй илрүүлэх, бүртгэх, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авах

4.6. Газар, хэлтэс, албууд уялдаа холбоотой ажиллаж, үйл ажиллагааны эрсдэлийн талаарх мэдээллийн тасралтгүй урсгалыг бий болгох

4.7. Үйл ажиллагааны эрсдэлийн төвшинг байнга хянаж, удирдлагыг тогтмол мэдээллээр хангадаг байх

4.8. Эрсдэлийн суурь шалтгааныг тодорхойлж арга хэмжээ авах

5. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын үе шат

5.1. Үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлохдоо дараах арга замуудыг ашиглана.

5.2. Компанийн үйл ажиллагааны эрсдэлийн дотоод болон гадаад мэдээллийг хамруулсан эрсдэлийн мэдээлэлд шинжилгээ хийн эрсдэлийг тодорхойлох

5.3. Компанийн газар, хэлтэс, албаны үйл ажиллагаа, үйлчилгээнд шинжилгээ хийж эрсдэлийг тодорхойлох


5.4. Цаг үеийн нөхцөл байдалд шинжилгээ хийн эрсдэлийг тодорхойлох

5.5. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд шинжилгээ хийх


6. Үйл ажиллагааны эрсдэлийг компанийн явуулж буй үйл ажиллагаа, үйлчилгээ, түүнийг зохицуулсан бодлого болон журам, ажлын уялдаа холбоо, ажилтны ёс зүй болон ур чадвар, ажиллах орчин нөхцөл, техник болон програм хангамж зэргийг хамруулан тодорхойлно

7. Үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэхдээ доорх арга, хэрэгслүүдийг ашиглана





- 7.1. Үйл ажиллагааны эрсдэлийг илэрхийлэх түлхүүр үзүүлэлтийг тодорхойлж үнэлэх
- 7.2. Газар, хэлтэс, албаны үйл ажиллагаа, үйлчилгээнд эрсдэл ба хяналтын үнэлгээ хийх
- 7.3. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар эрсдэлийн хохирлын хязгаарыг тогтоох, аргачлалыг сайжруулах
- 7.4. Бусад судалгаа шинжилгээнд тулгуурласан эрсдэлийн үнэлгээний арга
8. Үйл ажиллагааны эрсдэлийг удирдахдаа доорх арга хэмжээнээс оновчтойг сонгон хэрэгжүүлнэ
 - 8.1. Үйл ажиллагааны эрсдэл үүсэж болзошгүй гараар хийдэг үйлдлүүдийг аль болох автоматжуулах
 - 8.2. Тухайн эрсдэлийн онцлогоос хамааран эрсдэлээс зайлсхийх болон шилжүүлэх
 - 8.3. Өндөр болон дунд эрсдэлтэй гэж тодорхойлогдсон үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах зорилгоор “Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулж хэрэгжүүлэх
 - 8.4. Бага эрсдэлтэй гэж тодорхойлогдсон эрсдэлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авна
 - 8.4.1. Үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлэх талаарх ажилтнуудад заавар, зөвлөмж хүргүүлэх
 - 8.4.2. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт зохион байгуулах
 - 8.4.3. Шаардлагатай гэж үзвэл компанийн холбогдох заавар, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр заавар, журам боловсруулах
9. Үйл ажиллагааны эрсдэлийн хяналт, тайлагнал
 - 9.1. Эрсдэлийн түлхүүр үзүүлэлтүүдэд хязгаар тогтоох, хязгаарын хүрээнд хяналт тавих
 - 9.2. Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих
 - 9.3. Аудитын болон аудитын бус шалтгаанаар илэрсэн зөрчлийн эрсдэлийг тодорхойлж, судлах
 - 9.4. Үйл ажиллагааны эрсдэлийн төлөв байдлын талаар тайлан боловсруулж хянах,
 - 9.5. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтсолгоог компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд хянана





Сэнгэли ББСБ ХХК-ийн эрсдэлийн удирдлага





Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

1. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын гол зорилго нь зах зээлийн хэвийн, хэвийн бус нөхцөлд аливаа гуравдагч этгээдийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадахуйц бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрвөх чадвартай хөрөнгийн зохистой нөөцтэй байх, түүнчлэн компанийн ашигт ажиллагааг зохистой төвшинд барихад оршино.
2. Хөрвөх чадварын эрсдэлийг үнэлэхдээ дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.1. Хөрвөх чадварыг богино, дунд болон урт хугацаанд ангилж шинжлэх
 - 2.2. Макро эдийн засгийн судалгаа хийх
 - 2.3. Өнгөрсөн цаг хугацааны тоон мэдээлэл болон ирээдүйд үүсэж болзошгүй нөхцөл байдлын талаарх төсөөлөлд үндэслэн хөрвөх чадварын хандлагыг тодорхойлох
 - 2.4. "Хөрвөх чадварын хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулан баталж, дотоод болон гадаад нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдсөн үед шинэчилж байх
3. Хөрвөх чадварын эрсдэлийн арга хэмжээ нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:
 - 3.1. Дэлхий, бүс нутаг болон улс орны эдийн засгийн нөхцөл байдал, бусад гадаад болон дотоод хүчин зүйлийн өөрчлөлттэй уялдуулан, хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээнд зохицуулалт хийх
 - 3.2. Хөрвөх чадварт нөлөөлөхүйц эрсдэлээс зайлсхийх
 - 3.3. "Хөрвөх чадварын хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх

Хяналт, хариуцлага

1. Компанийн үйл ажиллагаанд гарч болох эрсдэлийг бууруулах зорилгоор шат дараалсан болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, хяналтыг компанийн холбогдох албан тушаалтнууд батлагдсан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэнэ.
2. Компанийн ажилтан Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, бодлого, журам, заавар, гарын авлага, аргачлалын дагуу ажил үүргээ гүйцэтгэж үнэнч шударгаар ажиллана. Мөн компани хамт олны үнэт зүйл, эрхэм зорилт, ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг хатуу баримтална.



3. Компанийн ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, банкны хэмжээнд хэрэглэж буй журам, заавар, компанийн газар, нэгжийн дотоод үйл ажиллагааны журам, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон ажилтны ажлын байрны тодорхойлолтоор зохицуулна.

1.8 КОМПАНИЙН АЖИЛЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

Үнэт цаас гаргагч нь нийтэд нээлттэй хувьцаагаа санал болгох үед ажилчид тухайн хувьцааг худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хөтөлбөр баталсан байна.

Энэхүү хөтөлбөрийн дагуу тус компанийн ажилтнууд 7 сарын хугацаанд, сар бүр 50,000-1,000,000 төгрөгийн хуримтлал үүсгэх боломжтой ба үүссэн хуримтлалын дүнг компаниас 50.0 хувиар нэмэгдүүлэхээр хөтөлбөрт тусгажээ.


Энэхүү хөтөлбөрийн хүрээнд үнэт цаас гаргагч болон түүний толгой, зэргэлдээ компаниудын нийт 150 гаруй ажилчдыг хамруулж, нийт 80-н сая гаруй төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсөн байна.



1.9 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, 46.5 дахь хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг гаргана. ТУЗ шийдвэртээ нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтооно. Үнэт цаас гаргагчийн 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн №08 дугаартай ТУЗ-ийн тогтоолоор компанийн хэлбэрийг өөрчилж, нээлттэй хувьцаат компани болгохтой холбогдуулан бэлтгэсэн Ногдол ашгийн бодлогын төслийг сайшааж, нээлттэй компани болсны дараах анхны хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлахаар төлөвлөсөн байна.

Ногдол ашгийн бодлогыг хураангуйлбал:

- Нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- Компани дор дурдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
 - компанийн тухайн жилийн цэвэр ашгийг тухайн жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх;
 - шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар байдал;
 - ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;





- **ногдол ашиг** төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй **ногдол ашиг**, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх.
- Компанийн дүрэм, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан тусгай зориулалтын сангуудад зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа.
- Компани нээлттэй хувьцаат компани болсон үеэс хойш нэг жилийн дараагаас эхлэн ТУЗ-ийн тогтоолоор татварын дараах цэвэр ашгийн 20 болон түүнээс дээш хувийг **ногдол ашиг** болгон хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.
- Ногдол ашгийг бэлэн мөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаас хэлбэрээр төлж болно.
- Жилийн тайланд тусгах мэдээлэлд **ногдол ашгийн хэмжээг** тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байна.
- Компани **ногдол ашиг** хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа **ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбарлана.**





Хоёр.

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

02



эндли 2025 ХХК - Үндэсний ганилцуулга

БҮРГЭВ

2.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ



2.1.1 МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

Улсын зээлжих зэрэглэл гэдэг нь гадаад дотоодын хөрөнгө оруулагчдаас тухайн улсад олгосон зээлийн хүү болон үндсэн төлбөрийг эргэн төлөх чадвар, зээлдэгчийн ерөнхий эрсдэлийг илтгэдэг үзүүлэлт юм.



Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 1999 оноос эхлэн Сангийн яам болон Монгол банкны зүгээс олон улсад нэр хүндтэй, бие даасан зээлжих зэрэглэл тогтоогч S&P Global Ratings, Fitch Ratings болон Moody's Investors Service агентлагуудтай гэрээ байгуулсны үндсэн дээр тогтоолгож эхэлсэн.

S&P болон Fitch агентлагийн үнэлгээгээр BBB түвшнээс Moody's агентлагийн үнэлгээгээр Baa түвшнээс доогуур тохиолдолд хөрөнгө оруулалтын эрсдэлтэй зэрэглэлд ангилагддаг бөгөөд одоогийн байдлаар манай улсын зээлжих зэрэглэлийг S&P болон Fitch агентлаг нар В тогтвортой, Moody's агентлаг В3 тогтвортой хэмээн үнэлж байгаа нь хөрөнгө оруулалтын эрсдэлтэй зэрэглэлд ангилагдаж буйг харуулж байна.

Хүснэгт 8: Монгол Улсын зээлжих зэрэглэл

Ангилал		S&P	Moody's	Fitch
Хамгийн өндөр зэрэглэл		AAA	Aaa	AAA
Өндөр зэрэглэл	Хөрөнгө оруулахад тохиромжтой ангилал	AA+	Aa1	AA+
		AA	Aa2	AA
		AA-	Aa3	AA-
Төлбөрийн өндөр чадамжтай	Хөрөнгө оруулахад тохиромжтой ангилал	A+	A1	A+
		A	A2	A
		A-	A3	A-
Төлбөрийн чадамжтай	Хөрөнгө оруулахад тохиромжтой ангилал	BBB+	Baa1	BBB+
		BBB	Baa2	BBB
		BBB-	Baa3	BBB-
Эрсдэлтэй	Хөрөнгө оруулахад тохиромжтой ангилал	BB+	Ba1	BB+
		BB	Ba2	BB
		BB-	Ba3	BB-
Өндөр эрсдэлтэй	Хөрөнгө оруулахад тохиромжтой ангилал	B+	B1	B+
		B	B2	B
		B-	B3	B-
Маш өндөр эрсдэлтэй	Эрсдэлтэй ангилал	CCC+	Caa1	CCC+
		CCC	Caa2	CCC
		CCC-	Caa3	CCC-
Дампуурхад ойр	Эрсдэлтэй ангилал	CC	Ca	CC
				C
Дампуурсан	Эрсдэлтэй ангилал	SD	C	SD
		D		DD
				D

Эх сурвалж: S&P, Moody's, Fitch агентлагуудын вэб сайт



Түүхэн өгөгдлийг авч үзвэл S&P агентлаг 2007-2013 онуудад Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хамгийн өндөр буюу “BB-” түвшинд үнэлж байсан. Харин 2016-2017 онд Moody’s агентлаг түүхэндээ хамгийн муу буюу “Caa1” төвшинд үнэлж байжээ. 2018 оноос хойш манай улсын зээлжих зэрэглэл одоогийн байгаа төвшинд тогтвортой хадгалагдсаар байна.





Эх сурвалж: Монгол банк

2.1.2 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хүснэгт 9: Монгол улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд

Үзүүлэлт	нэгж	2017	2018	2019	2020	2021
Үндэсний тооцоо						
ДНБ, оны үнээр	их наяд төг	27.8	32.4	36.8	36.9	43
ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	их наяд төг	24.5	26.4	27.9	26.6	27
ДНБ-ний бодит өсөлт	хувь	5.60%	7.70%	5.60%	-4.60%	1.50%
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	сая төг	9	10.3	11.6	11.4	12.6
Мөнгө санхүү						
Мөнгө M1	их наяд төг	2.8	4	3.9	4.1	6.5
Мөнгө M2	их наяд төг	15.8	19.4	20.8	24.2	27.8
Нэгдсэн төсвийн орлого	их наяд төг	7.9	10	11.9	10.4	14.2
Нэгдсэн төсвийн тэнцэл	их наяд төг	-1	0.8	0.5	-4.5	-1.3
Гадаад валютын албан нөөц	тэрбум ам.дол	3	3.5	4.3	4.5	4.3
Засгийн газрын гадаад өр	тэрбум ам.дол	7.3	7.1	7.7	8.6	8.4
Экспорт	тэрбум ам.дол	6.2	7	7.6	7.5	9.2
Импорт	тэрбум ам.дол	4.3	5.8	6.1	5.2	6.8
Төлбөрийн тэнцэл	тэрбум ам.дол	1.4	-0.1	0.4	2.2	2.4
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	тэрбум ам.дол	2	2.7	2.9	2.6	
Хүүгийн төвшин						
Бодлогын хүү	%	11.00%	11.00%	11.00%	6.00%	6.00%
Инфляцийн төвшин	%	6.40%	8.10%	5.20%	2.30%	13.40%
Хадгаламжийн хүү, жилээр	%	13.00%	11.20%	10.60%	8.30%	8.70%





Зээлийн хүү, жилээр	%	19.00%	16.90%	16.90%	15.80%	14.30%
Төгрөг ам.долларын албан ханш	төг	2,427	2,644	2,734	2,849	2,849

Банкны салбар						
Зээлийн өрийн үлдэгдэл	их наяд төг	13.6	17.2	18	17.6	20.7
Хугацаа хэтэрсэн зээл	%	6.00%	4.90%	4.60%	7.10%	4.50%
Чанаргүй зээл	%	8.50%	10.40%	10.10%	11.20%	9.90%
Зээлийн хүү, сараар	%	1.50%	1.30%	1.30%	1.30%	1.20%

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо, Монгол банк, Санхүүгийн Зохицуулах Хороо

Бодит сектор

Ковид-19 цар тахал дэгдэж дотоодод хорио цээрийн дэглэм тогтоосноор эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, бодит эдийн засаг 2020 онд 4.6 хувиар агшсан бол 2021 оны байдлаар 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 10: Бодит ДНБ /2015 оны зэрэгцүүлэх үнээр/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

2021 онд оны үнээрх ДНБ өмнөх оноос 14.8 хувиар өсөж 43.0 их наяд төгрөгт хүрлээ. Нэг талаас эдийн засгийг сэргээх, өрхийн орлогыг дэмжих бодлогын арга хэмжээ үргэлжилж, хөл хорионы дэглэм шат дараатай суларч байгаа нь эдийн засгийн идэвхжлийг дэмжиж буй хэдий ч нөгөө талаас хилийн боомтууд дээр үүсээд буй логистикийн асуудлууд нь гадаад худалдааны эргэлтийг хязгаарлаж, сэргэлтэд сөргөөр нөлөөлж байна. Хилийн боомтуудад үүсээд буй энэхүү асуудал нь 2022 оныг дуустал үргэлжлэх төлөвтэй байгаа тул бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт тус хугацаанд дунджаар 2.3 хувьтай байхаар хүлээгдэж байна.


Азийн хөгжлийн банкнаас жил бүр гаргадаг “Азийн Хөгжлийн Төлөв 2022” эдийн засгийн шинжилгээ, төсөөллийн тайланд өгүүлснээр Монгол улсын эдийн засгийн өсөлт 2022 онд 2.3 хувиар, харин 2023 онд дотоодын эрэлт, хөрөнгө



Сэндли ББСБ - Үнэг цааны ганилцуулга

3377 сар 10 өдөр
БҮРТГЭВ

Труулалт болон хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний салбар дахь сэргэлтийн зэрэг нөлөөллөөр 5.6 хувиар өсөх төлөвтэй байна гэжээ.



Хүснэгт 10: Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Институт	2022Т
Дэлхийн Банк	2.5%
Олон Улсын Валютын Сан	2.0%
Азийн Хөгжлийн Банк	2.3%
Монголбанк	2.5%
Дундаж	2.3%

Эх сурвалж: Олон улс болон дотоодын эдийн засгийн институт

Гадаад сектор:


2021 онд Монгол улсын нийт импорт 6.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 29.2 хувиар, харин экспорт 9.2 тэрбум ам.долларт хүрч 22.0 хувиар тус тус өссөн байна. 2021 онд гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнд Монгол улсаас гарах экспортын бараа, үйлчилгээний дүн ялангуяа түүхий эдийн бүтээгдэхүүний экспорт өссөн нь эерэг нөлөө үзүүлжээ.

График 11: Гадаад худалдааны нөхцөл




Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

2021 оны гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар буюу 3,221.0 сая ам.доллаароор өсөж 16,096.0 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд экспорт 22.0 хувиар буюу 1,671.0 сая ам.доллаароор, импорт 29.0 хувиар буюу 1,550.0 сая ам.доллаароор тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 121.0 сая ам.доллаароор өсч 2,398.0 сая ам.долларын ашигтай гарлаа.





Саямдли ББСБ-ийн үйлчилгээний танилцуулга



Хүснэгт 11: Гадаад худалдааны тэнцэл, экспорт, импорт

Төрөл	Жилээр			Өөрчлөлт	
	2019	2020	2021	2022/2021	
Сая Ам.доллар				Дүн	Хувь
Эргэлт	13,747	12,875	16,096	3,221	25.00%
Экспорт	7,620	7,576	9,247	1,671	22.00%
Импорт	6,128	5,299	6,849	1,550	29.00%
Тэнцэл	1,492	2,277	2,398	121	-

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Инфляц:

Монгол улсын инфляц 2021 оны эцсийн байдлаар жилийн 13.4 хувь байсан. Жилийн инфляцийг авч үзвэл 21.6 нэгж хувийг тээврийн бүлгийн үнэ, 19.0 нэгж хувийг зочид буудлын үйлчилгээний үнэ, 15.3 нэгж хувийг орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ, 13.4 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Инфляцийн өсөлтийг улсын дотоод эдийн засгийн идэвхжлээс илүүтэйгээр гадаад хүчин зүйлс тайлбарлаж байна. Үүнд:

- Хил хаагдсантай холбоотой импортын хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт эрчимжсэн
- Хил, гааль дээр үүссэн бэрхшээлийн улмаас хадгалалт, улс хоорондын тээвэрлэлтийн зардал нэмэгдсэн
- Бензин, шатахууны үнэ, тээврийн зардал, түүхий эд материалын үнийн өсөлтөөс шалтгаалан үйлдвэрлэл, үйлчилгээний зардал өссөн зэрэг нь инфляцийг өсгөх нөлөө үзүүлж байна.

График 12: Инфляцийн түвшин



Эх сурвалж: Монголбанк



Түсээд буй нөхцөл байдал, тээвэр, логистикийн асуудал хамгийн богино хугацаанд тэхэд 2022 оны 2 дугаар улиралд намжих төлөвтэй байгаа бөгөөд үүнээс хамаарч олон улсын болон дотоодын шинжээчдийн зүгээс Монгол Улсын жилийн инфляцийн түвшинг 2022 онд дунджаар 13.6 хувьд хүрнэ хэмээн төсөөлж байна.

Хүснэгт 12: Инфляцийн төсөөлөл

Институт	2022Т
Олон улсын валютын сан	15.5%
Азийн хөгжлийн банк	12.4%
Монголбанк	13.0%
Дундаж	13.6%

Эх сурвалж: Монголбанк болон ОУ-ын байгууллагууд

Мөнгөний нийлүүлэлт, мөнгөний бодлого

2021 онд мөнгөний нийлүүлэлт өмнөх оноос 13.8 хувиар өсөж, 27.9 их наяд төгрөгт хүрсэн байна. M2 мөнгөний жилийн өсөлтөд төгрөгийн харилцах 9.1 нэгж хувийн, төгрөгийн хадгаламж 6.8 нэгж хувийн, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.4 нэгж хувийн нөлөө үзүүлсэн бол гадаад валютын хадгаламж 2.8 хувиар бууруулах нөлөө үзүүлжээ.

2021 онд төгрөгийн харилцах өмнөх оноос 64.0 хувиар, төгрөгийн хадгаламж 12.0 хувиар өсжээ. 2020 оны эхнээс эрчимтэй өссөн мөнгөний нийлүүлэлт 2021 оны 2 дугаар улиралд хамгийн өндөр түвшинд хүрсэн бол оны төгсгөлд Ковид-19 цар тахлын өмнөх үетэй ижил түвшинд хүрч буурсан.

График 13: Мөнгөний нийлүүлэлт



2021 оны дунд үеэс иргэд, аж ахуй нэгжийг дэмжих, цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн Газар эдийн засгийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн, Арилжааны банкууд репо

[Handwritten signature]

УЛААНБААТАР ХОТ
 ӨЛЗИЙ ЭНД НО
 КАПИТАЛ УЙХ
 ХХК
 9019120768-6451289

РАЙНОС ИНВЕСТМЕНТ УЙХ
 ХХК
 INVESTMENT UYKH
 LLC
 УЛААНБААТАР ХОТ
 9019120768-6451289


Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2021 онд 358.6 сая ам.долларын ашигтай гарсан бол урсгал данс 148.0 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 438.1 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Ковид-19 цар тахлын тархалт, түүнийг хязгаарлах дэлхийн улсуудын бодлогоос шалтгаалан дэлхий даяар үйлчилгээний салбарын үйл ажиллагааны идэвх саарсан, гадаад үйлчилгээний эрэлт буурсан нь Монгол Улсын төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний алдагдал буурахад голлох нөлөө үзүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын төлбөрийн тэнцэл дээрх үйлчилгээний тэнцэл 1,380.0 сая ам долларт хүрч өмнөх оноос 4 хувиар буурсан. Энэ нь дэлхийн ихэнх улсууд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс үүдэлтэйгээр үйлчилгээний салбарын идэвх саарч, эрэлт буурсантай холбоотой юм.

Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан гадаадын хөрөнгө оруулагч компаниудын үйл ажиллагаа сэргэснээр ногдол ашгийн шилжүүлэг, гадаад ажилтнуудын цалингийн шилжүүлэг нэмэгдэж, анхдагч орлогын алдагдал 2,209.0 сая ам долларт хүрсэн. Харин хоёрдогч орлого буюу урсгал шилжүүлгийн орох урсгал 20 хувиар нэмэгдэж, 328.0 сая ам.долларт хүрсэн нь цар тахлыг даван туулахад чиглэсэн гадаадын буцалтгүй тусламжийн нөлөөнөөс үүдэлтэй байна.

График 14: Төлбөрийн тэнцэл



■ Урсгал болон хөрөнгийн дансны тэнцэл ■ Санхүүгийн данс
 ■ Алдаа болон орхигдуулга ■ Төлбөрийн тэнцэл

Handwritten signature

УЛААНБААТАР ХОТ
 ӨЛЗНИЙ ЭНД НО
 КАПИТАЛ ТҮК
 ХХК
 6183115
 021031115 & CFC2120


Эх сурвалж: Монголбанк
 RHINOS INVESTMENT UT-K LLC
 63
 УЛААНБААТАР ХОТ
 07768 & 6481299



2021 онд Монгол Улсын гадаад валютын албан нөөц 4,366.0 сая ам долларт хүрч өмнөх оноос 3.7 хувиар буурсан нь ДНБ-ий 29.0 хувь, импортын 8 сарын хэрэглээтэй тэнцэж байна. Монгол банк валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд 20.0 тонн алт худалдаж авсан нь өмнөх оноос 12.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Сүүлийн нэг жилийн хугацаанд дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотой экспортын орлого нэмэгдсэн, Монгол Улсын дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээ бусад улсын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад хямдхан болсон зэргээс шалтгаалж 2021 онд валютын ханш харьцангуй тогтвортой байв.

График 15: Гадаад валютын албан нөөц

ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ



Эх сурвалж: Монголбанк

Ам.долларын ханш:

2021 онд төгрөгийн ам.доллартой харьцах ханш харьцангуй тогтвортой буюу 2,850.0 түвшинд хадгалагдсаар 2022 оныг угтлаа. 2021 оны жилийн эцэст ам.долларын ханш 2,849.34 төгрөгт хүрч хаагдсан нь өмнөх оны мөн үеэс 0.02 хувь буурсан үзүүлэлт юм.

Хятадын юанийн ханш:

Төгрөгийн юаньтай харьцах ханш 2021 оны эцэст 446.96 төгрөгт хаагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.4 хувь өссөн үзүүлэлт болж байна.





Эх сурвалж: Монголбанк

2.1.3 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ


Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2021 оны жилийн эцсийн байдлаар 5.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 98.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Тодруулбал, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2020 онд ДНБ-ий 8.1 хувьтай тэнцүү байсан бол 2021 оны байдлаар 5.8 нэгж хувиар нэмэгдэж 13.9 хувьд хүрсэн байна. Энэ нь сүүлийн нэг жилийн хугацаанд дотоодын хөрөнгийн зах зээл асар хурдацтай тэлснийг харуулж байна.

ТОП 20 индекс 2021 оны эхэн үеэс эхлэн хурдацтай өссөөр 2021 оны 9 дүгээр сар гэхэд бүх цаг үеийн дээд хэмжээ болох 49,252 нэгжид хүрсэн ба үүнээс цааш алгуур буурсаар 2021 оны 4 дүгээр улирал дуусахад 41,000 нэгжийн орчимд хаагдлаа.

График 17: ХЗЗ-н үнэлгээ, ТОП-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж



Хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвх

2020 онд Монголын хөрөнгийн биржийн нийт арилжааны дүн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас улбаалан 65.0 тэрбум төгрөг болж буурсан боловч 2021 онд хувьцаат компаниудын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх сэргэсэн, Эрдэнэс таван толгой ХК 692.5 тэрбум төгрөгийн нээлттэй бондыг биржээр дамжуулан гаргасан зэрэг голлох хүчин зүйлсийн улмаас арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 22 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна.

График 18: Арилжааны идэвх



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж





2.2 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

2.2.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 703.0 тэрбум төгрөгөөр буюу 35.0 хувиар өсөж 2.7 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын 6.6 хувьтай тэнцэж байна. Активын өсөлтийн 97.5 хувийг нийт зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 13.7 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

График 19: Нийт хөрөнгө, нийт зээл



Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ

2021 оны байдлаар 534 банк бус санхүүгийн байгууллага 331 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зээлдэгчдийн давхардсан тоо 71.4 хувиар өсөж 4.8 саяд, зээлдэгчдийн тоо 1 дахин өсөж 1.6 саяд хүрчээ. Аппликейшн ашиглан бага дүнтэй, богино хугацаатай хэрэглээний зээл олгодог ББСБ-ууд нэмэгдсэнтэй холбоотойгоор зээлдэгчдийн тоо ийнхүү огцом өссөн байна.

График 20: ББСБ тоо, харилцагчийн тоо




Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ

Финтек зээлийн үйлчилгээг 2021 оны байдлаар 36 банк бус санхүүгийн байгууллага үзүүлж байгаа бөгөөд үүний 11 нь зөвхөн онлайн зээлийн үйлчилгээг санал болгож байгаа бол 17 нь уламжлалт болон дэвшилтэт технологи хослуулж

ӨЛЭНИЙ ЭХЭН
КАПИТАЛ
УЛААНСААТАС
6182865
9921031165 СТОС2420

УЛААНСААТАС
INVESTMENT
9919120768 СТОС1209



байна. Мөн 8 ББСБ онлайн зээл олгохоор туршилтын аппликэйшн гаргасан байна.

2021 оны байдлаар аппликэйшнээр зээл олгодог эдгээр банк бус санхүүгийн байгууллагууд нь нийт 1.4 сая зээлдэгчийн 308.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд нэг зээлдэгчид дунджаар 228.3 мянган төгрөгийн зээл олгосон байна. Энэхүү нэг зээлийн хэмжээ нь нийт зээлийн дунджаас 5 дахин, уламжлалт хэлбэрээр олгож байгаа зээлийн дунджаас 23 дахин бага байна.

Хүснэгт 13: Уламжлалт ба финтек ББСБ

	Зээлийн дүн /тэр.төг/	Эзлэх хувь	Зээлдэгчийн тоо	Эзлэх хувь	Харилцагчийн тоо	Эзлэх хувь	Дундаж зээл /мян.төг/
Уламжлалт	1,704.20	84.70%	329,023	19.60%	380,829	7.90%	5,179.40
Финтек	308	15.30%	1,349,116	80.40%	4,439,795	92.10%	228.3
Нийт	2012.2		1,678,139		4,820,624		1,199.10

Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ

2021 оны байдлаар нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 51.6 хувь буюу 685.2 тэрбум төгрөгөөр өсөж 1.8 их наяд төгрөгт хүрчээ. Мөн түүнчлэн нийт 114.7 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1.9 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

График 21: Зээлийн жингэсэн дундаж хүү

ЗЭЭЛИЙН ЖИГНЭСЭН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ

Хүснэгт 14: ББСБ тоо, хөрөнгө

Үзүүлэлт	Нийт хөрөнгийн дүн (тэрбум.төг)	ББСБ тоо	Нийт хөрөнгөөр салбарт эзлэх хувь
5.0 тэрбумаас дээш	1,869.60	93	69.00%
2.5-5.0 тэрбум	410.4	125	15.10%
1.9-2.5 тэрбум	215.8	99	8.00%
1.4-1.9 тэрбум	152.5	94	5.60%
0.6-1.4 тэрбум	39.1	36	1.40%
0.6 тэрбум хүртэлх	22.6	87	0.80%

Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм.





Салбарын нийт хөрөнгийн 84.1 хувь нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 218 ББСБ байгаа бол 8.0 хувь нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөтэй 99 ББСБ байна. Нийт салбарын хөрөнгийн 7.8 хувийг нь 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 217 ББСБ бүрдүүлж байна.

График 22: Нийт зээлийн хуваарилалт



Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм.

Нийт зээлийн үлдэгдлийн 90.5 хувийг буюу 1,821.9 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 2.5 хувийг буюу 50.0 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.0 хувийг буюу 140.2 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

График 24: Хуулийн этгээдэд олгосон зээл





График 23: Иргэдэд олгосон зээл



Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ

ББСБ-с иргэдэд олгосон зээлийн дийлэнх хувийг хэрэглээний зээл эзэлж байгаа нь финтек зээлийн хялбар үйлчилгээтэй холбоотой.





3 Сэдвийн өмчийн хэргийн танилцуулга




График 25: Эхүүсвэр

ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ



Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ

Сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг харвал салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2017 оны мөн үед 758.2 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 1.4 дахин өсөж 1.8 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 3.3 дахин өсөж 910.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.



График 26: Ашигт ажиллагаа

АШИГТ АЖИЛЛАГАА



Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ

2021 оны байдлаар нийт ББСБ-ууд 521.3 тэрбум төгрөгийн орлого олж, 311.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 210.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оноос орлогын хэмжээ 27.5 хувь буюу 112.5 тэрбум төгрөгөөр,



зардлын хэмжээ 22.5 хувь буюу 57.3 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 35.6 хувь буюу 55.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

ББСБ-ын нийт харилцагчийн тоо сүүлийн 2 жилийн дотор 2 дахин өсөж 4.8 саяд хүрсэн нь финтект суурилсан үйлчилгээ үзүүлдэг ББСБ -ууд нэмэгдсэнтэй шууд холбоотой бөгөөд хүйсээр авч үзвэл дийлэнх нь эрэгтэй харилцагчид байна. Харин финтек ББСБ-ын харилцагчдын тоо 2.5 дахин өсжээ. Энэ нь санхүүгийн хүртээмж тэлж байгааг харуулж байна.

График 27: Харилцагчид



Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ


Бичил санхүүгийн зах зээлд гарч буй технологийн дэвшил

Эдийн засаг, иргэдийн аж амьдралд мэдэгдэхүйц эерэг нөлөөг үзүүлж байгаа нэг төрлийн бүтээгдэхүүн бол технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ юм. Технологийн дэвшлийг зээлийн үйл ажиллагаанд ашигласнаар санхүүгийн байгууллагуудын зардал буурах, санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжрах, уламжлалт банкны зээлийн үйлчилгээнээс хасагдсан иргэд, аж ахуйн нэгжүүдэд санхүүжилтийн олон төрлийн боломж нээгдэх зэрэг олон давуу тал үүсэж байна.

Манай улсад хамгийн түгээмэл дэлгэрээд байгаа нь дижитал бичил зээл болон дижитал төлбөр тооцоо, цаашлаад дижитал хөрөнгийн зах зээл ч мөн хөгжих хандлагатай байна. Дэлхий дахинд нүүрлэсэн Ковид-19 цар тахал нь иргэд, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд эерэг, сөрөг аль аль талын нөлөө үзүүлсэн. Финтек үйлчилгээний хувьд Монгол улсад харьцангуй шинэ ойлголт бөгөөд өмнө амжилттай туршигдаж хэрэглэгчдэд танил болсон бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээл дээр мөн байна. Манай улсад нийт хэрэглэгчдийн тоо ойролцоогоор 2,900,000 хүн амыг хамрах төлөвтэй байгаа бөгөөд бизнесийн мөчлөгийн тогтворжилтынхоо үед зах зээлийн 20-25 хувийг эзэлнэ гэж үзэхэд ойролцоогоор 580,000-725,000 харилцагчтай болох боломжтой байна.



г танилцуулга



Өнөөдрийн байдлаар бидний төлөвлөж байгаа үйл ажиллагаатай адил буюу
Аппликейшн ашиглан цахим зээл олгож байгаа компани монгол улсын хэмжээнд
36 компани байна.

Хүснэгт 15: Аппликейшнээр зээл олгож буй компаниуд

№	Финтек	Апп нэр	№	Финтек	Апп нэр
1	Ашид капитал	Simple	19	Грийн финтек	T finance
2	Соно финтек	Sono mongolia	20	Тус финтек	TUS fintech
3	Лэндмн	LendMN	21	Нанокапитал	Nano capital
4	Очир ундраа ОМЗ	Opay	22	Монголиа импакт финанс	Qmoni
5	Ардкредит	Ard app	23	Хас хаан	Хас Хаан
6	Нөмөр кредит	Numur	24	Инвескор хэтэвч	Pocket.mn
7	Омни капитал	Moni dijital	25	Смарткапитал фонд	Mycredit.mn
8	Мобифинанс	Monpay	26	Фин экспресс	FinEx.mn
9	Сэндли	Sendly	27	Өсөх ундарга финанс	Ufinance
10	Централ капитал	Kmobi	28	Солонго капитал	100k.mn
11	Бизнес-Инвест девелопмент	БИД	29	Гурван зуун жар файнанс	Minu pay
12	Жи Эс Би Капитал	GSB capital	30	Гэрэлфинанс	Gerel
13	Хатан суудал инвест	Zeely	31	Микрокредит	Micro Credit
14	Эм Пи Эс Си	Toki	32	Начин заан финанс	Naizly.mn
15	Говьфинанс	Cash One	33	Нэйшнл кредит юнион	Tenlend
16	Таван богд финанс	PayOn.mn	34	Сэнд эм эн	Sendmn
17	Зээл Эм Эн платформ	Zeel.mn	35	Энт кредит инвестмент	Ent credit
18	Нэт капитал финанс корпораци	Netapp MN	36	Эс ай си эй финанс	SicaFinance

Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ

2.2.2 МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй уламжлалт болон цахим зээл, гадаад мөнгөн гуйвуулга, мерчант зээлийн зах зээлийн олон улсын болон дотоодын нөхцөл байдал, цаашдын чиг хандлага болон боломжит зах зээлийн багтаамжийг энэ бүлэгт оруулсан болно.

Дэлхийн мөнгөн гуйвуулгын өнөөгийн байдал

Олон улсын валютын сангийн тодорхойлсноор мөнгөн гуйвуулга гэдэг нь гадаад улсад түр хугацаагаар ажиллаж амьдарч буй хүмүүсийн хийж буй бизнесийн бус шинж чанартай мөнгөн шилжүүлэг юм.

НҮБ-с гаргасан "The World Migration Report 2022" тайланд дурдсанаар дэлхийн хэмжээнд нийт 280.5 сая хүн эх орноосоо бусад улс оронд түр болон урт хугацаагаар ажиллаж, амьдарч байгаа бөгөөд эдгээр иргэдийн үүсгэж буй мөнгөн

2022 оны 10 сар 10 өдөр

МОНГОЛЫН ХАТЭМЛИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-07-26
03-93

Гуйвуулгын зах зээлийн хэмжээ нь 705.5 тэрбум ам.доллар байна. Сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд эх орноосоо бусад улсад ажиллаж, амьдарч буй хүмүүсийн тоо жилд дунджаар 3.12 хувиар нэмэгдэж ирсэн ба энэхүү өсөлтийг даган мөнгөн гуйвуулгын үйлчилгээ ч өссөөр байна.

График 28: Дэлхийн мөнгөн гуйвуулгын хэмжээ




Эх сурвалж: НҮБ: The World Migration Report 2022

Мөнгөн гуйвуулга нь хүлээн авагч болон илгээгч гэсэн хоёр талд хуваагддаг ба мөнгөн гуйвуулгын урсгал нь орлогын төвшин өндөртэй улс орнуудаас орлогын төвшин дунд болон бага улс орнууд руу чиглэлтэй байдаг. Дэлхийн банк болон НҮБ-ын статистикийн санд тэмдэглэснээр АНУ илгээсэн мөнгөн гуйвуулгын хэмжээгээр дэлхийд тэргүүлж байгаа бол Энэтхэг улс нь хүлээн авсан мөнгөн гуйвуулгын хэмжээгээр тэргүүлж байна.

График 30: Илгээсэн мөнгөн гуйвуулгаар тэргүүлэгч 10 улс



График 29: Хүлээн авсан мөнгөн гуйвуулгаар тэргүүлэгч 10 улс




Эх сурвалж: НҮБ: The World Migration Report 2022

Handwritten signature

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗЛИЙ ЭНД ЛО
КАПИТАЛ ҮЙС
ХХК
8183855
9021031195 СТС2420

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЙС
ХХК
РАЙНОС
INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
9019120764 СТС21299



Дэлхийн Банкнаас гаргасан “Remittance Prices Worldwide Quarterly 2021 Q4” тайланд дурдсанаар 200 ам.доллар гуйвуулахад гарах жигнэсэн дундаж зардал дэлхийн хэмжээнд 6.0 хувь буюу 12.0 ам.доллар байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 0.5 пунктээр буурсан үзүүлэлт юм. Мөнгөн гуйвуулгыг гүйцэтгэж буй сектороор нь авч үзвэл дижитал хэлбэрийн гуйвуулга хамгийн бага өртөгтэй буюу 4.0 хувийн шимтгэлтэй байгаа бол банкны салбар хамгийн өндөр буюу 6.3 хувийн шимтгэлтэй байна. Цаашид мөнгөн гуйвуулгын үйлчилгээний салбарт дижитал шилжүүлгийн үйлчилгээ өссөнөөр НҮБ-н тогтвортой хөгжлийн зорилт болох 3.0 хувийг хангах боломжтой болох юм.

График 31: 200 ам.доллар шилжүүлэхэд гарах зардал



Эх сурвалж: Дэлхийн банк: “Remittance Prices Worldwide 2021 Q4” тайлан

Дэлхийн мөнгөн гуйвуулгын цаашдын төсөөлөл

Уламжлалт мөнгөн гуйвуулга нь банкууд болон хувь хүмүүс, Western Union, Money Gram зэрэг мөнгөн гуйвуулгын компаниуд дээр тогтож ирсэн бол орчин цагт технологи хурдтай хөгжиж, санхүүгийн салбарт ахиц өөрчлөлтүүд гарснаар мөнгөн гуйвуулгын салбар дижитал хэлбэрлүү эрчимтэй шилжиж байна. Дижитал мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь олон сая хүмүүст зардал багатай, аюулгүй ши


лжүүлгийг түргэн шуурхай хийх боломжийг олгодгоороо онцлогтой. 2020 оны байдлаар дэлхийн мөнгөн гуйвуулгын зах зээл 705.5 тэрбум ам.доллаароор


График 32: Дэлхийн мөнгөн гуйвуулгын төсөөлөл



— Дэлхийн хэмжээнд хийгдсэн мөнгөн гуйвуулга /тэрбум ам.доллар/
 ● Дэлхийн хэмжээнд гадаадад ажиллаж амьдарч буй хүмүүс /Сая хүн/

Эх сурвалж: Allied Market Research, The World Migration Report 2022





үнэлэгдэж байсан ба Allied Market Research судалгааны байгууллагаас 2021-2030 оны хооронд дэлхийн мөнгөн гуйвуулгын зах зээлийн хэмжээг жилд дунджаар 5.7 хувь өсөхөөр төсөөлсөн байна. Энэ нь 2030 он гэхэд 1.2 их наяд ам.доллар хүрэх төлөвтэй байна.

Дэлхийн хэмжээнд гадаадад ажиллаж амьдарч буй хүмүүс нь The World Migration Report 2022 тайланд дурдсанаар 2020 оны байдлаар 280.5 сая хүн байгаа бөгөөд түүхэн өсөлтийн дунжийг тооцоход жилд 2.8 хувиар өсөж байна. Энэхүү төсөөллөөр тооцоход 2024 онд дэлхий дахинаа гадаадад ажиллаж амьдарч буй хүмүүсийн тоо 313.9 саяд хүрэх төлөвтэй байгаа ба технологийн шилжилтийн нөлөөгөөр дижитал мөнгөн гуйвуулгын үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байна.

Дотоодын мөнгөн гуйвуулгын өнөөгийн байдал

Монгол улсын хүлээн авсан мөнгөн гуйвуулга 2021 оны жилийн эцсээр 198.2 сая ам.доллар, гадаад улс руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 78.1 сая ам.доллар байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 15.4 хувь болон 13.2 хувиар тус тус буурсан үзүүлэлт юм.


График 33: Дотоод мөнгөн гуйвуулгын хэмжээ



Эх сурвалж: Монгол банк: Гадаад секторын статистик

Дотоодын мөнгөн гуйвуулгын хэмжээ сүүлийн жилүүдэд буураад байгаа нь Монгол улсад FATF - аас (Дэлхийн мөнгө угаах терроризмтой тэмцэх байгууллага) 2017 оноос эхлэн хатуу хяналт тавьж сануулга өгч эхэлсэн, 2019 онд Монгол улс саарал жагсаалтад орсон, мөн дэлхий дахинаа Ковид-19 цар тахал тархсан зэрэг нөхцөл байдлуудтай холбоотой юм. Монгол улс 2020 оны 10 дугаар сард саарал жагсаалтаас гарсан, мөн Ковид-19 цар тахлын нөлөөлөл буурч эхэлсэн зэрэг нь цаашид мөнгөн гуйвуулгын эрэлт хэрэгцээ нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна. Цар тахлын нөлөөлөл ороогүй буюу 2019 оныг хүртэлх хүлээн авсан мөнгөн гуйвуулгын жилийн дундаж өсөлт 3.6 хувь, шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын жилийн дундаж өсөлт 5.7 хувь байна. Энэхүү төсөөллөөр цаашдын өсөлтийг тооцож үзэхэд, Монгол улс 2024 онд 220.7 сая





ам.долларын гуйвуулга хүлээн авах, 92.1 сая ам.долларын шилжүүлэг хийх төлөвтэй байна.

Нийт хүлээн авсан мөнгөн гуйвуулгын 30.3 хувийг, шилжүүлсэн гүйлгээний 21.1 хувийг Монгол улсын иргэд ихээр ажиллаж амьдарч буй БНСУ-тай харилцсан гуйвуулга эзэлж байна.

График 35: Хүлээн авсан мөнгөн гуйвуулга График 34: Шилжүүлсэн мөнгөн гуйвуулга



Эх сурвалж: Монгол банк: Гадаад секторын статистик

Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамж

Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамжийг тооцоолохдоо гадаадад суугаа Монгол иргэдийн тоо, мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нэвтэрсэн буюу АНУ, Австрали, Япон улсуудын нэг сарын дундаж шилжүүлгийн дүн дээр үндэслэн зах зээлийн багтаамжийг тооцоолов.


Гадаад улсад суугаа монгол иргэд

Үндэсний статистикийн хорооны 2020 оны хүн ам, орон сууцны сүүлийн тайлангаар гадаад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдийн тоог нас хүйс, зорилгоор нь авч үзвэл:

Хүснэгт 16: Гадаадад оршин суугаа Монгол иргэд – Зорилгоор

Зорилго	Эр		Эм		Нийт
	Тоо	Хувийг	Тоо	Хувийг	
Албан томилолт	737	1.30%	460	0.70%	1,196
Бусад	5,003	8.83%	6,565	10.00%	11,567
Гэр бүлийн шалтгаанаар	7,042	12.43%	8,363	12.74%	15,406
Суралцах	19,359	34.17%	22,464	34.22%	41,823
Суурьших	5,694	10.05%	8,650	13.18%	14,346
Хөдөлмөрийн гэрээгээр	7,314	12.91%	5,462	8.32%	12,776
Хувиараа ажиллах	11,507	20.31%	13,681	20.84%	25,187
Нийт	56,656	100.00%	65,645	100.00%	122,301

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо




Нийт гадаад улсад суугаа Монгол иргэдийн дийлэнх хувийг суралцах зорилгоор оршин суугаа иргэд бүрдүүлж байгаа бол албан томилолтоор оршин суугаа иргэд хамгийн бага хувийг бүрдүүлж байна. Албан томилолт, бусад зорилгоорх хүмүүсийг мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хэрэглэх хандлага багатай гэж үзэн нийт тооноос хасаж тооцвол мөнгөн гуйвуулгын үйлчилгээг идэвхтэй хэрэглэх хандлагатай 109,538 иргэн байна. Үнэт цаас гаргагчаар дамжуулан хийсэн нэг харилцагчийн сарын дундаж мөнгөн гуйвуулгын хэмжээ 370.4 ам.доллар байгаа бөгөөд энэхүү тоонд суурилан зорилгоор нь ангилж авч үзвэл сарын 40.5 сая ам.долларын багтаамжтай ба жилийн 486.0 сая ам.доллар болж байна.

Гадаад улсад оршин суугаа Монгол иргэд – Улсаар

Одоогийн байдлаар Үнэт цаас гаргагчийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нэвтэрсэн Америк, Япон, байна. Эдгээр иргэдийг Үнэт цаас гаргагчийн нэг харилцагчийн сарын дундаж шилжүүлгийн дүн болох 374.0 ам.доллаар тооцож үзвэл сард 12.4 сая ам.доллар, жилээр тооцвол 148.8 сая ам долларын зах зээлийн багтаамжтай байна. Цаашлаад БНСУ, Европын холбооны улсуудад нэвтэрснээр энэхүү багтаамж нь сарын 34.4 сая ам.доллар, жилийн 412.8 сая ам доллар болох төлөвтэй байна. Үнэт цаас гаргагч нь Европын холбооны улсууд болон БНСУ - д үйлчилгээгээ нэвтрүүлэн, 2026 он гэхэд нийт дотоодын зах зээлийн 20-30 хувийг эзлэхээр ажиллаж байна.

График 36: Гадаад улсад суугуу Монгол иргэдийн тоо

Гадаад улсад суугаа Монгол иргэдийн тоо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаад улсад оршин суугаа Монгол иргэд – Насны бүлгээр авч үзвэл

2020 оны байдлаар нийт 122,301 Монгол иргэд гадаад улсад оршин суугаа бөгөөд үүнээс Sendly аппликейшн идэвхтэй хэрэглэх хандлагатай 15-54 насны 102,293 хүн байгаа нь нийт гадаад улсад суугаа Монгол иргэдийн 83.0 хувийг бүрдүүлж байна.







График 37: Гадаадад суугаа Монгол иргэдийн тоо

ГАДААДАД СУУГАА МОНГОЛ ИРГЭДИЙН ТОО



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үүнээс Үнэт цаас гаргагчийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ ашиглах боломжтой Монгол иргэдийн тоо 102,293, Үнэт цаас гаргагчийн нэг харилцагчийн сарын дундаж шилжүүлгийн дүн 374.0 ам.доллараар тооцож үзвэл сард 38.3 сая ам.доллар, жилд 459.0 сая ам.долларын зах зээлийн багтаамжтай байна.

Хүснэгт 17: Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамж

Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамж тооцсон арга	Дүн / сая ам.доллар/
Гадаадад оршин сууж буй зорилгоор	486.0
Гадаадад оршин сууж буй улс орнуудаар	148.8
Гадаадад оршин сууж буй хүмүүсийн насанд суурилсан	459.0
Дундаж шилжүүлгийн хэмжээ	364.6
Дундаж /төгрөгөөр/	1.1 их наяд ₮

Эх сурвалж: Андеррайтерын тооцоолол

Үнэт цаас гаргагчийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах боломжтой гадаад улсад оршин суугаа иргэдийн зорилго, улс орон, насанд суурилсан тооцооллоос харахад дунджаар 364.6 сая ам.доллар буюу 1.1 их наяд төгрөгийн гадаад гуйвуулгын зах зээлийн багтаамж байна гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.





Үнэт цаас гаргагч нь цахим хэлбэрээр мерчантын болон хэрэглээний зээл олгодог ба зах зээлийн багтаамжийг тодорхойлохын тулд тус компанийн гол хоёр бүтээгдэхүүний зах зээлд төвлөрч шинжилгээ хийсэн болно.

Мерчантын зээл, багтаамж

Мерчант зээлийн үйлчилгээ нь жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан богино хугацаатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой бүтээгдэхүүн бөгөөд бараа татан авалт, яаралтай бэлэн мөнгөний шаардлага үүсдэг худалдаа наймаа эрхлэгчид болон үйлчилгээ эрхлэгчид, цахим худалдаа хийдэг хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн юм.

Мерчантын зээлийн салбарыг судлахын тулд эхлээд худалдааны салбарын нөхцөл байдлын талаар судалж үзсэн ба тус салбарт зээл олгодог банк болон ББСБ-ын тоо баримтаас харахад дараах үр дүн гарч байна.

Хүснэгт 18: Банк болон ББСБ худалдааны салбарт олгогдсон зээлийн нөхцөл/2021он/

Худалдааны зээл		Олгосон зээл	Зээлдэгч	Дундаж хугацаа	Дундаж хүү /жил/
Банк	А.а.нэгж	788 тэрбум төг	6,021	17 сар	12%
	Иргэд	167 тэрбум төг	31,966	45 сар	16%
Бусад	ББСБ	332 тэрбум төг	-	1 сараас 5 жил	33%
	ХЗХ	11 тэрбум төг	-	-	27%
Нийт		1.3 их наяд төг	-	-	22%

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо


Худалдааны салбарт Банк болон ББСБ, ХЗХ олгосон зээлийн дүн 2021 онд нийт 1.3 их наяд төгрөг байсан ба дундаж хүү нь 22 хувь байжээ. Банкны хувьд иргэдэд олгосон худалдааны зориулалттай зээлийн хэмжээ 167 тэрбум төг, зээлдэгчийн тоо 31 мянга байгаа бол аж ахуйн нэгжид олгосон худалдааны зээл 788 тэрбум төгрөг, зээлдэгчийн тоо 6 мянга байв. ББСБ болон ХЗХ зөвхөн худалдааны зориулалттай олгосон зээлийн дундаж хугацаа 1 сараас 5 жилийн хугацаатай байдаг байна..

Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй маш олон аж ахуйн нэгж, хувь хүн, хувиараа бизнес эрхлэгчид байдаг маш том салбарын нэг юм.

Монгол Улсад хүнсний худалдааны чиглэлээр 14,769¹ худалдааны газар үйл ажиллагаа явуулж байгаагаас 6,519 нь Улаанбаатар хотод байрладаг энэ тоонд лангуу түрээслэгчид, түргэн үйлчилгээний цэг, худалдааны төвүүдэд ил задгай худалдаа эрхлэгчид ороогүй болно.

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүний 15.7 хувь, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 38 хувийг бүрдүүлж байна. Мөн тус

¹ Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны дотоод худалдааны салбарын 2020 оны тоо баримт



салбарт Монгол Улсын нийт ажиллах хүчний 13 хувь буюу 143.5 мянган хүн ажиллаж байна.

2020 оны байдлаар худалдааны салбарын нийт борлуулалт 25.4 их наяд төгрөгтэй тэнцсэн ба үүнээс 16.9 их наяд төгрөгийн борлуулалт буюу 66 хувийг жижиглэнгийн худалдааны салбар эзэлж байна.


Хүснэгт 19: Худалдааны салбарын нийт борлуулалт /Нэгж: их наяд төгрөг/

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нийт борлуулалт	6.5	13.0	13.4	14.5	16.9	17.7	16.8	20.0	24.1	27.1	25.5
Жижиглэн худалдааны борлуулалт	2.7	5.5	5.6	7.4	9.2	10.0	8.9	9.8	12.2	13.5	16.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Харин тус салбарт олгосон арилжааны банкны зээлийн нөхцөл байдлын талаар судалж үзэхэд 2021 оны байдлаар арилжааны банкны нийт зээлийн үлдэгдлийн 17 хувийг худалдааны салбар эзэлж байна.

График 38: Арилжааны банкны зээлийн бүтэц



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэ тоо нь нийт арилжааны банкуудын зээлийн багцад эзлэх дүнгээр хэрэглээний зээлийн дараа орох хамгийн том салбар болохыг илтгэж байна.

Харин аж ахуйн нэгж байгууллагад олгосон зээлийн үлдэгдэл болон түүний чанарыг голлох дөрвөн салбараар авч үзэхэд уул уурхай, боловсруулах үйлдвэр, барилга, худалдааны салбар нь нийт зээлийн 77 хувийг эзэлж байна. Үүнээс худалдааны салбар нийт зээлийн 29.4 хувь, чанаргүй зээлийн 2.7 хувийг эзэлж эзэлж байна.

3




График 39: Нийт зээлд эзлэх хувь



График 40: Чанаргүй зээлийн түвшин



Эх сурвалж: Монголбанк

Монгол банкны статистик тоо баримтаас харахад худалдааны салбар нь бусад салбаруудын адил нийт зээлд эзлэх хувь хэмжээ өндөр байгаа ч чанаргүй зээлд эзлэх хувь бага байгаа нь тус салбарт олгосон зээл бусад салбараас харьцангуй эргэн төлөлт сайтай байдгийг харуулж байна.

Худалдааны салбар нь мөнгөн урсгал, ашигт ажиллагаа, үйл ажиллагааны эргэцийн хурд бусад салбараас илүү өндөр байдаг нь тус салбарт богино хугацаатай зээл олгох тохиромжтой салбар болохыг илтгэж байна. Мөн зээлийн чанаргүй зээлийн төвшин бусад салбараас харьцангуй бага байгаа нь энэ салбарт олгосон зээлийн эргэн төлөлт сайн байдгийг илтгэж байна. Иймд Сэндли ББСБ нь худалдааны салбар, тэр дундаа мерчантын зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад хүргэж эхэлсэн байна.






Мерчантын зээлийн салбарт тулгамдаж буй асуудал

Мерчантын зээлийн салбарт тулгамдаж буй асуудал болон түүнийг шийдвэрлэх бүтээгдэхүүн үйлчилгээг Үнэт цаас гаргагч нэвтрүүлэх болсон үндэслэлийг судалж үзэхэд дараах үр дүн гарсан болно.


График 41: Мерчантуудын санхүүжилтийн эх сурвалж ба санхүүжилтийн зарцуулалт²



Эх сурвалж: Монголбанк

Мерчантуудын хувьд ихэвчлэн банкнаас зээл авдаг гэж 81 хувь нь хариулсан бол бусад эх үүсвэрээс буюу 7 хувь нь ББСБ, 12 хувь нь найз нөхөд, хөнгөлөлттэй зээл болон бусад эх үүсвэрээс авдаг гэсэн байна. Зарцуулалтын хувьд 64 хувь нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилт хэлбэрээр ашигладаг гэж хариулжээ.



График 42: Мерчантуудад шаардлагатай зээлийн хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

² Монголбанкны жижиг дунд үйлдвэрлэл хөгжил, санхүүжилтийн байдал 2017 тайлан






Монгол банкнаас жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгаанаас харахад 1-50 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж 62.5 хувь нь хариулжээ.

График 43: Мөрчнүүд банкнаас зээл авахад тулгардаг асуудал

ЗЭЭЛ АВАХ НӨХЦӨЛ ХАТУУ БАЙСАН ШАЛТГААН **ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ ХАНГААГҮЙ ШАЛТГААН**




Эх сурвалж: Монголбанк



Дээрх түүвэр судалгааны үр дүнгээс харахад зээлд хамрагдаж чадахгүй байгаа жижиг дунд бизнес эрхлэгчдийн хамгийн том хүндрэл нь барьцаа хөрөнгийн бэрхшээл байдаг аж. Худалдаа эрхлэгчид ихэвчлэн лангуу түрээслэн бараа материал борлуулдаг учир лангуу түрээсийн гэрээ болон борлуулж буй бараа материалыг банкууд зээлийн барьцаа болгодоггүй байна.

Төгрөг-АТМ

Энэ салбарт банк болон банк бус санхүүгийн байгууллагаас гадна өдрийн зээл олгодог "Төгрөг-АТМ" буюу "Т-АТМ" нэртэй иргэний үнэмлэх, хурууны хээ уншуулан зээл олгодог үйлчилгээ зах худалдааны төвүүдэд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна. Нарантуул, Хархорин захуудад долоо хоногийн 10 хувь, 14 хоногийн 20 хувь, 21 хоногийн 30 хувийн хүүтэй зээл олгодог ба тухайн худалдаа эрхлэгчийн борлуулж буй бараа бүтээгдэхүүн зэргийг барьцаалбар болгон авдаг энэ төрлийн мөнгө зээлдүүлэгчид тус салбарын хамгийн том асуудал болоод байна.

Монголын Худалдаачдын Холбооноос авсан мэдээллээр албан бус 300 гаруй мянган худалдаа эрхлэгчдийн 70 гаруй хувь нь яаралтай бэлэн мөнгөний хэрэгцээ үүсэхэд өдрийн зээл авдаг тухай дурдсан ба ямар нэг татвар, бүртгэл мэдээллийн системээс гадуур хийгддэг энэ төрлийн үйлчилгээ нь маш том өрийн





сүлжээ үүсгэж, улмаар өндөр хүүний дарамтад худалдаа эрхлэгчдийг оруулдаг тухай дурдсан болно.


Өдрийн зээл олгодог хувь хүмүүс нь худалдаа эрхлэгчдэд байдаг яаралтай, бага хэмжээний, богино хугацаатай бэлэн мөнгөний эрэлт хэрэгцээнд үндэслэн өндөр хүүтэй, торгуультай, ил тод бус зээл олгодог гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна. Мерчантын салбарт тулгамдаж буй эдгээр асуудлуудыг шийдвэрлэж, ил тод, бүртгэлтэй, сахилга баттай, таатай нөхцөлтэй бүтээгдэхүүн үйлчилгээ энэ салбарт нэн шаардлагатай байна..

Сэндли ББСБ компанийн шийдэл

Сэндли ББСБ компани нь худалдаа эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн технологийн шийдэлд суурилсан, таатай нөхцөлтэй мерчантын зээл олгож эхэлснээр энэ салбарт тулгамдаад байгаа ил тод бус байдал болон өндөр хүүний дарамтыг бууруулахад хувь нэмэр оруулж эхлээд байна.


Гар утас ашиглан цахимаар зээл авах боломж нь харилцагч өөрийн боломжит зээлийн нөхцөл, үлдэгдэл, эргэн төлөлтөө хянах боломж олгохоос гадна харилцагч санхүүгийн сахилга баттай байх, нөгөө талаас хүмүүс хооронд хийгддэг байсан бүртгэлгүй зээлийг ил тод болгон бүртгэлжүүлж буй нь банк санхүүгийн салбарт хийж буй томоохон шийдэл болж байгаа юм.

Мөн Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани болох Хай Пэймэнт Солюшнс ХХК-ийн Hi Pay төлбөр тооцооны шийдлээр дамжуулан худалдаа эрхлэгчид төлбөр тооцоогоо хийх, гадаад мөнгөн гуйвуулга хийх зэрэг нэмэлт үйлчилгээнүүдэд холбогдох боломжийг олгож байна.



Сэндли ББСБ нь мерчантын зээл олгохдоо худалдаа үйлчилгээ эрхлэгчийн лангууны түрээслэгч гэдгийг нотлох гэрээ, бизнесийн орлого нотлох, зээлийн сангийн мэдээлэл зэрэгт үндэслэн зээлийн эрхийг тооцдог байна. Мөн Улаанбаатар хотод 6 салбар, хөдөө орон нутагт байрлах 48 салбараар дамжуулан худалдаа үйлчилгээ эрхэлж буй төлбөрийн чадвартай, байнгын бизнесийн орлоготой мерчантуудад хүрч байна. Сэндли ББСБ компани үйлчилгээ үзүүлдэг салбар нэгжийн тоогоороо банк бус санхүүгийн байгууллагын салбартаа эхэнд ордог бол санхүүгийн байгууллага дундаа Хаан банк болон Төрийн банкны дараа ордог байна.





Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамнаас хийсэн “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага” MNS 5021-1:2019³ стандартын 4 дүгээрт заасан нэр томъёоны төрлөөр үйл ажиллагаа явуулж буй жижиглэн худалдааны газруудын тоог судалж үзэхэд 15,763 гарсан байна.

Хүснэгт 20: Жижиглэн худалдааны газруудын тоо /2020 он/

№	Ангилал	Дэлгүүрийн төрөл	Хүчин чадлын хэмжээ м.кв		Нийт
			Улаанбаатар	Аймагт	
1.	Том	Хайпермаркет	33	10	43
2.	Дунд	Супермаркет	142	175	317
3.	Багавтар	Минимаркет	670	574	1244
4.		Ая тухтай дэлгүүр	84	70	154
5.		Хүнсний дэлгүүр	3,638	6,332	9,970
6.	Бага	ШТС-ын дэргэдэх дэлгүүр	30	69	99
7.		Мухлаг	1,669	82	2,251
8.	Хүнсний бус худалдаа	Төрөлжсөн барааны дэлгүүр	520	1,048	1568
9.		Аутлет	30	3	63
10.		Бутик	53	1	54
Нийт			6,899	8,864	15,763



Эх сурвалж: ХХААХҮЯ

Хүснэгт 21: Худалдааны газрын ангилал /2020 он/

№	Ангилал	Дэлгүүрийн төрөл	Хүчин чадлын хэмжээ м.кв		Нийт
			Улаанбаатар	Аймагт	
1.	Бөөний худалдаа	Бөөний худалдааны төв	18	129	147
2.		Агуулах дэлгүүр	12	22	34
Нийт			30	151	181
3.	Ерөнхий нэршил	Зах /хүнсний лангуу/	22/6650	39/3410	61/9960
4.		Худалдааны төв	81	69	150
Нийт			103/6550	108/3410	211/9960

³ ХХААХҮЯ: <https://mofa.gov.mn/exp/blog/10/181>





5.	Их дэлгүүр		3	6	9
6.	Дэлгүүрийн төрөл	Үйлдвэрийн нэрийн дэлгүүр	15	54	69
7.		Хуучин барааны дэлгүүр	74	178	252
		Нийт	92	238	330
8.		Авто чингэлэг	397	149	546
9.		Автомат	2	1	3
10.	Дэлгүүрийн бус	Цахим	-	11	11
11.	худалдаа	Шууд	-	8	8
12.		Үүргийн	-	9	9
13.		ТҮЦ	1091	22	1113
		Нийт	1490	200	1690
14.	Худалдааны агуулах	Худалдааны агуулах	59	48	107
15.		Төрөлжсөн агуулах	41	51	92
		Нийт	100	99	199
16.	Ил задгай хүнсний худалдаа		129	35	164
	Бүгд дүн /16 чиглэлээр/		1944/6550	831/3410	2775/9960

Эх сурвалж: ХХААХҮЯ

Дээрх тоон үзүүлэлтээс харахад Сэндли ББСБ компанийн мерчантын зээлийн үйлчилгээ үзүүлэх боломжит зах зээлд зах худалдааны төв, хуучин барааны дэлгүүр, түргэн үйлчилгээний цэг, ил задгай хүнсний худалдаа, минимаркет, мухлаг, хүнсний жижиг дэлгүүрүүдийг оруулан тооцож болохоор байна. Мөн зах худалдааны төвийн лангуу түрээслэгчдийн тоог гаргаж ирэх зорилгоор "Монголын Худалдаа Эрхлэгчдийн Холбоо"-ноос тодруулахад дараах үр дүн гарав.


Хүснэгт 22: Худалдаа үйлчилгээний төвийн түрээслэгчдийн тоо⁴

№	Худалдаа, үйлчилгээний томоохон төвүүд	Худалдаа эрхлэгч, түрээслэгчдийн тоо /албан бус/
Чингэлтэй дүүрэг		
1.	"Бөмбөгөр-1" худалдааны төв	2,400
2.	"Бөмбөгөр-2", "Содон" худалдааны төв	4,000
3.	"Алтжин бөмбөгөр" худалдааны төв	3,800
4.	"Шонхор зах"	2,100
5.	"Нарантуул-2" худалдааны төв	1,800
Баянзүрх дүүрэг		
6.	"Нарантуул" худалдааны төв	10,000

⁴ www.facebook.com/Монголын-Худалдаачдын-Холбоо



3



7. "Өгөөмөр" техникийн зах

8. Шөнийн зах

9. "Дүнжингарав" худалдааны төв

3,400

10. "Сандэй плаза" худалдааны төв

4,200

11. "Баянзүрх" худалдааны төв/хойд/

500

Сүхбаатар дүүрэг

12. 100 айл орчмын барилгын материалын бүх дэлгүүр

4,000

13. "Меркури" худалдааны төв

Баянгол дүүрэг

14. "Барс" худалдааны төв

1,800

15. "Хар хорин" худалдааны төв

6,200

Хан-Уул дүүрэг

16. "Мишээл экспо" худалдааны төв

1,100

Нийт

45,300

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мерчантуудын тоо⁵

17. 18 аймагт хийсэн судалгаа

52,000

Улсын хэмжээнд нийт

97,300

Эх сурвалж: Монголын Худалдаачдын Холбоо

Мерчантын зээл олгох боломжтой томоохон худалдааны төвүүдийн лангуу түрээслэгч, худалдаа эрхлэгчийн тоо 45,300 гарч байна. Мөн Сэндли ББСБ компаниас хийсэн зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад 18 аймагт 52,000 орчим мерчантууд байгаа гэсэн үр дүн гарчээ.

Сэндли ББСБ компанийн зүгээс мерчантын зээл олгох боломжит зах зээл нь эдгээр жижиг дунд бизнес эрхлэгчид болон лангуу түрээсэлдэг худалдаа эрхлэгчид байх боломжтой.

Мерчантын зээлийн зах зээлийн багтаамж


Мерчантын зах зээлийг судалж үзэхэд жижиг дунд бизнес эрхлэгчид, зах худалдааны төвийн лангуу түрээслэгчид, худалдаа эрхлэгчдийн тоо албан бусаар Улаанбаатар хотын лангуу түрээсэлдэг томоохон худалдааны төвүүдэд 45,300 орчим, хөдөө орон нутагт 52,000 орчим гарч байна. Эдгээр худалдаа эрхлэгчдэд сард дунджаар 1 сая төгрөгийн мерчантын зээл олгоно гэж үзэхэд, Улаанбаатар хотын томоохон худалдааны төвүүдэд 543 тэрбум төгрөг, орон нутагт 624 тэрбум төгрөг буюу нийт 1.2 их наяд төгрөгийн зах зээл байхаар харагдаж байна.

⁵ Сэндли ББСБ компанийн зах зээлийн судалгааны үр дүн






Зураг 8: Мерчантын зээлийн хэрэгцээ, зах зээл



Эх сурвалж: Андеррайтерийн зураглал

Одоогоор Сэндли ББСБ компанийн хувьд Улаанбаатар хотын нийт боломжит зах зээл болох 45,300 хэрэглэгчийн 10 орчим хувьд буюу 4,348 харилцагчид мерчантын зээл олгоод байгаа ба 2023 онд Улаанбаатар хотын боломжит зах зээлийн 20 хувьд хүрнэ гэж үзвэл 8,900 орчим мерчантын харилцагчтай болохоор байна.


График 44: Сэндли ББСБ компанийн мерчантын зээл авах боломжит зах зээл





Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Хэрэглээний зээл, багтаамж

Хэрэглээний зээлийн тооцооллыг хийхдээ 2021 оны цалин хөлс, ажил эрхлэлт болон финтек зээлийн дундаж үзүүлэлт зэргийг ашиглан зах зээлийн багтаамжийг тооцоолов.





Хүн амын насны бүлгээрх ангилал

Сэндли ББСБ -ийн зээлийн бүтээгдэхүүн хэрэглэгчдийг насны бүлгээр авч үзвэл 20-39 насныхан дийлэнх хувийг эзэлдэг. Цаашид тус компани нь энэ сегментэд хамаарах насны иргэдэд үйлчилгээ хүргэхээр зорьж байна. Эдгээр зорилтот насны бүлгийн хүн амын тоо улсын хэмжээнд 1,066,742 буюу нийт хүн амын 31.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 23: Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Ажиллах хүч (мян.хүн)	1,357.4	1,358.6	1,273.9	1,250.6	1,226.5
Ажиллагчид (мян.хүн)	1,238.3	1,253.0	1,146.2	1,162.9	1,127.1
Ажилгүй иргэд (мян.хүн)	119.1	105.6	127.7	87.7	99.3
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам (мян.хүн)	863.0	868.0	832.2	877.5	878.1
Ажиллах хүчний оролцооны түвшин (%)	61.1	61.0	60.5	57.0	58.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (%)	55.8	56.3	54.4	54.6	53.6
Ажилгүйдлийн түвшин (%)	8.8	7.8	10.0	7.0	8.1

Эх сурвалж: 1212.mn

2021 оны байдлаар Монгол улсын нийт ажиллах хүчний хэмжээ 1.2 сая, нийт ажиллагсдын тоо 1.1 сая байна. Сэндли ББСБ-н зүгээс нийт хөдөлмөр эрхлэгч 1.1 сая иргэдэд Sendly аппликейшнээр дамжуулан хэрэглээний зээлийн үйлчилгээг хүргэхээр төлөвлөж байна.


График 45: Улсын дундаж цалин

УЛСЫН ДУНДАЖ ЦАЛИН



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотод дундаж цалин хамгийн өндөр буюу 1.5 сая төгрөг, баруун бүсэд хамгийн бага буюу 1.0 сая төгрөг, улсын дундаж цалин 1.4 сая төгрөг байна.



Финтексийн зээлийн үлдэгдэл

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2021 оны тоон мэдээллээр Монгол улсад финтекээр зээлийн үйлчилгээ авсан 1.35 сая иргэн байгаа ба дунджаар нэг иргэн 228.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Үүнээс хэрэглээний зээлийг тооцоход:

Үндэсний статистикийн хорооноос гаргасан цалин хөлсний улсын дундаж дүнтэй харьцуулбал иргэд орлогынхоо 16 хувийг сар бүр цахим зээлийн төлбөрт зориулж, жилд 2.1 сая төгрөгийн зээл авч ашиглаж байна. Дээрх дүнг Хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тоо, Үндэсний статистикийн хорооноос гаргасан цалин хөлсний улсын дундаж статистик мэдээлэлтэй харьцуулах замаар цахим зээлийн зах зээлийн багтаамжийг тооцвол 2.3 их наяд төгрөг байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт хөдөлмөр эрхлэгчдийн тоо 1.1 сая хүн байна. Нэг иргэний сарын дундаж финтек зээлийн хэмжээ 228.0 мянган төгрөг гэж тооцоход сард 256.9 тэрбум төгрөг буюу жилийн 3.0 их наяд төгрөгийн зах зээлийн багтаамжтай байна.

2.2.4 НИЙТ ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ

Сэндли ББСБ-ын үйлчилгээ явуулж буй дараах үндсэн 3 сегментээр ангилан зах зээлийн багтаамжийг тооцооллоо.

- Мөнгөн гуйвуулга
- Хэрэглээний зээл
- Мерчантын зээл

Хүснэгт 24: Сэндли ББСБ-ийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нийт багтаамж

Боломжит нийт зах зээлийн багтаамж	Дүн /төгрөг/
Мөнгөн гуйвуулгын зах зээл	1.1 их наяд
Мерчантын зээлийн зах зээл	1.2 их наяд
Хэрэглээний зээлийн зах зээл	3.0 их наяд
Нийт боломжит зах зээл	5.3 их наяд

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Хэрэв Сэндли ББСБ нь дотоодын мөнгөн гуйвуулгын зах зээлийн 50 хувь, мерчантын зах зээлийн 20 хувь, хэрэглээний зээлийн зах зээлийн 5 хувийг эзлэх юм бол дараах үр дүн гарч байна.





Сэндли ББСБ ХХК - Үнэт цаасны танилцуулга



Хүснэгт 25. Сэндли ББСБ-ийн зорилтот зах зээлийн нийт багтаамж

Зорилтот зах зээлийн багтаамж	Дүн /төгрөг/
Мөнгөн гуйвуулгын зах зээл	550 тэрбум
Мерчантын зээлийн зах зээл	240 тэрбум
Хэрэглээний зээлийн зах зээл	150 тэрбум
Нийт боломжит зах зээл	940 тэрбум

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад Сэндли ББСБ үйл ажиллагаа явуулж буй мөнгөн гүйлгээ, мерчант болон хэрэглээний зээлийн зах зээлийн нийт багтаамж 5.3 их наяд төгрөг байна. Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, санхүүгийн нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогоос хамаарч боломжит нийт зах зээлд эзлэх орон зай тодорхойлогдох болно.






2.3 ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

2.3.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨРСӨЛДӨГЧИД

2021 оны эцсийн байдлаар мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөлтэй 36 ББСБ, онлайн зээлийн үйлчилгээ эрхэлдэг 36 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Онлайн зээлийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ-уудыг дотор нь ангилж үзвэл зөвхөн онлайн зээлийн үйлчилгээ үзүүлдэг 11 ББСБ, онлайн болон уламжлалт зээлийн үйлчилгээг хослуулан хүргэдэг 17 ББСБ байна. Мөн эдгээр компаниуд дээр нэмэгдэн 8 ББСБ зах зээлд шинээр нэвтэрхээр хөгжүүлэлтийн шатанд явж байна.


Зураг 9: Финтекийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн матриц



Эх сурвалж: App store, Play store, 2022 оны 5 дугаар сарын байдлаар

Дээрх зураглалд финтек үйлчилгээ үзүүлэгчдийг аппликейшний татан авалт, шимтгэлийн хувь, үйлчилгээний төрөл зэргээр нь харьцуулан үзүүллээ. Энэхүү харьцуулалтаас дүгнэхэд Сэндли ББСБ нь дан ганц мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлээд зогсохгүй Нирау аппликейшнтэй синержи үүсгэснээр мөнгөн гуйвуулга, зээлийн үйлчилгээг хослуулан хүргэдэг цор ганц ББСБ болж байна. Гуйвуулгын шимтгэлийн хувь, татан авалтаараа бусад аппликейшнтэй өрсөлдөхүйц байна.





Хүснэгт 26. Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-уудад олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчид

Тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	Нийт ББСБ	Сэндли	Лэнд.мн	Ард	Инвескор
Зээл	496	✓	✓	✓	✓
Факторингийн үйлчилгээ	40	✓	✓		✓
Төлбөрийн баталгаа гаргах	24	✓			✓
Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5		✓		
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	36	✓	✓	✓	
Гадаад валютын арилжаа	146	✓	✓	✓	
Итгэлцлийн үйлчилгээ	49	✓	✓	✓	✓
Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	20			✓	✓
Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	40		✓	✓	✓

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаас гаргагч нь харилцагчдад цахимаар зээлийн эрх олгохоос гадна салбар нэгжээс уламжлалт байдлаар зээл авсан харилцагчийн зээлийн үлдэгдлийг аппликейшнд харуулах, аппликейшн ашиглаж зээлээ төлөх, хянах боломжийг хангасан. Мөн зээлийн эргэн төлөлтийг харилцагчийн арилжааны банкны картаас автомат таталт хийж болдгоороо бусад ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-аас маш онцлогтой юм.

Финтекийн салбарт дээрх 36 ББСБ-аас гадна арилжааны 12 банк, 2 оператор компани үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс МХБ-д бүртгэлтэй ЛэндМН ББСБ, Ард Кредит ББСБ, Инвескор ББСБ нар финтек салбартаа тэргүүлж байна. Эдгээр ББСБ-уудтай харьцуулбал Сэндли ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээг технологийн шийдэлтэй хослуулан зах зээлд нэвтрүүлснээрээ онцлогтой.



Хүснэгт 27: Үйлчилгээний харьцуулсан үзүүлэлт

Үйлчилгээ	Сэндли	ЛэндМН	Покет	Ард	Симпл	Сторпэй	СэндМН
Зээл олгох	✓	✓	✓	✓	✓		✓
Шилжүүлэг хийх	✓	✓	✓	✓	✓		✓
Цахим мөнгөний үйлчилгээ		✓	✓	✓			
Оноо цуглуулах	✓	✓	✓			✓	
Төлбөр тооцоо хийх	✓	✓	✓	✓		✓	
Онлайн худалдаа	✓	✓	✓	✓		✓	
Гадаад мөнгөн гуйвуулга	✓						✓
Картын төлбөрийн систем							✓
Харилцагчийн тоо / App таталт	13,000+	1,000,000+	500,000+	500,000+	100,000+	100,000+	10,000+

Эх сурвалж: app store, play store

Хүснэгт 28: ББСБ-уудын орон нутаг дахь тархац





Аймаг	ББСБ-ын тоо	Сэндли ББСБ	Лөнд.мн	Ард	Инвескор
Архангай аймаг	3	1	-	-	-
Баян-Өлгий аймаг	7	1	-	-	-
Баянхонгор аймаг	8	1	-	-	-
Булган аймаг	2	1	-	-	-
Говь-Алтай аймаг	1	-	-	-	-
Говьсүмбэр аймаг	4	1	-	-	-
Дархан-Уул аймаг	18	1	-	-	-
Дорноговь аймаг	8	1	-	-	-
Дорнод аймаг	13	1	-	-	-
Дундговь аймаг	4	1	-	-	-
Завхан аймаг	3	1	-	-	-
Орхон аймаг	20	1	-	-	1
Өвөрхангай аймаг	15	1	-	-	-
Өмнөговь аймаг	12	1	-	-	-
Сүхбаатар аймаг	8	1	-	-	-
Сэлэнгэ аймаг	11	1	-	-	-
Төв аймаг	18	1	-	-	-
Увс аймаг	7	1	-	-	-
Ховд аймаг	4	-	-	-	-
Хөвсгөл аймаг	8	-	-	-	-
Хэнтий аймаг	7	1	-	-	-
Дүн	181	18	-	-	1



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монгол улсын 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт 181 ББСБ байгаа бөгөөд, үүнээс Орхон аймагт хамгийн олон, харин Говь-Алтай аймагт хамгийн цөөн ББСБ-ын салбар нэгж байдаг байна. Одоогийн байдлаар Сэндли ББСБ нь нийт 18 аймагт өөрийн салбар нэгжийг байгуулаад байна.

2.3.2 МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ӨРСӨЛДӨГЧИД

Олон улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг идэвхтэй үзүүлэгч байгууллагуудыг үйлчилгээний нөхцөлөөр нь харьцуулав.

Компанийн нэр	Улсууд	Валют	Шимтгэл	Байгуулагдсан он	Байршил
Moneygram	Дэлхийн 200 гаруй оронд байрлах 347,000 салбар нэгжүүдээс мөнгө гуйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой	50+	- Тухайн улсаас хамааран 2 хүртэл хувийн шимтгэлтэй	1980 он	АНУ, Техас муж
Western Union	Дэлхийн 200 гаруй орон руу мөнгө гуйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой	170+	- Тухайн улсаас хамааран 1-2 хувийн шимтгэлтэй	1851 он	АНУ, Колорадо муж
Swift	Дэлхийн 200 гаруй оронд байрлах 11,000 салбар нэгжүүдээс мөнгө гуйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой	200+	- Тухайн улсаас хамааран 0.1-1.5 хувийн шимтгэлтэй	1973 он	Белги улс, Ла Холпи муж
SendMN	Бэлнээр дэлхийн 170 гаруй орон, Онлайнаар Австрали, Япон,	10+	- Тухайн улсаас хамааран 0.1-	2016 он	Монгол улс,



	Солонгос зээлэг ази ниймхон далайн бүсийн 11 орон дээр нь Пакистан, Орос, Турк зэрэг улсууд		1.5 хувийн шимтгэлтэй		
Public Credit	Дэлхийн 160 гаруй улсын 400.000 гаруй салбар нэгжээр дамжуулан бэлнээр мөнгө шилжүүлэх боломжтой.	4	1.5-2.5%	2016 он	Монгол улс, Улаанбаатар хот
Хувь хүн	Бэлэн, Онлайн аль аль нь болно.	-	Нэгдсэн нэг шимтгэлийн дүн гэж байхгүй, шимтгэл багатай ч ханш өндрөөр бодогддог.	-	-

Олон улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ идэвхтэй үзүүлдэг байгууллагуудыг авч үзвэл:

- Хамгийн их улс руу шилжүүлдэг байгууллага: MoneyGram, Western Union, Swift
- Хамгийн олон валютын төрлөөр гүйлгээ хийдэг байгууллага: Western Union
- Хамгийн их хэрэглэгчтэй байгууллага: MoneyGram, Western Union
- Шууд гүйлгээ буцаадаг байгууллага: MoneyGram, Western Union, Finablr





Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний процессын зураглал

Хувь хүнээр дамжуулах мөнгөн гуйвуулга:

Хувь хүнээр дамжин хийгдэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хамгийн анхны олон улсын мөнгөн гуйвуулга хийх арга гэж хэлж болох ба зөвхөн итгэлцэл дээр явагддаг хуулийн зохицуулалтгүй гуйвуулгын үйлчилгээ юм. Энэ төрлийн гуйвуулгад дамжуулж байгаа хувь хүн нь гуйвуулгын шимтгэл, валютын ханш, хугацаа зэргийг өөрийн ашиг сонирхолд тохируулан тогтоодог сул талтай.



Банкаар дамжуулах мөнгөн гуйвуулгын зураглал:


SWIFT олон улсын мөнгөн гуйвуулгын системийг ашиглан гүйлгээг дамжуулдаг хамгийн найдвартай хууль ёсны арга юм. Зөвхөн харилцагч банкуудаар дамжуулан гүйлгээ хийгддэг тул харилцагч биш банк руу гүйлгээ шилжүүлсэн тохиолдолд дамжуулагч банкиг оролцуулдаг байна. Шилжүүлэгт оролцож буй бүх банк үйлчилгээнийхээ шимтгэлийг авдаг тул шимтгэлийн зардал хамгийн өндөр байдаг.






Sendly аппликейшний мөнгөн гуйвуулгын зураглал:

Олон улсын мөнгөн гуйвуулга хийх тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу авсан байгууллагуудаар дамжуулан хийгддэг албан ёсны үйлчилгээ юм. Шимтгэл бага, хурдан шуурхай найдвартай үйлчилгээг харилцагчдад санал болгодог.





Сэндли ББСБ-ын одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор дараах SWOT шинжилгээ хийлээ.

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - Хамгийн олон салбар нэгж: Сэндли ББСБ нь Улаанбаатар хотод 6, орон нутагт 48 салбартай. Монголын хамгийн олон салбартай ББСБ юм. - Анхдагч ББСБ: Мөнгөн гуйвуулга хийх улс орнуудын зохицуулагч байгууллагаас "Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл" авч финтек технологи ашиглан Монгол Улсад үйлчилгээ үзүүлж буй анхдагч ББСБ юм. - Анхдагч үйлчилгээ: Хилийн чандад байгаа Монгол иргэдэд орон сууцны зээлийн үйлчилгээ, үнэт цаасны арилжаанд орох, сайн дурын нийгмийн даатгал, онлайн худалдаа гэх мэт нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан үйлчилгээг аппликейшнээр дамжуулан хүргэдэг анхны ББСБ юм. - Экосистем: Хай Пэймент Солюшн ХХК, Радикс технологи ХХК-тай хамтран өөрсдийн бизнес модель, зээлийн коре системдээ тулгуурлан Сэндли экосистемийг бүрдүүлж байна. - Токен сервис: Гадаадын банкны данс болон картын мэдээллийг Sendly аппликейшн дээр тодорхой хугацаанд сануулж болох тул гүйлгээ хийх тоолонд картын мэдээлэл оруулах шаардлагагүй. - Аюулгүй байдал: Картын төлбөрийг аюулгүй дамжуулах (PCI DSS) олон улсын стандартыг хангасан. - Синержи: Sendly аппликейшнээр HiPay дансаа цэнэглэн аппликейшн доторх үйлчилгээг авах боломжтой. - Найдвартай: Олон улсын стандартыг хангасан найдвартай, албан ёсны мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгодог. - WeChat-тай хамтардаг: WeChat-тай интеграц хийгдэж Монголын финтек компаниудад төлбөрийн шийдлийг нэвтрүүлсэн. - ACH: Зээл олголтыг тухайн хэрэглэгчийн хүссэн банкны дансруу HiPay системээр дамжуулан Монгол банкны ACH-р шууд хийж гүйцэтгэдэг. - Автомат таталттай: HiPay-ийн карт хүлээн авах зөвшөөрөл, карт хадгалах токен сервис үйлчилгээг ашиглан зээлдэгчийн 	<ul style="list-style-type: none"> - Танигдаж эхэлж байгаа: Зах зээлд шинээр нэвтэрч буй тул хэрэглэгчдэд бүрэн танигдаагүй. - Шинэ үйлчилгээ нэвтрүүлэх хугацаа: Шинэ үйлчилгээгээ хэрэглэгчдэд таниулахад хугацаа их зарцуулдаг. - Шаардлага өндөр: Харилцагчийг таньж мэдэх стандарт нь шат дараалсан хяналттай тул шинэ харилцагчид тавигдах шаардлага өндөр. - Цаг хугацаа: Үйлчилгээгээ шинээр нэвтрүүлж буй улсуудын зохицуулагч байгууллагын дүрэм стандартаас шалтгаалж тусгай зөвшөөрлийг авахад цаг хугацаа, зардал их зарцуулдаг. - Иргэдийн технологийн чадавх: нийт зээлийн багцын дийлэнх хувийг эзэлдэг орон нутгийн зээлдэгч нар нь ухаалаг утас, шинэ технологийг хэрэглэх чадвар сул байдгаас зээл олгох, зээлийн эргэн төлөх үйл ажиллагаанд ажилтнууд цаг их зарцуулдаг.



Сэндли ББСБ ХХК - Үнэт цаасны танилцуулга



<p>Эргэн төлөлтийг автоматаар буюу recurring payment-ээр төлдөг.</p> <ul style="list-style-type: none"> - Чанаргүй зээлийн багц: Эргэн төлөлтийг автоматжуулснаар чанаргүй зээлийн багц 2021 оны жилийн эцсээр 0.1 хувь буюу салбарын дунджаас 7 дахин бага. 	
<p>Аюул</p> <ul style="list-style-type: none"> - Өрсөлдөөн их: Финтекийн салбар хурдацтай хөгжиж байгаа учир дотоод өрсөлдөөн их. - Хууль эрх зүй: Шинээр мөрдөгдөх СЗХ-ны "ББСБ-ын зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу Финтек ББСБ-уудад тавигдах шаардлага өндөр болсон - Тогтворгүй байдал: Хэрэв Монгол улс дахин саарал жагсаалтад орох тохиолдолд өөр улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг шинээр нэвтрүүлэхэд хязгаарлалтад орох эрсдэлтэй. - Давагдашгүй хүчин зүйлс: Цар тахал, байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойгүй нөхцөл байдал болсон тохиолдолд зээлийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй. - Эдийн засаг удаашрах: Монгол улсын 2022 оны ДНБ өсөлтийн төсөөллийг Олон улсын валютын сангаас 1 хувь, Дэлхийн банкнаас 2.5 хувь болгож бууруулсан бөгөөд эдийн засаг өсөлт удаашрах хүлээлттэй байна. 	<p>Боломж</p> <ul style="list-style-type: none"> - Тэргүүлэх: Сэндли ББСБ нь Хөгжингүй орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, компаниудтай хамтран ажилласнаар компанид шинэ инновац нэвтрүүлж салбартаа тэргүүлэх боломжтой. - UnionPay: UnionPay картын системийг ашиглан тухайн сүлжээ нэвтэрсэн бүх улс, оронд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх боломжтой. - Шинэ бүтээгдэхүүн: Мөнгөн гуйвуулга нэвтэрсэн улс орнуудад ажиллаж амьдарч байгаа Монгол улсын иргэдэд шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломжтой. - Зардлыг бууруулах: Орон нутгийн 48 салбараар дамжуулан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлыг бууруулах боломжтой.

Хүснэгт 29: Санхүүгийн тайлангийн төсөөлөл

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН					
Сая төгрөг	2022E	2023E	2024E	2025E	2026E
Эргэлтийн хөрөнгө					
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,611.6	26.8	4,941.2	9,070.4	23,638.5
Нийт зээл	31,101.5	53,595.5	69,334.8	80,588.4	87,356.3
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	131.4	2,029.5	2,606.2	2,982.7	3,050.9
Бусад актив	31.5	487.1	625.5	715.8	732.2
Эргэлтийн хөрөнгийн дүн	33,563.0	52,756.1	71,698.1	84,943.6	103,858.4
Эргэлтийн бус хөрөнгө					
Барилга, байгууламж	0.0	0.0	0.0	0.0	0.0
Компьютер, тоног төхөөрөмж	137.4	161.8	133.3	60.9	78.6
Тавилга, эд хогшил	101.4	122.4	119.7	103.4	87.1
Биет бус хөрөнгө	40.9	40.9	40.9	40.9	40.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	279.7	325.1	293.9	205.2	206.6
НИЙТ ХӨРӨНГӨ	33,842.7	53,081.3	71,992.0	85,148.7	104,065.0
Өр төлбөр					
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	1,058.2	8,058.2	13,058.2	8,058.2	8,058.2
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	4,700.0	3,700.0	700.0	(1,300.0)	(1,300.0)
Мөнгөн гуйвуулгын өглөг	5,002.8	6,609.4	8,643.1	10,676.8	10,676.8
Бусад пассив	24.7	385.7	463.4	465.8	468.2
Өр төлбөрийн дүн	10,785.7	18,753.4	22,864.7	17,900.8	17,903.2
Эздийн өмч					
Энгийн хувьцаа	17,428.5	17,428.5	17,428.5	17,428.5	17,428.5
Тайлант үеийн ашиг (алдагдал)	4,896.5	11,271.0	14,799.4	18,120.6	18,913.9
Хуримтлагдсан ашиг (алдагдал) эхний үлдэгдэл	731.9	5,628.4	16,899.4	31,698.8	49,819.4
Хуримтлагдсан ашиг (алдагдал) эцсийн үлдэгдэл	5,628.4	16,899.4	31,698.8	49,819.4	68,733.3
Эздийн өмчийн дүн	23,056.9	34,327.9	49,127.3	67,247.9	86,161.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧ	33,842.7	53,081.3	71,992.0	85,148.7	104,065.0

Эх сурвалж: Сэндли ББСБ

Сэндли ББСБ 2021 оны эцсийн байдлаар нийт 10.6 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй байсан бол 2026 оны жилийн эцэс гэхэд нийт хөрөнгийн дүн 104.0 тэрбум төгрөгт хүрч 9.8 дахин өсөх төсөөлөлтэй байна. Компанийн үйл ажиллагаа тогтвортой өргөжсөөр 2026 он гэхэд эздийн өмчийн дүн 2021 онтой харьцуулахад 12.0 дахин нэмэгдсэн байх бөгөөд нийт хөрөнгийн 82.8 хувийг бүрдүүлэхээр байна.






График 46: Өр төлбөр болон эздийн өмчийн харьцааны төсөөлөл

ХӨРӨНГИЙН БҮТЭЦ



Эх сурвалж: Сэндли ББСБ

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ирэх 5 жилийн өр төлбөр болон эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ дээрх байдлаар төсөөлөгдөж байна. 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн бүтцээс харвал 67.4 хувийг эздийн өмч, 32.6 хувийг өр төлбөр эзэлж байна. Ирэх жилүүдэд нийт хөрөнгөд эзлэх эздийн өмчийн хэмжээ тухайн жилийн цэвэр ашгаар нэмэгдэн тасралтгүй өссөөр 2026 оны байдлаар 82.8 хувь хүрэхээр байна. Харин өр төлбөрийн хэмжээ 2024 оноос эхлэн буурч 17.2 хувь хүрэхээр төсөөлөгдсөн байна.


График 47: Нийт зээлийн багц /2022-2026/



Эх сурвалж: Сэндли ББСБ

Сэндли ББСБ-ийн зээлийн багц 2021 оны байдлаар 8.6 тэрбум төгрөг байсан ба нийт хөрөнгийн 81.1 хувийг эзэлж байна. Нийт зээлийн багц жил бүр дунджаар CAGR-29.5 хувиар өсч 2026 оны байдлаар 87.36 тэрбум төгрөгт хүрэх тооцоотой байна. Зээлийн багцын энэхүү өсөлт нь өнгөрсөн оны цэвэр ашиг болон бусад эх үүсвэрээр татсан санхүүжилтээр нэмэгдэх юм.





Хүснэгт 30: Орлогын тайлангийн төсөөлөл /2022-2026/


ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН					
Сая төгрөг	2022E	2023E	2024E	2025E	2026E
Зээлийн бүтээгдэхүүний орлого	11,407.0	24,354.1	31,274.0	35,792.4	36,611.1
Зээлийн бүтээгдэхүүний зардал	(3,294.1)	(4,951.4)	(6,241.6)	(6,236.2)	(5,716.1)
Зээлийн бүтээгдэхүүний цэвэр орлого	8,112.8	19,402.7	25,032.4	29,556.2	30,895.0
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого	1,135.8	2,450.1	3,416.5	4,382.9	4,382.9
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээтэй холбоотой шимтгэлийн зардал	(607.3)	(1,217.2)	(1,665.6)	(2,114.1)	(2,114.1)
Апп-ын зардал	(96.0)	(96.0)	(96.0)	(96.0)	(96.0)
Платформ ашигласны төлбөр	(76.9)	(76.9)	(76.9)	(76.9)	(76.9)
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний цэвэр орлого	355.6	1,060.0	1,577.9	2,095.9	2,095.9
Нийт цэвэр орлого	8,824.0	21,522.6	28,188.3	33,747.9	35,086.7
Үйл ажиллагааны зардал	(3,324.5)	(3,857.1)	(4,633.9)	(4,658.2)	(4,681.7)
EBITDA	5,499.5	17,665.5	23,554.4	29,089.7	30,405.0
Элэгдлийн зардал	(58.9)	(80.5)	(88.7)	(88.7)	(81.8)
EBIT	5,440.6	17,584.9	23,465.6	29,001.0	30,323.2
Хүүгийн зардал	-	-	-	-	-
Татварын өмнөх ашиг (алдагдал)	5,440.6	17,584.9	23,465.6	29,001.0	30,323.2
Татварын зардал	(499.9)	(3,206.2)	(4,571.9)	(5,826.3)	(6,156.8)
Цэвэр ашиг (алдагдал)	4,896.5	14,088.7	18,499.2	22,650.8	23,642.4

Эх сурвалж: Сэндли ББСБ

“Сэндли ББСБ ХХК”-ийн үйл ажиллагааны үндсэн орлого нь зээлийн үйлчилгээнээс олох орлого байх бөгөөд 2021 оны байдлаар нийт 1.7 тэрбум төгрөгийг зээлийн үйлчилгээнээс олсон бол 2026 оны жилийн эцсийн байдлаар энэ дүн 36.6 тэрбум төгрөгт хүрэхээр төсөөлсөн байна. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс олсон орлого 2021 оны эцэст 260.0 сая төгрөг байсан бол 2026 он гэхэд 4.4 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөжээ.


Үйл ажиллагааны зардлын хувьд 2022 оноос 2024 он хүртэл 3.4 тэрбум төгрөгөөс 4.6 тэрбум төгрөгт хүртэл өсч цаашид тогтворжих төлөвтэй байгаа нь финтек бизнесийн онцлог юм.

2022 оны байдлаар цэвэр ашиг 4.9 тэрбум төгрөг байхаар төсөөлөгдөж байгаа ба үнэт цаас гаргагчийн төсөөллөөр 2026 он хүртэл жилд дунджаар 48.2 хувиар өсч 23.6 тэрбум төгрөгт хүрэхээр байна.



Грасник 48: Нийт орлого болон цэвэр ашгийн төсөөлөл /2022-2026/

НИЙТ ЦЭВЭР ОРЛОГО/ЦЭВЭР АШИГ



Эх сурвалж: Сэндли ББСБ

Цэвэр ашиг 2021 оны байдлаар 0.6 тэрбум төгрөг буюу нийт орлогын 33.3 хувийг эзэлж байгаа бол 2026 оны байдлаар нийтдээ 35.1 тэрбум төгрөгийн орлого олж 23.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна. 2026 онд цэвэр ашгийн төвшин 67.2 хувьд хүрэхээр төлөвлөсөн байгаа нь технологи суурьтай бизнесийн тэлэлтийн үр нөлөө билээ.

Хүснэгт 31: Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл /2022-2026/

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН					
Сая төгрөг	2022E	2023E	2024E	2025E	2026E
Цэвэр ашиг	4,896.5	11,271.0	14,799.4	18,120.6	18,913.9
Элэгдлийн зардал (+)	58.9	80.5	88.7	88.7	81.8
Ажлын капиталын өөрчлөлт	(16,462.4)	(20,810.2)	(11,916.3)	(7,080.1)	(4,344.4)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(11,507.0)	(9,458.7)	2,971.8	11,129.2	14,651.3
Үндсэн хөрөнгө худалдаж авсан	(8.1)	(126.0)	(57.4)	-	(83.2)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(8.1)	(126.0)	(57.4)	-	(83.2)
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасан	4,700.0	5,000.0	2,000.0	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(100.0)	(6,000.0)	(5,000.0)	(2,000.0)	10,000.0
Итгэлцлийн үйлчилгээ гаргасан	1,058.2	10,000.0	15,000.0	10,000.0	-
Итгэлцлийн үйлчилгээний төлбөр төлсөн	(2,580.0)	(3,000.0)	(10,000.0)	(15,000.0)	(10,000.0)
Хувьцаа гаргасан	11,000.0	-	-	-	-
Бусад	Ү(120.9)	-	-	-	-



Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	13,957.3	6,000.0	2,000.0	(7,000.0)	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	2,442.2	(3,584.7)	4,914.3	4,129.2	14,568.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,611.6	26.8	4,941.2	9,070.4	23,638.5
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага/Хүүгийн орлого	8.3%	8.3%	8.3%	8.3%	8.3%
Бусад актив/Хүүгийн орлого	2.0%	2.0%	2.0%	2.0%	2.0%
Бусад пассив/Үйл ажиллагааны зардал	10.0%	10.0%	10.0%	10.0%	10.0%
Мөнгөн гуйвуулгын өглөг/Мөнгөн гуйвуулгын хэмжээ (тухайн сарын)	38.9%	38.9%	38.9%	38.9%	38.9%

Эх сурвалж: Сэндли ББСБ

Үнэт цаас гаргагч нь 2022 онд нэмэлт хувьцаа гаргах замаар олон нийтээс 10.05 тэрбум төгрөгийн санхүүжилт татан, зээлийн үйл ажиллагаандаа зарцуулахаар төлөвлөсөн байна. Мөн финтек бизнесийн тэлэлтэд зориулж 2022, 2023, 2024 онд зээл болон өрийн үнэт цаас гаргах байдлаар үйл ажиллагаагаа санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 32: Компанийн харилцагчдын тоо

Үзүүлэлт	2021A	2022E	2023E	2024E	2025E	2026E
Нийт харилцагчдын тоо	5,100	17,160	29,220	37,656	43,692	47,328
Зээлдэгчдийн тоо	3,966	12,538	21,111	27,105	31,398	33,988
Цахим зээлдэгчдийн тоо	2,700	11,300	19,800	25,700	30,000	32,500
Зээлийн багц /сая төгрөг/	8,607	31,101	53,595	69,334	80,588	87,356
Мөнгөн гуйвуулгын тоо	18,313	91,948	185,276	252,683	320,090	320,090
Мөнгөн гуйвуулгын хэмжээ /сая төгрөг/	17,513	97,149	203,700	266,377	329,054	329,054

Зээлдэгчдийн тоо



Сэндли ББСБ нь 2021 оны эцсийн байдлаар нийт 3.9 мянган зээлдэгчтэй байсан ба үүний 70 орчим хувь буюу 2.7 мянган харилцагч нь цахим зээлийн харилцагчид байсан байна. 2022 оны жилийн эцэс гэхэд нийт цахим зээлдэгчдийн тоо 11.3 мянгад хүрэхээр төсөөлсөн ба 2022 оноос цааш цахим зээлийн харилцагчдын тоо жилд дунджаар 30 орчим хувиар нэмэгдэхээр төсөөлжээ.

Зээлийн багцын хэмжээ

NiPay аппликэйшнээр дамжуулан Сэндли ББСБ-ын цахим зээлийн үйлчилгээг 2021 оны 4 дүгээр сараас зах зээлд нэвтрүүлсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн эрхтэй харилцагчдын 61.5 хувь нь зээл авсан бөгөөд тэдгээрийн дундаж зээлийн хэмжээ 4.3 сая төгрөг байсан байна.

Компани 2026 он гэхэд 105.6 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй болж өсөхөөр төсөөлж байгаа ба үүнээс 82.6 хувийг буюу 87.3 тэрбум төгрөг нь зээлийн багцыг





бүрдүүлэхээр тооцолж байна. Зээлийн багцын 98.2 хувийг цахим зээл үлдсэн 1.8 хувийг уламжлалт маягаар олгосон зээл эзлэхээр төлөвлөж байна. Компанийн зүгээс нийт хөрөнгийн 91 хувийг зээлийн багц дээр барьж ажиллахаар төлөвлөж байна.


Хүснэгт 33: Зохистой харьцааны үзүүлэлт

Зохистой харьцаа					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт					
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн нийт актив	72.8%	61.6%	63.6%	71.6%	81.7%
Өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн нийт актив	72.8%	61.6%	63.6%	71.6%	81.7%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө/Нийт актив	68.1%	64.7%	68.2%	79.0%	82.8%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар					
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	33.6%	0.1%	22.1%	52.0%	135.6%
Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт					
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	138.8%	131.6%	128.2%	126.3%	125.0%
Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд					
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	4.6%	23.5%	26.6%	12.0%	9.4%
Үндсэн хөрөнгийн үзүүлэлт					
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	0.7%	0.5%	0.4%	0.2%	0.2%
Өгөөж					
Хөрөнгө /актив/-ийн өгөөж	14.2%	32.4%	29.6%	28.8%	25.0%
Өөрийн хөрөнгийн өгөөж	20.7%	49.1%	44.3%	38.9%	30.8%

Эх сурвалж: Сэндли ББСБ

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөлд үндэслэсэн ББСБ-ын зохистой харьцааг 2022-2026 оны хооронд тооцоолоход өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, хөрөнгийн төвлөрлийн харьцаанууд хангалттай төвшинд байхаар харагдаж байна.






Өгөөж



График 49: Өгөөж


Өөрийн хөрөнгийн өгөөж болон нийт хөрөнгийн өгөөж харгалзан 2022 онд 21.2 хувь, 14.5 хувь байсан бол 2026 оны байдлаар 102.5 хувь, 69.9 хувь болохоор төлөвлөсөн байна. Үүнд технологи суурьтай финтек бизнесийн тэлэлт болон зардлын тогтворжилт хүчтэй нөлөөлөх юм..



Эх сурвалж: Сэндли ББСБ

Санхүүгийн хөшүүрэг


График 50: Санхүүгийн хөшүүрэг



Сэндли ББСБ-ийн нийт харилцагчдын тоо 2026 оны байдлаар 47,328 хүрэхээр төсөөлсөн байна. Энэ нь цахим мөнгөн гуйвуулга, зээлийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ ямар төвшинд байгааг илтгэж байна. 2022 оны байдлаар 22.6 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байгаа бол 33.4 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй үйл ажиллагаагаа явуулж байна. 2026 оны байдлаар 1.21-д хүрэхээр төсөөлсөн байна. Энд технологи суурьтай бизнесийн давуу тал гарах бөгөөд хөшүүрэг ашиглаж бизнесийн тэлэлт хийж байгаа ч зардал тогтвортой байх нь ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлөх юм

Эх сурвалж: Сэндли ББСБ






2.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны дунд хугацааны стратеги

Сэндли ББСБ хувьд олон нийтэд танигдаж эхэлж байгаа энэ үед салбарын амьдралын мөчлөгийг тодорхойлох замаар үйл ажиллагаа, маркетингийн стратегийг боловсруулан ажиллаж байна.

Салбарын амьдралын мөчлөг



Сэндли ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй салбарын амьдралын мөчлөгийг Хилл энд Жонесийн аргачлалыг ашиглан тодорхойлов. Тухайн аргачлалаар тодорхойлоход салбарын амьдралын мөчлөг өсөлттэй үе дээр байна. Мөнгөн гуйвуулга, зээлийн үйлчилгээ нь финтек рүү шилжиж байгаатай холбоотой олон улс, Монгол улсад маш хурдан салбартаа өсөлтийг үзүүлж байна. Салбарын өсөлттэй үед эрэлт хурдацтай нэмэгдэж, ашигт ажиллагаа нэмэгдэж, үнэ буурч, салбар компаниудын харьцангуй бага өрсөлдөөнөөр тодорхойлогдоно. Салбарт шинэ өрсөлдөгч орж ирэхэд харьцангуй амархан байдаг.





Эх сурвалж: Зураг 2.4, Хилл энд Жонес (2008)

Сэндли ББСБ хувьд салбарын өсөлттэй байгаа үед дараах стратегийг баримталж ажиллаж байна.

- Монгол улсын иргэд хамгийн их оршин суудаг бүс нутгуудад мөнгөн гүйлгээний үйлчилгээгээ нэвтрүүлэх.





- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний зах зээлийн хувь хэмжээгээ нэмэгдүүлэхийн тулд хэрэглэгчийн санхүүгийн боловсролыг сайжруулах, хэрэглэгчдэд танигдах үйл ажиллагааг тогтмол хийх.
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж зах зээлийн шинэ сегментэд нэвтрэх.
- Эрэлт, ашгийн тогтвортой байлгахын тулд шимтгэл, хүүгийн зохистой хэмжээг барьж ажиллах.

Олон улсын мөнгөн гуйвуулга

Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь гадаад улсад сурч, ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд үйл ажиллагаагаа нэвтрүүлээд буй бөгөөд цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэн, үйл ажиллагаагаа шинэ улсуудад нэвтрүүлэх, таниулах ажлуудыг шат дараалалтайгаар төлөвлөн гүйцэтгэж байна.

Дээрх зах зээлүүдэд нэвтрэхийн тулд Үнэт цаас гаргагч нь зорилтот зах зээл болох хувиараа ажиллаж буй, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй, суурьшиж буй, суралцаж буй болон гэр бүлийн шаардлагаар гадаад улсуудад оршин сууж буй 15 – 54 насны 100,000 орчим иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг таниулах, хэрэглээг идэвхжүүлэх төлөвлөгөөт маркетингийн ажлуудыг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлэхээр бэлтгээд байна.



Цаашид Sendly аппликейшнийг зөвхөн Монгол улс ба бусад улсын хооронд мөнгөн гуйвуулга хийх бус олон улс хооронд мөнгөн гуйвуулга хийх платформ болгохоор зорин ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд нийт хийгдэж буй гадаад мөнгөн гуйвуулгын дүнгээр дэлхийд хоёрт ордог Арабын Нэгдсэн Эмират улс руу үйл ажиллагаагаа тэлэхээр зохих зах зээлийн судалгаа болон тусгай зөвшөөрөл авах ажлуудыг эхлүүлээд байна.


Үнэт цаас гаргагч нь зорилтот зах зээлд, хамгийн хямд үнээр бүтээгдэхүүн үйлчилгээгээ санал болгох буюу cost focus стратегийг баримтлан ажиллахын хажуугаар нэмэлт үйлчилгээнүүдийг нэвтрүүлснээр өрсөлдөгч байгууллагуудаас ялгарах буюу differentiation focus стратегийг давхар баримталж, одоогийн байдлаар албан ёсны тусгай зөвшөөрөлтэйгөөр олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хамгийн хямд буюу дунджаар 1.33 хувийн шимтгэлтэйгээр хэрэглэгчдэд санал болгож байна. Цаашид үнэт цаас гаргагч нь cost focus стратегийг differentiation focus стратегитай хослуулан баримталж, зах зээл дээрх өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэн ажиллахаар зорьж байна.

Зээлийн үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь уламжлалт болон дижитал сувгуудаар дамжуулан зээл олгодог ба эдгээр сувгууд нь тус бүр өөр өөрийн гэсэн зорилтот зах зээлд хүрэх зорилготойгоор ажиллаж байна. Дижитал зээл буюу мерчантын зээлийн зорилтот зах зээл нь жижиг дунд бизнес эрхлэгчид байдаг бол уламжлалт зээлийн үйлчилгээг хөдөө орон нутагт байршилтай салбаруудаар түлхүү олгож байна.

Үнэт цаас гаргагч нь зээлийн үйлчилгээндээ differentiation focus стратегийг түлхүү баримталж, хэрэглэгчдэд хүртээмжтэй, түргэн шуурхай, технологид суурилсан шийдлүүдийг ашиглах стратегийг баримтлан ажиллаж байна. Компани нь





хамгийн олон орон нутгийн салбартай давуу талаа ашиглан орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгч нэрт зориулсан мерчантын зээлийн бүтээгдэхүүнийг санал болгох замаар зах зээлийн эзлэх хувиа нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Зах зээлд нэвтрэх стратеги

Sendly аппликейшн нь 2021 оны жилийн эцсээр нийт 13,300 гаруй таталт, 5,300 гаруй идэвхтэй хэрэглэгчтэй байна.

2022 онд маркетингийг идэвхжүүлж аппликейшний таталтын тоог 50,000-с дээш хүргэх, идэвхтэй хэрэглэгчдийн тоог 15,000-с дээш хүргэх зорилттой ажиллаж байгаа ба хэрэглэгчдээс бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой судалгааг байнга авч, санал хүсэлтийг маркетингийн үйл ажиллагаанд тусган ажиллаж байна.

Зорилтот улсууд




Үнэт цаас гаргагч нь үндэсний статистикийн хорооноос хийсэн хамгийн сүүлийн буюу 2020 оны Монгол улсын хүн ам, орон сууцын тооллогыг харгалзан үзэж Монгол иргэд хамгийн ихээр суурьшсан улсуудад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон бусад санхүүгийн үйлчилгээг /Орон сууцны зээл, Онлайн дэлгүүр, Сайн дурын нийгмийн даатгал/ таниулах, үүний зэрэгцээ Монгол болон олон улсын зах зээлд брендийн нэр хүндийг өсгөхөд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. 2022 онд багтаан эхний ээлжид дараах улсуудад үйлчилгээгээ нэвтрүүлэхээр зорьсон билээ. Үүнд:

Улс	Оршин суугаа иргэдийн тоо	Нэвтрэх хугацаа	Үйл явц
Европын холбооны 27 улс	22,000	2022.05.31	Бодит орчинд нэвтрүүлэхээр ажиллаж байна.
Өмнөд Солонгос улс	40,000	2022.09.30	Программ хөгжүүлэлт
БНХАУ	5000	2022.08.31	Бодит орчинд тестлэхэд бэлдэж байгаа
Их Британи	1400	2022.08.31	Программ хөгжүүлэлт хийгдэж байна.



Сэндли ББСБХХ - Үнэт цааны танилцуулга



Зах зээлд танигдах ажлын хүрээнд европын холбооны улсуудад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэддээ зориулсан санхүүгийн үйлчилгээг мөнгөн гуйвуулгын аппликейшнээр дамжуулан үзүүлэх үйлчилгээг танилцуулах арга хэмжээ 2022 оны 5 - 6 сарын хооронд хийхээр төлөвлөж байна.



Цаашид Sendly аппликейшнийг зөвхөн Монгол улс ба бусад улсын хооронд мөнгөн гуйвуулга хийх бус олон улс хооронд мөнгөн гуйвуулга хийх платформ болгохоор зорин ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд нийт хийгдэж буй гадаад мөнгөн гуйвуулгын дүнгээр дэлхийд хоёрт ордог Арабын Нэгдсэн Эмират улс руу үйл ажиллагаагаа тэлэхээр зохих зах зээлийн судалгаа болон тусгай зөвшөөрөл авах ажлуудыг эхлүүлээд байна.

Байршуулалтын стратеги

Sendly олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний сегмент нь 200 мянга гаруй иргэд Sendly үйлчилгээгээр дамжуулан нийт 35 тэрбум төгрөгийн гүйлгээг амжилттай шилжүүлжээ. Үүний 46.7 хувь нь суралцахаар, 29.4 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр, 11.9 хувь нь гэр бүлийн шалтгаанаар гадаадад амьдарч байна.

Бид нийт гадаад улсад ажиллаж амьдарч байгаа Монголчууд болон Монгол улсад суугаа тэдний дотны хэн нэгэнд өөрсдийн үйлчилгээг таниулах зорилгоор өөрсдийн маркетинг, сурталчилгаагаа дотоодын зах зээл болон гадаад улсад суугаа Монголчууд хэмээн хуваагаад байна.

Гадаад улсад ажиллаж буй сегментэд хүрэхэд тухайн орны Монголчуудын төлөөлөл бүхий холбоо, тухайн улсад ажиллаж амьдардаг хүмүүсийн төлөөлөл, олны танил мөн нийгмийн хариуцлагын ажлууд зэрэг аргуудаар дамжуулан өөрсдийн үйлчилгээг албан ёсны, хурдан шуурхай, аюулгүй гэх мессежийн дор хүргэдэг. Бидний нэг томоохон амжилттай өрнөсөн кампанит ажлуудаас дурдваас АНУ-д оршин суугаа хэрэглэгчидрүүгээ ил захидлууд илгээх, Монгол улсад суугаа гэр бүлд нь хэрэглэгчдийг төлөөлөн бэлэг хүргэх, гүйлгээний шимтгэлийн тодорхой хувийг "Монголын Аутизмын Холбоо"-нд хандивлах зэрэг нийгмийн хариуцлагын хүрээнд олон маркетингийн ажлууд хийгээд байна.





2022-07-26

03

Харин Монгол улсад суугаа гэр бүл болон нийтэд өөрсдийн үйлчилгээг мөн адил 3 мессеж болох албан ёсны, хурдан шуурхай, аюулгүй мөнгөн гуйвуулгын үйлчилгээ гэх санааг хүргэснээр Гадаад улсад суугаа Монголчуудад бидний үйлчилгээг санал болгодог. Бид өөрсдийн үндсэн сувгууд болон сошиал медиа руу маркетингийн мессеж хүргэх замаар энэхүү ойлголтоо таниулан хоногшуулдаг.

Сурталчилгааны стратеги

Цогц маркетингийн харилцаа холбоо (IMC) Маркетингийн стратегийг өөрсдийн сурталчилгааны стратегид бид ашигладаг. Энэхүү стратегийг бид зурааснаас дээш, зурааснаас доош болон зураас дундуур гэсэн 3 хэсэгт задлан хувааж авч үздэг. Тухайн ангиллын тусламжтайгаар сурталчилгааны стратегийг нарийвчлан тодорхойлдог билээ.

Зурааснаас дээш буюу Above The Line - ATL

Өргөн хүрээг хамарсан, зорилтот сегмент, хэрэглэгчийн персонаг үл хамааран нийтийг хамарсан маркетингийн арга хэрэгслийг ашиглан хийж буй маркетингийг Зурааснаас дээш буюу ATL маркетинг гэж нэрлэдэг. ATL маркетинг нь зар сурталчилгаа, маркетингийн сувгуудаар дамжуулан урт хугацаанд брэнд хоногшуулах, таниулах зорилготой байдаг ба ихэвчлэн телевиз, радио, сонин/сэтгүүлийн сурталчилгаа нь энэхүү арга хэрэгсэлд хамаарна.

Зурааснаас доош буюу Below The Line - BTL

Зорилтот сегмент болон хэрэглэгчийн персонаг тодорхойлсны дараагаар тодорхойлсон сегмент рүү хамгийн боломжит, шууд үр дүн, хариу үйлдэлд суурилсан маркетингийн арга хэрэгслээр дамжуулан хүрэх маркетингийн аргыг BTL маркетинг гэж нэрлэдэг. BTL маркетинг нь и-мейл маркетинг, хайлтын системийн оновчлол, үзэсгэлэн худалдаа зэрэг аргаар зорилтот хэрэглэгч руу шууд хүрэх арга хэрэгслүүд хамаарна.

Зураас дундуур буюу Through The Line - TTL

Энэхүү маркетингийн арга зам нь ATL, BTL 2 арга замыг нийлүүлсэн буюу брэнд танигдалт болон хариу үйлдэл дээр суурилсан цогц маркетингийн арга хэрэгслээр дамжуулан хүрэхийг TTL маркетинг гэж нэрлэдэг. Ихэвчлэн хосолсон аргаар зорилтот болон макро түвшинд хүрэхүйц ажлууд байдаг ба ТВ реклам дундуур QR уншуулах сурталчилгаа, сошиал медиа маркетинг зэрэг арга хэрэгслүүд хамаарч болно.



Гэндли ББСГ ХХК Үнэт цаасны танилцуулга
 2022 оны 08 сарын 10 өдөр
БҮРТГЭВ
 № 51



Хүснэгт 34: ATL, BTL, TTL арга замуудын харьцуулалт

Зурааснаас дээш буюу ATL	Зурааснаас доош буюу BTL	Зураас дундуур буюу TTL
· Макро хэмжээг хамарсан	· Микро хэмжээг хамарсан	· Микро, макро аль аль хэмжээг хамарсан
· Масс медиа цацалт	· Зорилтот сегмент руу чиглэсэн	· Нийтийг болон зорилтот сегментэд зэрэг хүрч болдог
· Өргөн цар хүрээтэй	· Үр дүнг хэмжихэд хялбар	· Ихэвчлэн нийтийн онлайн сүлжээний платформ Фейсбүүк, Сошиал медиа зэрэг нь энэхүү ангилалд багтдаг
· Брэнд хоногшуулалт болон танигдалтад тохиромжтой	· Борлуулалт болон ашиг нэмэхэд тохиромжтой	
· Нийт хүрсэн хүмүүсийн тоо болон бусад мэдээлэл авах боломжгүй	· Нийт хүрсэн хүмүүсийн тоо болон бусад мэдээлэл авч хэмжихэд хялбар	

УЛААНБААТАР ХОТ
 ӨМНӨН ЗҮГДЭГ
 ХААГАГАМГААГЧИД ҮЦН
 ХХК
 5102855
 9021031155 СТС2420


РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК
 ХХК
 INVESTMENT LLC
 УЛААНБААТАР ХОТ
 9019120768 СТС481299



Гурав.

ҮНЭТ цаасны тухай






3.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1.1 Хувьцааны нэрлэсэн үнэ, хугацаа нөхцөл

Үнэт цаас гаргагч	"Сэндли ББСБ" ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Биржид бүртгүүлэх хувьцааны тоо ширхэг	223,570,000 ширхэг
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	50 төгрөг
Нэмж гаргах хувь	29.97%
Нэмж гаргах хувьцааны тоо	67,000,000 ширхэг
Стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох	75% - 50,250,000 ширхэг
Олон нийтэд санал болгох	25% - 16,750,000 ширхэг
Анхдагч зах зээлд санал болгох үнэ	150 /нэг зуун тавь/ төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	10,050,000,000 төгрөг
Стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох нэгж хувьцааны үнэ	150 /нэг зуун тавь/ төгрөг
Стратегийн хөрөнгө оруулагчийн хувьцааг тусгаарлах нэмэлт нөхцөл	<p>Эхний ээлжийн 16,750,000 /арван зургаан сая долоон зуун тавин мянга/ ширхэг буюу 2.5 тэрбум төгрөгийн хувьцааг авсан стратегийн хөрөнгө оруулагч 9 /ес/ сарын хугацаанд хувьцаагаа хоёрдогч зах зээлд худалдахгүй*. Энэ ээлжийн захиалгад ажилтнуудын захиалгыг хамруулна.</p> <p>Хоёр дахь ээлжийн 16,750,000 /арван зургаан сая долоон зуун тавин мянга/ ширхэг буюу 2.5 тэрбум төгрөгийн хувьцааг авсан стратегийн хөрөнгө оруулагч 18 /арван найм/ сарын хугацаанд хувьцаагаа хоёрдогч зах зээлд худалдахгүй*</p> <p>Гурав дахь ээлжийн 16,750,000 /арван зургаан сая долоон зуун тавин мянга/ ширхэг буюу 2.5 тэрбум төгрөгийн хувьцааг авсан стратегийн хөрөнгө оруулагч 24 /хорин дөрөв/ сарын хугацаанд хувьцаагаа хоёрдогч зах зээлд худалдахгүй*</p> <p>*Захиалга хийсэн дарааллаар тогтооно</p>
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Үндсэн үйл ажиллагааны эх үүсвэрт
Арилжаалах арга хэлбэр	Тогтоосон үнийн арга
Арилжаа эрхлэх байгууллага	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК





3.1.2 Кувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Хувьцааны	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
	Тоо /ширхэг/		/ширхэг/	
1 Монголын финтек групп ХК	126,141,700	80.56%	126,141,700	56.42%
2 Сэндли Эмплоие ХХК	20,000,000	12.77%	20,000,000	8.95%
3 Баттулга Наранбат	8,000,000	5.10%	8,000,000	3.57%
4 Радикс технологи ХХК	1,714,200	1.09%	1,714,200	0.77%
5 Батдорж Нямжаргал	285,700	0.18%	285,700	0.13%
6 Зургаа Цолмон	107,100	0.06%	107,100	0.05%
7 Чойжоо Дашсүрэн	71,400	0.05%	71,400	0.03%
8 Лхагважав Нарантуяа	71,400	0.05%	71,400	0.03%
9 Охиндоо Нямдэлэг	71,400	0.05%	71,400	0.03%
10 Ганхуяг Саруул-Од	71,400	0.05%	71,400	0.03%
11 Гантөмөр Гантуяа	35,700	0.02%	35,700	0.02%
12 Олон нийт	-	-	67,000,000	29.97%
Нийт	156,570,000	100.00%	223,570,000	100.00%


3.2 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Сангийн сайд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан “Бизнесийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээнд Зах зээлийн харьцуулалтын хандлага, Хөрөнгөд суурилсан хандлага, Орлогын хандлагыг авч үзэв.

- **Орлогын хандлага** [СТОУС 13] – Ирээдүйн дүнгүүд (жишээлбэл: мөнгөн гүйлгээ, орлого, зардлын дүн)-ийг өнөөгийн ганц дүн (өөрөөр хэлбэл хорогдуулан)-д хөрвүүлдэг үнэлгээний арга, хандлага. Бодит үнэ цэнийг хэмжихдээ ирээдүйн дүнгүүдийн талаарх зах зээлийн өнөөгийн таамаглалаар илэрхийлсэн үнэ цэнд суурилна.

- **Зах зээлийн хандлагаар** бизнесийн үнэ цэнийг тогтоохдоо үнийн мэдээлэл хангалттай олох ижил төстэй болон орлуулагч бизнестэй харьцуулах аргыг хэрэглэнэ. Энэ хандлагаар үнэлэх эхний алхам нь зах зээл хувьцаа нь арилжаалагдаж байгаа эсвэл зах зээл дээр саяхан борлогдсон үнэлгээнд хамрагдсан бизнестэй ижил төстэй бизнесийн хувьцааны үнэ эсвэл борлуулалтын үнийг авч үзэх явдал юм.

- **Өртгийн хандлагыг** мөн “Хөрөнгөд суурилсан хандлага” гэж нэрлэдэг ба энэ нь худалдан авагч үнэлэгдэж буй хөрөнгөд төлөх үнэ нь (цаг хугацаа, тохиромжгүй байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлийг эс тооцвол) тэнцүү чанартай



хөрөнгийг худалдан авах эсвэл барьж байгуулах зардлаас илүүгүй байна гэсэн зарнимд үндэслэнэ. Өртгийн хандлагаар бизнесийг үнэлэхдээ тухайн бизнесийн биет ба биет бус бүх хөрөнгүүдийг үнэлж, үүнээс бүх өр төлбөрүүдийн зах зээлийн үнэ цэнийг хасах замаар тооцно.

Үнэлгээний өдөр: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

№	Арга	Үнэлгээ /сая.төг/
1	Зах зээлийн харьцуулалтын хандлага	43,696.6
2	Хөрөнгөд суурилсан хандлага	7,084.7
3	Орлогын хандлага	34,096.6
100% бизнес өмчлөлийн үнэ цэн		34,096,591,256 ₮
IPO-оор татах шинэ мөнгө		10,050,000,000 ₮

3.3 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ



Үнэт цаас гаргагч нь өөрийн 67,000,000 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгож нийт 10,050,000,000 (арван тэрбум тавин сая) төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа билээ. Ийнхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн 99.5 хувийг өөрийн тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үндсэн үйл ажиллагааны эх үүсвэрт, 0.5 хувийг эх үүсвэр босгох санхүүжилтэд зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

№	Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Өөрийн тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үндсэн үйл ажиллагааны эх үүсвэр	10,000.0 сая
2	Эх үүсвэр босгоход гарах зардал	50.0 сая

3.4 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
2. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн бол эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;



2022-08-05

СЗХ
2022-08-10
БҮРТГЭЛ
№ 01
Худалдан авах



4. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах;
5. Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувь эзэмшигч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Үүнд:
 - 5.1 Нийлэх, нэгдэх, хуваах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах болсон бол;
 - 5.2 Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;
 - 5.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;
 - 5.4 Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
6. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
7. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.
8. Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад эрх.

Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ.

1. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх зэрэг үүрэг хүлээнэ.
2. Нийт гаргасан хувьцааны гуравны нэг болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хүссэн эсхүл эзэмшсэн этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.1-д заасны дагуу худалдан авах санал гаргана.

ӨЛЭГН ЭЛД НО
КАПИТАЛ
5103855
2021031195 CTC2420

ХХК
Handwritten signature

- 
- 
3. Нийт гаргасан хувьцааны таваас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн бол өмчлөх эрх үүссэнээс ажлын 3 хоног дотор компанид бичгээр мэдэгдэнэ.
 4. Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 9.4, 9.5 дах хэсэгт зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
 5. Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно.
 6. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад үүрэг.

3.5 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ

3.5.1 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжааг Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 3 дугаар бүлэгт заасны дагуу “ТОГТООСОН ҮНИЙН АРГА” -аар олон нийтэд нээлттэй санал болгоно.

3.5.2 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь

1. МХБ, СЗХ-оос үнэт цаасыг бүртгэх шийдвэр гарах
2. МХБ-тэй анхдагч арилжааны гэрээ байгуулах
3. Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах
4. Үнэт цаасны захиалга авах
5. СЗХ-нд анхдагч зах зээлийн арилжааны тайлан мэдэгдэх
6. Хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх


3.5.3 Эрх бүхий байгууллагын зөвшөөрөл

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтийг МХБ болон СЗХ-нд хүргүүлэх бөгөөд уг эрх бүхий байгууллагууд үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг олон нийтэд танилцуулж, арилжаалах эрх нээгдэнэ.


Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааг төлөвлөсөн өдрөөс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хугацаа болон хуваарийг тодорхой тусгасан зөвшөөрөл хүсэл албан бичгийг СЗХ-нд хүргүүлж, холбогдох зөвшөөрлийг авна. СЗХ нь уг зөвшөөрлийг олгосноор МХБ-тэй анхдагч арилжааны гэрээ байгуулж үнэт цаасыг олон нийтэд санал болгох боломжтой болно.

3.5.4 Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах



МХБ болон СЗХ үнэт цаасыг олон нийтэд санал болгохыг зөвшөөрч, үнэт цаасны бүртгэлд бүртгэснээр тухайн үнэт цаасыг олон нийтэд танилцуулах аяныг эхлүүлж дараах байдлаар зохион байгуулна.



ӨЛЗНИЙ ЭНД КО
КАПИТАЛ УРГАА
5103655
9927031155 CTC2420



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ULSIATOLGO MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-05





- Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдод зориулан үнэт цаас гаргагчийн танилцуулга, уулзалт зохион байгуулах,
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зар сурталчилгаа, мэдээллийг хүргэх, уулзалт зохион байгуулах,
- Үнэт цаасны хэвлэмэл танилцуулга, материал тараах,
- Стратегийн хөрөнгө оруулагчдад танилцуулга хийх,


3.5.5 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа

Үнэт цаас гаргагчийн хувьцаа нь МХБ-ийн хувьцааны бүртгэлийн II ангиллын шалгуурыг хангаж байгаа тул МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 12-р зүйлд заасны дагуу олон нийтэд санал болгон арилжаална. Үнэт цаасны худалдан авах захиалгыг МХБ-ийн гишүүн бүх брокер, дилерийн компаниар дамжуулна. Стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулагчдын захиалгыг андеррайтер болон үнэт цаас гаргагч нь тусгайлан авна.

Хөрөнгө оруулагчид	Нэмж гаргах хувьцаанаас санал болгох хувь	Санал болгох хувьцааны тоо /ширхэг/	Санал болгох үнэ /төгрөг/ Тогтоосон үнийн аргаар	Татан төвлөрүүлэх хөрөнгө /төгрөг/
Стратегийн хөрөнгө оруулагч	75.0%	50,250,000	150	7,537,500,000
Олон нийт	25.0%	16,750,000	150	2,512,500,000
Нийт	100%	67,000,000		10,050,000,000

- Хувьцааны тоо ширхгээс хувьцаа худалдан авах захиалгын тоо ширхэг илүү гарсан тохиолдолд “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу хувь тэнцүүлэх аргыг ашиглана.
- Стратегийн хөрөнгө оруулагч гэдэгт МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 3.4 хэсэгт тодорхойлсон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасаа 6-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагч болон хувьцаа худалдан авахаар захиалга өгсөн ажилтнуудыг ойлгоно. Стратегийн хөрөнгө оруулагч нь санал болгох үнийн түвшинд 50,000,000 (тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцаа захиалах хөрөнгө оруулагч бөгөөд энэхүү нөхцөлд ажилчдын захиалга хамаарахгүй болно.
- Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.6-д заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаанаас Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааг идэвхижүүлэх зорилгоор нийт **50,000,000** төгрөгийн үнийн дүнтэй тэнцэхээр тодорхой хувийг худалдаж авна.





Анхдагч арилжааг эхлүүлэх хугацааг Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь МХБ -тэй хамтран тогтоож, СЗХ-оос зөвшөөрөл авна.

3.5.6 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан анхдагч зах зээлийн арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч аливаа зөрчил гараагүй, амжилттай болсон гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх, арилжаа эрхлэх байгууллагад хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

3.5.7 Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг дараах 2 аргаас сонгон дансандаа байршуулах боломжтой.

1. Өөрийн хүссэн банкаар дамжуулан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх өөрийн нэртэй 12 оронтой дансны дугаарыг брокероосоо лавлаж дараах зааврын дагуу хувьцаа авах мөнгөн хөрөнгийг байршуулаад брокертоо мэдэгдэж захиалгаа баталгаажуулна.

Банкны нэр: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Дансны нэр: таны өөрийн нэр

Дансны дугаар: **** * (өөрийн брокероос лавлах)

Гүйлгээний утга: Хувьцааны мөнгө, регистрийн дугаар, нэр, утасны дугаар

2. Хэрэв үнэт цаасны дансгүй бол МХБ-д бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компаниас сонгон данс нээлгэнэ. Данс бүрэн баталгаажихад 1-2 хоног шаардлагатай байдаг. Ийнхүү шинээр данс нээлгэсэн, данс нь бүрэн баталгаажаагүй болон 1 дүгээр зааварчилгаа ойлгомжгүй байгаа хөрөнгө оруулагчийн хувьд тухайн үнэт цаасны компанийн номинал дансанд дараах байдлаар хувьцаа авах мөнгөн хөрөнгийг байршуулаад брокертоо мэдэгдэж захиалгаа баталгаажуулна.

Банкны нэр: ҮЦК-ийн номинал данс байршиж буй банкны нэр



Дансны нэр: Үнэт цаасны компанийн нэр

Дансны дугаар: Үнэт цаасны компанийн номинал дансны дугаар

Гүйлгээний утга: регистрийн дугаар, нэр, утасны дугаар

3.5.8 Арилжааны шимтгэл

Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн тогтоосон арилжааны шимтгэлийг үнэт цаас авах мөнгөн дүн дээр нэмж байршуулна. Уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын шимтгэл багтсан байна.





3.5.9 Албан татвар

Хөрөнгө оруулагч нь хувь хүн бол ХХОАТ-ын хуулийн 16.1.3-т заасан ногдол ашгийн орлогын нийт дүнгээс, 17.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнийн дүнг хассан зөрүүнээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн татвар төлнө.

Хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол ААНОАТ-ын хуулийн 18.6.2-т заасан ногдол ашгийн орлогын нийт дүнгээс, 18.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнийн дүнг хассан зөрүүнээс тус хуулийн 20.2.5-д заасан 5 хувийн татвар төлнө.


3.6 ҮНЭ ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨР


Андеррайтерууд нь үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс эхлэн нэг сараас доошгүй хугацаанд хэрэгжүүлнэ. Ингэхдээ бусад үнэт цаасны буюу зөвлөх компанитай хамтарч болох бөгөөд хөтөлбөрийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 8 дугаар зүйлд заасан зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрт оролцогч талууд нь дурдсан хугацаанд хувьцааны үнэ анхдагч зах зээлд санал болгосон үнээс буурах нөхцөл байдал бүрдсэн тохиолдолд хувьцааг анхдагч зах зээлд санал болгосон ханшаар худалдан авах арилжааг хийж эхэлнэ. Худалдан авах ажиллагааг явуулахдаа Үндсэн андеррайтер, Туслах андеррайтер, Зөвлөх гэсэн дарааллаар хэрэгжүүлнэ. Дурдсан нөхцөл бүрдээгүй тохиолдолд Хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй байж болно.

Хөтөлбөрийн нийт дүн 1 тэрбум төгрөг байх бөгөөд үүнээс хэтэрсэн тохиолдолд үнийн дүнг нэмж байршуулах замаар үргэлжлүүлнэ. Талууд хөтөлбөрийг бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх бөгөөд Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлсэн хөрөнгөөс суутган тооцохгүй. Андеррайтерууд болон Зөвлөх компани нь хувьцааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцаа худалдах, худалдан авах ажиллагааг гүйцэтгэж, эрэлт нийлүүлэлтийн зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.

Хөтөлбөрт оролцогч талууд нь үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаа дууссан өдрөөс хойш тогтворжуулалтын чиглэлээр хийсэн гүйлгээний тайланг ажлын 3 өдрийн дотор Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ. Түүнчлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглах ажиллагаа явуулахгүй болно.





Дөрөв.

**Үнэт цаас гаргах
үйл ажиллагаанд
оролцогчид**

04



4.1 АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр: "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК

Үйл ажиллагааны чиглэл: Брокер, Дилер, Андеррайтер

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити Тауэр, 25 давхар, 2506 тоот

Утас: +976 7777 6377

Цахим шуудан: Info@ucc.mn


Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, НьюЙоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн.

Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

- 2008 он, Брокер дилер андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсан.
- 2009 он, Лондонгийн хөрөнгийн бирж болон АНУ-н банк Bank New York Mellon-той хөрөнгө босгох боломжийн талаарх форумыг анх удаа зохион байгуулсан.
- 2010 он, Монголд анх удаа HKEX, LSE, ASX, NYSE зэрэг биржүүдийн гадаадын арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн.
- 2010 он, Bank of China International-тай түншлэв.
- 2011 он, Шилдэг брокерийн компани
- 2011 он, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн
- 2013 он, Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шинийг санаачлагч байгууллага"
- 2015-2018 он, Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх
- 2016 он, Австралийн CPS Capital ҮЦК-ийн Монгол дахь төлөөлөгч.
- 2018 он, МҮОНТ-ийн "Ногоон сум" реалити шоуны ялагч





- 2018 он, Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards “Шилдэг Мэргэжилтэн”
- 2019-2020 он, Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан.
- 2019 он, “Ард Кредит ББСБ” ХК-ийн IPO-д үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов.
- 2020 он “ЛэндМН” ББСБ ХК-ийн нээлттэй бондын үндсэн андеррайтер
- 2020 он, Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн
- 2020 он, МҮОНТ-н “Цагийн хүрдийн баатар”
- 2020 он, Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер
- 2021 он, Биржийн бус зах зээл /OTC/-ийн анхны гишүүн байгууллага
- 2021 он, Монгол банк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан “Sandbox” төслийн анхны бүтээгдэхүүн болох “Монпэй” бондын андеррайтер
- 2021 он, Биржийн бус зах зээлийн /OTC/-ийн анхны “БИД” бондын андеррайтер
- 2022 он, Биржийн бус зах зээл /OTC/-д гаргасан “Ашид капитал ББСБ” ХХК хаалттай бондын үндсэн андеррайтер
- 2022 он, МҮОНТ-ийн орон даяарх “Ногоон сум” аянд хамтрагч компани

Өнөөгийн байдлаар “ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК” нь:

“Мобифинанс ББСБ” ХХК	“Хүлэгү Инженеринг” ХХК
“Бэрс финанс ББСБ” ХХК	“Монголчех Метал” ХХК
“Бичил Глобус ББСБ” ХХК	“Ай Си Ти групп”
“Ард Кредит ББСБ” ХХК	“Монголиан мючүал финанс групп”
“Соно финтек ББСБ” ХХК	“Эрхэт Монгол групп”
“ЛэндМН ББСБ” ХХК	“Монголын финтек групп”
“Микрокредит ББСБ” ХХК	“ОНДО” ХХК
“БИД ББСБ” ХХК	“Мишээл лайф стайл” ХХК
“АБТС ББСБ” ХХК	“Гарнетон” ХХК
“Ашид Капитал ББСБ” ХХК	“Шарын гол” ХК
Капитрон банк	“Сүү” ХК
	“Говь экуйпмент рентал флийт”

зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 150.0+ тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.





4.2 ХАМТРАГЧ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр: "РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК

Үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер, Андеррайтер

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 13 давхар, 1308Б тоот

Утас: +976 7510 0575

Цахим шуудан: Info@rhinosinvest.com

"Райнос Инвестмент ҮЦК" ХХК нь БНСУ-ын хуулийн этгээд Райнос Эссет Менежмент ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2019 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын хөрөнгийн зах зээлд амжилттай үйл ажиллагаагаа явуулахаар зорин ажиллаж байна. "Райнос Инвестмент ҮЦК" ХХК нь Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, Номинал дансаар дамжуулан үнэт цаасны брокерын цогц үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгийн зах зээлд бонд зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Үйл ажиллагаа явуулж эхлээд удаагүй боловч манай компани гадаадын зах зээлд арилжаалагдаж буй Монгол Улсын Засгийн Газрын Бонд болон санхүүгийн байгууллагын бондуудад гадаадын хөрөнгө оруулагчдыг амжилттай зуучлаад байна.

"Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ийн толгой компани болох Райнос Эссет Менежмент компанийн Монголд хийсэн томоохон хөрөнгө оруулалтууд:

- Монголын анхны финтек компани болон ЛэндМН ББСБ-ын IPO-д стратегийн хөрөнгө оруулалтыг гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хувиар хийсэн.
- Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа АНД Системс ХХК-ийн санхүүжилтэд зориулж хувьцаа барьцаалсан солилцох бондын 7 тэрбум төгрөгийн санг амжилттай байгуулсан.
- 2017 оноос хойш БНСУ-ын хөрөнгө оруулалтын сантай хамтран нийт 14 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Монголын компаниудыг өсөлт үзүүлэхэд нь дэмжиж ажилласаар ирсэн.
- Монголын Хөгжлийн Банкны гаргасан хадгаламжийн сертификатын (CD) бүтээгдэхүүнд 2017-2019 онуудад хуримтлагдсан дүнгээр нийт 210.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.
- 2021 онд Технологийн салбарын старт-ап компанид 2.0 сая ам.долларын хөрвөх бондын санхүүжилт хийсэн байна.





Энэхүү гэрээгээр андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татах үйл ажиллагаатай холбоотой Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг боловсруулах, үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, мөн энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан СЗХ болон МХБ-тэй үнэт цаас гаргагчийг төлөөлөн харилцах гэх мэт талуудын хоорондын харилцааг зохицуулна.

- Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дугаарт заасны дагуу Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр зохион байгуулна.
- Андеррайтер тус бүр нь энэхүү гэрээ болон ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй бөгөөд андеррайтер тус бүр төлөвлөгөөнд заасан ажлыг заасан хугацаанд гүйцэтгэх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий этгээд нь нийтэд санал болгох Үнэт цаасны үнийг үндэслэлгүйгээр тогтоосон эсхүл тус үнэ нь Үнэт цаас гаргах үйл ажиллагааг амжилтгүй болгоход хүргэнэ гэж Андеррайтер үзсэн тохиолдолд Андеррайтер нь үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь андеррайтерийг шаардлагатай бүхий л мэдээ мэдээллээр үнэн зөв, түргэн шуурхай хангаж ажиллах үүрэгтэй.
- Андеррайтер нь Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.6-д заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаанаас анхдагч зах зээлийн арилжааг идэхижүүлэх зорилгоор нийт **50,000,000** төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээтэй тодорхой хувийг худалдаж авна.
- Андеррайтер нь Гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол Үнэт цаас гаргагч нь Гэрээг түдгэлзүүлэх мэдэгдлийг бичгээр үйлдэж, түүнд төлбөл зохих төлбөрийг түдгэлзүүлж болох бөгөөд энэхүү мэдэгдэлд биелүүлээгүй үүргийн шинж чанарыг тодорхойлох ба энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг андеррайтераас шаардах эрхтэй.

Үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг андеррайтертай зөвшилцөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, үүний улмаас үнэт цаас гаргагчийн үнэт цаасны үнэлгээнд эрс өөрчлөлт гарсан, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан бол Үнэт цаас гаргагч учирсан хохирлыг өөрөө хариуцна.



4.3 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр: "ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ" ХХК

Үйл ажиллагааны чиглэл: Аудитын үйлчилгээ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Метро бизнес төв, 6 даахар, 603 тоот

Утас: +976 8011 0088

Цахим шуудан: shonkhor.mn@gmail.com

"Шонхор үнэлгээ аудит" ХХК нь 2014 онд байгуулагдсан. 2017 оноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудитын байгууллагын бүртгэлд хамрагдаж эхэлсэн. Мөн 2018 оноос Даатгалын байгууллагад аудит хийх эрхтэй болсон. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын гишүүн байгууллага юм. Бид өнгөрсөн хугацаанд Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг томоохон компаниуд, санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг олон аж ахуйн нэгжүүдэд аудит, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлийн үйлчилгээг зохих хууль, дүрэм, журмын дагуу үзүүлсээр ирсэнийг дурдахад таатай байна. Тухайлбал 2022 онд буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэхэд MCS групп компаниуд, Монре даатгал, Simple asset ТЗК, Гүүдсек ХХК зэрэг томоохон болон олон нийтийн ашиг сонирхол бүхий 200 орчим аж ахуйн нэгжид аудитын үйлчилгээ үзүүлсэн байна.

Манай компани мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, хөрөнгийн үнэлгээчин гэх мэт мэргэжлийн зэрэг цол, туршлагатай ажилтнуудаа түшиглэхээс гадна шинэ тутам хөгжиж буй салбаруудын талаарх мэдлэгээ үргэлж дээшлүүлэхийг хичээн ажилладаг.


Бидний энэ удаагийн үйлчилгээний гэрээний зорилго бол Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуулиудыг удирдлага болгон СЗХ, санхүүгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудаас батлан гаргасан холбогдох дүрэм, журам, зааврыг анхаарч үзсэний үндсэн дээр үнэт цаас гаргагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд АОУС-ын дагуу санхүүгийн тайлангийн аудит хийж, тайлан дүгнэлт гаргахад оршиж байгаа юм.

Бид Сэндли ББСБ ХХК-ийн бэлтгэн гаргасан санхүүгийн тайлан холбогдох хууль, журам, СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн эсэхэд холбогдох дүгнэлтийг өгөхөөс гадна цаашид анхаарч ажиллах асуудлуудынх нь талаарх зөвлөмжийг хүргүүлсэн болно.

Аудитын үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх үүрэг:

Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын "Иргэний хууль" "Нягтлан бодох бүртгэл" "Аудитын тухай хууль" болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм,





журам, заавар олон улсын хэмжээнд дагаж мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудит стандартын дагуу үнэт цаас гаргагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргахад оршино.

4.4 ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр: "ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ" ХХК

Үйл ажиллагааны чиглэл: Үнэлгээний үйлчилгээ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо.

Сүхбаатарын талбай, 20-6 Эрдэм цамхаг, 1004 тоот

Утас: +976 7000 5000

Цахим шуудан: gantulga@geregepartners.mn

Гэрэгэ Эстимэйт ХХК нь хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлээр ажилладаг үнэлгээний мэргэжлийн компани юм. Үнэлгээний баг нь үнэлгээчин, актуарч, нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч зэрэг олон чиглэлийн нарийн мэргэжлийг гадаад дотоодын их дээд сургуулиудад эзэмшиж, мэргэжлээрээ ажилласан туршлагатай чадварлаг мэргэжилтнүүдээс бүрддэг. Бизнесийн үнэлгээний болон хөрөнгийн үнэлгээний томоохон ажлууд дээр Гэрэгэ Эстимэйт ХХК болон Гэрэгэ Партнерс ХХК-ийн мэргэжилтнүүдийн хамтарсан баг ажилладаг. Гэрэгэ Партнерс ХХК нь эдийн засаг, санхүү, бизнес, актуарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани юм.

Гэрэгэ Эстимэйт ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр үнэт цаас арилжаалах компаниудын бизнесийн үнэлгээ хийх эрхтэйгээр Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй компани бөгөөд үнэлгээний багт Монгол Улсын Сангийн Яамнаас олгодог Мэргэшсэн үнэлгээчин сертификаттай 3 үнэлгээчин ажиллаж байна.


"Сэндли ББСБ" ХХК -ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр анхлан гаргах (IPO) зориулалтаар хийсэн үнэлгээний багийн ахлагчаар Доноровын Гантулга ажиллав. Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Роял Институт (RICS)-ийн гишүүн, бизнесийн болон биет бус хөрөнгийн үнэлгээний мэргэшсэн үнэлгээчин болсон. RICS нь газар, хөрөнгө, дэд бүтэц, байгууламжийн үнэлгээний мэргэшил болон стандарт тогтоодог дэлхийн тэргүүлэх байгууллага юм.

Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн үнэлгээчид нийт 20 орчим бизнесийн үнэлгээний ажил хийж гүйцэтгэсэн. Тэрээр 2017 онд Монгол Улсын анхны финтек компани болох ЛендМН ББСБ, 2018 онд Инвекор ББСБ, 2019 онд Бодь Даатгал зэрэг компаниудын бизнесийн үнэлгээг тус компаниудын хувьцааг хөрөнгийн биржид анхлан гаргах зориулалтаар хийж гүйцэтгэсэн туршлагатай бөгөөд одоо эдгээр





Сэндэнгийн ББСБ ХХК-ийн цаасны танилцуулга



компаниудын хувьцаа арилжаалагдаж байна.

Монголын Хөрөнгийн Бирж дээр амжилттай



Үнэлгээний үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

Гэрээт ажлыг холбогдох хуулийн хүрээнд баримт материалаар баталгаажуулан цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгч талд тухай бүрт тайлагнах.

Гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай эд хөрөнгө өмчлөгчийн хууль эрх зүйн акт, санхүүгийн тайлан баланс, тооцоо болон бусад холбогдох баримт бичгүүдтэй сайтар танилцаж үнэн зөв тайлан гаргах.

Үйлчлүүлэгчийн тавьсан үндэслэл бүхий шаардлагыг бүрэн биелүүлж ажиллах үүрэгтэй. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг чанд мөрдөн ажиллана.

Мэргэжлийн байгууллагын хувьд өөрийн гаргасан тайлангийн үнэн зөвийг үйлчлүүлэгчийн өмнө бүрэн хариуцна.





4.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр: "ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН

Үйл ажиллагааны чиглэл: Хуулийн зөвлөгөө

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо.

Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048

Факс: +976 11 330049

Вэб хуудас: www.mdsa.mn

Цахим шуудан: info@mdsa.mn


"Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН нь Монгол Улсын томоохон хуулийн фирмүүдийн нэг бөгөөд "Илүү сайн үйлчилгээ үзүүлэх" зорилготойгоор 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээ бүртгэгдсэн (Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолын дагуу), үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:



Энэхүү гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагч үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд хуулийн зөвлөх нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхтэй холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Хуулийн зөвлөх нь Зөвлөх үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай үнэн зөв мэдээ мэдээлэл, баримт материалыг үнэт цаас гаргагчаас шаардан авах эрхтэй.
- Хуулийн зөвлөх нь гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тодруулга өгөх, танилцуулга хийх үүрэгтэй.
- Хуулийн зөвлөх нь гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, дүгнэлт гаргах, үнэт цаас гаргагчийн нууцыг хадгалах үүрэгтэй.





Сэндли ББСБ ХХК - Үнэт цаасны танилцуулга



- Үнэт цаас гаргагч нь Хуулийн зөвлөхөд Зөвлөх үйлчилгээтэй холбоотой байж болох аливаа бүх мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөвөөр өгөх үүрэгтэй.

ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ДҮГНЭЛТ

АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ


“Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК (Үндсэн андеррайтер гэх), “Райнос инвестмент ҮЦК” ХХК (Туслах андеррайтер гэх) нар нь Үнэт цаас гаргагч “Сэндли ББСБ” ХХК (РД: 5961548) -тай 2022 оны 3 сарын 16-ны өдөр, S-22/11 дугаартай “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулж, Үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 150 төгрөгийн үнэтэй, 67,000,000 ширхэг энгийн хувьцааг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгож нийт 10,050,000,000 төгрөг татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллаж байгаа билээ.


Андеррайтерууд нь энэхүү үйл ажиллагаанд Монгол улсын макро эдийн засгийн орчин, ирээдүйн төлөв, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл, салбарын чиг хандлага, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, стратеги, бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл зэргийг судалсны үндсэн дээр үнэт цаасны танилцуулгыг боловсруулан бэлтгэж, Андеррайтерийн мэргэжлийн дүгнэлтийг дараах агуулгын хүрээнд танилцуулж байна.

1. Үнэт цаас гаргагчийн тухай
2. Үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв
3. Бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл
4. Бизнесийн үнэлгээ, хувьцааны үнэ тогтоосон үндэслэл
5. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын тухай
6. Эрсдэлийн шинжилгээ
7. МХБ-ийн II ангилалын шалгуур хангасан тухай
8. Хөрөнгө оруулалтын боломж
9. Хөрөнгө оруулагчдад зөвлөх нь

1. Үнэт цаас гаргагчийн тухай

Үнэт цаас гаргагч нь 2015 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд “Гео финанс” ХХК, “Гялс кредит ББСБ” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж иржээ. Компанийн оноосон нэрийг өөрийн брэнд бүтээгдэхүүний нэрээр буюу “Сэндли ББСБ” ХХК хэмээн өөрчилснийг СЗХ-ны даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны 328 тоот тушаалаар зөвшөөрч, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэсэн байна.





“Сэндли ББСБ” ХХК нь зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үнэт цаас гаргагч нь өөрийн компанийн бусдаас ялгарах онцлог, давуу тал нь Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон жижиглэн худалдаа эрхлэгч буюу мерчантын зээлийн үйлчилгээ юм.

Салбартаа анх удаа олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлснээр гадаадад суугаа Монгол иргэд зардал багатайгаар мөнгөн гуйвуулга хийх, түүнчлэн эх орондоо орон сууц худалдаж авах, сайн дурын нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломжтой болсон байна. Цаашлаад Монгол улсад орох валютын урсгал ч нэмэгдэх таатай нөхцлийг бүрдүүлсэнийг 2021 онд “Сэндли ББСБ” ХХК-ийн хүлээн авсан мөнгөн гуйвуулгын тоо нь арилжааны банкуудын нийт хүлээн авсан SWIFT гүйлгээний тооны 46.2 хувьтай тэнцэж байгаагаас харж болохоор байна.

Үнэт цаас гаргагч нь 2021 онд жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой мерчантын зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн нь банкны барьцаа хөрөнгийн шаардлагыг хангаж чадахгүй байгаа жижиглэн худалдаа эрхлэгчдийг өндөр хүүтэй өдрийн зээл, далд эдийн засгийн харилцаанаас сэргийлсэн чухал ач холбогдолтой үйл явдал байв.

“Сэндли ББСБ” ХХК нь үйлчилгээ үзүүлдэг салбар нэгжийн тоогоороо банк бус санхүүгийн салбартаа тэргүүлдэг бөгөөд орон нутагт 48, Улаанбаатар хотод 6 нийт 54 салбараар уламжлалт болон цахим зээлийн үйлчилгээг үзүүлж байна.



Үнэт цаас гаргагчийн толгой компани нь өөрийн охин компаниудын зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвар, үнэ цэнийг ямагт нэмэгдүүлэхэд удирдлагаар ханган ажилладаг бөгөөд зэргэлдээ компани хоорондын синержи үүсгэн, харилцан бие биенээ дэмжин ажилладаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага нь банк, санхүүгийн салбарт олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн, ирээдүйн тогтвортой өсөлтийг бүрэн хангах чадвартай хэмээн үзэж байна.

2. Үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв

- Макро эдийн засгийн ерөнхий төлөв:

Ковид-19 цар тахлын нөлөө, хорио цээрийн дэглэмээс шалтгаалан 4.6 хувиар агшаад байсан бодит эдийн засаг 2021 оны жилийн эцэст 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Нэг талаас эдийн засгийг сэргээх, өрхийн орлогыг дэмжих бодлогын арга хэмжээ үргэлжилж, хөл хорионы дэглэм шат дараатай суларч байгаа нь эдийн засгийн идэвхжлийг дэмжиж буй хэдий ч нөгөө талаас хилийн боомтууд дээр үүсээд буй ложистикийн бэрхшээлүүд нь гадаад худалдааны эргэлтийг хязгаарлаж, инфляцыг өдөөж байна.

Улсын инфляц 2021 оны эцсийн байдлаар 13.4 хувь байлаа. Инфляцын өсөлтөд улсын дотоод эдийн засгийн идэвхжлээс илүүтэйгээр импортын хүнсний





бүтээгдэхүүний үнийн өсөлт, бензин шатахууны үнэ, хадгалалт, тээврийн зардал зэрэг гадаад хүчин зүйлс нөлөө үзүүлж байна.

Үүсээд буй нөхцөл байдал, тээвэр, логистикийн асуудал хамгийн богино хугацаанд шийдвэрлэхээр Монгол Улсын Засгийн газар ажиллаж байгаа. Дээрх нөхцөл байдлаас хамаарч олон улсын болон дотоодын шинжээчдийн зүгээс 2022 онд Монгол Улсын жилийн инфляцын түвшинг дунджаар 13.6 хувь, эдийн засгийн өсөлтийг 1-2.3 хувьд хүрнэ хэмээн төсөөлж байна.

Институт	2022 E	
	Инфляц	Эдийн засгийн өсөлт
Олон Улсын Валютын Сан	15.50%	1.00%
Азийн Хөгжлийн Банк	12.40%	2.30%
Монгол Банк	13.00%	2.50%
Дундаж	13.60%	1.93%

-Салбарын төлөв:

Үнэт цаас гаргагчийн голлох үйл ажиллагааны чиглэл нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон зээлийн үйлчилгээ билээ. 2021 оны жилийн эцсийн байдлаар Мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөлтэй 36 ББСБ, финтек шийдлийг ашиглан иргэдэд санхүүгийн үйлчилгээ хүргэж буй тогтворжсон 28 ББСБ, хөгжүүлэлтийн шатанд яваа 8 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Финтек шийдлээр аппликейшн ашиглан зээл олгодог 28 банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдэл нь 308.0 тэрбум төгрөг буюу нийт ББСБ-ийн салбарын зээлийн үлдэгдлийн 15.3 хувийг эзэлж байна. Зээлдэгчдийн тоогоор авч үзвэл финтек ББСБ-уудын нийт зээлдэгчдийн тоо 1.3 саяд хүрчээ. Энэ нь ББСБ салбарын нийт зээлдэгчдийн 80.4 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд нэг зээлдэгчид дунджаар 228.3 мянган төгрөгийн зээл олгосон байна. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг финтек шийдэл ашиглан хүргэж буй 2 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас Үнэт цаас гаргагч нь зээлийн үйлчилгээ, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хослуулан хүргэж буй анхны финтек компани юм.

Мөнгөн гуйвуулгын зах зээлийн төлөв:

Дэлхийн мөнгөн гуйвуулгын зах зээл өнгөрсөн оны байдлаар 705.5 тэрбум ам. доллараар хэмжигдэж байсан бөгөөд цаашид эх орноосоо өөр улс оронд амьдрах хүмүүсийн тоо тогтмол нэмэгдсээр байгаа тул энэ тоо өсөх нь тодорхой юм. Мөн түүнчлэн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ дижиталчлагдаж байгаатай холбоотойгоор гуйвуулгын шимтгэл буурч байна. 2021 онд дэлхийн хэмжээнд нийт онлайнаар хийгдсэн мөнгөн гуйвуулгын шимтгэл дунджаар 4.0 хувь байсан бол цаашид энэ тоо буурах төлөвтэй байгаа бөгөөд НҮБ-н тогтвортой хөгжлийн зорилт болох 3.0 хувийг ойрын хугацаанд хангахаар байна. Үнэт цаас гаргагч нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээндээ 0.6-1.3 хувийн шимтгэл авч үйлчилгээ үзүүлж байна.



-Зах зээлийн багтаамж:

“Сэндли ББСБ” ХХК-ийн үйлчилгээг мөнгөн гуйвуулга, хэрэглээний зээл, мерчантын зээл гэсэн үндсэн 3 сегментээр ангилан зах зээлийн багтаамжийг тооцоолов. Хэрэв “Сэндли ББСБ” ХХК нь дотоодын мөнгөн гуйвуулгын зах зээлийн 50 хувь, мерчантын зах зээлийн 20 хувь, хэрэглээний зээлийн зах зээлийн 5 хувийг эзлэх юм бол дараах үр дүн гарч байна.

Сэндли ББСБ-ийн зах зээлийн нийт багтаамж

Зах зээл		Сэндли	
Боломжит нийт зах зээлийн багтаамж	Дүн /төгрөг/	Зорилтот зах зээлийн багтаамж	Дүн /төгрөг/
Мөнгөн гуйвуулгын зах зээл	1.1 их наяд	Мөнгөн гуйвуулгын зах зээл	550 тэрбум
Мерчантын зээлийн зах зээл	1.2 их наяд	Мерчантын зээлийн зах зээл	240 тэрбум
Хэрэглээний зээлийн зах зээл	3.0 их наяд	Хэрэглээний зээлийн зах зээл	150 тэрбум
Нийт боломжит зах зээл	5.3 их наяд	Нийт зорилтот зах зээл	940 тэрбум



Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад Сэндли ББСБ үйл ажиллагаа явуулж буй мөнгөн гүйлгээ, мерчант болон хэрэглээний зээлийн зах зээлийн нийт багтаамж 5.3 их наяд төгрөг байна. Боломжит нийт зах зээлд эзлэх орон зайг тодорхойлохдоо Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, санхүүгийн нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогийг харгалзан авч үздэг.

3. Бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн хөрөнгө нь 2021 оны эцсийн байдлаар 10.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 4.6 дахин өссөн үзүүлэлттэй байна. Ирэх таван жилд нийт хөрөнгийн хэмжээ дунджаар 32.0 хувиар өсч 2026 онд 104.0 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Нийт хөрөнгөд эзлэх зээлийн хэмжээ дунджаар 94.0 хувьтай байх бөгөөд тус үзүүлэлтийн түвшин тогтвортой байж 2026 онд нийт хөрөнгийн 84.0 хувь буюу 87.3 тэрбум төгрөгт хүрэхээр төсөөлж байна. Үнэт цаас гаргагч нь бизнес төлөвлөгөөний дагуу зээлийн үйлчилгээг идэвхижүүлж, мөнгөн гуйвуулгын хэрэглээг нэмэгдүүлснээр санхүүгийн үзүүлэлтээ хангах бүрэн боломжтой хэмээн дүгнэж байна.

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН					
/Сая төгрөг/	2022E	2023E	2024E	2025E	2026E
Эргэлтийн хөрөнгө					
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,611.60	26.8	4,941.20	9,070.40	23,638.50
Нийт зээл	31,101.50	53,595.50	69,334.80	80,588.40	87,356.30
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	131.4	2,029.50	2,606.20	2,982.70	3,050.90
Бусад актив	31.5	487.1	625.5	715.8	732.2
Эргэлтийн хөрөнгийн дүн	33,563.00	52,756.10	71,698.10	84,943.60	103,658.40
Эргэлтийн бус хөрөнгө					



Барилга, байгууламж	0	0	0	0	0
Компьютер, тоног төхөөрөмж	137.4	161.8	133.3	60.9	78.6
Тавилга, эд хогшил	101.4	122.4	119.7	103.4	87.1
Биет бус хөрөнгө	40.9	40.9	40.9	40.9	40.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	279.7	325.1	293.9	205.2	206.6
НИЙТ ХӨРӨНГӨ	33,842.70	53,081.30	71,992.00	85,148.70	104,065.00
Өр төлбөр					
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	1,058.20	8,058.20	13,058.20	8,058.20	8,058.20
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	4,700.00	3,700.00	700	-1,300.00	-1,300.00
Мөнгөн гуйвуулгын өглөг	5,002.80	6,609.40	8,643.10	10,676.80	10,676.80
Бусад пассив	24.7	385.7	463.4	465.8	468.2
Өр төлбөрийн дүн	10,785.70	18,753.40	22,864.70	17,900.80	17,903.20
Эздийн өмч					
Энгийн хувьцаа	17,428.50	17,428.50	17,428.50	17,428.50	17,428.50
Тайлант үеийн ашиг (алдагдал)	4,896.50	11,271.00	14,799.40	18,120.60	18,913.90
Хуримтлагдсан ашиг (алдагдал) эхний үлдэгдэл	731.9	5,628.40	16,899.40	31,698.80	49,819.40
Хуримтлагдсан ашиг (алдагдал) эцсийн үлдэгдэл	5,628.40	16,899.40	31,698.80	49,819.40	68,733.30
Эздийн өмчийн дүн	23,056.90	34,327.90	49,127.30	67,247.90	86,161.80
НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧ	33,842.70	53,081.30	71,992.00	85,148.70	104,065.00

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН					
/Сая төгрөг/	2022E	2023E	2024E	2025E	2026E
Зээлийн бүтээгдэхүүний орлого	11,407.00	24,354.10	31,274.00	35,792.40	36,611.10
Зээлийн бүтээгдэхүүний зардал	-3,294.10	-4,951.40	-6,241.60	-6,236.20	-5,716.10
Зээлийн бүтээгдэхүүний цэвэр орлого	8,112.80	19,402.70	25,032.40	29,556.20	30,895.00
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого	1,135.80	2,450.10	3,416.50	4,382.90	4,382.90
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээтэй холбоотой шимтгэлийн зардал	-607.3	-1,217.20	-1,665.60	-2,114.10	-2,114.10
Апп-ын зардал	-96	-96	-96	-96	-96
Платформ ашигласны төлбөр	-76.9	-76.9	-76.9	-76.9	-76.9
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний цэвэр орлого	355.6	1,060.00	1,577.90	2,095.90	2,095.90
Нийт цэвэр орлого	8,824.00	21,522.60	28,188.30	33,747.90	35,086.70
Үйл ажиллагааны зардал	-3,324.50	-3,857.10	-4,633.90	-4,658.20	-4,681.70
ЕБИТDA	5,499.50	17,665.50	23,554.40	29,089.70	30,405.00
Элэгдлийн зардал	-58.9	-80.5	-88.7	-88.7	-81.8
ЕБИТ	5,440.60	17,584.90	23,465.60	29,001.00	30,323.20
Хүүгийн зардал	-	-	-	-	-
Татварын өмнөх ашиг (алдагдал)	5,440.60	17,584.90	23,465.60	29,001.00	30,323.20



Сэндли ББСБ ХХК Үйлчилгээний талчилцуулга



Татварын зардал	-499.9	-3,206.20	-4,571.90	-5,826.30	-6,156.80
Цэвэр ашиг (алдагдал)	4,896.50	14,088.70	18,499.20	22,650.80	23,642.40

Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн орлого үр дүнгийн тайлангийн төсөөлөл

MNT (сая.төг)	2022T	2023T	2024T	2025T	2026T
Нийт зээл	31,101.50	53,595.50	69,334.80	80,588.40	87,356.30
Хүүгийн орлого	11,407.00	24,354.10	31,274.00	35,792.40	36,611.10
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого	1,135.80	2,450.10	3,416.50	4,382.90	4,382.90

Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн зээлийн үзүүлэлтийн төсөөлөл

Сэндли ББСБ нь 2021 онтой харьцуулахад бизнес төлөвлөгөөний дагуу ирэх таван жилд зээлийн дундаж өсөлт нь 29.0 хувь буюу 87.3 тэрбум төгрөг, хүүгийн орлогыг 3.2 дахин өсгөж 36.0 тэрбум төгрөг байхаар төсөөлж байна. Харин мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлогыг 4.0 дахин өсгөж 4.4 тэрбум төгрөгт хүрэхээр төсөөлж байна.

4. Бизнесийн үнэлгээ, хувьцааны үнэ тогтоосон үнэлгээ

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний компани болох "Гэрэгэ эстимэйт" ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын Сангийн сайд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу Зах зээлийн харьцуулалтын хандлага, Хөрөнгөд суурилсан хандлага, Орлогын хандлагаар үнэлсэн.

Үнэлгээний өдөр: 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдөр

№	Арга	Үнэлгээ /сая.төг/
1	Зах зээлийн харьцуулалтын хандлага	43,696.60
2	Хөрөнгөд суурилсан хандлага	7,084.70
3	Орлогын хандлага	34,096.60

100% бизнес өмчлөлийн үнэ цэнэ	34,096,591,256 ₮
IPO-оор татах шинэ мөнгө	10,050,000,000 ₮
Эзлэх хувь	29.97%
Санал болгох ширхэг	67,000,000 ш
Нэмж хувьцаа гаргасны дараах ширхэг	223,570,000 ш


Үнэт цаас гаргагч нь нэгж хувьцаагаа олон нийтэд 150 төгрөгөөр санал болгож байгаа ба энэхүү үнэлгээ нь бизнесийн үнэлгээнээс 571,591,256 төгрөгөөр бага буюу 33,525,000,000 төгрөгөөр үнэлсэнээр санал болгож байна.

5. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө





Энд: БҮРТГЭЛТЭЙ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Үнэт цаас гаргагч нь өөрийн 67,000,000 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгож нийт 10,050,000,000 (арван тэрбум тавин сая) төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа билээ. Ийнхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн 99.5 хувийг өөрийн тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үндсэн үйл ажиллагааны эх үүсвэр, 0.5 хувийг эх үүсвэр босгох санхүүжилтэд зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

№	Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Өөрийн тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үндсэн үйл ажиллагааны эх үүсвэр	10,000.0 сая
2	Эх үүсвэр босгоход гарах зардал	50.0 сая

6. Эрсдэлийн бодлого

Үнэт цаас гаргагч нь “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг баталж эрсдэлийн удирдлагын тодорхойлолт, ангилал, төрөл, зарчим, хэмжих нэгж, үзүүлэлт, хүлээн зөвшөөрөх хязгаар, хяналт тавих асуудлыг тусган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахаас гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх журам” болон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг батлан мөрдөж байна. Дотоод хяналт шалгалтыг газар дээрх болон зайны гэсэн хэлбэрээр зээл, нягтлан бодох бүртгэл, салбарын үйл ажиллагаа, мэдээлэл технологи, компианс болон бусад гэсэн хүрээнд гүйцэтгэж байна.

Үнэт цаас гаргагч нь Covid-19 цар тахлын тархалт, дэгдэлтийн хугацаанд зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаанд болон өөрт учирч болох эрсдэлийг тооцон түүний сөрөг нөлөөг бууруулах, зайлсхийх эрсдэлийн удирдлагын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Байгууллагын дотоод сүлжээ, серверт зайнаас хандаж, онлайн горимоор ажиллах боломжийг fortclient программ ашиглан орон нутгийн бүх салбар, нэгжийн хүрээнд бүрдүүлсэн.
- Гамшгаас хамгаалах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан бүх нэгжид мөрдүүлсэн.
- 2021 онд нийт 295 мерчант зээлийн нэмэгдүүлсэн хүүг тэглэсэн.
- Цар тахлын нөлөө, барааны хомсдол, тээврийн үнийн өсөлт зэргээс шалтгаалан зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа доголдсон, зээлийн гэрээний хугацаа сунгах хүсэлт гаргасан 74 зээлдэгчийн 210 сая төгрөгийн зээлийн гэрээний бүтцэд өөрчлөлт оруулсан зэрэг болно.



Сэндли ББСБ ХХК Үндэс цаасны танилцуулга



Сэндли ББСБ нь зээлийн эрсдэлийн бодлогын хүрээнд нэг зээлдэгчид олгох зээлийн дээд дүнг бага байлгах, төвлөрлийн эрсдэлийг боломжит доод түвшинд барьдаг ба нэг зээлдэгчид ногдох зээлийн дүн 2021 оны эцсийн байдлаар 2.15 сая төгрөг байна. Чанаргүй зээлийн эзлэх хувь 2021 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцын 0.1 хувийг эзэлж байгаагаас харахад эрсдэлийн удирдлагыг зохистой хэрэгжүүлсэн хэмээн үзэж байна.

7. МХБ-ийн II ангиллын шалгуур хангасан тухай

Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн хувьцааны бүртгэлийн II ангиллын шалгуурыг хангаж байна.

Үнэт цаас гаргагчид тавигдах шалгуур:

Шалгуур	Хэрхэн хангаж байгаа тухай
Өргөдөл гаргахаас өмнө 2-оос доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх	Үнэт цаас гаргагч нь 2015 онд зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаа явуулж эхэсэн ба 2018 онд мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөл авсан.
Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна.	2020, 2021 оны санхүүгийн тайланд "Шонхор Үнэлгээ Аудит" ХХК аудит хийж, дүгнэлт гаргасан байна.
Компани бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капитал /эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн/-тай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан байх;	Үнэт цаас гаргагч нь 2021 оны жилийн эцсийн байдлаар 575.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах;	Үнэт цаас гаргагч нь СЗХ-оос батлагдсан ББСБ-ын үйл ажиллагаа явуулахтай холбоотой хууль, журмуудыг дагаж мөрдөхийн зэрэгцээ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Компанийн засаглалын сургалтанд хамрагдаж сертификат авсан, хараат бус гишүүн нь хуульд заасан шалгууруудыг хангасан, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан байгаа зэргээс үзэхэд компанийн засаглалын зарчмыг мөрддөг гэж үзнэ.

Үнэт цаасанд тавигдах шалгуурыг хангасан тухай:

Шалгуур	Хэрхэн хангаж байгаа тухай
Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 1 000 000 000 /нэг тэрбум/ төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийтэд санал болгож буй үнээр тооцно;	Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 150 төгрөгийн үнэтэй, нийт 156,570,000 ширхэг хувьцааг МХБ-д бүртгүүлэх юм. Энэхүү дүнгээр тооцоолж үзэхэд нийт зах зээлийн үнэлгээ 33.5 тэрбум төгрөг болж буй тул энэхүү шалгуурыг хангаж байна.





Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах;

Үнэт цаас гаргагч нь нийт 156,570,000 ширхэг хувьцааг МХБ-д бүртгүүлэх ба нийт хувьцааны 29.97 хувь буюу 67,000,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож байгаа тул энэхүү шалгуурыг хангаж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах;

Сүүлийн нэг жилийн хугацаанд бирж дээр гарсан нээлттэй хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд дунджаар 1,000-аас дээш хөрөнгө оруулагч оролцсон байна. Иймд энэхүү жишгээр хангах боломжтой хэмээн үзэж байна.

Богд банк ХК: 1,243 хөрөнгө оруулагч
Сентрал Экспресс Си Ви Эс ХК: 9,643 хөрөнгө оруулагч
Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК-ийн нэмэлт хувьцаа: 1,861 хөрөнгө оруулагч

Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр гаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.

УБЕГ-ын эдийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдээллийн сангаас шүүж үзэхэд Үнэт цаас гаргагчийн хувьцаа нь аливаа гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй байна.

8. Хөрөнгө оруулалтын боломж

Үнэт цаас гаргагч нь нэгж хувьцаагаа 150 төгрөгөөр олон нийтэд санал болгож байгаа бөгөөд 2022 онд бизнес төлөвлөгөөний дагуу ажиллахад хөрөнгө оруулагчид 37.0 хувийн өгөөж хүртэж болохоор таамаглагдаж байна. Доорх өгөөжийн тооцоолол нь үнэт цаас гаргагчийн ирэх таван жилийн санхүүгийн төлөвлөгөөнд үндэслэн хувьцааны дансны үнэ болон үржүүлэгчийн харьцаагаар тооцоолж таамагласан бөгөөд үржүүлэгчийг үнэлгээний тайлангийн жишгээр авсан болно.

Үнэт цаас гаргагч нь ногдол ашгийн бодлогодоо жил бүрийн цэвэр ашгийн 20 хувиас доошгүй хэмжээний ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Энэхүү шийдвэрийн дагуу дараагийн таван жилийн санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан цэвэр ашгаас тооцож гаргасан болно.

Нэгж хувьцааны өгөөж	2022E	2023E	2024E	2025E	2026E
Нийт хувьцааны ширхэг	223,570,000	223,570,000	223,570,000	223,570,000	223,570,000
Цэвэр ашиг (сая төгрөг)	4,896.50	14,088.70	18,499.20	22,650.80	23,642.40
Эздийн өмч (сая төгрөг)	23,056.90	34,327.90	49,127.30	67,247.90	86,161.80
Дансны үнэ	103.1	153.5	219.7	300.8	385.4
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	21.9	63	82.7	101.3	105.7
Ногдол ашиг 20%	4.4	12.6	16.5	20.3	21.1
Эздийн өмчийн үнэлгээ (P/B)	1.99	1.99	1.99	1.99	1.99
Боломжит (P/B)-д суурилсан ханш	205.2	305.6	437.3	598.6	766.9





Сэнди ББСБ ХХК - Үнэт цаасны танилцуулга



Жилийн өгөөж	37%	49%	43%	37%	28%
IPO өгөөж 150₮	37%	53%	119%	199%	283%
Боломжит нийт үнэлгээ (сая төгрөг)	45,883.20	68,312.50	97,763.30	133,823.30	171,462.00

Эх сурвалж: 2026 оныг хүртэлх жил бүрийн хувьцааны ханшийн таамаг: жишиг P/B=1.99(Үнэлгээний тайлан)

9. Хөрөнгө оруулагчдад зөвлөх нь

Дээрх өгөөжийн хүснэгтэд дурдсанчлан хөрөнгө оруулагч нь эхний жилдээ 37 хувь, урт хугацаандаа буюу ирэх 5 жилд 283 хувийн өгөөж хүртэхээр таамагласан болно. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн зүгээс хөрөнгө оруулагчдын өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс цэвэр ашгийн 20 хувийг ногдол ашиг болгон тогтвортой тараах бодлого баримталж байна. Цаашлаад стратегийн хөрөнгө оруулагчид нь олон нийтэд санал болгох хувийн 75 хувийг бүрдүүлж байгаа нь зах зээл дээрх ханшийн хэт савалгаанаас урьдчилан сэргийлэх боломжтой хэмээн үзэж байна.

Хөрөнгө оруулалтын өгөөжийн тооцооллыг Үнэлгээний компанийн бизнесийн үнэлгээний тайлан, үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө, зах зээлийн багтаамж, ирээдүйн боломж дээр үндэслэн гаргасан боловч хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргахад өгөөж болон эрсдлийг хамтад нь харж, дүгнэх хэрэгтэй. Дэлхийн нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал нэмэгдэж буй өнөө үед илүү олон төрлийн эрсдэлийн хүчин зүйлс байх тул үнэт цаасны танилцуулгын “Эрсдэлийн удирдлага” хэсэгтэй танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахыг зөвлөж байна.





Сэндли ББСБ ХХК - Үнэт цаасны танилцуулга

2022.08.10 өдөр

БҮРТГЭВ

№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРХ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2022-08-05

БҮРТГЭВ-03

АУДИТЫН ДҮГНЭЛТ
/2021 оны жилийн аудитлагдсан тайлан/



ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
SHONKHOR UNELGEE AUDIT LLC



АУДИТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
AUDIT AND CONSULTING SERVICE

АУДИТОРЫН ТАЙЛАН

"СЭНДЛИ ББСБ" ХХК-ийн

**2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
санхүүгийн тайлан**

Улаанбаатар хот

2022 он



141

СЗХ
2022 оо. 08. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-05
БҮРТГЭВ-03

АГУУЛГА

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ
АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

АУДИТЛАГДСАН САГХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭЛГҮЙ ТАЙЛАН
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
ТОДРУУЛГА



2022-08-05

БҮРТГЭВ-03



КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

"СЭНДЛИ ББСБ" ХХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ :

9

КОМПАНИЙН УДИРДЛАГА:

Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл

Нягтлан бодогч: О.Нямдэлэг

Утас: 99998149

И-МЭЙЛ: nyamdeleg@hipay.mn

РЕГИСТЕРИЙН ДУГААР:

5961548

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Зээлийн үйл ажиллагаа, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, Гадаад валютын арилжаа, Факторингийн үйлчилгээ, Төлбөрийн баталгаа гаргах, Итгэлцлийн үйлчилгээ

КОМПАНИЙН ХАЯГ:

УБ, ЧД, I хороо, Жуулчин, Бизнес-34 центр, А корпус, I тоот

Утас: 70177700

АУДИТЫН КОМПАНИ

"Шонхор үнэлгээ Аудит" ХХК

ХАЯГ:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 6 хороо



Сүхбаатар-13, 302 дугаар барилга, 6 давхарг 603 тоот

Захирал: Д.Шийрэв

Утас: 70150001, 80110088

Вэб хуудас: www.shonkhor.mn





“Сэндли ББСБ” ХХК-ийн
хувьцаа эзэмшигчдэд

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110008

Налам шуудал: www.shonkhor.mn

И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2022 08 27 № 22/144

талаар _____ -ны № _____ -т

АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Сэндли ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Сэндли ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгатгын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.





Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөн толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд логоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг баримтлан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудитормын хүлээх үүрэг, хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөн бөгөөд шударгаар толилуулагдсан эсэх талаар боломжит үндэслэлтэй баталгааг олж авах, түүнчлэн аудитормын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй бүхий залилан ба алдааг бүрэн илэрхийлдэг гэсэн баталгаа биш юм.

Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг. АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг.

Бусад


Энэхүү дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн ба дүгнэлтийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ЗАХИРАЛ

Д.ШИЙРЭВ







АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайланг үе

"СЭНДЛИ ББСБ" ХХК

(төгрөгөөр)



Балансын зүйл	2021.12.31	2020.12.31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	1,169,363,301	925,009,112
Зээл /цэврээр/	8,600,430,536	663,053,489
Бусад авлага	505,485,394	221,145,333
Бусад хөрөнгө	119,721,695	3,701,245
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	10,395,000,926	1,812,909,179
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	168,744,585	16,678,436
Биет бус хөрөнгө	40,890,000	59,849,781
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	209,634,585	76,528,218
Нийт хөрөнгийн дүн	10,604,635,512	1,889,437,397
Өр төлбөр		
Банк, санхүүгийн бйгууллагаас авсан богино хугацаат зээл	100,000,000	
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,580,000,000	
Мөнгөн гуйвуулгын өглөг	726,843,801	
Бусад өр төлбөр	50,586,982	333,838,564
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,457,430,783	333,838,564
Нийт өр төлбөрийн дүн	3,457,430,783	333,838,564
Эздийн өмч		
Энгийн хувьцаа	6,428,500,000	1,428,500,000
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	718,704,729	127,098,833
Эзэмшигчдийн өмчийн дүн	7,147,204,729	1,555,598,833
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	10,604,635,512	1,889,437,397





АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлант үе

"СЭНДЛИ ББСБ" ХХК		(төгрөгөөр)
ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2020.12.31
Хүүгийн орлого	558,315,550	444,601,492
Хүүгийн зардал	1,436,605	-
Цэвэр хүүгийн орлого	556,878,945	444,601,492
Хүүгийн бус орлого	1,808,592,217	328,768,012
Хүүгийн бус зардал	1,706,887,766	537,272,887
Цэвэр хүүгийн бус орлого зардалын дүн	101,704,451	(208,504,876)
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал	658,583,396	236,096,616
Болзошгүй эрсдэлийн зардал	7,792,956	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг	650,790,440	236,096,616
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	222,182
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	30,346,312	30,805,600
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	620,444,128	205,513,199
Орлогын татварын зардал	45,236,232	12,905,800
Цэвэр ашиг	575,207,896	192,607,399





СЭХ
2022.08.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ООРЧЛОЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлант үе

"СЭНДЛИ ББСБ" ХХК

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,428,500,000	(45,186,465)	1,383,313,535
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(20,322,100)	(20,322,100)
Залруулсан үлдэгдэл	1,428,500,000	(65,508,565)	1,362,991,435
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		192,607,399	192,607,399
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,428,500,000	127,098,833	1,555,598,833
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		16,398,000	16,398,000
Залруулсан үлдэгдэл	1,428,500,000	143,496,833	1,571,996,833
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		575,207,896	575,207,896
Хувьцаат капиталын өсөлт	5,000,000,000		5,000,000,000
2022 оны 6 дугаар сарын 30-ны үлдэгдэл	6,428,500,000	718,704,729	7,147,204,729



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БАНХ
КОМСОЛАН ЯТӨК Ж.СҮТЛЭХОВ
2022-08-05
БҮРТГЭВ-03



СЭХ
2022.08.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-05
БҮРТГЭВ-03

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлант үе

"СЭНДЛИ ББСБ" ХХК

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2020.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	274,700,501	254,383,981
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	2,199,391,707	773,369,503
Зээлийн хүүгийн орлого	558,315,550	444,574,922
114 Харилцах дансны хүүгийн орлого		26,570
Гадаад валютын арилжааны орлого	59,386,200	285,875
Гадаад валютын ханшийн зөрүү	84,040,900	
Мөнгөн гуйвуулгын орлого	260,027,532	80,149,227
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,237,621,525	
Бусад үйлчилгээний орлого		248,332,910
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	1,924,691,206	518,985,522
Үндсэн ба нэмэгдэл цалин	380,426,106	112,184,040
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж		375,000
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	43,510,181	5,722,669
Албан гомлолт, сургалтын зардал	8,545,100	977,978
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	131,949,245	
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг кэрэгсэлд төлсөн мөнгө	47,544,400	4,249,512
Бичигт хэргийн зардал, арнун цэврийн зардал	14,416,170	1,197,770
Татвар, даатгалын төлсөн мөнгө		1,000,000
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	176,223,201	10,949,363
Зээл болон түүнтэй холбоотой авлагын барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	274,500	9,851,000
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	27,825,500	
Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарах мөнгө		9,000,000
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	275,647,355	256,341,039
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө		2,320,000
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	818,329,449	104,817,152
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(30,346,312)	637,157,900
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	-	667,963,500
Бусад		667,963,500
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	30,346,312	30,805,600
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	19,803,012	305,600
Торгуулийн зардал		30,500,000
Бусад	10,543,300	
Бүт шөвтр мөнгөн гүйлгээ	244,354,189	891,541,881
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн зүйлийн өлдгээл	925,009,112	33,467,231
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн зүйлийн үлдэгдэл	1,169,363,301	925,009,112






МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE


2022-08-05

БҮРТГЭС-03

Агуулга

Агуулга	0
1. Компанийн талаарх мэдээлэл.....	1
2. Нягтлан болох бүртгэлийн гол бодлогуудын товчоо.....	1
3. Хүү болон хүүгийн бус орлого	7
4. Хүүгийн болон хүүгийн бус зардал.....	7
5. Удирдлагын болон үйл ажиллагааны зардал.....	7
6. Орлогын тагварын зардал	8
7. Монгол хөрөнгө түүнтэй адилтгах хөрөнгө.....	8
8. Зээл болон хүүгийн аялага	9
9. Бусад хөрөнгө.....	9
10. Үлдсэн хөрөнгө.....	10
11. Биет бус хөрөнгө /Программ хангамж/	10
12. 10.Зээлээр авсан санхүүжилт	10
13. 11.Итгэлцлийн үйлчилгээний өслөг.....	11
14. Бусад өр төлбөр.....	11
15. Хувьцаат капитал болон нөөц сангуул.....	11
16. Эрдэлийн удирдлагын тодруулга.....	12
17. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт	17
18. Холбоотой талуудын ажил гүйлгээ	18
19. Бусад тодруулга	19





1. Компанийн талаарх мэдээлэл

Сэндли ББСБ ХХК нь 2015 оны 5 сард банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор илх Гяле кредит ББСБ нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. Монгол улсын бүртгэлийн албанд бүртгэгдсэн аж ахуйн нэгжийн регистрийн дугаар 5961548, улсын бүртгэлийн дугаар 9015003084. Тус компанийн хувьд 2021 оны сүүлийн хагас жилээс хойш үйл ажиллагаагаа идэвхижүүлэн оргожүүлсэн байгаа бөгөөд 2021 оны 12 дугаар сард оноосон нэрээ өөрчлөн Сэндли ББСБ ХХК болгон оорчилсон байна. Одоогийг байдлаар Улаанбаатар хотод 6 салбар, Орон нутагт 48 салбартайгаар Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлж байна.

Тусгай зөвшөөрөл авсан үйл ажиллагааны төрлүүд:

- Зээлийн үйл ажиллагаа
- Цахым төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа
- Гадаад валютын арилжаа
- Итгэлцлийн үйл ажиллагаа
- Факторингийн үйлчилгээ
- Төлбөрийн баталгаа гаргах

Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, 40/50 мянгат Бакулд Рөнбүтигийн гудамж 8/4 тоот.

2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

Тайлан бэлтгэх үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангуудыг "Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого"-ын дагуу толилуулсанаар бэлтгэсэн.

Сэндли ББСБ-ын санхүүгийн тайлангууд нь түүхэн оргийн зарчим дээр үндэслэн бэлтгэгдсэн байна. Санхүүгийн тайлан болон тодруулга дахь дүнгүүдийг Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Монгол тогрогөөр мянгачинан тайлагнасан.

Өороор заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэл тууштай мөрдсөн болно.

Санхүүгийн хэрэглүүрүүд – Хэмжилтийн үндсэн нэр томъёо

Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас нь хамааруулан бодит үнэ цэнэ эсвэл хорголдуулан ортгоор дор тайлбарласны дагуу бүртгэлд тусгадаг.

Бодит үнэ цэнэ нь ажил гүйцээг бүртгэх өдрөөр тухайн зах зээлд оролцогчдын хоорондын арилжаагаар байнга хийгдэх хөрөнгийн худалдаа эсвэл өр төлбөрийг шилжүүлэх үнэ юм. Бодит үнэ цэнийг хамгийн сайн илэрхийлэх дүн нь тухайн илэхтэй зах зээлийн арилжааны үнэ юм. Илэхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйн түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ.

Илэхтэй зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцохдоо тухайн хөрөнгө болон өр төлбөрийн үнэ болон тухайн байгууллагын эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн тоо ширхэгээр үржүүлэн гаргана.

Гадаад зах зээлийн үнийн мэдээлэл авах боломжгүй санхүүгийн зарим хэрэгслийн бодит үнэ цэнийг хэмжихэд бэлэн мөнгөний урсгалын хөнгөлөлттэй занвар эсвэл сүүлийн үеийн гүйлгээний дүн эсвэл хөрөнгө оруулагчдын санхүүгийн мэдээллийг харгалзан үзэх зэрэг үнэлгээний аргачлалыг ашигладаг.

Бодит үнэ цэнийг дотор нь түвшингээр нь ангилан тодорхойлох ба эдгээр түвшинг дараах байдлаар тодорхойлно. Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийг илэхтэй зах зээл дэх зарласан (зохируулаагүй) үнийг ашиглан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 1-р түвшин, тухайн хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой шууд (үнэ) болон шууд бус (үнэ) боломжит өгөгдлүүдийг ашиглан, үнэлгээний аргуудаар бодит үнэ цэнийг тооцоолон гаргасан бол 2-р түвшин, зах зээл дээрх бэлэн өгөгдлүүд дээр бус зах зээл дээр мэдэгдэхгүй байгаа өгөгдлүүдийг илүү тулгаарлан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 3-р түвшингийн бодит үнэ цэнэ гэж тус тус ангилна.

Өртөг гэдэг нь хөрөнгийг худалдан авах үед мөнгөөр болон бусад хэлбэрээр төлсөн төлбөрийн бодит үнэ цэнэ бөгөөд үүнд хөрөнгө худалдан авахтай холбоотой гарсан ажил гүйлгээний зардлууд ч мөн багтана. Бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй эсвэл хөрөнгийн зах зээлээс үнийг нь





тодорхойлох боломжгүй, өмчөөрх хороого оруулалт болох дээрхтэй адилаар өмчийн хэрэглүүрээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг өртгөөр нь хэмжинэ.

Гүйлгээний зардал нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шингээр гаргах эсвэл борлуулахтай шууд

холбоотой нэмэлт зардал юм. Нэмэлт зардал гэдэг нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх байсан зардал юм. Гүйлгээний зардалд эзэл олгох, нягтлан бодох бүртгэл хөтөлөх үүрэг гүйцэтгэж буй ажиллагаад эзлэх, хуулийн болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулалтын үйлчилгээний төлбөр болон банкны шимтгэл, хураамж төлбөрүүд, мөн гадаад гүйлгээ, дотоодын банк, банк санхүүгийн байгууллагад шилжүүлэх өр төлбөрийн шилжүүлэг, ХАОАТ-агвар, Нийгмийн даатгалын байгууллагад төлөх татвар хураамжууд хамаарна. Мөн гүйлгээний зардалд репо зээлийн өрийн хямдруулалт буюу нэмэгдэл, санхүүжилтийн зардлууд, дотоод удирдлагын буюу нэгэлшлийн үйлчилгээний өгчлөгийн зардлууд орно.

Хуримдуулсан өртөг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үнэсэн дүнгийн аливаа

эргэн төлөлтийг хасан, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ гөнийн бузралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд шх хүлээн зөвшөөрөх үед хойшшуулсан

гүйлгээний зардал, мөн үнийн аливаа нэмэгдэл эсвэл хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүний орлого, хуримтлагдсан хүүний зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшигдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй бөгөөд гэдгээрийг санхүүгийн байшлын тайлан дахь холбогдох зүйлийн дансны үндэл оруулан тусгасан болно.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардалыг хугацааны туршид дагсны үнээс

тооцогдох хүүний хувийг тогтмол байнгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт үүний хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцогдсон мөнгөн орлого, гарах зардалыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискантлаж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүний хувь болно.

Үр ашигт хүүний хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалын хүүг оорчлох дараагийн мөч хүртэл дискантлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөнөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүний зөрүүг илэрхийлсэн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг мөн зах зээлийн түвшинд тохируулагдмалгүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Тийм нэмэгдэл, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна.

Өнөөгийн үнэ гөнийн тооцоололд гэрээний галуудын хооронд өгч авалдах бүх хураамжийг оруулах бөгөөд

тэдгээр нь үр ашигт хүүний бүрэлдэхүүн хэсэг болно.

Санхүүгийн хөрөнгийн ангилал

Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. (а) эзэл болон авлага; (б) худалдан борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө; (в) дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө; болон (г) бодит үнэ гөнийн

өөрчлөлт нь орлого, үр дүнтэй тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө. Бодит үнэ гөнийн оорчлолт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийг дотор нь 2 ангилдаг: (i) анх хүлээн зөвшөөрөх

үед ийнхүү ангилагдсан, бv (ii) худалдан борлуулах зорилгоор эзэмшихээр болсон. ББСБ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн хөрөнгө нь бүгд "эзэл болон авлага" хэмээн ангилагдсан. Эзэл болон авлагад ББСБ нь ойрын хугацаанд худалдан борлуулах зорилготой байгаа санхүүгийн хөрөнгүүдээ бусад тодорхойлж болохуйн эснэл тогтмол төлбөртэй, деривативгүй, харьцуулагдахуйц бус санхүүгийн хөрөнгүүд орно.

Санхүүгийн ор толборийн ангилал

ББСБ-ын бүх санхүүгийн өр төлбөрүүдийг бусад санхүүгийн ор толбор ангилалд ангижж, хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.





Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх

Бүх санхүүгийн хэрэглүүрүүдийн анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр бүртгэгдэг. Анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн найдвартай нотолгоо нь тухайн ажил гүйлгээний үнэ байдаг. Бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн хооронд зөрүү үүссэн тохиолдолд тухайн зөрүү дүнгээр анхдагч хүлээн зөвшөөрөлтийн олг, тархыг бүртгэх бөгөөд энэхүү бодит үнэ цэнэ нь ижил төрлийн хэрэглүүрийн саяхан арилжаалагдсан дүн болох нь эсвэл явахын зах зээл дээрээ бэлэн олж болохуйн мэдээлэл дээр үндэслэж үйлгээний арилчлааар тооцсон болох нь нотлогдсон байх ёстой. Тухайн санхүүгийн хэрэглүүрийг зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("энгийн" худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан хүлээлгэн өгөх шаардлагаатай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдаа, худалдан авалтын арилжаа хийсэн өдөр буюу ББСБ нь санхүүгийн хөрөнгийг хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн өдрөөр хүлээн зөвшөөрнө. Бусад бүх худалдан авалтыг ББСБ нь санхүүгийн хэрэглэлийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх

ББСБ-ын санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг хүлээн авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) ББСБ нь хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусад шилжүүлэн өгсөн эсвэл шаардлага хангасан, дамжуулан өгөх хэлцэлд оролцсоны үр дүнд (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлээгүй мөн авч үлдээгүй болонч хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Нөгөө тал нь хөрөнгийг бүхэл нь гуравдугч этгээдэд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр борлуулах бодит боломжгүй байгаа нөхцөлд хяналтын авч үлдсэн тооцоо.

Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх

Санхүүгийн өр төлбөрийн төлөх үүргийн хугацаа дууссан, санхүүгийн өр төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдсөн болон уг өр төлбөрийг төлөх үүрэг дуусгавар болсон үед санхүүгийн өр төлбөрийг данснаас хасна.

Санхүүгийн өр төлбөрийн хугацаа дуусаагүй үед тухайн өр төлбөрийн нөхцөл ихээхэн өөрчлөгдсөн үед эсвэл эсэлдүүлэгчээс хуучин өр төлбөрийнхөө оронд өөр нөхцөлтэй, шинэ өр төлбөр сольж хүлээж авсан тохиолдолд өмнөх өр төлбөрийг данснаас хасч, шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх бөгөөд шинэ болон хуучин өр төлбөрийн дансны үнийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Хоргодуулсан ортгоор бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

"Банк бус санхүүгийн байгууллагын тээлийн активыг ангилах, активын эрэлгийн сан байгуулах, зарцуулах" журмыг СЭХ-ны дарга болон Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг журмын дагуу олгосон тээлийг хугацаа хэтэрсэн хоногос хамааран 5 ангилал ба ангилал тус бүр урьдчилан тогтоосон, тогтмол хувиар үнэ цэнийн бууралтын санг тооцоолдог.

Тээлийн үнэ цэнийн бууралтын санг тооцоох хувийг доорх хүснэгтээр харуулав:

	Хэвийн	Хугацаа	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
		хэтэрсэн			
Хугацаа хэтэрсэн хоног	Хугацаандаа төлөгдөж байгаа	1-90 хоног	91-180 хоног	181-360 хоног	360 хоногос дээш
Тээлийн эрсдэлийн сангийн хувь %/	0%	5%	25%	50%	100%

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө, банкинд байршуулсан харилцах, хугацаагүй хадгаламжууд, банкинд 3 сар болон түүнтээ бага хугацаатай байршуулсан богино хугацааг хөрвөх чадвар оцортэй хөрөнгө орууллагууд орно. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хоргодуулсан өртгөөр бүртгэнэ. Хязгаарлалттай дансуудыг мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.





Үндсэн хөрөнгө

ББСБ-ын эзэмшиж буй үндсэн хөрөнгүүдийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын

хасагдуулгыг хассан дүнгээр тусгана. Урсгал засвар, үйлчилгээний өртгийг гарсан үед нь зардлаар бүртгэнэ.

Үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн томоохон бүрэлдэхүүн хэсгийг шинэчилсэн бол, холбогдох өртгийг капиталжуулж, хуучин сольсон хэсгийн дансны үнийг зарлагадана.

Тайлант хугацааны эцэст удирдлага үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх аливаа үзүүлэлт байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв ийм үзүүлэлт байгаа нөхцөлд хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох ба энэ хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөрөөр тодорхойлогддог. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулан үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэдэг. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан тооцоолол өөрчлөгдсөн нөхцөлд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж болно.

Хөрөнгө борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг дансны дүнтэй харьцуулан тооцож, тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ (үйл ажиллагааны бус орлого, зардал хэсэгт).

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

Ашиглалтын хугацаа /жилээр/

Барилга	40 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	3 жил

Хэрэв хөрөнгө хуучирсан, ашиглалтын хугацаа нь дууссан бол хөрөнгийн үлдэх өртгийг ББСБ-ын хөрөнгийг борлуулах боломжит үнээс худалдан борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээр тооцоолно. Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст хянаж, шаардлагатай гэж үзвэл өөрчилнө.

Биет бус хөрөнгө

Гүүдвэлээс бусад биет бус хөрөнгө нь ашиглах тодорхой хугацаатай бөгөөд ББСБ-ын үндсэн биет бус

хөрөнгө нь компьютерийн програм хангамж юм.

Худалдан авсан программ хангамжийг өртөг дээр нь тэдгээрийг ашиглахад бэлэн болгохтой холбогдон

гарсан зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгүүдийг тэдгээрийн ашиглагтын хугацааны туршид шулуун шугамын аргаар хөрогдуулна:

Ашиглалтын хугацаа, жилээр

Поларис нягтлан бодох бүртгэлийн програм	10 жил
--	--------

2021 оны ДНБ-ний өсөлтийн бүрэлдэхүүнийг зарим салбараар авч үзвэл уул уурхай 1.7%-иар, санхүү болон даатгалын үйл ажиллагаа 7.2%-иар тус тус өсөж, барилга -32.7%-иар, тээвэр агуулахын үйл ажиллагаа -16.7% тус тус буурчээ. "Trading economics" байгууллагын судалгаагаар 2022 онд Монгол Улсын ДНБ-ний бодит өсөлт 5.5%, 2023 онд 6% байхаар таамаглажээ.⁴

2026 он хүртэлх Монгол Улсын нэрлэсэн ДНБ, инфляцийн төсөөллийг Олон Улсын Валютын Санг 2021 оны 10-р сард тооцоолсноор доорх хүснэгтэд үзүүлэв.⁵


Хүснэгт 2: Монгол Улсын ДНБ-ний төсөөлөл, 2022 - 2026

	2021	2022	2023	2024	2025	2026
Нэолэсэн ДНБ, тэрбум төг	41,592.2	48,065.3	54,806.4	61,851.8	69,282.7	77,102.4
Өсөлт, %	12.5%	15.6%	14.0%	12.9%	12.0%	11.3%
Инфляци, %	7.0%	7.5%	7.0%	6.5%	6.0%	6.0%

Олон улсын валютын сангийн мэдээлснээр дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд 5.9% байсан бол 2022 онд 4.4%, 2023 онд 3.8% болно гэж таамаглаж байна. Энэ нь дэлхийн хоёр том зах зээл болох АНУ-ын мөнгөний нийлүүлэлтийг багасгах хатуу бодлого, Хятад улсын Ковид-19-ийн эсрэг хатуу хөл хорио болон барилгын салбар дахь санхүүгийн дарамт зэргээс ихээхэн шалтгаалж байна. Ойрын хугацаанд инфляцийн түвшин мөн өндөр хэвээр байхаар байна. Хөгжингүй орнуудын хувьд дундаж инфляцийн түвшин 2022 онд 3.9%, хөгжиж буй орнуудын хувьд 5.9% байхаар байна.⁶

ДНБ-д санхүү болон даатгалын үйл ажиллагаанаас олох орлогын эзлэх хувь жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Санхүү болон даатгалын үйл ажиллагаанаас олсон орлого 2016 онд ДНБ-ий 3.8%-ийг эзэлж байсан бол 2021 онд 5.1% хүртэл өсөн нэмэгдсэн байна.⁷

Зураг 2: ДНБ-д санхүү болон даатгалын үйл ажиллагааны эзлэх хувь



Ханш

Монголбанкны мэдээлснээр төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2021 оны жилийн эцсийн байдлаар 2,849.34 төгрөг, тайлангийн өдөр буюу 2022 оны 5-р сарын 9-ний өдрийн байдлаар 3,099.90 төгрөг болсон байна.

Инфляци

Мөнгөний зах зээлийн хувьд Монголбанкны бодлогын хүү 2016 онд хамгийн дээд түвшин буюу 15% хүрч байсан ба аажмаар буурч 2021 оны эцэст 6.0% болсон ба 2022 оны 3-р сарын

⁴ <https://tradingeconomics.com/mongolia/gdp-growth-annual>
⁵ IMF. World Economic Outlook (WEO) Database, October 2021
⁶ Дэлхийн эдийн засгийн тойм, 2022 оны 1-р сар, Олон улсын валютын сан
⁷ <http://1212.mn>





24-ныг өдөр 9.0% болж өсөөд байна. Инфляцийн түвшин 2022 оны 3-р сарын байдлаар улсын хувьд 14.4%, Улаанбаатар хотын хувьд 15.8% болсон нь инфляцын зорилтот 6% (+/-2%)-иас харьцангуй их байсаар байна.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын өнөөгийн байдал

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны мэдээлснээр⁸ 2008 онд 131 ББСБ байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 534 тусгай зөвшөөрөлтэй ББСБ байна. ББСБ нь нийт 10 төрлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх боломжтой байдаг. Үүнээс 92.9% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт 4.8 сая харилцагч бүртгүүлсэн бол нийт 1.7 сая зээлдэгч зээл авсан байна. Салбарын нийт орлого 521.3 тэрбум төгрөг, үүнээс хүүгийн орлого 421.7 тэрбум төгрөгт хүрчээ. Зээлийн жигнэсэн дундаж хүү 2021 оны эцсийн байдлаар 2.7%, дундаж зээлийн хэмжээ 1.2 сая төгрөг, чанаргүй зээлийн нийт эзэлд эзлэх хувь 7.0% байна.

2021 оны байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 51.6 хувиар буюу 685.2 тэрбум төгрөгөөр, 2017 оноос 215.4 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр өсөж оны эцэст 2.0 их наяд төгрөгийн швэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Үйл ажиллагааны хувьд ангилж авч үзвэл зээлийн үйлчилгээ эрхэлж буй 496, гадаад валютын арилжаа эрхэлж буй 146, итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй 49, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ эрхэлж буй 36 ББСБ байна.

Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-үүд нийт 331 салбартай байна. ББСБ-ын байршлыг зургаалаар харуулбал дийлэнх нь буюу 84.5 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна.

Финтек ББСБ-ын салбар

Финтек 28 ББСБ байгаагаас зөвхөн технологид сүүрилсэн 11, технологи болон уламжлалт үйл ажиллагаа эрхэлдэг 17 ББСБ байна.

Хүснэгт 3: Финтек, уламжлалт ББСБ-ын зарим үзүүлэлтийн харьцаа

ББСБ-ын хэлбэр	Нийт звал		Звалдэгч		1 авалдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /млн.төг/
	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%	
Финтек	308.0	15%	1,349,116	80%	228.3
Уламжлалт	1,704.2	85%	329,023	20%	5,179.4
Нийт	2,012.2	100%	1,678,139	100%	1,199.1

Салбарын нийт харилцагчдын 92.1% нь эдгээр финтек ББСБ-ын харилцагчид буюу технологид сүүрилсэн зээлийн үйлчилгээг хүртэх боломжтой байна. Нийт зээлдэгчдийн 80% нь зөвхөн гар үтсаараа дамжуулан зээл авч байна. Иймд финтек ББСБ нь зээлдэгчдийн тоогоор уламжлалт ББСБ-уудын зээлдэгчдийн тооноос хэд дахин илүү байгаа нь энэ төрлийн зээлийн эрэлт хэрэгцээ, мөн зээлдэгчдийн зээлийн үйлчилгээний чиг хандлага өөрчлөгдөж байгааг илтгэн харуулж байна.

2021 оны байдлаар санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 94.4%-ийг хэвийн зээл, 1.9%-ийг хугацаа хэтэрсэн зээл, 3.7%-ийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

⁸ http://www.frc.mn/resource/frc/Document/2022/02/22/fwt96cb8gasrhrw/20220210_nbf_report_site.pdf



Зураг 3: Финтек болон уламжлалт ББСБ-ын алгаа



Зөвхөн технологид суурилан зээл олгодог ББСБ-уудын хувьд салбарын нийт зээлийн үлдэгдэлд бага хувь эзэлж байгаа ч олгосон болон төлөгдсөн зээлд эзлэх хувиас харахад эдгээр ББСБ-уудын зээлийн эргэлт, эргэн төлөлт сайн байгаа нь харагдана.

4. КОМПАНИЙН ТУХАЙ

Сэндли ББСБ ХХК-ийн 98.11%-ийн хувьцаа эзэмшигч нь Монголын Финтек Групп хаалттай хувьцаат компани бөгөөд үлдсэн 1.89%-ийг ажилчид нь эзэмшиж байна. Монголын Финтек Групп ХК-ийн хувьцаа эзэмшигч нь Монголиан Мючүал Финанс Групп ХХК бөгөөд тус компанийн 100%-ийн өмчлөгч нь Сингапур улсад бүртгэлтэй Mongol Mutual Pte.Ltd компани юм.

“Монголын финтек групп” ХК нь финтеи технологид суурилсан бизнес эрхлэгч өөрийн охин компаниудыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай холбох, олон улсад тэдгээрийн бизнесийг таниулах, өргөжүүлэн тэлэх гүүр нь буюу “Санхүүгийн Холдинг” компани болох зорилгоор байгуулагдсан, финтек чиглэлээр ажилладаг 12 охин компанийн нэгдэл бөгөөд тэдгээрийн нэг нь дэлхийн зах зээлд гаргахаар ажиллаж байгаа олон улсын мөнгөн гүйвүүлгын Sendly англижэйшн юм. Тайлангийн өдрийн байдлаар Америк, Австрали, Япон дахь монголчуудад мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ үзүүлж, 15 мянга орчим идэвхтэй хэрэглэгчтэй болсон байна. Энэхүү аппаар дамжуулан өнгөрсөн хугацаанд 8.7 сая ам.доллар буюу 24.8 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний валют Монгол Улсын эдийн засагт оржээ. Ойрын хугацаанд Sendly Европын холбооны орнууд, Өмнөд Солонгосын зах зээлд үйлчилгээгээ нэвтрүүлж, гадаадад сүүгээ нийт монголчуудад хүрч ажиллахаар зорьж байна.

Sendly аппыг монгол мэргэжилтнүүд хөгжүүлсэн бөгөөд олон улсад өрсөлдөхүйц түвшний мөнгөн гүйвүүлгын бие даасан систем хөгжүүлж дундын зуучлагчдын оролцоо, шат дамжлагыг халж шимтгэлийг хамгийн бага хэмжээнд барих, богино хугацаанд гүйлгээ хийх боломжийг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна. Олон улсад өөрийн гэсэн бие даасан сүлжээг бий болгосноороо өнгөрсөн 30 жилийн турш гадаадын аль нэг мөнгөн гүйвүүлгын компанийн төлөөлөгч болж энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлж ирсэн Монгол Улсын санхүүгийн бусад байгууллагуудаас анхдагч болсон онцлогтой.

Сэндли ББСБ ХХК нь 2015 оны 5-р сард банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. 2018 оноос эхлэн зорилгын дагуу үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2021 оноос одоогийн финтек зээлийн платформиор дамжуулан зээл олгож эхэлжээ. Санхүүгийн зохицуулах хорооноос зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлга, гадаад валютын арилжаа, итгэлцэл гэсэн үйл ажиллагааны чиглэлээр түсгэй зөвшөөрөл аван ажиллаж байна. Зээлийн үйлчилгээ, мөнгөн гүйвүүлгын үйл ажиллагаанаас үндсэн орлогоо бүрдүүлж байна.

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНДЛИ ББСБ ХХК

12



Зээлийн үйлчилгээ

Уламжлалг зээлийн үйлчилгээнээс илүүтэйгүүр технологи дээр сүүрилсэн зээл олголт, зээлийн эргэн төлөлтийн үйл явцыг ханган ажилладаг. Зээлийн багцын дийлэнх кэспийг мерчантын зээл эзэлж байна. Энэ нь томоохон худалдааны төвүүд дээр байршилтай лангууны бизнес эрхлэгчид юм. Одоогийн байдлаар 5000 гаруй мерчанттай хамтран ажиллаж байна.

Зээл олгохдоо зээлдэгчийн ажлын байр, бараа бүтээгдэхүүнд шалгалт хийж лангуун дээрх бараа болон лангууны түрээсийн эрхийг барьцаалдаг. Зээлийн эргэн төлөлтийн хувьд ихэвчлэн өдөр бүр тэнцүү төлөх байдлаар гэрээ хийдэг. Эргэн төлөлтийг зээлдэгч өөрөө хийх шаардлагагүй бөгөөд Хай Пэй Солюшн ХХК-ийн хөгжүүлсэн төлбөр тооцооны програмын тусламжтайгаар зээлдэгчийн бүртгүүлсэн арилжааны банкны картаас өдөр бүр шууд татан авалт хийдэг. Энэ нь Сэндли ББСБ ХХК-ийн бусад банк бүсүүдээс ялгарах гол давуу тал болж байна. Түүнчлэн, өдөр түгмэн зээлийн эргэн төлөлт нь компанид мөнгөн хөрөнгийн тасралтгүй байдал, зээл олголтын тасралтгүй байдал гэсэн давуу талуудыг олгож байна.

Сэндли ББСБ ХХК-ийн хувьд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь бага байгаа нь зээлийн эргэн төлөлт 1-2 хоног хоцрохтой зэрэгцүүлэн зээлийг эргүүлэн төлүүлэх ажиллагааг яаралтай эхлүүлдэгтэй холбоотой гэж үзэж болно.

Мөнгөн гүйвүүлгэ

Тус компани нь олон улстай онлайнгаар мөнгөн гүйвүүлгэ хийх финтек технологид сүүрилсэн "Sendly" гар утасны аппликэйшнийг 2020 оны 5 сард амжилттай нэвтрүүлсэн. Sendly аппликэйшний тусламжтайгаар дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэдийн улс хоорондын мөнгөн гүйвүүлгэ хийх хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн, мэдээллийн аюулгүй байдлын орчинд, хүрдэн шүүрхай, хямд зардлаар хийхээр зорин ажиллаж байна.

Одоогийн байдлаар мөнгөн гүйвүүлгэ АНУ-аас Монгол улс руу, Монгол улсаас АНУ руу, Австрали улсаас Монгол улс руу, Япон улсаас Монгол улс руу гэсэн чиглэлийн дагуу хийж байгаа бөгөөд тун удахгүй Солонгос болон Европын холбооны улсуудаас мөнгө гүйвүүлгэ хийх гарцыг нээхээр шамдан ажиллаж байна. Гадаадаас шилжүүлсэн мөнгийг харилцагч Монгол Улсын арилжааны банкны дансанд хүлээн авах боломжтой.

Одоогийн байдлаар нийт 7 сая ам.долларын 15,000 гаруй мөнгөн гүйвүүлгын гүйлгээ хийсэн байна. Нийт 15,248 хэрэглэгч аппликэйшнийг татсан байгаагаас идэвхитэй хэрэглэдэг 4,000 гаруй хэрэглэгчид байгаа бөгөөд өдрөөс өдөрт хэрэглэгчдийн тоо өсөн нэмэгдэж байна.

Салбар

Хөвсгөл, Ховд, Говь-Алтай аймгаас бусад 18 аймгийн төв, 28 сум, Улаанбаатар хотод 7 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод Нарантуул, Бөмбөгөр, Хархорин, Дэнжийн мянга гэх мэт том худалдааны төвүүдэд салбараа нээн ажиллуулж байна. Салбар бүрт 2-5 хүн ажилладаг, бүх салбар интернетэд холбогдсон, гүйлгээний өндөрлөгөөг банкттай адил 24:00т автоматаар эхэлдэг.

Салбарын тоогоор Хаан банк болон Терийн банкны дараа, ББСБ-үүдын хувьд хамгийн олон салбартайгаар, өргөн хүрээг хамарч үйл ажиллагаа явуулж байгаагаараа давуу талтай. Энэ нь зээлийн төвлөрлийн эрсдлийг тархаан байршуулахад ач холбогдолтой. Орон нутагт олгож буй зээл чанаргүй болох магадлал бага байдаг. Энэ нь орон нутагт хүн амын төвлөрөл бага байдаг учраас зээлдэгчийг судлах, таньж мэдэхэд илүү хялбар байдагтай холбоотой. Олон салбартай, мөн онлайн програмын давуу талаа ашиглан зөвхөн зээлийн үйлчилгээгээр





зогсохгүй дээтгал, үнэт цаас, онгоцны билет, хоршооны үйлчилгээг сэлбараараа дэмжүүлэн хүргэн ажилладаг.

Хүний нөөц

Сэндли ББСБ ХХК нь үнэлгээний өдрийн байдлаар нийт 49 бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Гүйцэтгэх удирдлагын багт банк, санхүүгийн мэргэжилтэй, Сангийн яам, арилжааны банкуудад удирдах түвшний алба хашиж байсан туршлагатай, мэдлэгтэй боловсон хүчнүүд ажиллаж байна. Орон нутаг дахь салбарын захирлуудад 2016 онд Төрийн банкинд ажиллаж байсан олон жилийн туршлагатай хүмүүсийг томилон ажиллуулж байна. Хүний нөөцийн бодлогын хувьд идэвхжүүлэлт, урамшуулал, сургалт, эрүүл мэндийн үзлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлт гэх мэт урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.

Програм хангамж, дэд бүтэц

Хай Пэймэнт Солюшнс ХХК-ийн хөгжүүлсэн програм, аппликэйшний түслэмжтайгаар зээлийн үйлчилгээ болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байна. Хай Пэймэнт Солюшнс ХХК нь Монголбанктэй шилэн кабелиар холбогдсон бөгөөд 2019 оны 10-р сарын 24-ний өдөр Монголбанкаас “Карт хүлээн авагч”-ийн түсгэй зөвшөөрлийг авсан нь арилжааны банкнаас гадна энэхүү түсгэй зөвшөөрлийг эзэмшиж буй цорын ганц компани болсон. Иймд, арилжааны банктэй гэрээ хийх шаардлагагүйгээр зээлийн эргэн төлөлтийг тухайн харилцагчийн HiPay зээлийн аппликэйшн дээр холбуулсан данснаас шүүд татаж авах боломжтой болсон. Энэ нь бусад банк болон ББСБ-үүдтэй харьцуулахад зээлийн эргэн төлөлтийн эрсдлийг бууруулах, эргэн төлөлтийг цаг тухайд нь сүүтгэн авах давуу талыг олгож байна.

Монголбанк болон Монголын Хөрөнгийн Бирж тэй шилэн кабелиар холбогдсон. Тус компани нь цахилгаан тасалдлаас хамгаалсан TIER 3 үзүүлэлтийг хангасан 3 дата төвтэй байгаа нь харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан бие даасан шийдэл болж байна.

Хяналт, шалгалт


Орон нутаг дахь хүний нөөц болон интернет, шугам сүлжээний дэд бүтцийн тал дээр маш хяналттай ажилладаг. Орон нутаг дахь оффисын үйл ажиллагаанд хяналтын аппликэйшний түслэмжтайгаар шүүд хяналт тавин ажиллаж байна. Бэлэн мөнгөний гүйлгээ бараг хийгддэггүй, хэрэв харилцагч бэлэн мөнгөөр зээлийн эргэн төлөлтийг хийсэн тохиолдолд тухайн өдөр бүр банкны харилцахад тушаадаг.

Санхүүгийн үзүүлэлт

Сэндли ББСБ ХХК нь 2018 - 2020 оны хооронд хувь нийлүүлсэн хөрөнгийн хүрээнд уламжлалт зээлийн үйл ажиллагаа эрхэлж, 2019 оноос эхлэн финтек эзэл олголтын програм хангамжийн хөгжүүлэлтийг эхлүүлжээ. 2021 оны 8-р сард програм нь бүрэн ашиглалтанд орж одоогийн зээл олголт, зээлийн эргэн төлөлтийн дижитал процесс нь эхэлсэн. Толгой компанийн өрийн бичгийн санхүүжилтээр 2021 онд эздийн өмчөө нэмэгдүүлж, итгэлцлийн түсгэй зөвшөөрөл авч бусад эх үүсвэрээ нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 4: Сэндли ББСБ-ын балансын үндсэн үзүүлэлтүүд, 2018-2021 он

Балансын гол үзүүлэлтүүд (млн.төг)	2018	2019	2020	2021
Мөнгөн хөрөнгө	6,005	33,467	925,009	1,169,363
Зээл (цэрвэр)	1,058,381	1,017,134	663,053	8,600,431
Чанаргүй зээл	44,000	44,000	44,000	9,828
Нийт хөрөнгө	1,273,890	1,830,407	1,889,437	10,604,636
Итгэлцлийн өглөг	-	-	-	2,580,000



Бүсэд эх үүсвэр				826,844
Нийт өр төлбөр	85,739	467,415	333,839	3,444,195
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,000,000	1,428,500	1,428,500	6,428,500
Эздийн өмч	1,185,150	1,362,991	1,555,599	7,160,441

Хүснэгт 5: Сэндли ББСБ-ын орлогын үндсэн үзүүлэлтүүд, 2018-2021 он

Орлогын гол үзүүлэлтүүд (млн.төг)	2018	2019	2020	2021
Хүү, шимтгэлийн орлого	315,763	119,824	444,601	1,795,964
Нийт орлогод эзлэх хувь	100%	100%	57%	76%
Гадаад валютын арилжааны орлого	-	339	286	69,771
Нийт орлогод эзлэх хувь	0%	0%	0%	3%
Мөнгөн гүйвүүлгын орлого	-	-	80,149	260,028
Нийт орлогод эзлэх хувь	0%	0%	18%	11%
Нийт орлого	316,455	120,163	773,370	2,366,934
Хүүгийн цэвэр орлого	316,455	120,163	773,370	2,365,498
Үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого	214,512	226,294	236,097	650,817
Цэвэр ашиг/алдагдал	181,664	- 250,659	192,607	588,471

Орлогын үндсэн 3 үйл ажиллагаанаас олддог бөгөөд хүү, шимтгэлийн орлого хамгийн их хувийг эзэлж байна. Мөнгөн гүйвүүлгын хувьд програм хангамж бүрэн ашиглалтанд орж, одоогийн байдлаар хэрэглэгчдээ нэмэх, зах зээлээ тэлэх гэсэн маркетингийн стратеги барин ажиллаж байна.

Үйл ажиллагаа жигдэрсний дараах буюу 2021 оны гол харьцаануудыг харахад өр төлбөр хөрөнгө, өр төлбөр өөрийн хөрөнгийн харьцаа харьцангуй бага буюу зээлийг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр түлхүү бүрдүүлж байна. Нийт хөрөнгөд зээлийн эзлэх хувь 81%-тай байна. Сэндли ББСБ-ын хувьд хамгийн сайн үзүүлэлт нь чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2021 онд 0.11% байгаа нь дээр дурдсанчлан зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагааг өдөр алдахгүй эхлүүлдэгтэй холбоотой гэж үзэж болно.

Хүснэгт 6: Сэндли ББСБ ХХК-ийн санхүүгийн гол харьцаанууд

Балансын гол харьцаанууд	2018	2019	2020	2021
Өр төлбөр/Хөрөнгө	0.07	0.26	0.18	0.32
Өр төлбөр/Өөрийн хөрөнгө	0.07	0.34	0.21	0.48
Зээлийн багц/Хөрөнгө	0.83	0.56	0.35	0.81
Зээлийн багц/Өр төлбөр	11.93	2.18	1.99	2.50
Зээлийн багц/Өөрийн хөрөнгө	0.89	0.75	0.43	1.20
Зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь	4.16%	4.33%	6.64%	0.11%
Орлого, ашгийн гол харьцаанууд				
Үйл ажиллагааны ашгийн маржин	67.79%	-188.32%	30.53%	27.50%
Цэвэр ашгийн маржин	57.41%	-208.60%	24.90%	24.86%
Хөрөнгийн өгөөж ROA	14.26%	-13.69%	10.19%	5.55%
Өөрийн хөрөнгийн өгөөж ROE	15.33%	-18.39%	12.38%	8.22%

Хүүгийн цэвэр орлого 2.4 тэрбум төгрөг байгаа боловч үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого түүнээс харьцангуй бага буюу 651 сая төгрөг байгаа нь боловсон хүчин, мэргэжлийн үйлчилгээний зардал, Хай Пэй Солюшн ХХК-ийн технологийг ашигласны шимтгэлийн зардал





эндөр байгаатай холбоотой байна. Хөрөнгийн өгөөж 5.6%, өөрийн хөрөнгийн өгөөж 8.2%-тай байгаа нь салбарын дунджаас доогуур байна.

5. ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Сангийн сайд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу үнэлгээнд Зах зээлийн харьцуулалтын хандлага, Хөрөнгөд сүүрилсэн хандлага, Орлогын хандлагыг авч үзэв. Үнэлгээний нэр томъёоны тодорхойлолт болон аргачлалын талаар ерөнхий мэдээллийг Хавсралт 2-т үзүүлэв.

Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ

Зах зээлийн харьцуулалтын шинжилгээг Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, үйл ажиллагаандаа финтек үйлчилгээ нэвтрүүлж ажилладаг Инвескор ББСБ, Ард Кредит ББСБ, ЛэндМН ББСБ компаниудыг сонгон авч харьцуулалт хийлээ.

Харьцуулалтад авч үзсэн компаниуд

Инвескор ББСБ

Инвескор ББСБ ХХК нь 2016 онд үүсгэн байгуулагдсан. 2019 оны 4-р сард Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа олон нийтэд санал болгож нээлттэй хувьцаат компани болсон. Нийт хувьцааны 85%-ийг Эс Ай Би Жэй Капитал ХХК, 15%-ийг олон нийт тус тус эзэмшиж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн багцад бизнесийн зээл 40%, автомашины зээл 30%, дижитал зээл 19%, хэрэглээний зээл 11%-ийг тус тус эзэлж байна. Нийт 18 салбартай, үүнээс 16 нь Улаанбаатар хотод, 1 нь Орхон аймагт, 1 нь дижитал хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.⁹

Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS (Payment Card Industry Data Security Standard) олон улсын стандартыг хангасан цахим зээл, цахим төлбөр тооцооны Покет аппликэйшныг ажиллуулдаг. Покет аппликэйшн нь дараах санхүүгийн үйлчилгээнүүдийг өөртөө багтаажээ.

33.7 тэрбум төгрөгийн зээлийн багцтай, 146 мянган идэвхтэй зээл	Цахим төлбөр тооцооны 500 мянга + бүртгэлтэй хэрэглэгч	155+ нэр төрлийн купон, 150+ хамтрагч байгууллага	211+ Мерчант байгууллага, 200+ Брэнд, 400+ салбар
Pocket Loan	Pocket Pay	Pocket Coupon	Pocket Zero

Инвескор ББСБ ХК нь Киргиз улсад итгэлцэл татах, факторинг, гадаад арилжаа, баталгаа гаргах, зээл олгох чиглэлээр охин компани байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2021 онд цэвэр зээлийн багц 6.8 тэрбум төгрөгт хүрч, чанаргүй зээлийн хувь 0.3%-тай байна. Покет аппликэйшныг Киргиз улсад нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 2-р улиралд багтаан цахим зээлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгохыг зорин ажиллаж байна.

⁹ <https://www.invescore.mn/mn/investor/#report>



Санхүүгийн үзүүлэлтүүд

Инвэскор ББСБ ХХК-ийн зээлийн багц 2021 онд өмнөх оноос 82%-иар, нийт өр төлбөр 64%-иар, эздийн өмч 43%-иар, хүүгийн цэвэр орлого 31%-иар, цэвэр ашиг 65%-иар тус тус өссөн байна. Ингэснээр үйл ажиллагааны орлогын маржин 87%, цэвэр ашгийн маржин 70%, хөрөнгийн өгөөж 9%, өөрийн хөрөнгийн өгөөж 25% болсон.¹⁰

Хүснэгт 7: Инвэскор ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он

Балансын гол үзүүлэлтүүд (мян.төг)	2018	2019	2020	2021
Мөнгөн хөрөнгө	2,297,690	4,440,168	26,588,675	24,638,751
Зээл (цэвэрээр)	34,868,286	62,301,229	96,409,802	175,508,816
Нийт хөрөнгө	39,015,183	82,322,748	136,044,313	212,222,295
Итгэлцлийн өглөг	10,374,109	19,933,800	42,209,511	56,477,725
Бусад эх үүсвэр	14,363,836	18,702,417	75,610,777	38,666,774
Нийт өр төлбөр	25,120,823	41,100,253	83,243,727	136,705,532
Хувь нийлүүлсэн хөрөнгө	6,096,873	16,282,237	16,282,237	16,282,237
Эздийн өмч	13,894,360	41,222,495	52,800,586	75,516,763
Орлогын гол үзүүлэлтүүд (мян.төг)				
Хүүгийн цэвэр орлого	8,221,267	15,167,006	21,094,365	27,564,379
Үйл ажиллагааны цэвэр орлого	8,623,334	15,992,633	14,345,311	24,078,727
Цэвэр ашиг/алдагдал	5,056,969	9,508,062	11,619,109	19,191,536

Хүснэгт 8: Инвэскор ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он

Балансын гол харьцаанууд	2018	2019	2020	2021
Өр төлбөр/Хөрөнгө	0.64	0.50	0.61	0.64
Өр төлбөр/Эздийн өмч	1.81	1.00	1.58	1.81
Зээлийн багц/Хөрөнгө	0.89	0.76	0.71	0.83
Зээлийн багц/Өр төлбөр	1.39	1.52	1.16	1.28
Зээлийн багц/Эздийн өмч	2.81	2.00	2.58	2.81
Зээлд зэлэх чанаргүй зээлийн хувь	n/a	2.6%	3.0%	2.7%
Орлого, ашгийн гол харьцаанууд				
Үйл ажиллагааны орлогын маржин	105%	105%	68%	87%
Цэвэр ашгийн маржин	62%	63%	55%	70%
Хөрөнгийн өгөөж-ROA	13%	12%	9%	9%
Өөрийн хөрөнгийн өгөөж-ROE	36%	23%	22%	25%

Хувьцааны арилжаа

Инвэскор ББСБ ХХК-ийн хувьцааны ханш, зах зээлийн үнэлгээ, харьцаануудын мэдээллийг 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар доор харуулав.¹¹


52 долоо хоног, ₮	2,859-4,400	Хаалтын үнэ	4,043
Зах зээлийн үнэлгээ, ₮	289,995,972,474	Дансны үнэ	1,053
Нийт хоёрдогч арилжааны дүн, ₮	4 тэрбум	P/E	15.11
Эгэлгэд гаргасан хувьцаа, ширхэг	71,727,918	P/B	3.84

¹⁰ https://www.invescore.mn/media/report-file/InvesCore_2021_consolidated_audited_for_MSE.pdf

¹¹ <https://mse.mn/mn/campa:iv/553>



Зүрэг 4: Инвeснор ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа



Ард Кредит ББСБ

Ард Кредит ББСБ ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан. 2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл хөрөнгө оруулалт хийснээр шинэ удирдлага, шинэ стратегиар ажиллаж эхэлсэн. 2019 оны 1-р улиралд хувьцаагаа олон нийтэд санал болгож нээлттэй хувьцаат компани болсон.

Монгол шуудан ХК-ийн салбаруудаар дамжуулан 2019 оноос харилцагчдадаа санхүүгийн үйлчилгээг хүргэж байна. 2020 онд EigoGigo олон улсын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг Монгол шуудан ХК-тай хамтран зах зээлд нэвтрүүлсэн.

2021 онд нийт зээл олголтын 71%-ийг цахим зээл, 23.3%-ийг бизнесийн зээл, 5.7%-ийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар Ард аппликэйшнийг нийт 1,094,096 хэрэглэгч татсан ба харилцагчдын тоо 1,012,184-д хүрсэн байна. 2021 онд 890,787 зээлийн хүсэлт ирсэн бөгөөд зээлийн жингэсэн дундаж хүү 35.6% байна.


Санхүүгийн үзүүлэлтүүд

Нийт хөрөнгө 2021 онд өмнөх оноос 163%-иар, нийт өр төлбөр 178%-иар, эздийн өмч 138%-иар, хүүгийн цэвэр орлого 19%-иар, цэвэр ашиг 238%-иар тус тус өссөн байна. Цэвэр ашгийн маржин 67%, хөрөнгийн өгөөж 5%, өөрийн хөрөнгийн өгөөж 16% байгаа нь компани 2021 онд үр ашигтай ажилласныг илтгэж байна.

Хүснэгт 9: Ард Кредит ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он

Балансын гал үзүүлэлтүүд (мян.төг)	2018	2019	2020	2021
Мөнгөн хөрөнгө	1,123,729	1,873,425	3,249,682	6,956,116
Зээл (цэвэрээр)	7,545,803	18,058,000	20,300,000	34,177,792
Нийт хөрөнгө	10,471,767	23,093,659	29,655,028	79,387,751
Бусдаас авсан зээл	554,606	2,540,636	2,664,401	10,544,388
Бусад эх үүсвэр	3,858,575	5,130,197	11,506,836	18,189,153
Нийт өр төлбөр	6,714,384	11,401,230	18,401,758	50,782,486
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,100,000	2,800,000	2,800,000	2,800,000
Эздийн өмч	3,757,384	10,692,429	11,253,270	22,605,265
Орлогын гал үзүүлэлтүүд (мян.төг)				
Хүүгийн цэвэр орлого	873,689	2,555,973	4,184,469	3,854,741
Үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого	237,327	2,427,775	1,563,757	4,161,452
Цэвэр ашиг/алдагдал	342,046	2,186,578	1,240,775	3,924,817





Хүснэгт 10: Ард Кредит ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он

Балансын гол харьцаанууд	2018	2019	2020	2021
Өр төлбөр/Хөрөнгө	0.64	0.54	0.62	0.69
Өр төлбөр/Эздийн өмч	1.79	1.16	1.64	2.25
Зээлийн багц/Хөрөнгө	0.72	0.78	0.68	0.47
Зээлийн багц/Өр төлбөр	1.12	1.46	1.10	0.67
Зээлийн багц/Эздийн өмч	2.01	1.69	1.80	1.51
Зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь	4.2%	6.5%	9.4%	7.00%
Орлого, ашгийн гол харьцаанууд				
Үйл ажиллагааны орлогын маржин	27%	95%	37%	108%
Цэвэр ашгийн маржин	39%	86%	30%	102%
Хөрөнгийн өгөөж-ROA	3%	9%	4%	5%
Өөрийн хөрөнгийн өгөөж-ROE	9%	20%	11%	17%

Хувьцааны арилжаа

Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны ханш, зах зээлийн үнэлгээ, харьцаануудын мэдээллийг 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар доор харуулав¹²

52 долоо хоног, ₮	118.35-351.12	Хаалтын үнэ	220
Зах зээлийн үнэлгээ, ₮	61,526,152,286	Дансны үнэ	96
Нийт хоёрдогч арилжааны дүн, ₮	24.7 тэрбум	P/E	14.67
Зогсолт гаргасан хувьцаа, ширхэг	279,753,341	P/B	2.30

Зураг 5: Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа



ЛэндМН ББСБ

ЛэндМН ББСБ ХК нь 2016 онд байгуулагдсан. 2018 онд Монголын хөрөнгийн биржийн нээлттэй хувьцаат компани болсон. Нийт хувьцааны 75%-ийг Анд Системс ХХК, 25%-ийг олон нийт эзэмшиж байна. ЛэндМН ББСБ нь технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан финтек бизнес моделийг ЛэндМН аппликэйшнээр дэмжүүлэн барьцаагүй, хямд өртөлтэй, хэрэглээний бичил цахим зээлийн үйлчилгээ үзүүлдэг компани юм.

¹² <https://mse.mn/mn/company/550>



2021 оны жилийн эцсийн байдлаар ЛэндМН аппликэйшн нь нийт 987,372 хэрэглэгчтэй, 182,528 зээлийн харилцагчтай болсон байна. 2021 оны зээлийн багцын 65%-ийг Улаанбаатар хотын, 35%-ийг орон нутгийн харилцагчид эзэлж байна. 2021 онд нийт 867,000 удаа 183.4 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

2021 онд дэлхийн хамгийн том крипто биржийн нэг болох Binance дээр хэрэглэгчдэдээ ЛэндМН аппликэйшний тусламжтайгаар крипто арилжаанд оролцож төлбөр тооцоогоо төгрөгөөр хийх боломжийг бүрдүүлжээ.

Түүнчлэн, дэлхийн 126 орны 9000 гаруй компанийн төлбөрийн системтэй хамтран ажилладаг Thunes компанитай сүүлийн 2 жил гаруй хамтран ажиллаж байгаа бөгөөд ЛэндМН аппликэйшний хэрэглэгчдэд хамгийн хурдан, хамгийн бага шимтгэлтэйгээр Монгол улс руу мөнгөн гуйвуулга хийх үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.

Монгол орон даяар буюу 21 аймаг, 9 дүүрэгт ЛэндМН аппликэйшнийг ашиглан цахим зээлийн гэрээ байгуулах боломжтой болсон. Тэрээр, 7, 14, 21, 28 хоногийн хугацаатай хамгийн ихдээ 1 сая төгрөг хүртэлх цахим итгэлцлийн "Plus итгэлцэл" нэртэй хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн ажиллаж байна. Цаашид, ЛэндМН-ий загварыг Филиппин, Индонез, Япон улсуудад нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.¹³

Санхүүгийн үзүүлэлтүүд

Зээлийн багц 2021 онд өмнөх оноос 28%-иар, эздийн өмч 12%-иар тус тус өсч, нийт хөрөнгө 3%-иар, нийт өр төлбөр 15%-иар тус тус буурсан байна. Хүүгийн цэвэр орлого 2021 онд өмнөх онтой харьцуулахад 17%-иар буурсан бол үйл ажиллагааны орлого 12%-иар өсч, улмаар цэвэр ашиг 60%-иар өссөн байна.

Тухайн 11: ЛэндМН ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он

Балансын гол үзүүлэлтүүд (млн.төг)	2018	2019	2020	2021
Мөнгөн хөрөнгө	4,218,150	2,382,196	10,348,101	4,900,000
Зээл (цэвэрээр)	19,199,366	49,457,676	25,430,960	32,430,000
Нийт хөрөнгө	24,323,437	58,100,953	40,735,460	39,310,000
Итгэлцлийн өглөг		13,845,212	10,485,907	15,070,000
Бусад эх үүсвэр	10,092,417	24,734,810	5,317,823	2,950,000
Нийт өр төлбөр	10,969,062	40,902,475	23,021,642	19,490,000
Хувь нийлүүлсэн хөрөнгө	10,756,859	10,490,773	9,767,920	8,480,000
Эздийн өмч	13,354,375	17,198,478	17,713,818	19,820,000
Орлогын гол үзүүлэлтүүд (млн.төг)				
Хүүгийн цэвэр орлого	6,531,385	13,666,841	11,654,292	9,690,000
Үйл ажиллагааны цэвэр орлого	6,222,860	12,048,039	9,293,611	10,420,000
Цэвэр ашиг/алдагдал	2,560,313	4,910,189	2,432,193	3,890,000


Үйл ажиллагааны орлогын маржин 37%, цэвэр ашгийн маржин 40%, хөрөнгийн өгөөж 10%, өөрийн хөрөнгийн өгөөж 20% байгаа нь компани өр төлбөрөөс илүүтэйгээр өөрийн хөрөнгөөр зээлийн олголтыг санхүүжүүлдэг болох нь ажиглагдаж байна.

Тухайн 12: ЛэндМН ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он

Балансын гол харьцаанууд	2018	2019	2020	2021
Өр төлбөр/Хөрөнгө	0.45	0.70	0.57	0.50

¹³ <https://lend.mn/ipo3.html>





Өр төлбөр/Эздийн өмч	0.82	2.38	1.30	0.98
Зээлийн багц/Хөрөнгө	0.79	0.85	0.62	0.82
Зээлийн багц/Өр төлбөр	1.75	1.21	1.10	1.66
Зээлийн багц/Эздийн өмч	1.44	1.88	1.44	1.64
Зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь	1.8%	3.5%	9.1%	7.0%
Орлого, ашгийн гол харьцаанууд				
Үйл ажиллагааны орлогын маржин	41%	41%	26%	37%
Цэвэр ашгийн маржин	39%	36%	21%	40%
Хөрөнгийн өгөөж-ROA	11%	8%	6%	10%
Өөрийн хөрөнгийн өгөөж-ROE	19%	29%	14%	20%

Хувьцааны арилжаа

ЛандМН ХК-ийн хувьцааны ханш, зах зээлийн үнэлгээ, харьцаануудын мэдээллийг 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар доор харуулав.¹⁴

52 долоо хоног, ₮	37.42-51.25	Хаалтын үнэ	40.31
Зах зээлийн үнэлгээ, ₮	29,849,834,428	Дансны үнэ	26.77
Нийт хоёрдогч арилжааны дүн, ₮	14.3 тэрбум	P/E	7.67
Эсгэлтэд гаргасан хувьцаа, ширхэг	740,506,932.00	P/B	1.51

Зураг 6: ЛандМН ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа



Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт

Салбарт валгах хувь

Банк бүс санхүүгийн салбарын харьцуулж буй компаниудыг үнэлгээний компани болох Сэндли ББСБ ХХК-ийн санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдтэй харьцуулан авч үзэв.

Хүснэгт 13: Үндсэн үзүүлэлтээр салбарт валгах хувь

Салбарт валгах хувь	Инвeстoр	Аад Кредит	ЛандМН	Сэндли
Зээл (шөврээр)	9.2%	1.8%	1.7%	0.5%

¹⁴ <https://mse.mn/mn/company/545>



Нийт хөрөнгө	7.8%	2.7%	1.5%	0.4%
Өөрийн хөрөнгө	4.2%	1.3%	1.1%	0.4%
Үндсэн үйл ажиллагааны орлого	4.7%	0.8%	2.0%	0.1%
Цэвэр ашиг/алдагдал	9.1%	1.9%	1.9%	0.3%

Инвестор ББСБ дээрх санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийн хувьд нийт зах зээлийн ойролцоогоор 9%-ийг эзэлж байна. Ард Кредит, ЛэндМН ББСБ цэвэр ашиг, алдагдлын хувьд ойролцоо буюу нийт зах зээлийн тус бүр 2%-ийг эзэлж байна. Сэндли ББСБ нь зээлийн эх үүсвэр нь ихэвчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжиж байгаа, мөн технологийн хөгжүүлэлтэнд зардал их гарсан, үйл ажиллагаа жигдрээд удаагүй байгаа зэрэг нөхцөл байдлаас шалтгаалаад одоогийн байдлаар зах зээлийн 0.1-0.5%-ийг эзэлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

СЭХ-ны холбогдох журмын дагуу гаргасан 2021 оны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд харуулав.


Хүснэгт 14: СЭХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, 2021 он

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	Инвестор	ЛэндМН	Сэндли
Нагдугээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	30.7%	48.6%	70.7%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	33.1%	55.5%	70.7%
Нагдугээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	31.7%	50.3%	67.5%
Төлбөр тургэн гүйцэтгэл чадаврын харьцаа	8%-иас дээш	16.2%	29.4%	34.0%
Гадаад актив, пассивын зөрүү, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	{+/-}40%	18.0%	11.1%	4.7%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	74.7%	33.5%	36.0%
Өрийн бингийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	38.5%	32.3%	0.0%

Сэндли ББСБ ХК-ийн давуу тал болон бусдаас ялгарах байдал

- Монголбанкнаас "харт хүлээн авагч"-ын тусгай зөвшөөрөл авсан Нирау компанитай нэг зээмшигчийн өмчлөлд байдаг бөгөөд энэ нь арилжааны банкуудтай гэрээ хийх шаардлагагүйгээр зээлдэгчийн гэрээнд тусгасан аль ч банкны данснаас зээлийн эргэн төлөлтийг зээлдэгчийн оролцоо шаардлагагүйгээр татан авах боломжтой.
- Зээлийн эргэн төлөлтийг зээлдэгчийн шаардлагагүйгээр өдөр бүр тэнцүү дүнгээр татаж авах нь зээл чанаргүй болох магадлалыг бууруулж байна.
- Зээлийн эргэн төлөлтийг өдөр бүр татаж авдаг бизнес модель нь компанид мөнгөн хөрөнгийн тасралтгүй байдал, зээл олголтын тасралтгүй байдал гэсэн давуу талуудыг олгож байна.
- Улаанбаатар хотоос гадна 18 аймаг, 28 сүмэнд салбартай тул зээл олголтын эрсдлийг тархаан байршуулж чадаж байна. Орон нутаг дахь чанаргүй зээлийн хувь бага байдаг талаар компанийн удирдлагууд дурдсан.
- Улаанбаатар хот дахь гол томоохон худалдааны зах, төвүүд дээр салбар байгуулж, мерчантын зээлд, ялангуяа хүнсний үйл ажиллагаа эрхэлдэг бөөний болон жижиглэн худалдаачидтай хамтарч ажиллаж байгаа нь зээл олголтыг нэмэгдүүлж байна.





ЭТ цаасны танилцуулга



- Wechat рэу-ийн Монгол дахь албан ёсны партнер болсон нь БНХАУ-ын жуулчид Монгол улсад аялахдаа Wechat-р гүйлгээ хийх, монгол дахь мерчантүүдэд төлбөрүүд нь цаг тухай бүр орох, Монголын жижиг дунд үйлдвэр эрхлэгчид Wechat дээр бараагаа борлуулах, төлбөрөө цаг тухайд нь авах боломжийг бүрдүүлнэ.
- Цаашид бүрэн автомажсан зээлийн процесс нь хүний нөөцийн зардлыг хэмнэх, үр бүтээмжийг нэмэгдүүлэх, хүнээс хамаарсан алдаа, хүлгэйг багасгах, зээлдэгчдийн цаг хугацааг хэмнэх зэрэг маш олон давуу талуудыг олгох болно.

Гадаадын компаниудтай харьцуулах нь

Үнэлгээнд хамрагдсан компанитай ижил төстэй үйл ажилгаа явуулдаг гадаадын санхүүгийн байгууллагын олон нийтэд нээлттэй мэдээлэл олдоц сайтай байна. Жишээ болгох үүднээс (бичил) санхүүгийн зах зээл харьцангуй сайн хөгжсөн Балба үлсын хөрөнгийн бирж¹⁵ дээр арилжаалагдаж буй бичил зээлийн санхүүгийн байгууллагуудаас сонгон авч хөрөнгө оруулалтын үндсэн харьцааг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 15: Гадаадын компаниудын үндсэн үржүүлэгчид

Компанийн нэр	RMDC LBSL	Sana Kisan Bikas LBSL	Nerude LBSL	Summit LBSL	First Microfinance LBSL	Дундаж
Үнэлгээ, сая \$	107.30	159.62	54.09	45.55	61.97	65.71
P/E	38.86	30.07		32.66	36.20	34.45
P/B	4.17	5.07		8.09	6.16	5.87

Дээрх харьцуулалтаас үзэхэд дунджаар 65.71 сая ам.доллар буюу ойролцоогоор 250 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй бичил санхүүгийн байгууллагуудын хувьд санхүүгийн бизнесийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг үнэ, ашгийн харьцаа (P/E ratio) 30.07 – 38.86 хооронд, дундаж нь 34.45, үнэ, өөрийн хөрөнгийн харьцаа (P/B ratio) 4.17-8.09-ийн хооронд, дундаж нь 5.87 байна.

Зах зээлийн харьцуулалтын аргын үр дүн

Сэндли ББСБ ХХК нь Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа анхлан санал болгож (IPO) 10.0 тэрбум төгрөгийн хувьцааны санхүүжилт татахаар төлөвлөж байна. Тайлангийн 2-р бүлэгт тайлбарласны дагуу энэхүү үнэлгээ нь санхүүжилт орж ирсэний дараах буюу Post Money Valuation болно. Иймд зах зээлийн харьцуулалтын шинжилгээнд Сэндли ББСБ ХХК-ийн нийт эздийн өмчийн дүнг үнэлгээний өдрийн байдлаарх эздийн өмчийн дүн болох 7,144.0 сая төгрөг, IPO нэмэлт санхүүжилт 10,000.0 сая төгрөг, нийт 17,144.0 сая төгрөг байхаар авч ашиглав.

Хүснэгт 16: Зах зээлийн харьцуулалтын шинжилгээний үр дүн

Компаниуд	P/B	Харьцуулсан үнэлгээ, сая төгрөг
Инвестор ББСБ ХК	3.84	65,835.8
Ард Кредит ББСБ ХК	1.51	25,819.7
ЛэндМН ББСБ ХК	2.30	39,434.2
Дундаж	2.55	43,696.6

¹⁵ <http://www.mongol.com>



зах зээлийн харьцуулалтын шинжилгээгээр Сэндли ББСБ-ын хөрөнгийн зах зээлээс 10.0 тэрбум төгрөг татсаны дараах бизнес өмчлөлийн 100%-ийн үнэ цэн 25.8 – 65.8 тэрбум, дундаж нь 43.7 тэрбум төгрөг байх баримжаа тооцоолол гарч байна.

Үнэлгээний компанийн бизнесийн онцлог болон үнэлгээний ажлын зорилготой уялдуулан бусад үржүүлэгчийг зах зээлийн шинжилгээнд ашиглах нь тохиромж мүүтэй болно.

Хөрөнгөд суурилсан үнэлгээ

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн түлд Сэндли ББСБ ХХК-ийн биет болон биет бүс бүх хөрөнгүүд, мөн өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар эцвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай болно.

Сэндли ББСБ ХХК-ийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг үнэлгээний зориулалтаар дараах байдлаар хувааж үнэлэв. Үүнд:

1. Эргэлтийн бүс хөрөнгө:
 - Үндсэн хөрөнгө
 - Биет бүс хөрөнгө
2. Эргэлтийн хөрөнгө:
 - Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
 - Авлага
 - Дансны авлага
3. Өр төлбөр:
 - Өглөг, зээл, бусад зэрэг орно.

Эргэлтийн бүс хөрөнгүүдийн онцлог байдлуудаас хамааран ҮОУС-д тодорхойлсон өртгийн хандлагын аргыг ашиглав. Эргэлтийн бүс хөрөнгийн үнэлгээнд Сэндли ББСБ ХХК-ийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгө болон биет бүс хөрөнгүүдийг хамруулав. Үнэлгээний үр дүнг дараах хүснэгтэд, үнэлгээний дэлгэрэнгүй тооцооллыг Хавсралт 3-д үзүүлэв.


Хүснэгт 17: Эргэлтийн бүс хөрөнгийн үнэлгээ

Хөрөнгө	Тодорхойлолт	Тооцоолсон үнэ цэн, төгрөгөөр
Үндсэн хөрөнгө	195ш тавилга, компьютер дагалдах хэрэгсэл	221,586,362
Биет бүс хөрөнгө	2ш программ хангамж	45,322,728
Нийт дүн		266,909,090

Сэндли ББСБ ХХК-ийн эргэлтийн бүс хөрөнгийн нийт үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар 266,909,090 төгрөг байхаар тооцоолов.

2021 оны 4-р улирлын санхүүгийн тайланд орсон дүнгээр тус компанийн нийт эргэлтийн хөрөнгө 10,275,279,231, нийт өр төлбөр 3,457,430,799 төгрөг байна.





Цэвэр хөрөнгө



Хөрөнгөд суурилсан аргаар бизнесийг үнэлэхэд нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассан цэвэр хөрөнгөд үндэслэн тооцоолов.

Хүснэгт 18: Сэндли ББСБ ХХК-ийн цэвэр хөрөнгийн дүн

Үзүүлэлтүүд	Дүн, төгрөгөөр
Эргэлтийн хөрөнгө	10,275,279,231
Эргэлтийн бус хөрөнгө	266,909,090
Өр төлбөр	3,457,430,799
Цэвэр хөрөнгө	7,084,757,522

Дээрх тооцооллоор Сэндли ББСБ ХХК-ийн цэвэр хөрөнгө үнэлгээний өдрийн байдлаар 7,084,757,522 төгрөг байх тооцоолол гарч байна. Энэ аргаар Сэндли ББСБ ХХК-ийн үнэ цэнийг тодорхойлох нь үнэлгээний ажлын зорилгод тохиромж мүүтэй. Учир нь тооцоололд тус компанийн ирээдүйн орлого олох үйл явцад чухал нөлөө үзүүлэх IPO-оор татах санхүүжилт, компанийн менежмент, хүний нөөцийн түршлэг, үр чадвар, санхүүгийн бизнесийн онцлог, шинэ технологи хөгжүүлэлт зэрэг хүчин зүйлсийг авч үздэггүйтэй холбоотой.

Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ

Сэндли ББСБ нь IPO-оор татахаар төлөвлөж байгаа нэмэлт хөрөнгө оруулалтыг 100% компанийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөж байгаа нь тус компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шүүд болон дам нөлөө өндөргүй тул олон нийтээс хөрөнгө татасны дараах үеийн орлогын хандлагаар хийсэн үнэлгээ (Post-Money valuation) нь үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний даалгавартай нийцнэ гэж дүгнэв.

Үнэлгээнд Орлогын хандлагын Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, тодруулбал Эздийн өмчийн чөлөөт мөнгөн үрсгал (Free Cash Flow to Equity) загварыг ашиглав.


Үнэлгээнд ашигласан орц, төсөөллүүд болон үндсэн тооцооллыг доор тайлбарлав.

Үнэлгээний үндсэн орц, төсөөллүүд

Зах зээлийн багтаамжийн ирээдүйн төсөөлөл

СЭХ-ны мэдээлснээр Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагуудын нийт өөрийн хөрөнгө 2021 оны эцсийн байдлаар өнгөрсөн оноос 24%-иар өсөж 1.8 орчим их наяд төгрөгт хүрсэн байна. Харин нийт зээлийн хэмжээ 51.6%-иар өсөж 2.0 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбартай харьцуулахад 9.5% болж өнгөрсөн оноос 2.0 функт нэгжээр өсжээ.⁵

Сэндли ББСБ ХХК нь 2022 онд IPO-оор нийт 10.0 тэрбум төгрөгийн хувьцааны санхүүжилт, "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэж дүрмийн санг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр нэмэлт хөрөнгө оруулалтыг татсаны дараах үеийн Сэндли ББСБ-ын нийт эздийн өмч 17.8 тэрбум төгрөг болж байгаа нь банк бус санхүүгийн байгууллагын зах зээлийн 1.0%, салбарын нийт зээлийн 1.1% орчим хувийг тус тус эзлэхээр тооцоолж байна.



Энэ нь зах зээлийн багтаамж талаас авч үзвэл Сэндли ББСБ-ын бизнес төлөвлөгөө хэрэгжих хангалттай орон зай, боломж байгааг харуулна.

Сэндли ББСБ-ын зээлийн эх үүсвэрийн төсөөлөл

Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн эх үүсвэр нь үндсэндээ өөрийн хөрөнгө болон бүсдаас татсан эх үүсвэрээс бүрдэнэ.

Өөрийн хөрөнгө

Сэндли ББСБ-ын IPO-оор татах 10.0 тэрбум төгрөг нь 2022 оны 10-р сард зээлийн үйл ажиллагаанд бэлэн болно гэж төсөөлөн үнэлгээнд тусгав. Сэндли ББСБ нь "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулж хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргаад байна.

"Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийн 2021 оны эцсийн санхүүгийн аудитлагдсан тайланд туссанаар үнэлгээний өдрийн байдлаар тус компани нь 1,653.5 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй, үүнээс мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө 791.1 сая төгрөг, зээл 490.5 тэрбум төгрөг, зээлийн хүүгийн авлага 366.9 сая төгрөг буюу нийт 1,648.5 тэрбум төгрөгийг зээлийн үйл ажиллагаанд зориулагдсан хөрөнгө гэж үзэж болно. Иймд "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийн дүрмийн сан болох 1.4 тэрбум төгрөгийг 2022 оны 6-р сараас эхлэн Сэндли ББСБ-ын зээлийн эх үүсвэрт оруулж тооцов.

Сэндли ББСБ нь 2021 онд нийт 715.5 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан бөгөөд цаашид тухайн жилийн эцсийн байдлаарх хуримтлагдсан ашгийг ирэх жилийн зээлийн боломжит нийт эх үүсвэрт оруулж тооцоолов.

Бүсдаас татсан эх үүсвэр


Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журмын дагуу банк бус санхүүгийн байгууллагын бүсдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ итгэлцлийн үйлчилгээний хувьд эздийн өмчийн 80% хүртэл, өрийн бичгийн хувьд 50% хүртэл, нийт 130% хүртэл байх боломжтой. Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Инвескор ББСБ, Ард Кредит ББСБ, ЛэндМН ББСБ компаниуд нь бүсдаас татан төвлөрүүлэх хөрөнгийг зохицуулах байгууллагаас тогтоосон дээд хэмжээнд тулган татахыг зорин ажиллаж байна. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд мэдээлснээр эдгээр компаниудын бүсдаас татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийг эздийн өмчид харьцуулсан дундаж харьцаа 2019, 2020, 2021 онуудын эцэст харгалзан 130%, 123%, 130% хэмжээтэй байна.

Сэндли ББСБ нь хувьцаат компани болсноор итгэлцлийн гэрээгээр болон өрийн бичгээр бүсдаас хөрөнгө татан төвлөрүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Сэндли ББСБ-ийн бүсдаас татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт дүнг зохицуулах байгууллагын тогтоосон дээд хэмжээний 90%-иар буюу 117% байхаар авч үнэлгээнд тооцсон болно. Энэ нь харьцуулсан 3 компанийн Ковидын жил болох 2020 оны дундаж дүн болох 123%-иас бага байгаа тул үнэлгээний ажлын зорилгод нийцсэн харьцангуй болгосомжтой төсөөлөл гэж Үнэлгээчид үзэж байна.

Сэндли ББСБ-ын нийт зээлийн төсөөлөл

Нийт зээл

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: СЭНДЛИ ББСБ ХХК



Үнэлгээний тооцоололд ирэх жилүүдийн Үйлчлүүлэгчийн нийт зээлийн хэмжээг тооцоолох зорилгоор тухайн жилийн боломжит нийт зээлийн эх үүсвэрийн хэмжээг дараах байдлаар тодорхойлов.

$$\text{Зээлийн нийт боломжит үүсвэр (t)} = \text{Хувьцаат капитал (t)} + \text{Бусдаас татсан эх үүсвэр (t)} + \text{Хуримтлагдсан ашиг (t-1)}$$

энд, (t) тухайн жил, (t-1) өмнөх жилийг илэрхийлнэ.

Дээрх тодорхойлолтоор авч үзвэл 2021 оны эцсийн байдлаар Сэндли ББСБ-ийн нийт цэвэр зээлийн үлдэгдэл нь нийт боломжит эх үүсвэрийн 93.2%-ийг эзэлж байна. Үнэлгээнд энэ харьцаа ирэх жилүүдэд хадгалагдахаар төсөөлөв.

2021 оны эцсийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Инвескор ББСБ, Ард Кредит ББСБ, ЛэндМН ББСБ компаниудын хувьд дээрх тодорхойлолтоор тооцсон харьцаанууд нь харгалзан 97%, 101%, 60% буюу хоорондоо зөрүү өндөр байгаа тул санхүүгийн төсөөлөлд Үйлчлүүлэгчийн өмнөх жилийн гүйцэтгэлд илүүтэй ач холбогдол өгч үндэслэлтэй гэж үзэв.

Хэвийн болон хугацаа хэтэрсэн зээл

2021 оны эцсийн байдлаар нийт зээлд эзлэх хэвийн болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ Үйлчлүүлэгчийн хувьд 99.9%, харин харьцуулсан 3 компанийн дундаж 95.1% байсан болно. Цаашид Үйлчлүүлэгчийн зээлийн үйл ажиллагаа өргөжиж зах зээлийн дундаж үзүүлэлтэд дөхнө гэж төсөөлөв.

Цаашлаад хэвийн болон хугацаа хэтэрсэн зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээг мөн харьцуулсан 3 компанийн дундаж дүнгээр авч үнэлгээний тооцоололд ашиглав.

Эдгээр үндсэн төсөөллийг ашиглан мөн СЭХ-ны журмын дагуу зээлийн эрсдэлийн санг тооцоолж үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 19: Сэндли ББСБ ХХК-ийн зээлийн үйл ажиллагааны төсөөлөл, сан тог

Зээлийн үзүүлэлтүүд	2021	2022	2023	2024	2025	2026
Нийт цэвэр зээл	8,608.2	22,651.4	43,484.3	53,758.3	65,489.7	77,659.9
Нийт эх үүсвэрт эзлэх хувь	93.2%	93.2%	93.2%	93.2%	93.2%	93.2%
Хэвийн + Хугацаа хэтэрсэн зээл	8,598.4	21,546.6	41,372.9	51,136.2	62,295.4	73,871.9
Нийт зээлд эзлэх хувь	99.9%	95.1%	95.1%	95.1%	95.1%	95.1%
Хэвийн	8,491.6	21,050.3	40,419.9	49,958.4	60,860.5	72,170.4
Нийт цэвэр зээлд эзлэх хувь	98.8%	97.7%	97.7%	97.7%	97.7%	97.7%
Анхаарал хандуулах	106.8	496.3	952.9	1,177.8	1,434.8	1,701.5
Нийт цэвэр зээлд эзлэх хувь	1.2%	2.3%	2.3%	2.3%	2.3%	2.3%
Чанаргүй зээл	9.8	1,104.8	2,121.5	2,622.1	3,194.3	3,787.9
Хэвийн бүс	9.8	523.8	706.0	695.8	721.6	757.6
Эргэлзээтэй	-	145.3	353.9	481.6	618.2	757.6
Мүү	-	435.8	1,061.6	1,444.7	1,854.6	2,272.8
Эрсдэлийн сан	7.8	564.2	1,462.7	1,918.4	2,415.8	2,926.0



Хөрөнгийн бусад үзүүлэлтүүдийн төсөөлөл

Сэндли ББСБ-ийн бизнесийн оншлогоос хамаарч тус компанийн эргэлтийн бүс хөрөнгө нь харьцангуй бага дүнтэй бөгөөд барилга байгууламжийг түрээсээр эзэмшиж байна. Тус компанийн компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамжийн ирэх жилүүдийн төсөөллийг компанийн менежментийн төсөөлснөөр авч үнэлгээнд ашиглав.

Хүүгийн орлогод харьцуулсан хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг Үйлчлүүлэгчийн менежментийн тооцоолсон дүн буюу 8.3%-иар, бусад активыг 2021 оны гүйцэтгэл болох 6.7%-иар тус тус төсөөлөв.

Сэндли ББСБ-ын орлого, зардлын үзүүлэлтүүдийн төсөөлөл

Сэндли ББСБ-ын орлогын үндсэн бүрэлдэхүүнд зээлийн бүтээгдэхүүний хүү, шимтгэлийн орлого болон мөнгөн гүйвүүлгын орлого орж байна.

Зээлийн бүтээгдэхүүний орлого

Тодорхойлолтын зөрүү үүсэх эрсдэлээс сэргийлж энэхүү үнэлгээнд зээлийн хүү гэдэгт зээлийн бүтээгдэхүүний хүү болон шимтгэлийн орлогыг дундаж цэвэр зээлд харьцуулсан дүнгээр тодорхойлж хэрэглэв.

Сэндли ББСБ-ийн зээлийн сарын дундаж хүү 2021 онд 3.2% байсан ба 2022 онд 3.9% байхаар тооцоолж байна. Зээлийн сарын дундаж хүү 2021 онд харьцуулалтаар авсан 3 компани болох Инвэскор ББСБ, ЛэндМН ББСБ, Ард Кредит ББСБ-ын хувьд хэргэлзэн 3.1%, 3.7%, 4.8%, дундажаар 3.9% байсан байна.

Үнэлгээнд Сэндли ББСБ-ийн 2022 оны зээлийн сарын дундаж хүү цаашид жигд хэмжээгээр бүүрч 2026 он гэхэд 3.0% байхаар тооцоолов. Хэдийгээр энэ дүн нь тайлангийн өдрийн байдлаарх Үйлчлүүлэгчийн бодит гүйцэтгэл болон ирээдүйн төсөөллөөс харьцангуй бага байгаа боловч Үнэлгээнд нь дэлхийн үлс төр, эдийн засагт үүссэн тодорхойгүй энэ цаг үед илүү болгоомжтой хандлага барих нь үнэлгээний ажлын зорилгод нийцтэй гэж үзсэн болно.

Мөнгөн гүйвүүлгын цэвэр орлого

Сэндли ББСБ нь олон улстай онлайн-аар мөнгөн гүйвүүлга хийх финтек технологид сүүрилсэн "Sendly" гар утасны аппликэйшнийг 2020 оны 5 сард амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна. Үнэлгээний өдрийн байдлаар мөнгөн гүйвүүлгыг АНУ-аас Монгол улс руу, Монгол улсаас АНУ руу, Австрали улсаас Монгол улс руу, Япон улсаас Монгол улс руу гэсэн чиглэлийн дагуу хийж байгаа бөгөөд тун удахгүй Солонгос болон Европын холбооны улсуудаас мөнгө гүйвүүлга хийх гарцыг нээхээр ажиллаж байна. 2022 оны 3-р сарын байдлаар нийт 7 сая ам.долларын 15,000 гаруй мөнгөн гүйвүүлгын гүйлгээ хийсэн ба нийт 15,248 хэрэглэгч аппликэйшнийг татаж, үүнээс идэвхитэй 4,000 гаруй хэрэглэгчидтэй болсон байна.

Сэндли ББСБ нь үлс хоорондын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг амжилттай эхлүүлэн ажиллаж байгаа боловч мөнгөн гүйвүүлгын үйлчилгээнд тусгайлан бизнес төлөвлөгөөг Үнэлгээндэд ирүүлээгүй болно. Иймд мөнгөн гүйвүүлгын цэвэр орлогыг Үйлчлүүлэгчийн менежментийн төсөөллийн 50%-иар авч үнэлгээнд оруулав.





Бусдаас татсан эх үүсвэрийн зардал

Зээл, өрийн үнэт цаасны дундаж зардал болон итгэлцлийн үйлчилгээний зардлыг 2022 онд харгалзуулан сарын 1.3% болон 1.5% байхаар зах зээлийн мэдээлэлд үндэслэн авсан ба цаашид Сэндли ББСБ-ын зээлийн хүүний төсөөлөлтэй шууд хамааралтайгаар бүүрахаар үнэлгээний загварт тооцоолов.

Үйл ажиллагааны болон бусад зардал

Сэндли ББСБ-ын менежментийн багийн тооцоолсон үйл ажиллагааны болон бусад зардлын төсөөлөлд Үнэлгээчид шинжилгээ хийсэн бөгөөд уг тооцоолол нь харьцангуй бодит болсон гэж дүгнэсэн болно. Учир нь эдгээр зардал нь борлуулалт болон зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч шууд өөрчлөгдөнө гэж үзэхээс илүүтэй менежментийн бизнес төлөвлөгөөний дагуу менежментийн шийдвэрээр гардаг онцлогтой зардлууд багтаж байна.

Зээл олгохтой холбоотой банкны гүйлгээний шимтгэлийн зардал Нирау-и 1% шимтгэлийг оруулаад 2021 оны байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 1.7%-г эзэлж байсан бөгөөд цаашид энэ хувийг хадгалагдахаар төсөөлөв.

Хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувь

Сэндли ББСБ-ын хувьцаанд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн тооцооллыг Капитал хөрөнгийн үнэлгээний CAPM загварыг ашиглан хийж гүйцэтгэв. Харин CAPM аргыг шууд хэрэглэхэд манай улсын хөрөнгийн зах зээлийн мэдээлэл хангалттай биш тул хөгжиж байгаа орнуудад элбэг хэрэглэгддэг арга буюу хөгжсөн зах зээлтэй харьцуулж үнэлдэг аргыг хэрэглэв.¹⁶ Аргыг товч тайлбарлавал:

$$k_e = R_f + \beta_e MMERP + \lambda_e CDS$$

энд,

- k_e - cost of equity capital
- R_f - risk-free reference rate in a developed country
- $MMERP$ - mature market equity risk premium
- β_e - exposure to market risk
- CDS - country credit default swap rate
- λ_e - exposure to country risk

1. Энэхүү Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа тоон мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, гэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Энэхүү Дүгнэлтэд өөроор дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх талаар;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна." гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийгэд илэрхий мэдээллийн талаар;
6. Энэхүү Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Гийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон, эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
7. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, гэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү Дүгнэлттэй холбоотой бид гаргахгүй болно;
8. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны хилбао, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл болол илэрхийлээгүй болно.





Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дуузуу танилцуулсан нохиолд үүсэх асуудлаар МДСХ харнууллага хүлээхгүй.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН
ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДУГЭРЖАВ



АГУУЛГА

Үндиртгэл 5

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийлвэр нь хуулийн дагуу гарсан эсэх 7
2. Компанийн Төлөөлөл удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооникс баталсан Компанийн засаглалын кодексыг зассан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чанар, дадлага гуршлагын талаар мэдээлэл 9
3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооны баталсан “Компанийн засаглалын кодекс”-т нийцсэн эсэх 18
4. Бусалтай байгуулсан худалдах худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжил нийцэж байгаа эсэх 27
5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлбэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх 38
6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зөвшөөрлийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугаанаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь болитой нөлөөлж болохуйн нохиол буй эсэх 44
7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх 46
8. Үнэт цаас бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх 48
9. Компанийн толгой, охин, хараат, зэргэмдээ компанийн талаарх мэдээлэл үндэслэн Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох 49
10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт даруцагчаар татагдаж байсан эсэх 50
11. Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийлвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх 51
12. Тухайн компанийн эрхэдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ 52

Гол дүгнэлт 52



Хувиулга

"Өмгөөллийн Эм Дл Эс энд Ханлекс" ХХК (цаашид "МДСХ", эсхүл "Бид" гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (**Хавсралт 1.1**)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "Сэндли ББСБ" ХХК (Регистрийн дугаар: 5961548), (цаашид "Компани", эсхүл "Үнэт цаас гаргагч" гэх) нь хувьцаагаар анх удаа нийтэд санал болгох гэж буйгай хэлбэрдүүлэн Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсч, улмаар бид 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр S-22/03 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрэл" (**Хавсралт 1.2**) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү Хууль зүйн дүгнэлт (цаашид "Дүгнэлт" гэх)-ийг гаргаж байна.

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 23.1-т "... хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно", 4.3-г "Компанийн дүртэд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаасыг гаргаж болно" гэж хуульчилсны дагуу Компани нь хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар компанийн хэлбэрийг хувьцаат компани болгон өөрчлөн байгуулагдах эрх зүйн үндэслэлтэй гэж үзэсний үндсэн дээр гаргаж байна. Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэгт заасны дагуу нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох эрх зүйн үндэслэлтэй байна. Тус Компани нь Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйл (Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх), 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 10 дугаар зүйл (Үнэт цаасны танилцуулга), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу нэмж хувьцаа гарган СЗХ, Монголын хөрөнгийн бирж (цаашид "МХБ" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

Хангагдсан тоонох нөхцөл

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл мэлгтүүд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга гэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьцаагаар ийнхэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, үнэн зөв;
4. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжил боломжгүй биш байна;
5. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;





6. Загвар хувилбараар ирсэн баримт бичиг нь тухайн хуяагбарыг үндэс болгон бичиглэжээ.
7. Компани, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв бодитой.
8. Шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв.
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв.
10. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь гийхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй.

Энэхүү хувьцааны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дахь хэсэг, СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын дагуу явагдана.

Бид Дүгнэлт гаргах зорилгоор Компаниас түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтын эх хувь болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн Компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөнддөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:





Дээр дурасанаас үзвэл, 2015 оны 05 дугаар сарын 04-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгсэн тухай 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр олгогдсон Улсын бүртгэлийн гэрчилгээ (Хавсралт 1.3) бүхий "Сэндли ББСБ" ХХК нь хууль зүйн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 05 дугаар шийдвэр (Хавсралт 1.7)-ээр Компанийн хүчмэцгээг хувааж зарах байдлаар өөрчлөхөөр шийдвэрлэсэн байна.

Гарчиг	Одоо	Хувьцаа хуваасны дараа
Хувьцааны нийт тоо ширхэг	6,428,500	128,570,000
Нэг хувьцааны нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	1,000	50

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ХЭХ-ын шийдвэрийн дагуу СЗХ-оос зөвшөөрөл авах, Улсын бүртгэлд бүртгүүлэх ажиллагаа хийгдэж байна.


Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн "Сэндли ББСБ ХХК-д "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах болон түүнтэй холбогдох бусад хэлэлцсэн асуудлыг батлах тухай" 06 тоот шийдвэр (Хавсралт 1.8) гарсан байна. Уг шийдвэртэй холбоотой холбогдох зөвшөөрөл авахаар 2022 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр (Хавсралт 1.10) СЗХ-д хандсан ба Дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг асуудлыг СЗХ хянаж байна.


Үнэт цаас гаргах тухай шийдвэрийн талаар.

"Сэндли ББСБ" ХХК-ийн 2022 оны 02-р сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар (Хавсралт 1.9) ББСБ нь үйл ажиллагааны эх үүсвэрт зарцуулах зорилгоор компанийн энгийн хувьцааг нэмж гаргах, нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 08 дугаар шийдвэр (Хавсралт 1.11)-ээр Компаниас хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгон нэмж гаргах, энгийн хувьцаанаас Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх, үнэт цаасны нэг бүрийн нэрлэсэн үнэ, татан төвлөрүүлэх хөрөнгө, нөхцөл зэргийг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 50 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 156,570,000 ширхэг энгийн хувьцаан дээр 50 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 67,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргах;
- Нийтэд санал болгож буй хувь нь 29,97 хувь, нийтэд санал болгох үнэ 150 төгрөг байх;
- Нийтэд санал болгох хувьцааны бүртгэлийг Монголын хөрөнгийн биржийн II самбарг бүртгүүлэх;
- Стратегийн хөрөнгө оруулагчийн хувьцааг тусгаарлах нэмэлт нөхцөл 9-36 сарын хугацаанд байх;
- Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох замаар 10,050,000,000 "Арван тэрбум гавин сам" төгрөгийг татан төвлөрүүлэх;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийг шийдвэрт заасны дагуу өөрийн тусгай зөвшөөрөлтэй үндсэн үйл ажиллагааны эх үүсвэрт зарцуулах.

"Хувьцаа хуваах тухай" Сэндли ББСБ ХХК-ийн 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоол, "Сэндли ББСБ" ХХК-д "Гэгээн алтан од" ББСБ" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах болон түүнтэй холбогдох бусад асуудлыг батлах тухай" Сэндли ББСБ ХХК-ийн 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 06 дугаар тогтоолыг СЗХ-ноос материаллаг өөрчлөлтгүйгээр зөвшөөрч, зохих ёсоор Улсын бүртгэлд бүртгэнэ гэж үзвэл, хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгох тухай ХЭХ-ын шийдвэр нь Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан бүрэн эрх болон хуульд нийцсэн байна.





Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн 1 тоот тогтоол (Хавсралт 2.2)-оор ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна. Сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн гишүүдийн боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн дүрмийн 3.13-д тус Компанийн эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалтад "Компани өөрийн онцлогтой тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрмдээ заасан байна" гэж заасан шаардлагад нийцсэн байна. Иймд Компанийн тухай хууль болон Компанийн дүрмд¹ үндэслэн тус Компанийн Эрх бүхий албан тушаалтан гэдэг: ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал, Салбарын удирдлага хариуцсан захирал, Мэдээлэл, технологи хариуцсан захирал, Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал, Мөнгөн гуйвуулга хариуцсан дэд захирал, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд хамруулан аач үзлээ.

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч "Монголын финтек групп" ХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу нэг хувьцаа эзэмшигч ("Монголын мөчүлэл финанс групп" ГХОХХК, РД: 6234151)-гэйгээр 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна. Монгол Улсын хуулийн этгээд "Монголын финтек групп" хаалттай ХК (Улсын бүртгэлийн дугаар: 4008001006; РД: 6692257) нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэгдсэн 252 хувьцаа эзэмшигчтэй хаалттай хувьцааг компани (Хавсралт 9.1, Хавсралт 9.2) юм.

Компанийн ТУЗ нь Хувьцаа эзэмшигчийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 17 тоот шийдвэр (Хавсралт 2.1)-ээр нийт 5 бүрэлдэхүүнгэйгээр сонгогдсон гишүүдээ Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 04 тоот шийдвэрээр улируулан сонгосон (Хавсралт 2.1). Мөн Компанийн тухай хуулийн 62.1.7, 77.3-т тус тус заасны дагуу Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 07 тоот шийдвэрээр ТУЗ-ийн зарим гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгож ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна (Хавсралт 2.32). Ийнхүү Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор СЗХ-оос холбогдох төвшөөрөл алахаар 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 131 тоот албан бичгээр хандсан байна (Хавсралт 2.33). Дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг асуудлыг СЗХ хянаж байна.

Б.Наранбат нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2021 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн 1 тоот тогтоол (Хавсралт 2.2)-оор ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна. Сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн, гишүүдийн боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:


№	Нэр	Боловсрол	Ажлын туршлага
ЕРДИЙН ГИШҮҮД:			
1.	Багтуялын Наранбат (Хавсралт 2.3)	2003-2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургууль санхүүч мэргэжлээр бакалавр; 2010-2011 онд Японы гадаад	2008-2012 онд Сангийн яаманд мэргэжилтэн; 2012-2013 онд Төрийн банкны Хөрөнгө зохицуулалтын

¹ Компанийн дүрмийн 3.13: ББСБ нь Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирлыг Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.





		худалдааны байгууллагад эдийн засагч.	хэлтэст захирал: 2013 онд Төрийн банкны Хөрөнгө зохицуулалтын газарт захирал; 2013-2016 онд Төрийн банкны Санхүү хариуцсан дэд захирал; 2016 онд Төрийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч; 2016 оноос одоог хүртэл Гяле гогрог ХЗХ-нд үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал.
2.	Мөнхтөрийн Цолмон (Хавсралт 2.4)	2007 онд Америкийн Нэгдсэн Улсын Индиангийн их сургуульд санхүүч мэргэжлээр бакалавр.	Сангийн яаманд мэргэжилтэн; Тээвэр дархан ХК-д Эдийн засагч; 2014-2016 онд Тариалан эрхлэлтийг дэмжих санд Гүйцэтгэх захирал.
3.	Лхагжавын Нарантуяа (Хавсралт 2.5)	2004 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр Бакалавр.	2008-2009 онд сар Зоос банк ХХК-д Мэргэжилтэн; 2009-2018 онд Төрийн банкинд Хуульч, Ахлах хуульч; 2018-Одоог хүртэл Хай пэймэнт солюшнс ХХК-д Хууль эрх зүй хариуцсан захирал.
4.	Найдангийн Билгүүн (Хавсралт 2.6)	2009 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр Бакалавр; 2012 онд АНУ-ын Миссури их сургуульд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр.	2013-2018 онд Сангийн Яамд мэргэжилтэн; 2018-2021 онд Сэлус Номадс компанид Менежер; 2021-2022 онд Дэлхийн банкинд Зөвлөх.
5.	Батбаярын Эрдэнэ (Хавсралт 2.7)	2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд бизнесийн удирдлагын бакалавр; 2014 онд Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльсийн их сургууль (UNSW)-д	2007-2012 онд Сангийн яамны ДАХШҮГ-т Мэргэжилтэн; 2014-2015 онд Сангийн яамны ЭУДАГ-т Ахлах мэргэжилтэн;






		удирдлагын мастер.	2015-2016 онд Төрийн банкны Хяналт шалгалтын газрын Захирал; 2016-2017 онд Төрийн банкны Актив, пассивын удирдлагын газрын Захирал; 2017 оноос одоог хүртэл Техбюкс ХХК-ийн Гүйцэтгэх захирал.
ХАРААТ БУС ГИШҮҮД:			
6.	Баатархүүгийн Анужин (Хавсралт 2.34)	2008-2012 онд Бритиш Колумбигийн Их сургуульд Байгаль орчин, тогтвортой хөгжил мэргэжлээр бакалавр; 2015-2016 онд Гренобль Бизнес сургуульд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр.	2012-2015 онд АНУ-ийн Азийн санд Хөтөлбөрийн мэргэжилтэн; 2016-2018 онд Эрнст энд Янг Аудитид Ахлах аудитор; 2018-2021 онд Централ ТВ-д Гүйцэтгэх захирал.

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл нь "Тялс кредит ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот шийдвэр (Хавсралт 2.8)-ээр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Гантуяа нь ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 02 тоот тогтоол (Хавсралт 2.9)-оор, Ерөнхий нягтлан бодогч Х.Ичинхорлоо Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/93-1 тоот тушаал (Хавсралт 2.10)-аар, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал Х.Ичинхорлоо Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/93-1 тоот тушаал (Хавсралт 2.11)-аар, Салбарын удирдлага хариуцсан захирал П.Болорчулуун Гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Б/27 тоот тушаал (Хавсралт 2.12)-аар, Мэдээлэл, технологи хариуцсан захирал И.Түвшинзуул Гүйцэтгэх захирлын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/25 тоот тушаал (Хавсралт 2.13)-аар, Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал Э.Мөнхдэлгэр Гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Б/68 тоот тушаал (Хавсралт 2.14)-аар, Мөнгөн гуйвуулга хариуцсан дэд захирал Б.Нямжаргал Гүйцэтгэх захирлын 2021 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Б/62 тоот тушаал (Хавсралт 2.15)-аар, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал Д.Баярбат Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/29 тоот тушаал (Хавсралт 2.16)-аар тус тус томилогдон ажиллаж байна.


Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 10.1-д заасны дагуу ТУЗ нь а/ Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, б/ Аудитын хороо, в/ Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо гэсэн байнгын хороодтой байхаар заасан. Гэсэн хэдий ч ББСБ нь уг хороодыг байгуулаагүй ба анх удаа хувьцаагаа нийтэл санал болгох үед ТУЗ-ийн дэргэдэх хороодыг зохих ёсоор байгуулж ажиллахаа Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.4). Компанийн тухай хуулийн 81.1, 81.2-д зааснаар ХХК-ийн "Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно" гэж тусгажээ. ББСБ нь журамд заасан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг зохих ёсоор байгуулаагүй нь Компанийн тухай хуулийг зөрчөөгүй ба ББСБ цаашид зохих арга хэмжээ авна гэж МДСХ үзлээ.

Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав:






№	Нэр	Боловсрол	Ажлын гуриллага
1.	Балжинням Олгэрэл (Гүйцэтгэх захирал)	(Дээрхээс танилцана уу.)	(Дээрхээс танилцана уу.)
2.	Гантөмөр Гантуяа (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) (Хавсралт 2.17)	2008-2012 онд Монголын Үндэсний Их Сургуульд Бизнесийн эдийн засгийн бакалавр; 2015-2017 онд Монголын Үндэсний Их Сургуульд Эдийн засгийн магистр.	2012-2015 онд Төрийн банкны Дорноговь салбарт Архив бичиг хэрэг; 2015-2017 онд Төрийн банкны Дорноговь салбарт Мэдээлэл судалгааны эдийн засагч; 2017-2018 онд Төрийн банкны Дорноговь салбарт Харилцааны менежер; 2018-2020 онд Гялс төгрөг ХЗХ-ны менежер; 2020-2021 онд Гялс кредит ББСБ ХХК-ийн Дотоодын данс хариуцсан менежер; 2021 оноос одоог хүртэл Хай плеймэнт солиошис ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тулал; 2022 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.
3.	Хандахүүгийн Ичинхорлоо (Ерөнхий нягтлан бодогч) (Хавсралт 2.18)	1995-1999 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр; Эдийн засгийн үндэсний дээд сургуульд Бизнесийн удирдлагын магистр.	Зоос банкны Кассын нярав, Хяналч нягтлан бодогч, Теллер, Ахлах теллер, Ерөнхий нягтлан бодогч; Төрийн банкны Ерөнхий нягтлан бодогч, Харилцааны менежер, Мэргэжилтэн;
4.	Хандахүүгийн Ичинхорлоо (Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал) (Хавсралт 2.18)		2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал.





5.	<p>Пүрэвдоржийн Болорнулуун (Салбарын удирдлага хариуцсан захирал) (Хавсралт 2.19)</p>	<p>2000-2004 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд Санхүүгийн удирдлагын бакалавр.</p>	<p>2004-2010 онд Монгол шуудан банкны Нийтлэн, Эдийн засагч, Мэргэжилтэн, Хянан шалгагч; 2010-2013 онд Хадгаламж банкны Ахлах аудитор, Ахлах менежер; 2013-2021 онд Төрийн банкны Глобсоны төвийн захирал, Менежер. 2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Салбарын удирдлага хариуцсан захирал.</p>
6.	<p>Иширэнцэгийн Түвшинзуул (Мэдээлэл, технологи хариуцсан захирал) (Хавсралт 2.20)</p>	<p>2002 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд Банк санхүүгийн эдийн засагч, санхүүч мэргэжлээр бакалавр.</p>	<p>2002-2003 онд Хаан банкны; 2004-2009 онд Монгол шуудан банкны; 2009-2011 онд Хадгаламж банкны; 2011-2015 онд Төрийн банкны; 2015-2017 онд Караван ХХК-ийн; 2017-2021 онд Тээвэр хөгжлийн банкны; 2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Мэдээлэл, технологи хариуцсан захирал.</p>
7.	<p>Энхжаргалын Мөнхдэлгэр (Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал) (Хавсралт 2.21)</p>	<p>2008 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд Эдийн засгийн кибернетикч мэргэжлээр бакалавр.</p>	<p>2008-2009 онд Финпак ХХК-ийн; 2009-2013 онд Хадгаламж банкны; 2013-2016 онд Төрийн банкны; 2016-2021 онд Гялс төгрөг ХЗХ-ны; 2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ны Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал.</p>






8	Бадаржийн Нимжаргал (Мөнгөн гуйвуулга харуусан дэд захирагч) (Хавсралт 2.22)	2011 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд Санхүүгийн менежментийн бакалавр; 2015 онд Pacific States University-д Бизнесийн удирдлагын магистр.	2010-2012 онд Вагнер Али Тоног Төхөөрөмж ХХК-ийн; 2016-2017 онд Голомт банкны; 2018 онд Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн; 2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Мөнгөн гуйвуулга харуусан дэд захирагч.
9	Данзангийн Баярбат (Эрсдэл, хяналт шалгалт харуусан дэд захирагч) (Хавсралт 2.23)	2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд Санхүүч мэргэжлээр бакалавр; 2016 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд Санхүүгийн менежер мэргэжлээр магистр.	2007-2009 онд Анод банкны Эдийн засагч; 2010-2017 онд Төрийн банкны Ахлах хянан шалгагч; 2017-2020 онд Гялс төгрөг ХЗХ-д Эрсдэл, хяналт шалгалт харуусан дэд захирагч.

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд бусад эрх бүхий албан тушаалтнуудын мэргэжил, боловсрол, эрхэлж байсан байгаа ажлын туршлага зэргээс дүгнэвэл Компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай гэж үзвээ.


Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА					
№	Нэр/Шаардлага	Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, нэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх	Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)*	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)	Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)
1.	Б.Наранбат (ТУЗ-ийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430282/	Тийм





				(Хавсралт 2.24)	
2.	М.Цолмон (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм (2021.05.17-ны өдөр, Дугаар 0430814) (Хавсралт 2.25)	Тийм
3.	Л.Нарангуяа (ТУЗ-ийн гишүүн) *СЗХ-ноос зөвшөөрөл хүлээгдэж байгаа	Үгүй	Үгүй*	Тийм (2021.05.17-ны өдөр, Дугаар 0430825) (Хавсралт 2.26)	Тийм
4.	Н.Билэгүүн (ТУЗ-ийн гишүүн) *СЗХ-ноос зөвшөөрөл хүлээгдэж байгаа	Үгүй	Үгүй*	Тийм (2021.05.17-ны өдөр, Дугаар 0430824) (Хавсралт 2.27)	Тийм
5.	Б.Эрдэнэ (ТУЗ-ийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм (2021.05.17-ны өдөр, Дугаар 0430816) (Хавсралт 2.28)	Тийм
6.	Б.Анужин (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм (2022.05.09-ны өдөр, Дугаар 0132018) (Хавсралт 2.35)	Тийм
7.	Г.Гантуяа (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм (2021.05.17-ны өдөр, Дугаар 0430854) (Хавсралт 2.29)	Тийм
8.	Х.Ичинхорлоо (Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий зохицуулалт)	Үгүй	Үгүй*	Тийм (2021.05.17-ны өдөр, Дугаар 0430819) (Хавсралт 2.30)	Тийм



СЗХ
2022.08.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01




	хариуцсан захирал)				
9.	П.Болорчулуун (Салбарын удирдлага хариуцсан захирал)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
10.	И.Түвшинзул (Мэдээлэл, технологи хариуцсан захирал)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
11.	Э.Мөнхэлээр (Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм
12.	Б.Нямжаргал (Мөнгөн гуйвуулга хариуцсан дэд захирал)	Үгүй	Үгүй*	Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430879 (Хавсралт 2.31)	Тийм
13.	Д.Баярбат (Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал)	Үгүй	Үгүй*	Үгүй	Тийм

* Мөнгөн Улсын Хууль зүйн сайдын 2013.01.31-ний өдрийн А/12 тоот тушаалын 4 дүгээр хавсралтад заасны дагуу Ял шийтгэлтэй эхэл хэргээсээ өмсгөлийн мөдөртөө өлгөөсөгүй тул Компанийн тухай хуулийн 34.3.2-т заасан эл шийтгэл эдэлгээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүтэй албан тушаалтан хангаж байгаа эсэхийг жинхэнэ гаргаж өссөн мэдүүлэг, баталгааг үндэслэж бүтэн.

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага		
№	Шаардлага	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс






		Б.Анужин
1.	Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КгХ-ийн 79.1.1)	Тийм**
2.	Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд алваа ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КгХ-ийн 79.1.2)	Тийм**
3.	Төрийн үйлчилгээнийхээ бусад төрийн алба хашдаггүй байх (КгХ-ийн 79.1.3)	Тийм**
4.	Компанигай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КгХ-ийн 79.1.4)	Тийм**
5.	Сүүлийн 5 жилд компани нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх	Тийм**
6.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх	Тийм**
7.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх	Тийм**
8.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх	Тийм**
9.	Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх	Тийм**
10.	Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх	Тийм**

**Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хариат бус гишүүнд тивчлэх шаардлагыг тус Компанийн ТУЗ-ийн хариат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдэгдэл, баталгааг үндэслэж дүгнэв.

Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чалвар, даллага туршлагатай гэж дүгнэв.





Үнэт цаас танилцуулга болон үүнийг хангахыг нь хийгчид үзсэн гэмтлэгч Хэрэгжүүлэгчид нь "Компанийн үнэт цаасны танилцуулга" гэмтлэгчид

Компанийн дүрэм. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 17 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Сэндли ББСБ" ХХК-ийн дүрэм (шаашид "Дүрэм" гэж) -ийг (Хавсралт 1.4) баталсан байна. Дүрмээр компанийн үндсэн мэдээлэл, эрх, үүрэг, хариуцлага, компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө, ББСБ-н удирдлага, түүний эрх хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, түүний бүрэл эрх, ажиллах журам, ББСБ-ын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт, ББСБ-ыг өөрчлөн байгуулах, таган буулгах харилцааг тодорхойлж, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах тухай нийт 13 бүлэг зохицуулалтыг тодорхойлсон байна. Энэхүү дүрэм нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, СЭХ-ны 2016 оны 03-р сарын 11-ний өдрийн 71 дугаар тогтоолоор баталсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн болно.

Компанийн үндсэн үйл ажиллагаанд замзарах журам

Хөдөлмөрийн дотоод журим. (Хавсралт 3.1). "Сэндли ББСБ" ХХК-ны зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт тавих, хөдөлмөрийн бусад харилцааг зохицуулах зорилгоор Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/11 тоот тушаалын хавсралтаар нийт 15 бүлэг, 9 хавсралтаас бүрдэх Хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, Сэндли ББСБ ХХК-ийн удирдлага, зохион байгуулалт, Сэндли ББСБ ХХК-ийн дотоод үйл ажиллагаа, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, ажилтныг ажилд авах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дуусгавар болгох, цуцлах, Сэндли ББСБ ХХК-д хамт ажиллахыг хориглох, хязгаарлах, ажил хүлээлцэх, ажил олгогчийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, ажил, амралтын цаг, чөлөө, ажилтанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, тэтгэмж, нохон олговор, ажилтанд хориглох зүйл, хөдөлмөрийн сахилгын болон эд хөрөнгийн хариуцлага, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт хяналтыг тодорхойлсон байна. Түүнчлэн журмын нэгдүгээр хавсралтаар Ярилцлагын үнэлгээний хуудас, хоёрдугаар хавсралтаар Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний загвар, гуравдугаар хавсралтаар хөдөлмөрийн гэрээний загвар, дөрөвдүгээр хавсралтаар эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, тавдугаар хавсралтаар нууцын гэрээ, зургаадугаар хавсралтаар туршилтын хугацаанд ажиллаж буй ажилтныг үндсэн ажилтнаар томилох саналын хуудас, долдугаар хавсралтаар тойрох хуудас, наймдугаар хавсралтаар зөрчлийн акт, ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах саналын хуудасны загварыг тус тус баталсан байна.

Компанийн тухай хуулийн 85.1, Компанийн дүрмийн 9.8.9 дэх заалтад заасан бүрэн эрхийн дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан байх ба энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.10 дахь заалт, 12 дугаар тийлд заасан шаардлагад нийцсэн байна.

Ажиллагсад, хамтран ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ (Хавсралт 3.33). "Сэндли ББСБ" ХХК-ийн ажиллагсад, хамтран ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн зорилго нь компанийн хөгжилд хувь нэмрээ оруулж, үр бүтээлтэй ажиллаж буй ажилтан, хамтран ажиллагсад урамшуулах, хөрөнгийн хуримтлалтай болох боломжийг өгөх, ажлын гүйцэтгэлийг сайжруулахад хувьцаа эзэмшүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн н-01 тоот шийдвэрийн хавсралтаар нийт 7 зүйл, 1 хавсралтаас бүрдэх Ажиллагсад, хамтран ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг батлан мөрдүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь нийтлэг үндэслэл, хамрах хүрээ, баримтлах зарчим, ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх, тагвар,



Handwritten signature in blue ink





хөтөлбөрийн дагуу хувьцаа эзэмшиж буй ажиллагсад ажлаас гарах, чөлөө авах, ажиллагааг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Зээлийн үйл ажиллагааны журам. (Хавсралт 3.2) Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тоот тушаалын Хавсралтаар зээлийн эрх нээх гэрээний дагуу зээл олгох, үндсэн зээл болон хүүг төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн Зээлийн үйлчилгээний журмыг (Хавсралт) батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар Компанийн зээлийн өргөдлийг хүлээн авах, үнэлэх, шийдвэр гаргах үйл явц баримтлах зарчим, зээлэгчид тавих шаардлага, зээлийн бүтээгдэхүүн, зээлийн эрх нээх гэрээ байгуулах, зээлийн хэмжээ, барьцааны зүйл, зээл олголт, эргэн төлөлт, сунгалт, зээлийн хяналт, зээлийн үйлчилгээний процесс болон ажилтны харилцаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Энэхүү журам нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Зээлийн хорооны үйл ажиллагааны журам. (Хавсралт 3.3) Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн А/04 тоот тушаалын Хавсралтаар Компанийн Зээлийн Хорооны бүрэлдэхүүн, ажиллах зарчим, эрх үүрэг, хурал хуралдуулах, шийдвэр гаргах үйл явц хариуцлагын тогтолцоог зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн Зээлийн хорооны ажиллах журам болон Зээлийн хорооны шийдвэрийн маягтыг хавсралтаар батлан мөрдүүлж байна. Зээлийн хорооны гишүүд болон нарийн бичгийн даргын гүйцэтгэх үүрэг, хорооны хурлын дэг болон хурлаас шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Уг журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

Зээлийн бодлого. (Хавсралт 3.4) Харилцагчдын санхүүгийн хэрэгцээнд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, зээлийн үйл ажиллагаанд хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 06 тоот тогтоолын хавсралтаар нийт 5 бүлгээс бүрдэх Зээлийн бодлого (Хавсралт)-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү Зээлийн бодлого нь Компанийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, барьцаа болон зээлийн багшын газар баримтлах бодлого болон зээлийн эрсдэлийн удирдлага, хяналтын бодлогыг тодорхойлсон. Энэхүү бодлого нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох дүрэм, журамд нийцэж байна.

Дотоод хяналтын үйл ажиллагааны журам. (Хавсралт 3.5) ББСБ-ын хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон хянан шалгагчийн эрх, үүргийн тодорхойлолж, хяналт, шалгалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү дотоод хяналтын үйл ажиллагааны журам нь зорилго, нэр томьёо, хамрах хүрээ, чиг үүрэг, хянан шалгагчийн ёс зүй, хянан шалгагчийн эрх, үүрэг, хориглох үйл ажиллагаа, хяналтын нэгжийн үйл ажиллагааны төрөл, хяналт төлөвлөлтийн ажлыг төлөвлөх үе шатууд, газар дээрх болон зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт, харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь 2011 оны Засгийн газрын 311 тоот тогтоол, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна. Мөн хяналтын нэгжийн үйл ажиллагааны төрөл нь Банк бус санхүүгийн





MDSKhanLex

байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл суурилсан хяналт шалгалт хийх журамд заасан хяналт шалгалтын үйл ажиллагааны төрөлтэй нийцсэн байна.


Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/28 (Хавсралт 3.5) тоот тушаалаар дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажил үүргийг хавсран гүйцэтгүүлэхээр Х.Ичинхорлоог томилсон байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээ сэргийлэх, харилцагчийг таниж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам. (Хавсралт 3.6) Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тушаалын Хавсралт 2-оор "Сэндли ББСБ" ХХК-аар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй гэмцэх, сэжигтэй харилцагчийг таниж мэдэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээ сэргийлэх, харилцагчийг таниж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй гэмцэх тухай хууль", Санхүүгийн зохицуулах хорооны баталсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээ сэргийлэх, харилцагчийг таниж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам" зэрэг эрх бүхий байгууллагаас баталсан журам заарыг зөрчсөн зүйл байхгүй байна.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ботоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр. (Хавсралт 3.7) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна гэсний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 06 тоот голтоолын Хавсралт 2-оор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, "Сэндли ББСБ" ХХК-ийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээ сэргийлэх, харилцагчийг таниж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмын хэрэгжилтийг хангах, Банк бусаар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд эрсдэлийг тодорхойлох, харилцагчид үнэлгээ өгөх, гүүнд үндэслэн эрсдэлийн түвшинээр ангилах, удирдах, хянах зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн хөтөлбөр баталсан байна. Энэхүү хөтөлбөр нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкнаас баталсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээ сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/29 (Хавсралт 2.23) тоот тушаалаар "Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан ажилтан" албан тушаалыг хослон гүйцэтгүүлэхээр Д.Баярбатыг томилсон. Уг ажилтны ажлын байрны голорхойлолтод зааснаар Д.Баярбат нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4.11-д заасны дагуу Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээ урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ба энэ талаар мөн Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.4).

Комплагенсийн үйл ажиллагааны журам. (Хавсралт 3.8) Банк бус санхүүгийн байгууллагын комплагенсийн бодлого болон комплагенсийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх хүрээнд ББСБ-д учирч болзошгүй комплагенсийн эрсдэлийг тодорхойлох, буруулах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дүгээр сарын 24-ны өдрийн А/10 тоот тушаалын хавсралт №3-аар баталсан нийт 7 бүлгээс бүрдэх Комплагенсийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү Комплагенсийн үйл ажиллагааны журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, ББСБ-ын комплагенсийн үйл ажиллагаа, комплагенсийн ажилтны эрх хэмжээ, тайлагнах, комплагенсийн үйл ажиллагааны хяналт, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл суурилсан хяналт шалгалт хийх журамд нийцсэн байна.





Мөнгөн гуйвуулгын журам. (Хавсралт 3.9) Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээгээр харилцагч Гадаад улсаас Монгол улс руу, Монгол улсаас гадаад улс руу мөнгөн гуйвуулга илгээх, хүлээн авахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 3-р сарын 24 өдрийн А/10 тоот тушаалын 4-р хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү мөнгөн гуйвуулгын журам нийтлэг зүйл, журмын нэр томьёо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчилгээний нөхцөл, төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга илгээх, хүлээн авах, шилжүүлэх, гүйлгээг буцаах, валютын ханш, Тест зүйлгээ, тайлан, мэдээ, эрхийн гүйшлэн буюу мэдээллийн аюулгүй байдал, хариуцлага, хяналттай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгалалж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна.

Итгэлцлийн үйлчилгээний журам. (Хавсралт 3.10) Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу итгэлцлийн үйлчилгээтэй холбогдсон "Сэндли" Банк бус санхүүгийн байгууллага болон итгэлцэл үүсгэгч талуудын хоорондын харилцааг зохицуулах зорилгоор "Сэндли ББСБ" ХХК-ийн 2022 оны 3-р сарын 24 өдрийн Гүйцэтгэх захирлын А/10 тоот тушаалын 5 дугаар хавсралтаар нийт 8 бүлгээс бүрдэх Итгэлцлийн үйлчилгээний журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү итгэлцлийн үйлчилгээний журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёо, итгэмжлэгчийн эрх, үүрэг, итгэмжлэгдэгчийн эрх, үүрэг, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах, дуусгавар болох, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Факторингийн үйл ажиллагааны журам. (Хавсралт 3.11) Факторингийн үйл ажиллагааны журмыг зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгэгчээс мөнгөн төлбөрийн үүргийн шаардах эрхийг шилжүүлэн авах, эрхээ хэргжүүлэх болон үүсэн гарах харилцааг зохицуулах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь шаардах эрхээ шилжүүлэх зохицуулалт, түүний үйл ажиллагааны бүрдэл, хяналт, хариуцлага, бусад харилцааг зохицуулсан байна. Шаардах эрхээ шилжүүлэх зохицуулалтын тухайд Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль болон Иргэний хуулийн Эдийн бус хөрөнгө олж авах 122 дугаар зүйл, Шаардах эрхээ шилжүүлэх 123 дугаар зүйлд нийцсэн байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн зааврын дагуу Факторингийн авлагын бүртгэл, Факторингийн авлагын эрсдэлийн сан /ФАЭС/-ийн бүртгэл, Факторингийн тооцоогоор үүссэн авлагын ангиллыг өөрчлөлтийн бүртгэлийг хийхээр тусгасан байна.

Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам. (Хавсралт 3.12) Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журмыг иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн гуравдагч этгээд буюу үүрэг гүйцэтгүүлэгчид баталгаа гаргах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёо, баталгааны гөрөл, ангилал, баталгаа гаргахад баримтлах ерөнхий нөхцөл, төлбөрийн баталгаа гаргах, баталгааны нөхцөлд нэмэлт, оорчлолт оруулах, баталгааны дагуу төлбөр гүйцэтгэх, баталгааг цуцлах, дуусгавар болгох, тайлан мэдээ, баталгааны үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагыг зохицуулсан нийт 11 бүлэг, 4 хавсралтаас бүрдэнэ. Журам нь Иргэний хуулийн 234 дүгээр зүйл, 457 дугаар зүйлд нийцсэн ба тус журамд заасан банк бус санхүүгийн байгууллагаас гаргах төлбөрийн баталгааны дүн нь Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд заасан дүнтэй нийцж байна.

Гадаад валютын арилжааны журам. (Хавсралт 3.13) Гүйцэтгэх захирлын 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/14 тоот тушаалын хавсралтаар гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх гусгай зөвшөөрлийн дагуу компанийн салбаруудад гадаад валютыг арилжаалах, энэхүү үйл ажиллагаанаас ашиг олох болон уг арилжаанд оролцох албан тушаалтнуудын эрх, үүргийг тодорхойлох, тэдгээртэй холбогдон гарах бусад харилцааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс






бүрэлсн Гадаад валютын арилжааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, журмын нэр томьёо, арилжаа хийхэд мөрдөгдөх зарчим, самбарын болон дотоод ханш, ханш зарлах, түүнийг мөрдөх, арилжааг хягаарлах, арилжааг хийж гүйцэтгэх, арилжааны орлого хуваарилах, арилжааны гүйлгээ болон хяналт, хариуцлага зэргийг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцж байна.

Орон сууц худалдан авах зээлийн үйл ажиллагааны журам. (Хавсралт 3.14) Гадаад улсад албан ёсоор амьдарч, хөлөлмөр эрхэлж буй Монгол Улсын иргэн Монгол Улсад байршилтай орон сууцныг худалдан авахад зориулан зээлийн хүсэлтийг хүлээн авч, судалгаа шинжилгээ хийх, зээл олгох тухай шийдвэр гаргах, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, зээлийг төлүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 1 үйцэтгэх захирлын 2022 оны 2-р сарын 01-ний өдрийн А/05-01 тоот тушаалын 1-р хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар зээлийн тодорхойлолт, зориулалт, нэр томьёо, зээл олгох нөхцөл, барьцааны зүйлд тавигдах шаардлага, зээлдэгчид тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, зээлийн судалгаа шинжилгээ, зээл олголт, зээлийн хувийн хэрэг, зээлийн төлбөр хүлээн авах, зээлийг төлүүлэх, зээлийн хяналттай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна.

Хөрөнгийн үнэлгээний заавар. (Хавсралт 3.15) ББСБ-ын зээлийн үйлчилгээнд хөрөнгө барьцаалах үндэслэл, барьцаа хөрөнгөд үнэлгээ хийх аргачлалыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 17/05 тоот тогтоолын хавсралтаар нийт 6 бүлгээс бүрдэх Хөрөнгийн үнэлгээний заавар (Хавсралт 3.1)-ыг батлан мөрдүүлсэн байна. Энэхүү заавар нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл, хөрөнгийн үнэлгээ хийх арга, аргачлал, бусад, хариуцлага гэсэн үндсэн зохицуулалтаас бүрдэх ба зааврын хавсралтаар Зээлийн барьцаа хөрөнгө болох тээврийн хэрэгсэл, орон сууц (орон сууц, амины сууц, хашаа байшин, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга бийгууламж)-ны үнэлгээг тодорхойлох хүснэгтийн загварыг багасан байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.11-т зааснаар зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбогдсон журмыг Санхүүгийн Зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлахаар зохицуулсан боловч СЭХ-ноос энэ талаар журам хараахан батлагдаагүй байна <http://www.frc.mn/frc/wc-78/d/2022/8/87>. ББСБ-аас олгосон зээлийн гэрээний барьцаа хөрөнгийг хэрхэн үнэлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй тул үнэлгээ хийх аргачлал, үндэслэл нь аливаа хуулийн зөрчилгүй гэж үзнэ. Зааврын үндэслэлийг хянан үзвэл, энэ зааврын зорилт нь Сэндли ББСБ-ын зээлийн барьцаа хөрөнгөд үнэлгээ хийх, барьцаанд авах үндэслэлийг тогтоож, МУ-ын Үндсэн хууль, Иргэний хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хадгаламж зээлийн ББСБ-ын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан ББСБ-ын Тэргүүлэгчлийн зөвлөлийн баталсан, заавар журмыг мөрдөж ажиллах, холбогдох арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахаар заасан.

Нийгмийн хөгжлийн санг байгуулах, зарцуулах журам. (Хавсралт 3.16) Нийгмийн хөгжлийн санг бүрдүүлэх болон зарцуулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 2-р сарын 14-ний өдрийн А/06-01 тоот тушаалын хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, нийгмийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт, үүрэг хариуцлагатай холбоотой 4 бүлэг харилцааг зохицуулсан байна.

Компанийн засаглалын бодлого, журам





ТУЗ-ийн үйл ажиллагааны журам. (Хавсралт 3.17) ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага, гишүүдийн үүрэг хариуцлага, ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрх, хариуцлага, ТУЗ-ийн хороолын чиг үүрэг, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, шалгаруулах, гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, ТУЗ-ийн хурлыг зарлах, түүнд бэлтгэх, хуралдуулах, ТУЗ дээр шийдвэр гаргах, шийдвэрийг мэдээлэх, биелэлтэд хяналт тавих, ТУЗ-ийн гишүүдийн идэвхи санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхүйц шалги урамшуулал олгох, хариуцлага хүлээлэх тэрэг ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 15 бүлэг 6 Хавсралтаас бүрдсэн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хурлын 07 тоот тогтоолын хавсралт 1-ээр баталсан байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 2.14-д Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх банк бус санхүүгийн байгууллага нэг буюу түүнээс дээш тхоны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байх шаардлага тавьдаг бөгөөд Журмын 2.3-д зааснаар ТУЗ нь ердийн 4, хараат бус 1 гишүүнтэй байхаар зохицуулсан нь хуульд нийцж байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10.19-д эрсдэл (комплаенс)-ийн хороо нь 3 гишүүнтэй байх ба түүний 2/3 нь хараат бус гишүүн байхаар зохицуулсан. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь боловч Компани нь уг хороодыг байгуулаагүй ба анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох үед ТУЗ-ийн дэргэдэх хороодыг зохих ёсоор байгуулж ажиллах талаар Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.4).

Компанийн дүрмийн 8.5-д “ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл хэдийд ч хуралдуулж болно” гэж зохицуулсан боловч ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11.1-д “ТУЗ-ийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал хийж болно” гэдэгтэй нийцж байна.

Энэхүү журам нь Компанийн тухай хуульд нийцж байна.

Эрсдэлийн удирдлагын бодлого. (Хавсралт 3.18) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 07 тоот шийдвэрийн хавсралт 2-оор компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар компанийн хүлээж болзошгүй хохирлыг бууруулах эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн эрсдэлийн удирдлагын бодлогыг баталсан байна. Энэхүү бодлогод эрсдэлийн төрөл, хэрэгжүүлэх үе шат, бүтэц зохион байгуулалт мөн зах зээл, үйл ажиллагаа, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага болон хяналт хариуцлага зэргийг тусгасан байна.

Хүний нөөцийн бодлого. (Хавсралт 3.19) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 08 тоот шийдвэрийн хавсралтаар мэргэжлийн болон харилцааны чадвар чадавхтай өндөр бүтээмжтэй хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, компанийн өмнөө тавьсан зорилго зорилгод хүрэхэд дэмжин ажиллах хүсэл эрмэлзэлтэй ажилтныг төлөвшүүлэх, ажлын гүйцэтгэл сайн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтан бүрийн хувийн үр чадварыг бүрэн нээж хөгжүүлэн оновчтой үр бүтээлтэй ашиглах компанийн хүний нөөцийн менежментийн үндсэн чиглэл, бэримтлэх үндсэн зарчим, эрхэмлэх зүйлсийг тодорхойлох, компанийн амжилтад оруулсан хувь нэмрээ шударгаар үнэлүүлэн урамшуулан шагнагдах, албан тушаал ахих нөхцөлүүдийг бүрдүүлэх зорилгоор нийт 11 бүлгээс бүрдсэн хүний нөөцийн бодлогыг баталсан байна. Энэхүү бодлогод удиртгал буюу бодлогын зорилго, үндсэн чиглэл, зарчмууд, үйл ажиллагаанд мөрдлөг болгох зүйлс, ажилтнуудад тавих шаардлага, нэр томьёо.



хүний нөөцийн стратеги, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлүүд, хүний нөөцийн төлөвлөлт, ур чадварын тогтолцоо, ажлын байрны шинжилгээ ба тодорхойлолт, хүний нөөцийн бүрдүүлэлт, хүний нөөцийн сонголт, карьер хөгжлийн төлөвлөлт, хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт, гүйцэтгэлийн удирдлага, цалин хөлс уршигуудад нийгмийн халамж, хөдөлмөрийн сахилга ба хариуцага зэргийг тусгаж өгсөн байна.

Ёс зүйн дүрэм. (Хавсралт 3.20) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 09 тоот шийдвэрийн хавсралтаар компани түүний бүх ажилтанд Байгууллагын нууцлал тухай. Хувь хүний нууцлал тухай, Мөнгө усаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон компанийн дотоод дүрэм, журмаар тодорхойлсон зэриг, эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, дагаж мөрдөх, ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн Ёс зүйн дүрмийг баталсан байна. Энэхүү дүрэмд нийтлэг үндэслэл, нэр томъёоны тодорхойлолт, ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зөрчлийг мэдгээлх, шийдвэрлэх, хяналт, хариуцлага, бусад зэргийг тусгасан байна.

Хороодын ажиллах журам. (Хавсралт 3.21) Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/02 тоот шийдвэрийн хавсралтаар хүний нөөцийн хороо, эрсдэлийн удирдлагын хороо, актнв пассивын удирдлагын хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны хэлбэр, зохион байгуулалт, хэлэлцэх асуудал, шийдвэр гаргалт болон гишүүдийн үүрэг хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлэг, 6 хавсралтаас бүрдсэн Хороодын ажиллах журмыг баталсан байна. Энэхүү журамд ерөнхий зүйл, хүний нөөцийн хороо, эрсдэлийн удирдлагын хороо, актнв пассивын удирдлагын хороо, хяналт хариуцлагын талаар тусгасан байна.

Ногдол ашигын бодлого. (Хавсралт 3.22) Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Компанийн тухай хууль, компанийн засаглалын кодексд нийцүүлэх тодорхойлох зорилгоор Ногдол ашгийн бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 08 тоот тогтоолын хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцж байна.

Салбар, нэгжийн үйл ажиллагааны журам (Хавсралт 3.23) Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/15 тоот тушаалын хавсралтаар салбарын бүтэц зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн Салбар, нэгжийн үйл ажиллагааны журмыг баталсан байна. Тус журамд нийтлэг үндэслэл, салбарын бүтэц бүрэлдэхүүн, салбарын үйл ажиллагааны бүтэц бүрэлдэхүүн, салбарын үйл ажиллагааны зохион байгуулалт, тайлагнал, зээлийн үйл ажиллагаа, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа, валют арилжааны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, кассын үйл ажиллагаа, аюулгүй ажиллагаа, хяналт, хариуцлагын талаар тусгасан байна.

Компани нь дор дурдсан нийт 54 салбар (Хавсралт 3.24)-ын үйл ажиллагааг тус журмаар зохицуулж байна. Үүнд:

Салбарууд /Байршил/	Тоо
---------------------	-----





Улаанбаатар (Чингэлтэй дүүрэг 2, Баянзүрх дүүрэг 2, Сонгинохайрхан дүүрэг 1, Налайх дүүрэг 1)	6
Архангай аймаг	3
Баянхонгор аймаг	1
Баян-Өлгий аймаг	1
Булган аймаг	1
Говьсүмбэр аймаг	2
Дархан-Уул аймаг	2
Дорноговь аймаг	4
Дорнод аймаг	3
Дундговь аймаг	2
Завхан аймаг	2
Орхон аймаг	1
Өвөрхангай аймаг	5
Өмнөговь аймаг	3
Сүхбаатар аймаг	4
Сэлэнгэ аймаг	6
Увс аймаг	3
Хэнтий аймаг	4
Төв аймаг	1

СЗХ-ны 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 212 дугаар тушаалаар Төв аймаг Зуунмод суманд нэг салбараа нээж нийт 54 салбартай болсон. Уг нэмэгдсэн салбарыг зохих ёсоор Улсын бүртгэлд бүртгүүлж салбарын гэрчилгээ авахаар ажиллаж байгаа талаар Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.4).


Түүнчлэн Компанийн хэлбэрийг "хязгаарлагдмал хариуцлагатай компани"-аас "нээлттэй хувьцаат компани"-ийн хэлбэрт шилжүүлэх замаар үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотойгоор "Сэндли ББСБ" ХХК нь Нээлттэй хувьцаат компанийн дүрэм (Хавсралт 3.26)-ийн төсөл, "Мэдээллийн үйл ажиллагааны журам" (Хавсралт 3.27)-ын төсөл, "Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам" (Хавсралт 3.28)-ын төсөл, "Ногдол ашгийн бодлого" (Хавсралт 3.29), "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам" (Хавсралт 3.31), "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээ хүргэх журам" (Хавсралт 3.32)-ын төслийг боловсруулж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас сайшаасан тогтоол гаргасан байна (Хавсралт 3.25, Хавсралт 3.30). Эдгээр дүрэм, журам, бодлогын баримт бичгүүдийн төслүүд нь цаашид энэхүү найруулгаараа багцлагдана гэж үзэж Компанийн тухай тэрэг Монгол Улсын хуулиуд, СЗХ-ны журам, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

Компанийн дүрэм, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос баталсан журамд нийцсэн байна.

СЗХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдсэн 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Шинэчилсэн кодексийн 1.2 (залгамж халааны бодлого), 1.4 (ТУЗ-д хүйсийн тэнцвэрийг хангах), 1.5 (чиглүүлэх сургалт), 2.1 (Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь харааг бус гишүүн байх), 5.3 (байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, хэрхэн удирдаж байгааг тайлбарлах), ТУЗ-ийн гишүүдийн олонх нь



хараат бус байх зэрэг болон бусад шинэ нөхцөл, шаардлагыг харгалзан уг кодексийн хэрэгжилтийг хангах талвар тусгай төлөвлөгөө гаргаж ажиллахыг Үнэт цаас гаргагчид зөвлөж байна.





Энэхүү танилцуулга нь зөвхөн мэдээллийн зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд үндэслэлгүй хэлэлцээний үр дүнд хэрэглэж болно.

Бид тус Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.


Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ /Контракт/. Гүйцэтгэх захирал Б.Оагэрэл нь 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр (Хавсралт 2.8)-ээр томилогдсон. Компанийн тухай хуулийн 83.7-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Наранбаттай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г (Хавсралт 4.1)-г 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр шинэчлэн байгуулсан байна. Энэхүү гэрээг хугацаагүй байгуулсан бөгөөд гэрээгээр гэрээний зүйл, гол нөхцөл, хугацаа, ажлын цаг, ажил олгоогчийн эрх, үүрэг, ажлын эрх, үүрэг, шалын олгох, ажил дүгнэх, шагнах, урамшуулах нөхцөл, нууцлал, оюуны өмч, гэрээг дуусгавар болгох, дуцлах, хариуцлага тооцох, эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх үндсэн болон бусад нөхцөлийг тодорхойлсон байна. Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын гэрээ нь 2022 оны 01-р сарын 01-ээс хүчин төгөлдөр хэрэгжинэ буй Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар туйлд заасан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд хамаарах тул тус зохицуулалтад тавьсан шаардлагад нийцсэн байна.

Түрээсийн гэрээ /Баннзүрх дүүрэг/ (Хавсралт 4.2). "Гялс кредит" ББСБ болон Монгол Улсын иргэн нар нь 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдөр №2021/07 тоот түрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, Энхтайваны орлон чөлөө гудамж, 64-р байрны V1 тоот хаягт байрлах үйлчилгээний зориулалттай 83.68м2 талбай бүхий ажлын байрыг 1 жилийн хугацаанд 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийг дуустал Түрээслэгчид түрээсээр эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хуулийн хорин долоодугаар бүлэгт заасан агуулгад нийцсэн ба Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3-т заасны дагуу зохих ёсоор 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлжээ.

Түрээсийн гэрээ /Налайх дүүрэг/ (Хавсралт 4.3) "Гялс кредит" ББСБ болон Монгол Улсын иргэн нар нь 2021 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр 2021/08 түрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар хот, Налайх дүүрэг 2-р хороо, Жаргалант Д.Давлаажав гуламж 13-р байр 1 давхарт хаягт байрлах үйлчилгээний зориулалттай (бие даасан өмчлөх эрхийн гэрчилгээгүй талбай) 290 кв.м талбай бүхий ажлын байрыг 1 жилийн хугацаанд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл Түрээслэгчид эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Түрээсийн гэрээ (Хавсралт 4.4) "Сэндли ББСБ" ХХК болон Монгол Улсын иргэн нар нь 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр түрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат /15171/, Бакуда Ренбүчи гудамж 8/4 гоот хаяг байрлах үйлчилгээний зориулалттай 1 давхрын 200мкв талбайн 100 мкв талбайг 3 жилийн хугацаанд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Түрээслэгчид эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Энэхүү гэрээ нь Иргэний хуулийн хорин долоодугаар бүлэгт заасан агуулгад нийцсэн. Түүнчлэн талууд түрээсийн зүйлийг Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3-т заасны дагуу зохих ёсоор бүртгүүлэхээр 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Улсын бүртгэлд хандсан байх ба





мэдүүлэг хүлээн авсан улсын бүртгэгчийн баримт (Хавсралт 4.4)-ад зааснаар гүрээсийн гэрээг бүртгэж олгох огноо 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар гүрээсийн гэрээг бүртгэх ажил хийгдэж байна.

Гүрээсийн гэрээ /Хархорин салбар/. (Хавсралт 4.5) "Гялс кредит"ББСБ болон "Кондитер-Улаанбаатар" ХХК нь 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр 2 тоот гүрээсийн гэрээг байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 17-р хороо, 1-р хороолол, Москвагийн гудамж 43/А байр 2-р давхрын 50 кв.м талбай бүхий Ү-2201019587 дугаартай гүрээсийн объектыг 1 жилийн хугацаанд 2023 оны 05 дугаар 01-ний өдрийг хүртэл Түрээслэгчид эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан гүрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Павильон түрээслэх гүрээсийн гэрээ /Динжийн 1000/. (Хавсралт 4.6) "Гялс кредит"ББСБ болон "Мөнгөт Цахир Трейд" ХХК нь 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр 2021/0219 тоот Павильон түрээслэх гүрээсийн гэрээг байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Динжийн 1000 үйлчилгээний төвд 2 байрлах, 14-р павильон 1 жилийн хугацаанд 2022 оны 03 дугаар 17-ны өдрийг хүртэл Түрээслэгчид ашиглуулах, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан гүрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хуульд ийцэж байна. Гэрээний 2.2-д "Гүрээсийн гэрээг 1 жилээр сунгах ба гэрээний сунгалт хэсэгт Талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар гэрээг сунгасанд тооцно" гэжээ. Ийнхүү гэрээний хавсралтад заасан сунгалтын хэсэгт 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл 1 жилээр сунгаж талууд гарын үсэг зурж, тамга гэмдэг дарсан байх тул гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Гүрээсийн гэрээ /Нарантуул салбар/. (Хавсралт 4.7) "Гялс кредит" ББСБ болон "Нар-мон" ХХК нь 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр ШЗ-8 тоот гүрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар, Балзүрх дүүрэг, 14-р хороо, 14-р хороолол, Намынжүгийн гудамж, 51-р байр, 3-р давхрын 44 кв.м талбай бүхий ажлын байр оффисын 1 жилийн хугацаанд 2023 оны 05 дугаар 16-ны өдрийг хүртэл гүрээсийн талбайн тодорхой хэсгийг эзэмшиж, ашиглах, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан гүрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Гүрээсийн гэрээ (Хавсралт 4.8). "Сэндли ББСБ" ХХК болон Монгол Улсын иргэн нар нь 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Гүрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгаг /15171/, Бакуда Ренбүчи гудамж 8/4 тоотод байршилтай үйлчилгээний зориулалттай 124кв талбайтай, 4 дүгээр давхар мөн өмчлөлийн 000157456 тоот гэрчилгээний дугаартай Ү-220217941 дугаартай, 1 давхарын 200кв талбайн 100кв талбайг 3 жилийн хугацаанд 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл Түрээслэгчид эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан гүрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Энэхүү гэрээ нь Иргэний хуулийн хорин долоодугаар бүлэгт заасан агуулгад ийцсэн. Түүнчлэн талууд гүрээсийн зүйлийг Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3-г заасны дагуу холх ёсоор бүртгүүлэхээр 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Улсын бүртгэлд хандсан байх ба мэдүүлэг хүлээн авсан улсын бүртгэгчийн баримт (Хавсралт 4.4)-ад зааснаар гүрээсийн гэрээг





бүртгэж олгох огноо 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар гүрээсийн гэрээг бүртгэх ажил хийгдэж байна.

Холбогдох гүрээсийн гэрээний үндсэн дээр ББСБ-ын хөдөө орон нутгийн салбар үйл ажиллагаагаа явуулах ба дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг гүрээсийн гэрээнүүд хүчин төгөлдөр талаар Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.4).

Төрийн мэдээлэл солилцооны систем /ХУР/-ээр дамжуулан мэдээлэл ашиглуулах гэрээ. Компани нь Улсын бүртгэлийн ерөнхий газартай улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7-р зүйлд заасан зорилгоор ашиглахтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахаар 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр 2020/118, 20/01 тоот "Төрийн мэдээлэл солилцооны систем /ХУР/-ээр дамжуулан мэдээлэл ашиглуулах гэрээ" (Хавсралт 4.9)-г 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн дуустал хугацаагаар байгуулжээ. Энэхүү гэрээнд улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл, гэрээний хугацаа, хамтран ажиллах ерөнхий чиглэл, талуудын эрх, үүрэг, хориглох зүйл гэсэн 6 зүйл, 2 хавсралтаас бүрдсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас зөвшөөрөл авах замаар Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем /ХУР/-д мэдээлэл дамжуулах, Үндэсний дата төвтэй хамтран ажиллах, мэдээлэл солилцоо ажиллагаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Засгийн газрын 2019 оны 220-р тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай шатим хилбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ын 3.3, 4.1.6 дахь заалтуудад тус тус нийцсэн байна.

Дээрх гэрээний хугацааг 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 21/028, 2021/435 тоот "Төрийн мэдээлэл солилцооны систем /ХУР/-ээр дамжуулан мэдээлэл ашиглуулах гэрээний сунгалт" гэрээ (Хавсралт 4.10)-гээр 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл сунгаж, үндсэн гэрээний дагуу ББСБ-д мэдээллийг үргэлжлүүлэн ашиглуулахыг зөвшөөрчээ.

Хамтын ажиллагааны гэрээ (Хавсралт 4.11) ББСБ нь Монголбанкны ажиллуулж буй зээлийн мэдээллийн санд болон зээлчүүлэгчид байгаа иргэд, аж ахуй нэгжийн зээл, хүлээж буй болзошгүй үүрэг, үнэт цаас, бусад актив, аливаа өр төлбөр болон холбогдох бусад мэдээллийг харилцан солилцохтой холбоотой харилцааг зохицуулахаар Монголбанкттай 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 0619/281 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулжээ. Энэхүү гэрээ нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28.3 дахь хэсэгт нийцсэн байна.

Программ хангамж түрээсээр ашиглах гэрээ (Хавсралт 4.12) ББСБ нь ГрэйпСити Монгол ХХК-тай харилцагч, харилцагчийн данс, хугацаат хадгаламж, барьцаа хоронго, зээл, монголбанкны зээлийн мэдээллийн сан руу мэдээлэл илгээх, дотоодын данс, балагсын гадуурх данс, ерөнхий дэвтэр, МОСТ платформын интерфэйс буюу поларис суурь системийг түрээсээр ашиглах, гүүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэх болон мэдээллийн нууцлал, төлбөр тооцоотой холбогдсон харилцааг зохицуулахаар 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ДА-21/50 тоот "Программ хангамж түрээсээр ашиглах гэрээ"-г байгуулсан. Энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажил, техникийн шаардлага, төслийн үе шат ба хугацаа, төслийн хяналт ба хэрэгжилт, гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл, нэвтрүүлэлтийн дараах засвар үйлчилгээ, төслийн баг, талуудын эрх, үүрэг, хариуцлага, мэдээллийн нууцлал, оюуны өмч ба зохиогчийн эрх, хэвлэл нийтлэх, маргаан шийдвэрлэх, гэрээ дуусгавар болгох, цуцлах харилцааг зохицуулсан нь Иргэний хуулийн 31-р бүлэг, Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35.1.2 дахь хэсэг, 37.2 дахь хэсэгт нийцсэн байна.



Санамж бичиг (Хавсралт 4.13) Хөүм моргейж корпорэйшн ХХК-ийн Гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэд эх орондоо орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх төсөл дээр хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулсан Техбокс ХХК, Хөүм моргейж корпорэйшн ХХК-иудтай Санамж бичгүүд байгуулж ажилсан байна. Эдгээр санамж бичиг нь хэлцлийн хувьд сонирхлын зөрчилтэй боловч аливаа үүрэг хүлээсэн шинжгүй байх тул сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцон оруулаагүй болно. Тус компаниудтай санамж бичиг байгуулах, цаашилбал төсөлтэй холбоотой гэрээ хэлцэл байгуулах бүрэн эрхийг Компанийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 07 тоот тогтоол (Хавсралт 4.14)-оор олгосон нь хуульд нийцж байна.

Сэндли ББСБ ХХК-ийн хамтын ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл

№	Нөгөө тал	Огноо	Гэрээний нэр, агуулга
1.	Австрали улсын Flexewallet Pty Limited	2020.04.02	Flexewallet түншлэлийн үйлчилгээний гэрээ / Flexewallet affiliate services agreement нь Үйлчлүүлэгчээс мөнгөн хөрөнгийг цуглуулж, улс, хороонд шилжүүлэх, шилжүүлгийн талаар мэдээлэл өгөх, холбогдох шимтгэл, төлбөртэй холбоотой талуудын харилцааг зохицуулсан.
2.	Япон Улсын City express money transfer Japan Co.Ltd.,	2021.06.22	Мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн гэрээ нь Үйлчлүүлэгчээс мөнгөн хөрөнгийг цуглуулж, улс, хороонд шилжүүлэх, шилжүүлгийн талаар мэдээлэл өгөх, холбогдох шимтгэл, төлбөртэй холбоотой талуудын харилцааг зохицуулсан.
3.	"XXX" Компани	2019.05.16	Sub-marketing partner agreement нь мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн маркетингийн үйл ажиллагаатай холбоотой талуудын харилцааг зохицуулсан.
4.	Герман Payment Technologies Co., Ltd.	2021.11.11	Wechat төлбөрийн улс хоорондын үйлчилгээг ашиглан төлбөр тооцоо хийх, аюулгүй байдлыг хангахтай холбоотой талуудын харилцааг зохицуулсан.

Дээр дурдсан хамтын ажиллагааны гэрээ хэлцэлд гадаад улсын хууль тогтоомж, шүүх, арбитрын харьяаллыг сонгосон байна.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний загварууд:

МДСХ нь дараах гэрээний загвар баримт бичгүүдийг хянасан бөгөөд хууль зөрчсөн явдал илрээгүй ба гэрээний гал, нөхцөлүүдээс хамаарч өөрчлөгдөх боломжтой болно. Үүнд:

Баримт бичгийн нэр	Огноо, Дугаар, тайлбар
Цахим зээлийн эрх нээх гэрээний загвар (Хавсралт 4.15)	-
Орон сууцны зээлийн гэрээний загвар (Хавсралт 4.16)	Орон сууц худалдан авах зээлийн үйл ажиллагааны журмын хавсралт
Цахим зээлийн эрх гэрээний загвар /мерчант/ (Хавсралт 4.17)	-
Зээлийн шугамын гэрээний загвар (Хавсралт 4.18)	-
Нууцны гэрээ (Хавсралт 4.19)	Хөдөлмөрийн дотоод журмын хавсралт





ББСБ-ын баталгааны гэрээ Төлбөрийн баталгаа гаргах/ (Хавсралт 4.20) Компанийн харилцагчтай байгуулдаг ББСБ-ын баталгааны гэрээний загварын дагуу Компани нь үүрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр төлбөрийн баталгаа гаргаж, үүрэг гүйцэтгэгч нь ББСБ-ын баталгаанд шимтгэл төлөх, төлбөрийн нэхэмжлэх ирсэн тохиолдолд баталгааны үнийн дүнтэй гэнцэх хэмжээний зээл олгох төлбөр гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү баталгааны гэрээний загварыг хянаж үзэхэд гэрээний түйл, баталгааны дүн, хугацаа, шимтгэл, ББСБ-ын баталгаа гаргах, төлбөр гүйцэтгэх, зээл олгох, үүрэг гүйцэтгэгчийн эрх үүрэг, ББСБ-ын эрх үүрэг, гэрээ дуусгавар болох түүнийг цуцлах нөхцөлүүд, баталгаа, маргаан шийдвэрлэх, хууль хэрэглэх, бусад зүйл гэх 9 бүлэг зохицуулалтыг тусгасан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хуулийн 457-р зүйлд нийцсэн байна. Түүнчлэн Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журмын 3-р хавсралтаар ББСБ-ын баталгааны нэмэлт гэрээний загварын баталсан бөгөөд тус загвараар Баталгааны гэрээний гол нөхцөлд өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Зээлийн эрх нээх гэрээний загвар/ Төлбөрийн баталгаа гаргах/ (Хавсралт 4.21) Компанийн харилцагчтай байгуулдаг зээлийн эрх нээх гэрээний загварын дагуу ББСБ нь Зээлдэгчид зээлийн эрх нээж зээл олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, зээлийн зарцуулалтад ББСБ-ын зүгээс хяналт тавих, зээлийг буцаан төлүүлэх, Зээлдэгч нь ББСБ-ын зээлийн нөхцөлийг хүлээн зөвшөөрч, зээлийг авах, зээлийг буцаан төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Энэхүү зээлийн эрх нээх гэрээний загварыг хянахад гэрээний зүйл, гэрээний нөхцөл, зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгчийн эрх үүрэг, ББСБ-ын эрх үүрэг, баталгаа зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлах, үүргийн гүйцэтгэлийг хангах, бусад зүйл гэх 8 бүлэг зохицуулалтыг тусгасан нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

Барьцааны гэрээний загвар/ Төлбөрийн баталгаа гаргах/ (Хавсралт 4.22) Компанийн харилцагчтай байгуулдаг барьцааны гэрээний загварын дагуу ББСБ, Үүрэг гүйцэтгэгчийн хооронд байгуулсан Зээлийн эрх нээх гэрээний дагуу Үүрэг гүйцэтгэгчдийн бичгээр ирүүлсэн нэхэмжлэхээр хийх төлбөрийн хугацаа болоход үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, төлбөрийн баталгаа гаргах, баталгааны төлбөрт шаардлагатай дүнгээр зээл олгосон тохиолдолд эрсдэлийг багасгах зорилгоор барьцаалах хөрөнгийг сонгох, тэдгээрийг үнэлэх, чанарыг тодорхойлох, барьцаалсан хөрөнгийг хадгалах хамгаалах, барьцаалуулагч баталгааны төлбөр, түүний эрсдэлийг шимтгэл, баталгааны төлбөрт шаардлагатай дүнгээр олгох зээл, түүний хүүгийн төлбөр, зээлийн үйл ажиллагааны шимтгэлийг хугацаагаар төлөгдөөгүй тохиолдолд талуудын хүлээх эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Энэхүү барьцааны гэрээний загварыг хянахад нийтлэг үндэслэл, барьцааны зүйл, барьцаалуулагчийн эрх, үүрэг, ББСБ-ын эрх үүрэг, бусад зүйл гэх 5 бүлэг зохицуулалтыг тусгасан нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

Хөдөлмөрийн гэрээний загвар (Хавсралт 4.23) Компанийн хөдөлмөрийн дотоод журмын хавсралтаар ажил олгогч, ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулж буй "Сэндли ББСБ" ХХК, "Ажил олгогч"-ын ажилтнуудтайгаа байгуулдаг хөдөлмөрийн гэрээний загварыг баталжээ. Энэхүү загвар нь гэрээний гол нөхцөл, хугацаа, ажлын цаг, ажилтны эрх үүрэг, ажил олгогчийн эрх, үүрэг, гэрээг дуусгавар болох, цуцлах, харнуулага, маргаан шийдвэрлэх бусад гэсэн нийт 13 зүйлээс бүрдэж байна. Хөдөлмөрийн гэрээний загвар нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцэж байна.



Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загвар (Хавсралт 4.24). Компани нь ажилтанда эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх зорилгоор байгуулагдах энэхүү гэрээний загвар нь нийтлэг үндэслэл, компанийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, хариуцлага, бусад зүйл гээг 5 бүлэг бүхий зохицуулалтаас бүрдсэн байна. Гэрээг Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хянахад аливаа хуулийн зөрчил илэрсэнгүй.

Үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл

Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ (Хавсралт 4.25) Компанийн бизнесийн үнэлгээг Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон Олон улсын үнэлгээний стандарт, Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аас баталсан дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхд үүсэх харилцааг "Сэндли ББСБ" ХХК болон "Гэрээг-Эстимэйт" ХХК-тай 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан S-22/02 тоот Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээгээр зохицуулсан байна. Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээнд бизнесийн үнэлгээний зориулалт, үнэлгээний зүйл, талуудын эрх үүрэг, бизнесийн үнэлгээний хөлс, бизнесийн үнэлгээний тайланг хүлээлтэн өгөх журмыг тусгасан нь Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн 6.3 дахь хэсэгт нийцсэн байна.

Андеррайтерийн гэрээ (Хавсралт 4.26) Үнэт цаас гаргагчийн Монголын Хөрөнгийн Биржид анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох ажлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-а заасан Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах (Best Effort) хэлбэрээр зохион байгуулах, андеррайтерийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдуулан талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан S-22/11 тоот "Андеррайтерийн гэрээ"-г 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний ТЗ 301/42 дугаар /<http://www.frc.mn/n6703>, 5183855 регистрийн дугаартай "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, брокер, дилерийн, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, ТЗ 301/116 дугаар /<http://www.frc.mn/n198521>, 6481299 регистрийн дугаартай "Райнос инвестмент ҮЦК" ХХК нартай байгуулсан. "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд "Андеррайтер"-аар, "Райнос инвестмент ҮЦК" ХХК нь "Синдикат"-аар оролцож, хамтран ажиллахаар тохиролцсон. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.5 дахь хэсэг, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

"Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, "Райнос инвестмент ҮЦК" ХХК нар нь Үнэт цаас гаргагчтай холбогдох этгээд биш байна.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 4.27) "Сэндли ББСБ" ХХК /Компани/ нь "Райнос Инвестмент ҮЦК" ХХК /Зөвлөх/ нар нь 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулжээ. Энэхүү гэрээгээр Зөвлөх нь "Сэндли ББСБ" ХХК-ийн санхүүгийн загварыг гэрээнд тогтоосон хугацаанд Компанид гаргаж өгөх, Компани нь үнэлгээний тайланг хүлээн авах, төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хуульд нийцсэн байна.

Үнэ тогтоормуулах хит, бөр хэрэгжүүлэх гэрээ (Хавсралт 4.28) Үнэт цаас гаргагч нь 2022 оны 05 дугаар сарын 02-ний өдөр үнэт цаасны компани буюу андеррайтеруудтай хамтран Үнэт





цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж байгад хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаа буюу СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 8-р зүйлд заасан хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сараас доошгүй хугацаанд гүйцэтгэх, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг Хорвоо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхтэй холбоосон гарах харилцаа зохицуулсан зорвон галт гэрээ Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээг "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК, "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, "Стоктаб Секьюритиз ҮЦК" ХХК нартай байгуулжээ. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон СЗХ-ноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 8.1, 8.2-д нийцсэн байна.

Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ (Engagement Letter). (Хавсралт 4.29) (Хавсралт 1.9) Үнэт цаас гаргагч нь 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Компанийн санхүүгийн жилийн эцсийн тайланг 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгож, хагас жилийн тайланд 2022 оны 06 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон СТОУС-д нийцүүлэн аудитын хяналт хийж, дүгнэлт, тайлан гаргах, зөвлөмж өгөх үйлчилгээ үзүүлэх, Компани нь аудитын тайланг хүлээн авах, төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулсан Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг "Эрнст энд Янг Монголиа Аудит" ХХК /EY/-тай байгуулжээ. Тус гэрээ нь Иргэний тухай хууль, Компанийн тухай хууль болон Аудитын тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний ерөнхий нөхцөл (General Terms and Conditions for Audit and Review Engagements). (Хавсралт 4.30) (Хавсралт 1.9) "Сэндли ББСБ" ХХК нь 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр аудитын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хялгаралт, хариуцлагаас чөлөөлөх, мэдээллийн хамгаалалт, нууцлал, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас аль нэг тал гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх тохиолдлын урьдчилсан нөхцөл, гэрээг цуцлах болон маргаан шийшвэрлэх зэрэг нөхцөлүүдийг зохицуулсан Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг "Эрнст энд Янг Монголиа Аудит" ХХК /EY/-тай байгуулжээ. Энэхүү Ерөнхий нөхцөл нь Иргэний тухай хууль, Компанийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

Аудитын үйлчилгээний гэрээ. "Сэндли ББСБ" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргаж өгөхтэй холбогдсон харилцааг "Чадварлаг аудит" ХХК-тай байгуулсан 22/02 дугаартай гэрээ (Хавсралт 4.43)-гээр зохицуулсан байна. Уг гэрээгээр талуудын эрх, харилцан хүлээх үүрэг, хариуцагда, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-г заасан шаардлагад нийцсэн байна. "Чадварлаг аудит" ХХК нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй, Сангийн яамны 150-2017 дугаар аудитын үйл ажиллагаа эрхлэх 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийг хүргэл хүчин төгөлдөр тусгай зөвшөөлийн гэрчилгээтэй компани тул уг үйлчилгээг үзүүлэх бүрэн эрхтэй байна.

Зээлийн гэрэлнүүд:

"Монголын финтекс групп" ХХК болон "Гэлс кредит ББСБ" ХХК нарын хооронд 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулагдсан Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 4.31)

- Гэрээний мэдээлэл:
- Зээлийн дүн: 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг
 - Зээлийн зориулалт: эрсэлтийн хөрөнгө



- Зээлийн хүү: жилийн ХХ хувь
- Зээл олгох валют: төгрөг
- Зээлийн хугацаа: 24 сар

Энэхүү гэрээ нь Компанийн тухай хуулийн 87-р зүйлийн 87.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэлд, мөн Компанийн тухай хуулийн 89-р зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан сонирхлын зорчилтэй хэлцэлд нэгэн зэрэг камаарч байна. Компанийн тухай хуулийн 92.5 дахь хэсэгт "Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд ... түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зорчилтэй хэлцлийг энэ хуулийн 92.3-т заасны дагуу батлуулах шаардлагагүй" гэж заасан байдаг.

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 (Хавсралт 4.32) тоот "Сонирхлын зорчилтэй болон их хэмжээний хэлцэл хийхнийг зөвшөөрөх тухай" тогтоолоор уг зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрч, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Одгэрээд олгосон байна. "Монголын финтек групп" ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Наранбат гарын үсэг зурсан байна. Компанийн тухайн үеийн санхүүгийн тайлангийн мэдээллээс үзвэл энэхүү зээлийн шугамын гэрээний үнийн дүн нь хэлцэл хийхний өмнөх сүүлийн балансын актаны нийт дүнгийн 25 хувьас их буюу их хэмжээний хэлцэл гэж үзэхээр байна. Энэхүү тогтоол нь 88.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл хийх журамд нийцсэн ба Сэндли болон түүний төлгөй компани болох "Монголын финтек групп" ХХК-ийн хооронд 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Зээлийн шугамын гэрээ нь хүчин төгөлдөр байна.

Капитрон банк болон "Сэндли ББСБ" ХХК нарын хооронд 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулагдсан 3096-2022/59 тоот Зээлийн гэрээ /зээлийн шугам/. (Хавсралт 4.33)


Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөг
- Зээлийн зориулалт: эргэлтийн хөрөнгө
- Зээлийн хүү: жилийн ХХ хувь
- Нэмэгдүүлсэн хүү: үндсэн хүүгийн 20 хувь
- Зээлийн хугацаа: 12 сар
- Хариушлага: Зээлдэгч, хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч нь зээлийн төлбөрийг энэ гэрээний Хавсралтад заасан хуваарийн дагуу тухай бүр төлөхөөр банктай энэхүү хуваарийн дагуу зээл, түүний хүү төлөхөөгүй бол зээл хугацаандаа төлөгдөөгүй гэж үзэх үндэслэл болно /5.1/
- Эргэн төлөлт: зээлийн гэрээний хугацаанд сарын 15-ны өдөр

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл олгох, эргэн төлөх хэлбэр, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариушлага, багалгаа ба зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх ааштуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн халгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

3096-2022/59 тоот зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Капитрон банктай 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан 3096-2022/59 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ байгуулжээ.

Ээл алсгоход зуучлах, репо хэлцэл хийх мастер. (Хавсралт 4.37) "Сэндли ББСБ" ХХК нь "Монн Маркет Фонд" ХХК-тай мөнгөн хөрөнгийн чөлөөт эх үүсвэрийн хэрэгцээтэй үед хуулийн этгээдээс зээл авах, зээл олгохтой холбоотой харилцааг зохицуулах сронхий тохиролцоотой





холбоотой Зээл олгоход зуучлах, репо хэлцэл хийх мастер гэрээг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээгээр репо арилжааны нөхцөл, гүйлгээ, хариуцлагыг зохицуулсан нь Иргэний хуулийн 281 дүгээр зүйл болон 451 дүгээр зүйлд заасан ерөнхий шаардлага, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д нийцсэн байна. Үнэт цаас гаргагч нь уг арилжаанд зээл авах байдлаар оролцдог байна.

Репо зээлийн гэрээ (Хавсралт 4.38) Сэндли ББСБ ХХК болон Жэт Финанс ББСБ ХХК нар нь Мони Маркет Фанд ХХК-тай байгуулсан Зээл олгоход зуучлах, репо хэлцэл хийх мастер гэрээг үндэслэн 2022 оны 04 сарын 14-ний өдөр 200,000,000.00 төгрөгийн 20220414-33-3/14-25 Репо зээлийн гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээгээр репо арилжааны нөхцөл, гүйлгээ, хариуцлагыг зохицуулсан нь Иргэний хуулийн ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Энэхүү репо зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Жэт Финанс ББСБ ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр В-20220414-33-3/14-25 тоот барьцааны гэрээ байгуулжээ.

Репо зээлийн гэрээ (Хавсралт 4.39) Сэндли ББСБ ХХК болон Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК нар нь Мони Маркет Фанд ХХК-тай байгуулсан Зээл олгоход зуучлах, репо хэлцэл хийх мастер гэрээг үндэслэн 2022 оны 04 сарын 14-ний өдөр 100,000,000.00 төгрөгийн 20220414-13-13/14-26 Репо зээлийн гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээгээр репо арилжааны нөхцөл, гүйлгээ, хариуцлагыг зохицуулсан нь Иргэний хуулийн ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Энэхүү репо зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр В-20220414-13-13/14-26 тоот барьцааны гэрээ байгуулжээ.

Репо зээлийн гэрээ (Хавсралт 4.39) Сэндли ББСБ ХХК болон Шийдэл Финанс ББСБ ХХК нар нь Мони Маркет Фанд ХХК-тай байгуулсан Зээл олгоход зуучлах, репо хэлцэл хийх мастер гэрээг үндэслэн 2022 оны 05 сарын 03-ны өдөр 300,000,000.00 төгрөгийн 0220503-18-26/14-27 Репо зээлийн гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээгээр репо арилжааны нөхцөл, гүйлгээ, хариуцлагыг зохицуулсан нь Иргэний хуулийн ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Энэхүү репо зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Шийдэл Финанс ББСБ ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр В-20220503-18-26/14-27 тоот барьцааны гэрээ байгуулжээ.

Репо зээлийн гэрээ (Хавсралт 4.40) Сэндли ББСБ ХХК болон Шийдэл Финанс ББСБ ХХК нар нь Мони Маркет Фанд ХХК-тай байгуулсан Зээл олгоход зуучлах, репо хэлцэл хийх мастер гэрээг үндэслэн 2022 оны 05 сарын 03-ны өдөр 100,000,000.00 төгрөгийн 20220503-18-27/14-28 Репо зээлийн гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээгээр репо арилжааны нөхцөл, гүйлгээ, хариуцлагыг зохицуулсан нь Иргэний хуулийн ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Энэхүү репо зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Шийдэл Финанс ББСБ ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр В-20220503-18-27/14-28 тоот барьцааны гэрээ байгуулжээ.

2022 оны 05-р сарын 18-ний өдрийн Зээлийн мэдээллийн лавлагаагаас үзвэл дээрх зээлүүд нь хэвийн (Хавсралт 4.42) хэрэгжиж байна.

Одоогоор дээр дурдсан зээлийн гэрээнээс өөр хүчин төгөлдөр үйлчилж буй зээлийн гэрээ байхгүй, тэдгээр гэрээний үүргийн гүйцэтгэл хэвийн хэрэгжиж байгаа ба сүүлийн 3 жилд





байгуулсан бусад бүх зээлийн гэрээ зохих ёсоор хэрэгжиж дууссан болохыг Компанийн Гүйцэтгэх захирлын албан бичгээр мэдэгдсэн болно (Хавсралт 12.4).

Орийн хэрэгсэл.

Компани нь нээлттэй, хаалттай өрийн хэрэгсэл гаргаалгүй болно (Хавсралт 12.4).

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн (Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний 5 хувь нь 2022 онд 321,425,000 төгрөгөөс дээш, 2021 онд 71,425,000 төгрөгөөс дээш, 2020 онд 71,425,000 төгрөгөөс дээш, 2019 оны 06 сараас хойш 71,425,000 төгрөгөөс дээш, 2019 онд 50,000,000 төгрөгөөс дээш үнийн дүн) бүхий үүрэг хүлээсэн нийт 6 гэрээ байгуулсан. Тэдгээрээс их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэцүүг оруулан нийт 6 гэрээ тус тус хэвийн хэрэгжиж байгаа талаар Компанийн гүйцэтгэх захирал 2022 оны 05 дугаар сарын 18-ний өдрийн 143 дугаар албан бичиг (Хавсралт 12.4)-ээр билэгнэж мэдэгдсэн.

№	Гэрээний дугаар	Гэрээний огтоо	Гэрээний нэр	Үнийн дүн /төгрөг/	Хуулийн шаардлага хангасан эсэх	Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх
1.	ЗГ/21/1027	2021.10.27	Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 4.34)	110,000,000	Хангасан	Хэрэгжиж байгаа
2.	-	2021.07.05	Зээлийн шугамын гэрээ гэрээ (Хавсралт 4.33-ээс дэлгэрэнгүй үзнэ үү)	5,000,000,000	Хангасан	Хэрэгжиж байгаа
3.	3096-2022/59	2022.04.05	Зээлийн шугамын гэрээ гэрээ (Хавсралт 4.33-ээс дэлгэрэнгүй үзнэ үү)	1,500,000,000	Хангасан	Хэрэгжиж байгаа
4.	ИГ/22/01	2022.01.28	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.35)	656,000,000	Хангасан	Хэрэгжиж байгаа
5.	ИГ/18/02	2021.12.06	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.36)	100,000,000	Хангасан	Хэрэгжиж байгаа





6.	ИГ:8-01	2021.10.10	Хөрөнгө итгэмжлэн узиргах гэрээ (Хавсралт 5.19-ээс дэлгэрэнгүй танилцана уу)	2,450,000,000	Хангасан	Хэрэгжиж байгаа
----	---------	------------	---	---------------	----------	--------------------

Дээр дурдсан гэрээнүүд нь Монгол Улсын хууль тогтоомж, СЗХ-оос олгосон тусгай
ювшөөрлийн хүрээнд байгуулагдсан гэж үзэв.

Үнэт цаас гарагчийн байгуулсан гүүний үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой дээр дурдсан
гэрээ, гэрээний загвар нь хууль тогтоомжил нийцсэн байна.





		хэлбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Н-21/12 тоот Нууцлалын гэрээ (Хавсралт 5.2)-г байгуулсан.			
4.	"Хай пэймэнт солюншис" ХХК	Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу "Hi-Pay" аппликэйшн болон QR-аар дамжуулан бараа, үйлчилгээний төлбөрийг хүлээн авахтай холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 21-01/38 тоот Мерчанг ЛЦМХА-тай хамтран ажиллах гэрээг (Хавсралт 5.4)-г байгуулсан.	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Хангасан	Хэрэгжиж байгаа
5.	"Хай пэймэнт солюншис" ХХК	Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу Компани нь өөрийн цахим үйлчилгээгээр дамжуулан ногоо талын Автонэй үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх, автоматаар бараа, үйлчилгээний төлбөр авахтай холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр S21-01/01 тоот Мерчангтай "Автонэй" үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.5)-г байгуулсан.	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Хангасан	Хэрэгжиж байгаа
